

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
БАТЛАН ХАМГААЛАХ
СУДЛАЛ**

№28 (38) 2019

Улаанбаатар

2019



Institute for Defense Studies

**JOURNAL
of
SECURITY AND DEFENSE STUDIES**

№28 (38) 2019

EDITORIAL BOARD:

Editor in Chief: T.Dulamdorj (M.A.)

Editor: B.Munkhsaikhan (Ph.D, Professor)

Deputy Editor-in-Chief: Ch.Battulga (Ph.D, Professor)

Editorial Panel:

L.Battsengel (Sc.D, Professor)

O.Urjin (Sc.D, Professor)

Sh.Palamdorj (Sc.D, Professor)

Technical Editor: B.Bayarmagnai

ISSN 2220-9115

The authors will bear the responsibility for facts, information and views expressed in the article.

Address:

Postal box-184, Branch 22, Mongolpost,

Ulaanbaatar city, 13320

Phone: 976-453942

www.mids.gov.mn

АГУУЛГА

Цэргийн эрдэм судлал

Ш.Паламдорж	Цэргийн эрдэм судлалын нэгэн жарны хөгжил, үр дүн	5
Ж.Базарсүрэн	Цэргийн эрдэм судлалын залуурчид	14
П.Цэдэв	Цэргийн эрдэм судлалын “эрдмийн гал тогоог баригч”	18

Аюулгүй байдал

Б.Эрдэнэчимэг	Шинэ эринд баримтлах хятадын батлан хамгаалах бодлого . . .	26
Б.Нэргүй	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад эрдэс баялгийн салбар дах төрийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд	33
Д.Энхчимэг,		
М.Индрабүд	Хүний аюулгүй байдалд насжилт нөлөөлөх нь	39
Р.Энхболд	Умард солонгосын цөмийн болон баллистик пуужингийн туршилт, түүний хөгжлийн чиг хандлага	53
Б.Баярцэнгэл	Хүчний тэнцвэр, эвсэл холбооны тухай реалист болон либерал үзэл	65

Зэвсэгт хүчний хөгжил шинэчлэл

Ц.Гандорж	Байлдааныг зохион байгуулах үеийн захирагч, штабын ажилд тавигдах шаардлагын судалгаа	72
С.Пүрэвдорж	Зэвсэгт хүчний тусгай томилгоот анги, салбарын террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны сургалтын туршлага, сургамж	81
Б.Далайбаатар,		
Г.Эрдэнэбаатар	Радио цахим гэмцлийг зохион байгуулах нь	97
Т.Намсрай	“Өнгөт хувьсгал” ба гибрид дайны мөн чанар, онцлог	111
Б.Баатарсүрэн	Эмэгтэй алба хаагчдын хууль эрхзүйн байдал болон энхийг дэмжих ажиллагаан дахь оролцоо	125
Ч.Улаанхүү,		
Н.Орхон	Офицерын ёс суртахууны асуудал	140

Цэргийн сургалт, боловсрол

Б.Өлзийхуяг	Батлан хамгаалах боловсролын сургах зүй ба сэтгэл зүйн зарим асуудал	147
Т.Соронзонболд,		
С.Юндэн	Цэргийн эмнэлгийн сургалтын тогтолцооны зарим асуудалд	154

Түүх уламжлал

Т.Сүхбаатар	Түшээ гүн Гадинбалын Чагдаржав ба Монгол Улсын батлан хамгаалах бодлого	161
Ц.Бямба-Эрдэнэ	Уйгурын хотын байршил, тархалт, зохион байгуулалтын онцлог	168
Г.Балжинням,		
М.Баярмаа	Юань улс Корёгийн улс төрийн дотоод хэрэгт нөлөөлсөн нь	177
Ч.Улаанхүү	Өнгөрсөн зууны эхэн үеийн хилийн чанд дахь Орос орны цэргийн соёл	182

JOURNAL of SECURITY AND DEFENSE STUDIES

ISSN 2220-9115

Contents

Military studies

Sh.Palamdorj	Development of military studies for six decades	5
J.Bazarsuren	Leading scholars of the military studies	14
P.Tsedev	Coordinators of military studies	18

Security

B.Erdenechimeg	China's defense policy in New era	26
B.Nergui	Some issues of improving state management in mining sector to ensure Mongolia's national security.	33
D.Enkhchimeg, M.Indrabud	Issue of ageing population and human security	39
R.Enkhbold	On the tendency of North Korea's Nuclear and Ballistic missile tests	53
B.Bayartsengel	Realistic and Liberal concepts on Balance of Power and alliance	65

Development and reform of Armed Forces

Ts.Gandorj	Research on requirements for commander and staff activities during battle	72
S.Purevdorj	Anti-terrorism training for special operations units of Armed Forces	81
B.Dalaibaatar, G.Erdenebaatar	Organizing radio electronic warfare	97
T.Namsrai	On "Color revolution" and hybrid warfare	111
B.Baatarsuren	Legal status of female members of Armed Forces and their participation in peace operations	125
Ch.Ulaankhuu, N.Orkhon	Issues on officers' ethics	140

Military training and education

B.Ulziikhuyag	Some issues of psychological training in the defense education	147
T.Soronzonbold, S.Yunden	Training of the Military Medical personnel	154

History

T.Sukhbaatar	Chagdarjav Gadinbal and defense policy of Mongolia"	161
Ts.Byamba-Erdene G.Baljinnyam, M.Bayarmaa	Distributions and organizations of Uyghur cities	168
Ch.Ulaankhuu	Yuan Dynasty's influence on Goryeo's domestic political affairs	177
	Russian military culture overseas in early XX century	182

Редакцийн зурвас

Хүндэт уншигчид аа, Эрдэмтэн, судлаачид аа,

Та бүхэнд “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүлийн шинэхэн дугаар хүрэх өдрийн мэндийг сэтгүүлийн редакцийн зөвлөлийн нэрийн өмнөөс хүргэе.

БХЭШХ-ээс хагас жил тутам эрхлэн гаргадаг “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүлийн энэ удаагийн дугаарыг урьдын адил ивээн тэтгэн бидний ажил дэмжлэг үзүүлж буй Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлд нэн түрүүнд талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Энэ онд Батлан хамгаалах салбарын эрдэм судлалд олон чухал үйл явдал тохиолоо. Тухайлбал энэ онд Цэргийн эрдэм судлалын 60 жил, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн үүсэн байгуулагдсаны 40 жил, БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл байгуулагдсаны 30 жилийн ой тохиосон бөгөөн энэ хүрээнд бид олон улсын болон үндэсний хэмжээний чухал арга хэмжээг зохион байгуулсан.

Бид энэ онд Халхын голын байлдааны ялалтын түүхт 80 жилийн ойг тохиолдуулан уламжлал ёсоор олон улсын эрдэм шинжилгээний хурал болон бусад арга хэмжээг зохион байгуулсан нь энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажилд бодит хувь нэмэр оруулахуйц байсныг гадаад, дотоодын эрдэмтэд хүлээн зөвшөөрч байна.

Түүнчлэн Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх олон улсын хэмжээний, Монгол Улсын Аюулгүй байдлын орчны талаарх үндэсний хэмжээний болон Зэвсэгт хүчний хөгжил, шинэчлэлийн талаарх дотоодын хэмжээний жил тутам зохион байгуулагддаг эрдэм шинжилгээний хурлуудыг амжилттай зохион байгууллаа.

“Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт уламжлал ёсоор Аюулгүй байдал, Зэвсэгт хүчний хөгжил шинэчлэл, Цэргийн сургалт, Түүх, уламжлал гэсэн булангуудад тухайн салбаруудын тулгамдаж буй асуудлууд, хөгжлийн чиг хандлагын талаар энэ чиглэлийн эрдэмтэн, судлаачдын туурвисан өгүүллүүдийг багтаасны зэрэгцээ их ойн хүрээнд сонирхолтой зарим өгүүллүүдийг багтаасан тусгай буланг нэмж оруулав.

Ирэх онд ч мөн адил БХЭШХ олон чухал ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж буйн дотор уламжлал ёсоор “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал” сэтгүүлийн хоёр дугаарыг эрхлэн гаргахаар төлөвлөж байна. Энэ хүрээнд цаашид сэтгүүлийн чанарыг шинэ түвшинд гаргаж www.mongoliajol.info цахим хуудаст (скопуст) бүртгэлтэй, дотоодын мэргэжлийн уншилттай сэтгүүл болгох чиглэлд идэвхтэй ажиллахаар төлөвлөж байна.

Аюулгүй байдал, цэргийн ухааны чиглэлээр судалгаа хийж, бүтээл туурвидаг эрхэм судлаач, мэргэжилтэн та бүхэн сэтгүүлийн ирэх оны дугааруудад эрдэм шинжилгээний өгүүллийн нийтлэг шаардлагад нийцсэн өгүүлэл нийтлэлээ хэвлүүлэхээр редакцид илгээх боломжтойг энэ завшааныг тохиолдуулан мэдэгдье.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

Таныг хүндэтгэсэн,

Сэтгүүлийн эрхлэгч, БХЭШХ-ийн захирал, доктор (Ph.D),
профессор, хурандаа Б.Мөнхсайхан

Цэргийн эрдэм судлалын нэгэн жарны хөгжил, үр дүн

Ш.Паламдорж

БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
Монголын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн,
шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Монголын үндэсний цэргийн эрдэм ухаан нэн эртнээс эхтэй, энэ тухай сурвалж¹, судалгааны анхдагч бүтээлүүдэд² дурдсан нь арвин юм. Монголчууд цэрэг, дайны асуудлыг нэн эрт үеэс чухалчилж байсан улс үндэстний нэг бөгөөд түүний тухай мэдээллийг бичиг үсэг хөгжөөгүй үед өвөг дээдсээс үр хүүхэд, хойч үедээ хэлж таниулах, ухуулж ойлгуулах, хад чулуунд сийлж үлдээх аргаар үеэс үед дамжуулж ирсэн юм. Монголчууд үндэсний бичиг үсэгтэй болсон үеэсээ өөрсдийн аюулгүй байдлаа хангах, улс, үндэснийхээ язгуур эрх ашгийн хамгаалах, цусан өшөө авах, олз омог олох, найрсаг харилцаа тогтоох зэрэг олон учир шалтгааны улмаас хөрш зэргэлдээх улс үндэстэй байлдсан тухайгаа бичиж үлдээдэг болжээ. Үүний тод нэг баримт бол өнөөдөр бидэнд нэн үнэ цэнтэй эх сурвалж болж буй “Монголын нууц товчоо” юм. Энэ үеийн цэргийн эрдэм ухааны талаар гадаад, дотоодын олон судлаач, эрдэмтэд арвин их судалгааны бүтээлийг нийтлүүлжээ³. Энэ үеийн цэргийн эрдэм ухаан судлалыг эл өгүүлэлд эс дурдаж, харин сүүлчийн нэгэн жаранд цэргийн эрдэм судлал хэрхэн хөгжсөн, Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалан бататгах үйлсэд онол, арга зүйн болон зохион бүтээх, туршин сайжруулах талаар оруулсан хувь нэмрийг өнгөц дурдах болно.

1950-иад оны төгсгөлөөр 1921 оны ардын хувьсгал, 1939 оны Халхын гол дахь дайн, Дэлхийн II дайны төгсгөл дэх Чөлөөлөх дайны гай гамшиг, үр дүн, төгсгөлийг хойч үедээ сургамжлах үүднээс тэдгээр түүхэн үйл явдлыг судлах, шинжлэх хэрэгцээ шаардлага нийгмийн захиалгаар бий болсон байна. “Цэргийн түүхээс сургамж ав. Түүх бол шавхагдашгүй ухаант багш, мэргэн зөвлөгч” гэсэн мэргэдийн сургаалын дагуу “БНМАУ-ын Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах яамны

¹ Монголын нууц товчоо. УБ., 2004 он. (Цэргийн нэр томъёоны тайлбар бүхий хэвлэл). - 20хх;

² Монгол Улсын шинжлэх ухааны 108 боть бүтээлийн 51 дүгээр боть - Цэргийн шинжлэх ухаан. УБ., “Согоонуур” ХХК. – 324х; ISBN 978-99929-65-18-5;

³ Гадаадын судлаачдын арвин их бүтээлээс гадна, Ж.Болдбаатар, Х.Шагдар, Ж.Базарсүрэн, Ш.Паламдорж, Д.Гомбосүрэн нарын олон эрдэмтдийн бүтээлүүд байдаг;

сайдын 1959 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн тушаалаар Цэргийн түүх боловсруулах секцийг, Батлан хамгаалах яамны сайдын 1973 оны 7 дугаар сарын 20-ны тушаалаар цэргийн эрдэм-шинжилгээний тасгийг тус тус байгуулсан байна. Ийнхүү “Цэргийн түүхийн комисс”-оос эхэлсэн цэргийн эрдэм шинжилгээний байгууллага өнөөдөр Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн болон төлөвшжээ. Өнөөдөр цэргийн түүх сонирхогч гуравхан хүнээс эхэлсэн судлаачдын тоо өссөөр 40 шахам мэргэшсэн судлаачдыг эгнээндээ багтаасан хамт олон болон хүрээгээ тэлжээ. Армийн доторх орчин үеийн эрдэм-шинжилгээний байгууллагын эх үүсвэр тавигдсанаас” хойш нэгэн жаран өнгөрчээ.

XX дугаар зууны хоёр дугаар хагасаас XXI зууны эхний хориод жилд Монголд цэргийн эрдэм судлалын ажил онол, арга зүй хувьд хэрхэн хөгжсөн, түүний ололт амжилт, үр дүнг практикт хэрхэн нэвтрүүлж ирсэн байдлын тухай Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (БХЭШХ)-гийн эрдэмтэн судлаачдын хамтын хэд хэдэн бүтээлд⁴ дэлгэрэнгүй бичиж тайлбарласан байдаг.

Цэрэг армийнхаа түүх уламжлалыг сэргээн бичих, үе үеийн хүүхэд залуучуудад эх оронч хүмүүжил олгох, үндэсний бахархалт зүйлсийг таньж мэдүүлэх, эцэг өвгөдийн амьдралын утга, агуулга, зорилго, тэмүүллийг уламжлуулах зорилгоор “Цэргийн түүх”-ийг бичиж нийтлүүлэх шийдвэрийг гаргаж⁵, Цэргийн түүх боловсруулах секцийг улс төрийн газрын дэргэд байгуулж байжээ. Энэ үеийн цэргийн түүхийн секц нь XX зууны монголын цэргийн түүхээр голлож судалгааг явуулж байжээ.

Харин хойд, урьд хөршүүдийн үзэл суртлын зөрчил хурцадсан, социалист системийн ихэнх улс орнуудын улс төрийн бодлогын “догматик” байр суурь, урд хөршийн Хятадын онцлогтой социализм байгуулах үзэл санаа хоёрын зөрчилдөөн ихэссэн, үүнийг дагаад тухайн үед манай улсын нам, засгийн бодлогын байр суурь нэн тодорхой байх нөхцөлийг бүрдүүлсэн учир БНМАУ нь ЗХУ-ын талд гэсэн уламжлалт байр сууриа хадгалсан түүхэн цаг үе байлаа. Чухам энэ цаг үед, МАА-ийн оператив байлдааны болон улс төрийн бэлтгэлийн тэргүүний туршлагыг нэгтгэн дүгнэж нэвтрүүлэх, цэргийн түүх судлах зорилгоор Батлан хамгаалах яамны цэргийн түүхийн болон Ардын армийн Жанжин штабын цэргийн эрдэм-шинжилгээний тасгийг нэгтгэн Цэргийн эрдэм-шинжилгээний институт байгуулжээ⁶. Цэргийн эрдэм шинжилгээний бие даасан институт байгуулснаас хойш өнөөдөр **40 дэх жилийнхээ** нүүрийг үзэж байна. Тус хүрээлэн байгуулагдсан явдал нь цэргийн шинжлэх ухааны хэд хэдэн салбар судлагдахууныг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах эхлэл болсон бөгөөд энэ дөчин жилд чамгүй үр дүнд хүрсэн

⁴ Хорьдугаар зууны монгол цэрэг. УБ., 2001 он. -450х; Хорьдугаар зууны монгол цэргийн урлагийн түүх. УБ., 2009 он. -240х; Боевое содружество /Дайчин нөхөрлөл/ О Советско-монгольском боевом содружестве. М., Воениздат., 1983. -334с. гэх мэт;

⁵ БНМАУ-ын Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1959.01.13-ны өдрийн тушаал;

⁶ МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1979.05.29-ний өдрийн “Батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх талаар авах зарим хэмжээний тухай” 13 тоот тогтоол ба БХЯ-ны сайдын 1979 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн тушаал;

болохыг тэдний онол, арга зүйн болон практик шинжилгээний олон бүтээл, туурвил харуулдаг.

Монгол Улсад ардчилсан хувьсгал 1990-ээд оноос өрнөж эхэлсэн цаг үеэс⁷ эхлэн Цэргийн Эрдэм шинжилгээний институтийн эрдэмтэн судлаачид Монголынхоо цэргийн эрдэм судлалын ажлыг XX зуунаар хязгаарласан үзэл суртлын байр суурийг баримтлахаа больж, Эзэн богд Чингис хааныхаа XIII зууны үеийн Их Монгол Улсынхаа цэргийн эрдэм ухааны уламжлалыг гүнзгийрүүлэн судалж эхэлсэн юм. Энэ талаарх бүтээл туурвил нь олширч, Их Монгол Улсын Цэргийн эрдэм судлалын төв болон дэлхийн олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүртлээ хөгжсөн байна. “Цэргийн эрдэм шинжилгээний институт”-ээ “Цэргийн түүхийн хүрээлэн” болтол цэргийн эрдэм судлалын ажлыг цэргийн түүх тал руу зонхилон хөгжүүлж ирсэн юм. “Монгол цэргийн түүхийн товчоон” гэсэн тэргүүн болон дэд дэвтрээс бүрдсэн нэг сэдэвт томоохон суурь бүтээлийг тав, зургаан жилийн судалгаанд суурилж, 1996 онд хэвлэн нийтлүүлсэн юм.

Улс оронд ардчилсан хувьсгал явагдаж, нийгэм, төрийн байгуулал үндсээрээ өөрчлөгдөж, Монгол Улс бие даан хөгжих, Зэвсэгт хүчнээ зөвхөн “өөрийгөө хамгаалах”⁸-д чиглүүлэн хөгжүүлж эхэлсэн юм. Энэ нь Монгол Улсад өөрийн өнгө төрх, онцлогтой цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэхийг шаардсан байна. Цэргийн шинжлэх ухааныг ОХУ-ын цэргийн шинжлэх ухааны онол, арга зүйг удирдамж болгон өөрийн улсын үндэсний цэргийн урлагийн уламжлал, шинэчлэл, онцлогт нийцүүлэн хөгжүүлж эхэлсэн юм. Ингэхдээ цэрэг бол улс үндэстнээ хамгаалах, хамгаалан тэмцэх, зэвсэгт тэмцэл явуулах түүхэн үүрэгтэйд нийцүүлэн, төрийн бодлого, эрх зүйн үндэсэд тулгуурлан хөгжүүлж ирлээ. Монголын цэргийн шинжлэх ухаан хамгийн түрүүнд төр, засгийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлох, батлан хамгаалах байгуулалт, цэргийн байгуулалтыг оновчтой хөгжүүлэх, үүн дотроо голлох үүрэг нөлөөтэй Зэвсэгт хүчнийхээ байгуулалтын тулгуур үндэсийг шинжлэх ухаанчаар тогтооход чиглүүлж, бүтээл, туурвилыг нийтлүүлж ирсэн юм.

Цэргийн шинжлэх ухаан шиг ярвигтай, амьдрал практиктай нягт уялдаатай, олон хүний хичээл зүтгэл, ур чадвар, асгарах хөлс, гоожих цустай холбоотой тийм шинжлэх ухаан бараг үгүй гэж хэлж болно. Батлан хамгаалах нь баялаг бүтээхээс чухал гэдэг. Монголчууд бидний өвөг дээдсээс хэдэн зуу, мянган жилээр хуримтлуулж, өвлүүлж ирсэн ахуй, соёл, байгалийн баялаг, тусгаар тогтнол, үнэт зүйлсээ хамгаалах нь өнөөдрийн барьж байгуулж буй ямар ч стратегийн объектоос илүү үнэ цэнтэй болохыг хэлж буй хэрэг хэмээн бид ухамсарладаг. Тиймээс монголын үндэсний цэргийн шинжлэх ухаан бусад орны цэргийн шинжлэх ухааны нэгэн адил үндэсний өвөрмөц онцлогтой шинжлэх ухаан болон төлөвшиж байна. Монгол Улсын ҮБХИС-ийн харьяа Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэн ч Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний

⁷ Монгол Улсын үндсэн хууль. УБ., 1992 он. – 46х;

⁸ Монгол Улсын Үндсэн хууль. Арван нэг дүгээр зүйл. 2. Заалт;

хүрээлэн болон төлөвшиж, Зэвсэгт хүчний байгуулалт, цэргийн урлагаар хязгаарлахгүй батлан хамгаалах бодлого, стратегийн түвшинд судалгаа явуулж эхэлжээ.

БХЭШХ-ийн судалгаа шинжилгээний ажилд гаргасан түүхэн ололт амжилтыг тэмдэглэхэд:

Аюулгүй байдал, цэрэг, батлан хамгаалах судлалын онол, арга зүйгээр:

Нэгдүгээрт, Дундад зууны үеийн Монголын үндэсний цэргийн урлагийн түүхийг түүхэн баримт, үйл явдалд үндэслэн тус хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид өндөр зохион байгуулалтай бичин туурвиж⁹, олны хүртээл болгож иржээ.

Хоёрдугаарт, хорьдугаар зууны монголын цэргийн байгуулалт¹⁰, урлаг¹¹, удирдлага¹² зохион байгуулалтыг судалж, сургалт бэлтгэл¹³, бэлэн байдлыг дээшлүүлэх онол, арга зүйн үндэсийг боловсруулжээ.

Гуравдугаарт, өнөө үеийн Монгол Улсын батлан хамгаалах бодлого¹⁴, стратеги¹⁵, Зэвсэгт хүчний хөгжлийн стратеги¹⁶, ажиллагааны стратеги¹⁷, операц¹⁸, тактик¹⁹ - ийн онол, арга зүйн үндсийг боловсруулж ирсэн байна.

Дөрөвдүгээрт, аюулгүй байдлын онол, практик²⁰, батлан хамгаалах бодлого судлал²¹ - ыг хөгжүүлж, учирч болзошгүй эрсдэл, түүнээс сэргийлэх арга замыг тодорхойлсон бүтээл туурвилыг хэвлэн нийтлүүлсээр ирлээ.

Тавдугаарт, төрөл, мэргэжлийн цэргийн түүх, алдар түүхт цэргийн анги, байгууллагын түүхийг бичих онол, арга зүйг боловсруулж, түүнийхээ дагуу нэлээд олон тусгай мэргэжлийн²² болон алдар түүхт нэгтгэл, ангиудын түүхийг бичиж, тэдгээрийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүгээр хойч үеийн залуусд цэрэг эх оронч хүмүүжил олгоход үнэтэй хувь нэмэр үзүүлж байна.

Зургаадугаарт, цэргийн нэрт зүтгэлтнүүдийн амьдралын түүхэн замнал, тэдний төр, нийгэм, цэргийн үйл хэрэгт оруулсан хувь нэмэр, гавьяа зүтгэлийг нэхэн судалж, намтар судлалын цуврал бүтээл²³ - ийг

²⁰ Ч.Улаанхүү. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. УБ., 2012 он. -306х; Ч.Улаанхүү. Цэргийн аюулгүй байдал. УБ., 2016 он. -312х; Монгол Улсын аюулгүй байдал. /онол аргазүй, орчны шинжилгээ/. УБ., 2019 он. - 216х; Үндэсний аюулгүй байдал ба уул уурхай /Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл/. УБ., 2018 он. -206х; Эрдэс баялагийн олборлолт ба үндэсний аюулгүй байдал. /Хамтын бүтээл/. УБ., 2019 он. - 236х;

²¹ Батлан хамгаалах эрсдэлийн удирдлага. /Хамтын бүтээл/. УБ., 2019 он. - 132х; Б.Эрдэнэчимэг. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого. УБ., 2016 он. -252х;

²² Цэргийн холбооны түүхийн тойм. УБ., 2001 он. - 397х; Химийн цэргийн товч түүх /нэмж боловсруулсан хоёр дахь хэвлэл/. УБ., 2017 он. -328х; Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг /түүхийн товчоон/. УБ., 2004 он. - 262х; Газрын артиллерийн түүхэн замнал. УБ., 2001 он. -236;

²³ Д.Гомбосүрэн. Өрлөг жанжин Х.Чойбалсан. /Цэргийн үйл ажиллагаа/. УБ., 2003 он; Г.Мягмарсамбуу. Төр, цэргийн нэрт зүтгэлтэн, домогт жанжин ардын Хатанбаатар С.Магсаржав. /187821927/. УБ., 2011 он. -390х; Ш.Паламдорж, Ж.Базарсүрэн, Ч.Даваадаш, Х.Шагдар. Монгол Улсын төр цэргийн нэрт зүтгэлтэн, дэслэгч генерал Шаггалын Жадамбаа. /Цуврал дөрвөн боть/. УБ., 2009 он; Б.Равжаа, Ш.Паламдорж, Ч.Улаанхүү, Ч.Сосорбарам, Д.Санжсүрэн. Монгол Улсын төр цэргийн нэрт зүтгэлтэн, хошууч генерал Рашмаагийн Гаваа. /Цуврал гурван боть/. УБ., 2014 он;

туурвиж, олон нийтэд цэрэг эх оронч үзэл суртал, хүмүүжил олгоход үнэтэй хувь нэмрийг үзүүлж байна.

Долоодугаарт, дэлхийн дахинаа өрнөж буй дайн, операц, байлдааны туршлага, сургамж, онол, практик²⁴ - ийг шинжилж, тэдгээрийг өөрийн цэрэг, цэргийн алба хаагч нарын сургалтад нэвтрүүлсээр иржээ.

Наймдугаарт, НҮБ болон олон улсын хэмжээнд энхийг дэмжих ажиллагаанд оролцох үндэслэл, үр дүн, өгөөжийг судалж²⁵, өөрийн оронд болон гадаадад улс орноо, Монгол цэргээ сурталчлах, улс төр дипломатын аргаар батлан хамгаалах зорилгоо хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж байна.

Есдүгээрт, Бүс нутгийн аюулгүй байдлыг хангах арга зам судлалаар судалгаа шинжилгээний ажил явуулж, үр дүнг нь ашиглан Зүүн Хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар олон улсын эрдэм шинжилгээний хурлыг сүүлийн жилүүдэд тогтмол зохион байгуулж²⁶, өөрийн улсын улс төрийн бодлогод дэмжлэг үзүүлсээр ирлээ.

Шинэ бүтээл, иновац, техник, технологи судлалаар: Зэвсэглэл, цэргийн техникийн ашиглалтыг сайжруулах, операц, байлдаанд тэдгээрийг хэрэглэх арга технологийг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлыг явуулж, үндэсний цэргийн өвөрмөц арга тактикийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрийг оруулж байна. Үүнийг тодруулбал:

Нэгдүгээрт, орчин үеийн дайн, байлдаанд хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй байлдааны техник, зэвсэгтэй тэмцэх хэрэгсэл (ТЭУП-ийн хөөргөх болон удирдах төхөөрөмж)-ийг өөрийн орны болон Зэвсэгт хүчний онцлогт нийцүүлэн боловсронгуй болгоход чиглэсэн туршилт, зохион бүтээх ажил (эрдэм шинжилгээний ажилтан Г.Хүрэлбаатар)-ыг явуулж иржээ. Энэ туршилт, зохион бүтээх ажлаар байлдааны машин дээрх танк эсэргүүцэх пуужингийн хөөргөх төхөөрөмж, удирдлагыг монголчилж, явган цэрэг, жижиг бүлэг ашиглаж болохоор, үүргэвч (зөөвөр)-ийн болгож, хөөргөх төхөөрөмж, удирдлагын хэрэгслийг газарт байрлуулахаар болгожээ.

Хоёрдугаарт, их, бага бууны сумны толгойг гол төмрөөс хөөх цэнэг (дарь)-т тэсрэлт өгөх анхдагч (өдөөгч) тэсрэх бодис (А.Хүү-Ухнаа)-

²⁴ Ш.Паламдорж, Л.Бямбасүрэн. Дайны: онол, сургамж. УБ., 2001 он. – 350х; Ш.Паламдорж. Мэдээллийн дайн, түүнээс хамгаалах. УБ., 2003 он. - 162х; Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг. Олон улсын терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс. УБ., 2006 он. - 232х; Ш.Паламдорж. Дайны хувьсал өөрчлөлт, цэргийн урлагийн хандлага. УБ., 2011 он. – 184х; Б.Шагдар. Цэргийн урлаг: түүх, сургамж. /Хоёр боть/. УБ., 2014 он. -1450 х; Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг нарын. Хүч тэнцвэргүй дайн, байлдаан. УБ., т2018 он. – 186х;

²⁵ Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих үйлсэд. УБ., 2912 он. -134х;

²⁶ Зүүн хойд Азийн аюулгүй байдал. УБ., 2013. х158; Зүүн хойд Азийн эрчим хүчний аюулгүй байдал. УБ., 2014. . ISBN 978-99973-45-33-2. х152; Зүүн хойд Азийн хүрээлэн буй орчны аюулгүй байдал. УБ., 2015. ISBN 978-99973-31-86-1 х159; Зүүн хойд Азийн дэд бүтцийн хөгжил, стратегийн ач холбогдол. УБ., 2016. х124; Possibilities to promote economic security and cooperation of Northeast Asian countries. UB., 2017. p112; Information security: Emerging issues in theory and practice. UB., 2018. х105; Зүүн хойд Азийн аюулгүй байдал ба Солонгосын хойгийн асуудал. УБ., 2019 . ISBN 978-9919-22-139-3. х123;

ыг гарган авч, бууны бялтыг монголчилж, шинээр бялт шалгагч, бялтын механизм (эрдэм шинжилгээний ажилтан Г.Хүрэлбаатар)-ыг зохион бүтээж, сургалт, судалгаанд болон практикт нэвтрүүлээд байна. Байлдааны сум бүхэнд зайлшгүй ашиглагддаг өдөөгч тэсрэх бодис, бялтыг зохион бүтээсэн явдал нь галт хэрэглэлийн үйлдвэрлэл байгуулах суурь үндэс болно. Бялт шалгагчийг зохион бүтээсэн явдал нь өдөөгч бодисын найрлага, стандартыг тогтоох, он удаан жилийн хадгалалтад байгаа сумны бялтны чанар байдлыг шалган тогтоох боломжийг олгож байна.

Гуравдугаарт, цэргийн зориулалт бүхий тэсрэх бодисыг дотооддоо үйлдвэрлэх технологи, техник эдийн засгийн үндэслэл (төслийн удирдагч профессор Ш.Паламдорж, гүйцэтгэгч Б.Баяржаргал, А.Хүү-Ухнаа)-ийг боловсруулж, эх орондоо дарь, цэргийн зориулалттай тэсрэх бодис үйлдвэрлэх үндэслэлийг боловсруулжээ.

Дөрөвдүгээрт, байлдааны 9 мм-ийн сум, тусгай зориулалт (сургалтын болон цэргийн бус ажиллагаанд ашиглах)-ын гранат үйлдвэрлэх технологийн судалгаа (А,Хүү-Ухнаа, Г.Хүрлээ нар) -г явуулж, сургалтыг осол авааргүй явуулах, зардлыг багасгах үндэслэлийг бүрдүүлж, эх орондоо тэдгээрийг олноор үйлдвэрлэх боломжийг нээжээ.

Тавдугаарт, цэргийн сургалтын оргил болох буудлагатай хээрийн сургуулийг явуулахад зайлшгүй хэрэглэгдэхүүн болох байн цагийн байдлыг автоматжуулах, алсаас удирдахад чиглэсэн туршилт, зохион бүтээх ажлыг явуулж, радио долгионы удирдлагатай, бай өргөх, буулгах төхөөрөмжийг зохион бүтээж, олноор үйлдвэрлэж, цэргийн нэгтгэл, ангиудыг түүгээр хангаж, цэргийн хэрэгт нэвтрүүлээд байна.

Зургаадугаарт, Зэвсэгт хүчний сургалт, байлдааны ажиллагааг дээшлүүлэх, энэ үеийн осол аваарыг багасгах, хяналтын бүс, районыг тасралтгүй хянаж, дохиолол өгөх, хөнөөх үйлчилгээ үзүүлэх зэрэгт ашиглах алсын удирдлагатай, олон зориулалтын минэ-ийн систем “Арваалж”-ийг зохион бүтээжээ. Үүнийг практикт нэвтрүүлбэл, дээр дурдсан боломж бүрдэхээс гадна иргэний зориулалтаар ч ашиглаж болно.

Долоодугаарт, улс орны хэмжээнд цацраг идэвхт бодисын хордолтыг тасралтгүй хянах, мэдээллийг төвлөрүүлэн нэгтгэх, архивлах боломжийг бүрдүүлэх туршилт, зохион бүтээх ажил²⁷-ыг гүйцэтгэж, автоматаар хяналт тавих, үр дүнг компьютерт хүлээн авах, дамжуулах, хадгалах програм хангамж, модем бүхий цацрагийн хяналтын багажийг зохион бүтээж туршсан бөгөөд үр дүнгээ холбогдох байгууллага (ЗХЖШ, ОБЕГ)-т хүлээлгэн өгсөн юм.

Эрдэмтэн судлаачдыг бэлтгэх үйл хэрэгт оруулж буй хувь нэмрээр: Аюулгүй байдал судлал, цэрэг, батлан хамгаалахын мэргэжилтэн судлаачдыг бэлтгэхэд тус хүрээлэн үнэтэй хувь нэмрийг оруулсаар байна. Тухайлбал, магистр, докторын боловсролтой мэргэшсэн судлаачдыг бэлтгэхэд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, сургалтад оролцох, тэдгээрийн магистр, докторын судалгаа, шинжилгээний ажлыг

²⁷ Цацрагийн хяналт “Цацраг” /эрдэм шинжилгээний ажлын тайлан/. Төслийн удирдагч Ш.Паламдорж. Төслийн багийн гишүүн: Б.Баяржаргал. УБ., 1994 он. БХЯ-ны ЭШХ;

удирдах, онол, арга зүйн сурах бичиг гарын авлагыг боловсруулж, сургалтад ашиглах зэрэгт хүрээлэнгийн удирдлага, төвүүдийн дарга нар, эрдэмтэн судлаачид оролцож, ҮБХИС-ийг судалгаанд суурилсан их сургууль болох зорилтыг хангахад үнэтэй хувь нэмэр үзүүлж байна. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалаар сүүлийн 20 гаруй жилд бэлтгэсэн 100 гаруй эрдэмтдээс зөвхөн БХЭШХ-ийн эрдэмтэн судлаачдаас докторын судалгаа, шинжилгээний ажлыг нь удирдаж хамгаалуулсан эрдэмдийн тоо үүний гуравны хоёрыг нь эзэлж байна.

БХЭШХ эрдэмтэн судлаачдаа чадваржуулж, оюуны чадавхаа дээшлүүлж байгаа туршлага, сургамжийн хувьд: БХЭШХ нь батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хэмжээнд оюуны санааны манлайлагчийн үүрэг гүйцэтгэж ирлээ. Судалгаа шинжилгээний ажил явуулах эрдмийн чадавх дээшилж, зөвхөн Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнд л гэхэд шинжлэх ухааны доктор – 3, цэргийн төрөл бүрийн ухааны доктор -11, профессор, дэд профессор цолтой – 15 хүн ажиллаж байна. Батлан хамгаалах салбар өөртөө эрдэмтэн бэлтгэх түвшинд хүртэл эрдмийн чадавх нь өссөөр ирсэн байна.

Батлан хамгаалах бодлого, хууль эрх зүйг боловсронгуй болгоход онол, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлж ирсэн үр дүнгийн хувьд: улс оронд ардчилсан хувьсгал өрнөсөн, нийгэм, төрийн байгуулал өөрчлөгдөж эхэлсэн 1990-ээд оноос хойш БХЭШХ Монгол Улс “өөрийгөө хамгаалах” батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн онол, арга зүйн судалгааг явуулж эхэлсэн²⁸ бөгөөд төр засгаас батлан хамгаалах бодлогыг тодорхойлох, хууль эрх зүйн үндэсийг бүрдүүлэхэд үргэлж дэмжлэг үзүүлсээр ирсэн юм. Үүнийг 2015 онд Улсын Их Хурлаас батлан гаргасан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, 2016 оноос шинэчлэн найруулан дагаж мөрдөж буй “Батлан хамгаалах тухай”, “Зэвсэгт хүчний тухай”, шинээр гаргасан “Орон нутгийн хамгаалалтын тухай” зэрэг хуулиудыг анхан шатанд боловсруулж ирсэн түүхэн үйл явдал нотлон харуулдаг.

Батлан хамгаалах бодлого, стратеги, ЗХ-ний хөгжлийн стратеги, удирдлага, сургалт, бэлтгэл, хангалтын шинжлэх ухаанч чанар тавигдаж, амьдрал практикт нэвтэрч биелэлээ олж байна. Үүнийг цөөн хэдэн эрдэмтэд хийх боломжгүй бөгөөд салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдамж доор явагдах асуудал учир 1989 онд Батлан хамгаалах яаманд салбарын шинжлэх ухааны ажлыг удирдан чиглүүлэх үндсэн үүрэгтэй салбарын шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийг байгуулсан юм. Энэ Зөвлөл байгуулагдснаас хойш даруй **30 дахь жилтэйгээ** золгож байна. Батлан хамгаалах яаманд шинжлэх ухаан технологийн Зөвлөл байгуулагдсан явдал нь хэд хэдэн чиглэлд ахиц дэвшил гаргах үндэс тавигдсан байна. Нэгд, батлан хамгаалах хүрээнд судалгаа, сургалт явуулдаг бүх судалгааны байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангаж, тухайн жилд болон ойрын ирээдүйд явуулах судалгаа, шинжилгээний

²⁸ Монгол Улсын Батлан хамгаалах тогтолцоо /эрдэм шинжилгээний ажлын тайлан/. Төслийн удирдагч Ш.Паламдорж. Төслийн багийн гишүүд: Ч.Пүрэвдорж Л.Моломжамц С.Гомбосүрэн Я.Дамдинжав Г.Дугарсүрэн; УБ., БХЯ-ны ЭШХ. 1993. 459,0 з.х;

ажлын чиглэл, сэдвийг тогтоож, даалгаваржуулдаг болсон; хоёрт, судалгаа шинжилгээний ажлын явцыг хянан шалгаж, үр дүнг нь хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгч, практикт нэвтрүүлэх ажлыг зохион байгуулдаг болсон; гуравт, судалгаа шинжилгээний байгууллагуудын судлаач, эрдэмтдийг бэлтгэх, тэднийг оновчтой байршуулах, ашиглах талаар²⁹ нэгдсэн удирдлага, тогтолцоонд шилжүүлсэн; дөрөвт, судалгаа, шинжилгээний байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, цэргийн анги, байгууллагуудыг судалгааны бааз болгон ашиглах, тэдэнтэй хамтарч туршилт, сургууль явуулах асуудлыг шийдвэрлэдэг болсон зэргийг дурдаж болох байна. Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан технологийн Зөвлөлийн ажил хэр зэрэг үр өгөөжтэй байх нь хууль эрх зүйн зохицуулалт, түүнийг толгойлж буй сайд, дэд сайд нарын удирдлага, ШУТЗ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, гишүүдийн санаачилга, бүтээлч чанараас ихээхэн хамаарч байна. Жилээс жилд БХЯ-ны ШУТЗ-ийн ажил тогтмолжиж, эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтэд анхаарч байгаа нь энэ түүхт ойн үед тэмдэглэшүүтэй.

Цэргийн эрдэм шинжилгээний ажил нь цаг үеийн шаардлага, хэрэгцээнд нийцэн зөвхөн зэвсэг тэмцлийг явуулах цэргийн урлаг, Зэвсэгт хүчний байгуулалт, удирдлага, хангалтаас илүүтэй аюулгүй байдлыг хангах, энхийг сахиулах, батлан хамгаалах бодлого, стратегийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах талдаа илүүтэй анхаарлаа төвлөрүүлж байна. Үүнийг сүүлийн үед БХЭШХ-ээс явуулсан судалгаа шинжилгээний ажлын үр дүнгээс³⁰ харж болно.

Цэргийн шинжлэх ухааны байгууллагууд үүсэн байгуулагдаж, хөгжиж, батжин бэхжиж байгаа нь Монгол Улс “өөрийгөө хамгаалах” Зэвсэгт хүчний байгуулалтыг шинжлэх ухаанч байдлаар бататган хөгжүүлэх, батлан хамгаалах зорилтоо улс төр дипломатын арга замаар найдвартай хэрэгжүүлэх, бүс нутгийн болон дэлхийн “халуун цэгүүдэд” НҮБ болон олон улсын энхийг дэмжих ажилдлагаанд Зэвсэгт хүчний төлөөлөгч - ажиглагч, баг, салбар, ангийг идэвхтэй оролцох үндэс суурийг тавихад үнэтэй хувь нэмрээ оруулж байгаа юм.

Аливаа нэгэн төгсгөл, дараагийн ирээдүйн эхлэл байдаг. Цэргийн эрдэм судлалын нэгэн жарны түүх ч Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ судалгааны дараагийн их ажлын эхлэлийн суурь хөрс, уриа дуудлага байх учиртай.

Батлан хамгаалах онол, практик өргөжин тэлэхийн хэмжээгээр цэргийн шинжлэх ухааны судалгааны объект, судлах зүйлийн цар хүрээ нэмэгдэж байна. Зэвсэгт тэмцлийн арга хэлбэр нарийсч, тэмцлийн хэрэгслэл хөгжин шинэчлэгдэх хэмжээгээр цэргийн шинжлэх ухааны судлах зүйлийн агуулга гүнзгийрч байна. Даяаршил шинжлэх ухааныг, түүний дотор цэргийн шинжлэх ухааныг ч даяаршуулж байна.

Цэргийн эрдэм судлалын ирээдүйн үндсэн чиглэл нь цэргийн

²⁹ Батлан хамгаалахын сайдын тушаалаар эрдэм шинжилгээний ажилтан нарыг сонгон шалгаруулалтаар томилдог журам тогтоосон;

³⁰ Батлан хамгаалах стратеги. УБ., 2017 он. -400х; Зэвсэгт хүчний стратеги УБ., 2017 он. -444х; Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих үйлсэд. УБ., 2912 он. -134х;

аюулгүй байдлын онцлог шинж чанарыг үечилсэн байдлаар тодорхойлж байх, батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэх, зэвсэгт тэмцлийн стратеги, тактикийг шинэ нөхцөл байдалтай уялдуулан боловсруулах, шинжлэх ухааны үндэслэлийг тогтооход чиглэдэг боллоо.

Энэ зорилтыг хэрэгжүүлэх үндсэн арга нь шинжлэх ухааны бусад байгууллагуудтай хоршин ажиллах явдал байх болно. Судлаачдын инженер, техникийн сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэх ухаан технологийн сүүлийн үеийн ололтыг цэргийн хэрэгт нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн нийлүүлэхэд инноваци чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь цэргийн шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг байх төлөвтэй байна.

Эдүгээ БХЭШХ “Шинжлэх ухаан технологийн тухай” хуулийн дагуу шинжлэх ухаан-боловсролын байгууллагын хэлбэрээр ажиллаж батлан хамгаалахын тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд батлан хамгаалахын цэргийн дээд удирдлагын байгууллагад шинжлэх ухааны дэмжлэг үзүүлэх, ҮБХИС-ийн эрдмийн чадавхыг дээшлүүлэхийн төлөө шамдан ажиллаж байна. Түүх үргэлжилсээр, бүтээл арвижсаар байх болно.

Цэргийн эрдэм судлалын залуурчид

Ж.Базарсүрэн

БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), профессор

2019 он Халхын голын дайны ялалтын 80 жилээс гадна батлан хамгаалах салбарт холбогдолтой олон дурсгалт ойн жил болж буйгаараа онцлог. Тэдгээрийн нэг нь батлан хамгаалах салбарт шинжлэх ухааны албан ёсны байгууллага, тухайлбал Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулагдсаны 40 жилийн ой. Анх МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1979 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн “Батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 13 дугаар тогтоолоор армийн дотор тэргүүн туршлагыг нэгтгэн судлах, армийн түүхийг бичиглэх зорилгоор Монголын ардын армийн Улс төрийн газрын Цэргийн түүхийн тасаг, Зэвсэгт хүчний жанжин штабын нэгдүгээр газрын Цэргийн эрдэм шинжилгээний тасаг хоёрыг нэгтгэн БХЯ-ны Цэргийн эрдэм шинжилгээний институт (ЦЭШИ)-ийг байгуулсан байна.

Ийнхүү армид эрдэм шинжилгээний байгууллагыг бие даалган байгуулсан нь цэргийн дотор эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимтэй өрнүүлэх, бие даасан мэргэжлийн эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтдийг бий болгох, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, судалгааны материаллаг үндэс, бааз суурийг бий болгон хөгжүүлэхэд чухал алхам болсон билээ.

Хүрээлэн байгуулагдсанаас хойших 40 жилийн хугацаанд нийт 13 хүн захирлаар ажилласан байна. Үүнд: анхны захирал дэд хурандаа (тэр үед докторант байсан) Дэндэвсүрэнгийн Гомбосүрэн томилогдож 1979.8-1986.4 хүртэл нийт 6 жил 8 сар ажилласан ба түүний дараа дэслэгч генерал Чойндонгийн Пүрэвдорж 1986.4-1991.10 сар хүртэл хүрээлэнг удирджээ. Гуравдахь захирал нь хурандаа Шижээгийн Паламдорж бөгөөд тэр үед хүрээлэн Цэргийн их сургуулийн харьяалалд шилжсэн тул тэрээр тус сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлаар томилогдож, 1991.10-1996.11 сар хүртэл, дараа нь хурандаа Гэрэлийн Мягмаржав 1996.12-1999.04 сар хүртэл, тав дахь захирал хошууч генерал Рашмаагийн Гаваа 1999.06 сараас 2000.07 хүртэл, түүний дараа хурандаа Ш.Паламдорж дахин томилогдож 2000.07-2004.10 сар хүртэл ажиллажээ. Долоо дахь захирал, тэр үед хурандаа байсан Загдсүрэнгийн Болдбаатар 2004.11-

2005.06 хүртэл, найм дахь захирал хурандаа Дашдоржийн Батболд 2005.07-2009.01 хүртэл, ес дэх нь болох хошууч генерал Бадамын Шагдар 2009.02-2010.9 хүртэл, арав дахь бригадын генерал Бэгзийн Даваадорж 2010.9-2011.9 сар хүртэл, арван нэг дэх хурандаа Доржжүгдэрийн Мөнх-очир 2011.9-2012.12 хүртэл, арван хоёр дахь хурандаа Галиндэвийн Мягмарсамбуу (түр орлон гүйцэтгэгч) 2012.12-2013.2.5 хүртэл, арван гурав дахь хошууч генерал О.Үржин 2013.2-2015.8 сарыг хүртэл тус тус хүрээлэнг удирдсан байгаа бөгөөд арван дөрөв дэх захирал доктор, профессор, хурандаа Банзрагчийн Мөнхсайхан 2015.8 сараас одоог хүртэл ажиллаж байна.

**Нэг. БХЭШХ-ийн захирлуудын намтрын
нийтлэг товчоон буюу “Хамгийн хамгийн . . .”**

БХЭШХ-ийн захирлуудын намтрын нийтлэг онцлогийг тодотговоос:

- Захирлын албан тушаалд 2 удаа томилогдсон хүн ганц байдаг нь Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор Ш.Паламдорж бөгөөд тэрээр хүрээлэнгийн захирлын албыг нийт 9 жил 4 сар хашсан байна. Удаах нь түүхийн шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Д.Гомбосүрэн 6 жил 8 сар, дэслэгч генерал Ч.Пүрэвдорж 5 жил 6 сараар орж буй бол доктор, профессор, хошууч генерал З.Болдбаатар 7 сар гаруйхан хугацаанд эл албанд байж байгаад дэвшсэн, өөрөөр хэлбэл хамгийн богино хугацаанд захирал байсан, түр орлогчийн үүрэг гүйцэтгэсэн доктор, профессор Г.Мягмарсамбуу 1 сар 10 гаруй хоног үүрэг гүйцэтгэсэнээрээ онцлог.

Дунджилваас, өнгөрсөн 40 жилийн хугацаанд 13 хүн захирлаар ажилласнаас сар гаруйхан хугацаанд түр орлон гүйцэтгэгчээр ажилласан нэгнийг эс тооцвоос энэ албан тушаалд ажиллагсад 3,08 жил тутам өөрчлөгдөж байсан байна;

- Насны хувьд авч үзвээс доктор, профессор, хошууч генерал Б.Шагдар 60 настайдаа томилогдож байснаараа хамгийн ахмад нь болж буй бөгөөд шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал О.Үржин 59 настай байснаараа удаалж, харин хурандаа Д.Мөнх-Очир 37-той, хурандаа Д.Гомбосүрэн 42-той байснаараа хамгийн залууд орж байна. Ажиллагсдын дундаж нас 44,7 байна;

- 13 захирлын 5 нь генерал цолтойдоо эл албанд томилогдсон (дэслэгч генерал Ч.Пүрэвдорж, хошууч генерал Р.Гаваа, хошууч генерал Б.Шагдар, бригадын генерал Б.Даваадорж, хошууч генерал О.Үржин) ба 1 хүн (З.Болдбаатар) дэвшиж явсан хойноо генерал цол хүртэж байжээ.

Дэд хурандаа цолтой томилогдсон 1 байгаа нь Д.Гомбосүрэн бөгөөд хурандаа 6 байна;

Эл албанд томилогдохоосоо өмнө Батлан хамгаалахын тэргүүн дэд сайд,

ЗХЖШ-ын дарга байсан - 2 (Ч.Пүрэвдорж, Р.Гаваа), ЗХЖШ-ын орлогч байсан - 1 (Б.Шагдар), захирлын ажлаа өгсөнийхөө дараа ЗХЖШ-

ын орлогч болсон-1 (Д.Гомбосүрэн), мэргэжлийн цэргийн дарга байсан 1 (Ш.Паламдорж химийн цэргийн дарга);

- ОХУ-ын ЗХЖШ-ын академи төгссөн-4 (Ч.Пүрэвдорж, Р.Гаваа, Б.Шагдар, З.Болдбаатар);

- Мэргэжлийн хувьд: ерөнхий цэргийн 1 (Б.Шагдар), артиллерийн - 3 (О.Үржин, Ч.Пүрэвдорж, З.Болдбаатар), улс төрийн 3 (Д.Гомбосүрэн, Г.Мягмаржав, Г.Мягмарсамбуу), холбооны 2 (Р.Гаваа, Д.Батболд), олон улсын харилцааны 1 (Б.Даваадорж), түүхч, аюулгүй байдал судлалын магистр 1 (Д.Мөнх-Очир), химийн цэргийн 1 (Ш.Паламдорж), инженер-сапёрын -1 (Б.Мөнхсайхан);

- дурдагдан буй 13 хүний дотор шинжлэх ухааны доктор 4 байгаагаас О.Үржин цолтойгоо томилогдсон ба Ш.Паламдорж захирал байхдаа, Д.Гомбосүрэн, Г.Мягмаржав нар дараа нь тус тус хамгаалсан.

Боловсролын доктор (Ph.D) - 6, магистр 3 (дэслэгч генерал Ч.Пүрэвдорж, бригадын генерал Б.Даваадорж, хурандаа Д. Мөнх-Очир);

- Профессор цолтон - 9 (Д.Гомбосүрэн, Ш.Паламдорж, Б.Шагдар, Г.Мягмаржав, Г.Мягмарсамбуу, Р.Гаваа, З.Болдбаатар, Б.Мөнхсайхан, О.Үржин) дэд профессор цолтой (Д.Батболд);

-Захирал байгаагаас Монгол Улсын гавьяат 2 төрсөн, тухайлбал Ш.Паламдорж Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Г.Мягмаржав Гавьяат багш цолоор шагнагдсан;

-Аймаг, харьяаллын хувьд гэвэл Архангайн 1 (Г.Мягмарсамбуу), Баянхонгорын 2 (Ш. Паламдорж, З. Болдбаатар), Өвөрхангайн 1 (Ч.Пүрэвдорж), Өмнөговийн2(Р.Гаваа, Б.Шагдар), Увсын1(Г.Мягмаржав), Улаанбаатарын 3 (Д.Батболд, Д.Мөнх-очир, Б.Мөнхсайхан) Ховдын 2 (О.Үржин, Б.Даваадорж), Хэнтийн 1 (Д.Гомбосүрэн) байна.

-Захирлаас Монгол Улсын Их хурлын гишүүнээр сонгогдсон 1 (Р.Гаваа), БХЯ-ны газрын даргаар дэвшсэн 1 (Д.Мөнх-Очир), цэргийн атташегаар томилогдсон 1 (Б.Даваадорж), өөр хүрээлэнгийн захирлаар очсон 1(Д.Батболд), ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн захирлаар томилогдсон -1-(З.Болдбаатар), тэтгэвэртээ гарсан - 5 (Д.Гомбосүрэн, Ч.Пүрэвдорж, Б.Шагдар, Ш.Паламдорж, О.Үржин), өөр бусад ажилд шилжсэн 2 (Г.Мягмаржав, Г.Мягмарсамбуу), одоо хэвээр ажиллаж байгаа 1.

Хоёр. Эрдэм судлалын ажлын тухайд

40 жилийн тэртээ хүрээлэн байгуулагдаж байх үед Монголын ардын арми (чанагш МАА гэнэ)-д эрдэмтэд цөөхөн байсны дээр ялангуяа цэргийн урлаг, оперативын чиглэлээр тусгайлан бэлтгэсэн эрдэмтэд төдийлэн байгаагүй төдийгүй эрдэм шинжилгээний зориулалттай номын сан ч байсангүй. Тиймээс захирал Д.Гомбосүрэн эрдэм судлалын ажилд авьяас сонирхолтой хүмүүсийг олж эрдэм шинжилгээний ажилд татан оруулахын зэрэгцээ эн түрүүнд номын сан байгуулахаас ажлаа эхэлсэн гэдэг. Тэгэхдээ Цэргийн ерөнхий дээд сургуулийн номын санд байсан олон

тоотой ном, цэргийн түүхтэй холбогдолтой номыг тохиролцсоны үндсэн дээр балансаас балансад шилжүүлэх, ЦНДС-ийн (хуучин нэрээр) номын сангаас авах, захиалгаар авчруулах зэрэг арга замаар бүрдүүлж байжээ.

Эрдэм судлалын хувьд хүрээлэн байгуулагдсан жил Халхын голын ялалтын 40 жилийн ой тохиолдсон тул их ойд зориулж “Дайчин батарейн улс төрийн удирдагч” (Гэлэгбаатарын тухай-Д.Г), мөн “Халхын голын байлдаан” номыг эрхлэн хэвлүүлсэн нь хүрээлэнгийн бүтээл туурвилын шан татсан бүтээлүүд байлаа.

1980-онд тус хүрээлэнд эрдмийн зэрэг, цолтой эрдэмтэд дэд доктор Д.Цэдэв, Б.Товд нараас өөр хүн байгаагүй бөгөөд захирал дэд хурандаа Д.Гомбосүрэн, өөрөө Зөвлөлтийн цэргийн академиудийн эчнээ адъюнктурт суралцаж байв. Хүрээлэнгийн захирал, удирдлага санаачлага гарган хөөцөлдсөний үр дүнд удалгүй Хүрээлэнгийнхээ дэргэд Эрдмийн Зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Эрдмийн Зөвлөлийн даргаар БНМАУ-ын Зэвсэгт Хүчний Жанжин штабын дарга, орлогч даргаар ЦЭШИ-ийн захирал ажиллах болов. Хүрээлэнгээ бэхжүүлэх талаар анхаарч ирсний үр дүнд 1983 он гэхэд үндсэн гурван сектор, номын сан, нууцтай, 16 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах болов. Тус хүрээлэн эн түүрүүнд шийдвэрлэх 5 асуудлыг дэвшүүлж, түүнийхээ хүрээнд МАХЦ-ийн түүхийг гүнзгийрүүлэн судлах, тус орны физик газар зүй, цаг агаарын онцлог, байлдааны техникийн ашиглалтад нөлөөлөх нь, цэргийн сахилгыг бэхжүүлэх арга зам, МАА-д улс төрийн сургуулийн систем үүсч тогтсон нь сэдвүүдээр судалгааг явуулж эхэлсэн цаашдын эрдэм судлалын их ажлын гараа байв.

Хүрээлэн ийнхүү үүсэн байгуулагдаж, Зэвсэгт хүчний хэмжээнд судалгаа шинжилгээний ажлыг өргөн далайцтай, үр өгөөжтэй өрнүүлэхэд Хүрээлэнгийн удирдлагад ажиллаж ирсэн дарга нар түүчээлэн манлайлж, 40 жилийн турш батлан хамгаалах салбарт өрнүүлж ирсэн шинжлэх ухаан, технологийн судалгааны ажлуудыг гардан удирдаж, өөрийн биеэр үлгэрлэн залуурдаж ирсэн гавьяатай байна.

Эдүгээ тус хүрээлэн ОХУ, БНСУ, Япон, бусад олон улсын ижил төстэй байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, зөвхөн салбарын дотоодын төдийгүй улсын захиалгатай болон олон улсын чанартай, өргөн цар хүрээтэй судалгааны томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлж их ойгоо угтаж байгаа бөгөөд тэдгээрт хүрээлэнгийн үе үеийн захирал, удирдлагын гүйцэтгэж ирсэн үүрэг улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Цэргийн эрдэм судлалын “эрдмийн гал тогоог баригч”

П.Цэдэв

БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,
Боловсролын ухааны доктор (Ph.D), профессор

Энэ жил Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн байгуулагдсаны 40 жилийн ой тохиож байгаатай холбогдуудан БХЭШХ-ийн ЭШТА, доктор, профессор Ж.Базарсүрэн хүрээлэнгийн захирлуудын тухай “Цэргийн эрдэм судлалын залуурчид” нэртэй нийтлэл бичсэн билээ. Түүний үргэлжлэл болох хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нарын тухай Цэргийн эрдэм судлалын “эрдмийн гал тогоо баригч” эрдэмтэн нарийн бичгийн дарга нарын тухай өгүүлэх болно.

Аливаа байгууллага өдөр тутмын дотоод ажлыг эрхэлдэг бүтэц бүхий нэгжтэй байдаг. Энэ ажлыг эрдэм шинжилгээний байгууллагад эрдэмтэн нарийн бичгийн дарга нар гүйцэтгэнэ.

Эрдэмтэн гэдэг үгийг ШУ-ны ямар нэгэн салбарт онцгой мэргэшсэн буюу эрдмийн зэрэгтэй хүн¹ гэсэн утгаар бичсэн байдаг. Эрдэм шинжилгээний байгууллагад ЭШ-ний ажлыг шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэдэг мэргэшсэн судлаач нар гүйцэтгэнэ. Тийм учраас эрдэмтэн нарийн бичгийн даргын ажлыг боловсролын хувьд эрдмийн зэрэг хамгаалсан хүн ёс мэт гүйцэтгэдэг байна.

БХЯ-ны сайдын 1979 оны 08 дугаар сарын 03-ны өдөр баталсан Цэргийн эрдэм шинжилгээний институт /ЦЭШИ/-ийн орон тоог 19 хүнтэй байхаар тогтоож, эрдэмтэн нарийн бичгийн дарга гэсэн анхны албан тушаалыг бий болгожээ. ЦЭШИ байгуулагдмагц оны сүүлчээр ЦЭШИ-ийн тамга тэмдгийг албан ёсоор гардан авсан байна. БХЯ-ны Сайдын 1980 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн н/04 тоот тушаалаар анхны ажилтнуудыг томилсон бөгөөд эрдэмтэн нарийн бичгийн дарга хэмээх албан тушаал “институтгийн эрдмийн гал тогоо баригч” -ыг бий болгосон түүхтэй байна.

Хамгийн анхны эрдэмтэн нарийн бичгийн дарга “институтын эрдмийн гал тогоо баригч”-аар түүхийн ухааны дэд эрдэмтэн **Баярын Товдод** атгуулсан байна. **Хоёр дахь дэд дарга, эрдэмтэн нарийн**

¹ ШУА, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ., 1062 талд

бичгийн дарга, техникийн ухааны доктор, профессор, хурандаа Ж.Дашцэвэг 1981-1988 онд 6 жил гаруй хугацаанд “эрдмийн гал тогоог” барьсан байна.

Гурав дахь дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ШУ-ны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж 1988.07-1991.10 сар хүртэл 3 жил 3 сар ажиллаж байгаад тус хүрээлэн Цэргийн их сургуулийн харъяалалд шилжсэн тул их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлаар дэвшин ажиллажээ.

Энэ үед МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны 1989.08.02-ны өдрийн 50-р тогтоолоор Цэргийн түүхийн хүрээлэн болжээ.

Цэргийн түүхийн хүрээлэнгийн *дөрөвдэх дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ШУ-ны доктор, профессор, хурандаа Д.Мягмар* 1991.10-1993.10 сар хүртэл хоёр жил, айргийн *тав дахь дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор, профессор, хурандаа Б.Бадарч* 1993.10 -1996.12 сар хүртэл 3 жил 2 сар ажилласан байна.

Зургаа дахь дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор, профессор, хурандаа А.Түвшинтөгс 1996-2001 хүртэл таван жил ажилласан бөгөөд энэ үед Монгол Улсын Засгийн газрын 1999.09.05-ны өдрийн 138 дугаар тогтоолоор БХЭШХ болж нэр нь өөрчлөгдсөн байна. Энэ үеэс эхлэн БХЭШХ-ийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн *долоо дахь даргаар социологийн ухааны доктор, профессор, хурандаа Ч.Эрдэнэчулуун* 2001-2012 он хамгийн олон жил буюу 12 жил гаруй, *найм дахь дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар түүхийн ухааны доктор, профессор, хурандаа Г.Мягмарсамбуу* 2012.03.15-наас 2013.08.01-н хүртэл 1 жил 5 сар гаруй хугацаанд *ажиллажээ*.

Ес дэх дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор, профессор, хурандаа Ц.Дэмчигсүрэн 2013-2016 онд 3 жил, *арав дахь дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор, профессор, хурандаа Ч.Баттулга* 2017 оноос хойш одоог хүртэл ажиллаж байна.

Хүрээлэн байгуулагдсан 40 жилийн хугацаанд эрдэмтэн нарийн бичгийн даргын албыг нийт 10 хүн гүйцэтгэжээ.

Нэг. БХЭШХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нарын нийтлэг товчоон буюу “Хамгийн хамгийн ...”

БХЭШХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нарын намтрын нийтлэг байдлыг тодотгож үзвээс:

Анхны гэдгээрээ онцлог дэд эрдэмтэн, хурандаа Б.Товд гуай 61 настайдаа хамгийн ахмад настай нь, бас 1 жил 1 сар богино хугацаанд ажилласан гэдгээрээ онцлог байна. Доктор, профессор, хурандаа Г.Мягмарсамбуу 47 настайдаа энэ албан тушаалд томилогдож 1 жил 5 сар энэ албыг хашсан жил, өдрөөрөө удаалсан байна. Харин хамгийн залуудаа 33 настайдаа дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар

доктор, профессор, хурандаа А.Түвшинтөгс 5 жил гаруй, удаах нь 40 настайдаа ШУ-ны доктор, профессор, хурандаа Д.Мягмар 2 жил гаруй, ШУ-ны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж 3 жил гаруй хугацаанд хийж байгаад сургуулийнхаа дэд захирал, хүрээлэнгийн захирлаар дэвшин ажилласан бол, хожмоо ШУ-ны доктор, профессор, хошууч генерал Д.Мягмар БХИС-ийн захирал болж байжээ.

Доктор, профессор, хурандаа Ч.Эрдэнэчулуун 34 настайдаа хүрээлэнд орж, 44 настайдаа, дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар 12 жил гаруй хамгийн удаан хугацаанд тогтвортой ажилласнаараа тэргүүлж байжээ. Удаах нь доктор, профессор, хурандаа Ж.Дашзэвэг гуай 47 настайдаа энэ албанд томилогдож 6 жил гаруй ажиллажээ. Доктор, профессор, хурандаа Б.Бадарч 44 настайдаа, доктор, профессор, хурандаа Ц.Дэмчигсүрэн 52, Ч.Баттулга 53 насандаа энэ албанд томилогдон бүгд 3 жил гаруй хугацаанд алба хашжээ.

Мэргэжлийн үндсэн гарлын хувьд авч үзвэл, улс төрийн /Б.Бадарч, Г.Мягмарсамбуу, Ч.Эрдэнэчулуун (социологич), Ц.Дэмчигсүрэн/-4, цэргийн холбооны мэргэжлийн /Д.Мягмар, А.Түвшинтөгс/ -2, инженер /Ж.Дашзэвэг, Ч.Баттулга/-2, артиллерийн /Б.Товд/, химийн /Ш.Паламдорж/, тус бүр нэг байна.

Цэргийн цолны хувьд бүгд хурандаа цолтой, докторын зэрэгтэй байх үедээ эрдэмтэн нарийн бичгийн даргаар томилогдсон байна. Б.Товд гуайг эс тооцвол, бүгд профессор цолтон байжээ.

Аймаг, харьяаллыг авч үзвэл, Архангай /Г.Мягмарсамбуу, Ч.Эрдэнэчулуун/-2, Улаанбаатар хот /Ч.Баттулга, Ц.Дэмчигсүрэн, А.Түвшинтөгс/-3, Сэлэнгэ /Ж.Дашзэвэг/, Баянхонгор /Ш.Паламдорж/, Дорнод /Б.Товд/, Говь-Алтай /Д.Мягмар/, Сүхбаатар /Б.Бадарч/ тус бүр нэг байна.

Дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нараас генерал цолтон /Д.Мягмар/, **МУ-ын ШУ-ны гавъяат зүтгэлтэн** /Д.Мягмар, Ш.Паламдорж/ нар төрөн гарсан байна. **Одоо ажиллаж байгаа дэд захирал**, эрдэмтэн нарийн бичгийн дарга Ч.Баттулгаас бусад нь Д.Мягмар, Ш.Паламдорж, А.Түвшинтөгс нар БХИС-ийн сургуулийн захирал, дэд захирал, харьяа сургуулийн захирлаар дэвшин бусад дарга нар **тэтгэврээ тогтоолгосон хэдий ч ямар нэгэн албанд томилогдон ажилласан байна. Энэ байдал нь эрдмийн ажилд нас, мэргэжил, албан тушаал төдийлэн нөлөөлдөггүй**, тэдгээрийн туршлагыг ашиглаж байдгийн нэг илрэл мөн юм.

Хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байх хугацаандаа **доктор, профессор, хурандаа** Ч.Баттулга **хамгийн олон удаа гадаад оронд томилолт**, сургалтаар **удаан хугацаагаар** АНУ-ын Хавай мужийн Хонолулу хот дахь “Ази Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын судалгааны төв”-д 2018 онд “Аюулгүй байдлын хамтын ажиллагаа 18-02” дамжаа болон 2019 оны 9-11сард ХБНГУ-д 2 сарын хугацаатай явж сурч /туршлага, эрдэм ном

зууж/ ирсэн даргаар, мөн ажиллаж байх хугацаандаа сайн ажиллаж хамгийн олон удаа /баяр, тэмдэглэлт ойгоор дээд байгууллагаас шагнал авсан/ шагнуулж байсан дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, хурандаа Ц.Дэмчигсүрэн нар тодорч байна.

Дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарыг гадаадад, дотоодод томилолт, амралтаар явахад нь ахлах даргын шийдвэрээр түр орлон үүрэг гүйцэтгэгчээр БХДШ төвийн дарга, доктор, профессор, хурандаа Т.Соронзонболд байнга ажиллаж байсан бөгөөд хүрээлэнгийн ой болох энэ үед ч ажилласаар байна.

Хоёр. Эрдэм судлал “эрдмийн гал тогооны ажил”-ын тухайд

Эрдэмтэн нарийн бичгийн дарга нарыг ажиллаж байсан хугацаанд зарим онцлогтой үйл явдал, бүтээлүүд гарч байсан байдаг.

Б.Товд гуай юуны өмнө институтийн номын санг нэн яаралтай байгуулах ажилд онцгой санаа тавьжээ. Институт нь тухайн үеийн БХЯ-ны төв аппаратын бүрэлдэхүүнд байгуулагдсан учир /БХЯ-ны 29 дүгээр газар/ ажлаа БХЯ-ны коллеги МАА-ийн Улс төрийн газрын товчооны өмнө шууд тайлагнадаг байжээ. Институт байгуулагдмагцаа Институтийн дүрмийн төслийг боловсруулж батлуулан ажилдаа орсон байна. Байгууллагын ажлын тайлан, дүрмийн төслийг эрдэмтэн нарийн бичгийн дарга голчлон гүйцэтгэсэн байдаг.

Дэд эрдэмтэн Б.Товд Цэргийн нэр томъёоны толь бичгийн эхийг шинэчлэн боловсруулах тухай армийн командлалын шийдвэр гаргуулж, комиссын бүрэлдэхүүнд Б.Товд, Б.Ядамцоо, Ц.Гончигжав, ЦНДС-ийн Орос хэлний кафедрын дарга Г.Дашзэвэг зэрэг хүмүүс орсон байна. Хожмоо Б.Товд, Ц.Чойндон, Ц.Гончигжав, Н.Элбэг, Д.Цэрэндорж, ЦНДС-ийн орос хэлний тэнхимийн дарга Г.Дашзэвэг нар бэлэн болгосон байна. Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Товд нь Хөгжлийн онолын шинэ хандлагын нөлөөг судлах тухай асуудлаар Олон Улсын нийгмийн ухааны мэргэжилтэн нарын зөвлөгөөнд “Зэвсэглэлийг бүх нийтээр бүрэн төгс хураах асуудал гэсэн сэдвээр үг хэлж оролцсон байдаг. БНМАУ-ын Зэвсэгт хүчин номын эхийг бэлтгэх, олон асуудлыг гүйцэтгэхэд оролцон арга хэмжээнүүдийг гүйцэтгэсэн байна.

ЦЭШИ-ийн хоёр дахь эрдэмтэн нарийн бичгийн даргаар цэрэг-техникийн секторын дарга, дэд хурандаа Ж.Дашцэвэгийг 1981 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс /Сайдын н/36 тоот тушаал/ хавсруулан томилсон байна. Ж.Дашцэвэг нь ЗХУ-ын Москва хотын Цэргийн инженерийн академийн адъюнктур /1975-1979 онд/-т суралцаж, техникийн шинжлэх ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

Эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Ж.Дашцэвэг дурсамждаа “Армийг өргөтгөн зохион байгуулах ажил ид өрнөж шинэ шинэ асуудал тулгарч байсан тэр үед судалгаа шинжилгээний ажил эрхлэн хийх туршлага дадал чадвар хэн хэнд маань ч хомс байсныг бас анхны үед удирдлагаас шинжлэх ухааны ач холбогдлыг ойлгож үнэлэх,

судалгааны байгууллагад тодорхой үүрэг даалгавар өгөх, удирдан чиглүүлэх, институт, секторуудыг эрхлэн гүйцэтгэх судалгааны ажил тодорхой бус, их бүрхэг байсныг хэлэх юун. Үүн дээр судлаачид маань цоо шинэ ажилд томилогдож, судалгаа шинжилгээний арга барилд бие дааж суралцах шаардлагатай болсон гээд, эхэн үедээ институт удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхэд анхаарч байсан билээ. Яамны удирдлагаас эрдэм шинжилгээний ажилтнуудыг шинжлэх ухааны арга барилд суралцуулах, энэ талын туршлага судлуулахад анхаарч, бололцоотой дэмжлэг тусалцаа үзүүлж байсныг дурсан хэлэх нь зүйтэй²” гэжээ.

1981 оны 11 дүгээр сард манай ЦЭШИ-ийн захирал, хурандаа Д.Гомбосүрэн тэргүүтэй /бүрэлдэхүүнд нь эрдэмтэн нарийн бичгийн дарга, Ж.Дашцэвэг, ЦНДС-ийн орлогч захирал, хурандаа Л.Дамбийням/ төлөөлөгчид ЗХУ (хуучин нэрээр) БХЯ-ны Цэргийн түүхийн институтэд туршлага судлахаар явсан байна.

Цэргийн түүхийн институтийн дарга ЗХУ (хуучин нэрээр)-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн, дэслэгч генерал П.А.Жилин гуай манай төлөөлөгчдийг туйлын элэгсэг дотно хүлээн авч үнэтэй зөвлөгөө өгөхийн хамт институтийнхээ бүтэц, зохион байгуулалт, эрдэм шинжилгээний ажлын арга зүйтэй дэлгэрэнгүй танилцуулсан байдаг. П.А.Жилин гуайтай уулзсан тухай Ж.Дашцэвэг гуай дурсамж бичихдээ “Та нар эрдэм шинжилгээний боловсон хүчин сонгоход онцгой анхаарах хэрэгтэй. Энэ асуудал бол их чухал шүү. Шилэн сонгож авсан ажилтан тань аливаа асуудлыг задлан шинжлэх аналитик сэтгэлгээ, оюун ухаан, ур чадвартай байвал сайн даа. Та нар эхлээд эрдэм шинжилгээний зөв арга зүйг сонгож, практикт хэрэглэх нь чухал. Ер нь практик үйл ажиллагаандаа тохирох судалгааны чиглэлийг сонгож авах, бий болгох, хэрэглэх нь чухал...” гэж захиж хэлсэн нь санаанаас гардаггүй юм³” гэжээ.

Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Дашцэвэг гуайн удирдлагаар Улаанбаатар-Сулинхээрийн чиглэлд армийн нэгтгэл, ангиудыг байлдааны ажиллагааны районд гаргах маршрут, байлдааны болзошгүй зааг, районыг судлах нэгдсэн экспедицийг 1980 оны намар ажиллуулсан байна. Ийм судалгааг хэд хэдэн чиглэлд хийсэн байна.

ШУ-ны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж “Эрдмийн чадавхыг нэмэгдүүлэхийн төлөө...” дурсамждаа “Хүрээлэнд эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллахад надад содон мэдэгдсэн зүйл бол тус хүрээлэн нэг талдаа төрийн захиргааны байгууллага шиг эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг армийн хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг дагнан зохицуулдаг, нэгтгэл, ангиудын цэргийн эрдэм шинжилгээний секцүүдийг удирддаг, эрдэмтэн судлаачдыг сонгон шалгаруулж гадаад, дотоодын их сургууль, академиудад явуулах ажлыг зохион байгуулдаг, нөгөө талдаа эрдэм шинжилгээний байгууллагын хувьд судалгаа шинжилгээний

² БХЭШХ, Эргэн дурсах эрдмийн хамт олон /Дурсамжийн эмхэтгэл/, УБ., 2009, 33 талд

³ БХЭШХ, Эргэн дурсах эрдмийн хамт олон /Дурсамжийн эмхэтгэл/, УБ., 2009, 34 талд

ажлыг гүйцэтгэдэг байлаа. Үүнийг өөрчилж, захиргааны шинжтэй ажлыг нь БХЯ-д өгөх, хүрээлэнг судалгаа, шинжилгээний ажлыг дагнан явуулдаг болгох санаачилгыг гаргаж, хэрэгжүүлэх тушаал, шийдвэрийн үндсийг боловсруулсан юм. Үүний үрээр БХЯ-д ШУТЗ, ЦИС, БХЭШХ-д эрдмийн зөвлөлүүд байгуулж билээ⁴” гэж бичжээ. Энэ үед хүрээлэнгийнхээ түүхийг цэргийн эрдэм судлал 40, 50 жил гэсэн номууд, Монгол Улсын Шинжлэх ухааны 108 ботийн 51 дүгээр боть Цэргийн шинжлэх ухаан гэсэн бүтээлдээ бичиж үлдээсэн байна.

Мөн тэрээр эрдмийн зөвлөлийн хуралдааныг жинхэнэ ёсоор ухаан уралдуулах, ном хаялцах, мэтгэлцээний тавцан болгож, ажил хэрэгч, хуралдааны байгууллага болгож төлөвшүүлэх, эрдмийн зөвлөлийн гишүүд төдийгүй, эрдэмтэн судлаачдынхаа эрдэм шинжилгээний онол, арга зүйг өсгөх, төлөвшүүлэх, хэрэгсэл болдог. Хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн гишүүдийг нэн оновчтой сонгож байх нь нэн чухал байдаг юм билээ. Эрдмийн зөвлөлийн хуралдаан бол мэтгэлцээн, ном хаялцах, ухаан уралдуулах газар болохоос биш «хэрүүлийн алим»-ын газар биш. Иймээс ёс суртахууны хувьд ямар хүн бэ гэдгийг харгалзан, Эрдмийн зөвлөлийн хуралдааныг үймүүлэхгүй, ёс жаягийг хүндэтгэх чадвартай хүлээцтэй хүмүүсээр бүрдүүлмээр юм билээ⁵ гэсэн байдаг.

ШУ-ны доктор, профессор, хурандаа Д.Мягмар нарын олон эрдэмтэн нарийн бичгийн дарга нар нь хүрээлэнгийн эрдэм судлалын ажлыг суурь болон хавсарга судалгааны чиглэлээр хөгжүүлэх, бүрэлдэхүүнийг эрдэмжүүлэх, шинэ залуу судлаачдыг эрдэм шинжилгээний ажлын дөртэй болгох, эрдмийн зөвлөлийг байгуулж, батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээний ажлын зорилго, чиглэлийг тодорхойлж, энэ салбарын үйл ажиллагааг шинжлэх ухаанч байлгах хандлагыг баримталж байжээ.

Мөн хүрээлэнгийн төлөвлөгөөг боловсруулах, ажилтнуудын судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангах, армийн хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг бэлтгэж хийх, хүрээлэнгийн ажилтнуудын эрдмийн зэрэг цол хамгаалах ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажилласан байна.

Доктор, профессор, хурандаа Б.Бадарч нь ОХУ-ын Цэргийн их сургуулийн докторантурт суралцаж, философийн ухааны дэд эрдэмтний зэргийг 1993 онд хамгаалж ирээд тэр үеийн Батлан хамгаалах яамны сайд дэслэгч генерал Ш.Жадамбаад ОХУ-д академид суралцан эрдмийн зэрэг хамгаалснаа цэргийн хүний ёсоор орж илтгэхэд тэрээр баяр хүргээд боловсон хүчний хэлтсийн дарга хурандаа П.Бямбасүрэнг дуудаж хурандаа мөрдэс аваад ороод ир гээд надад шууд тушаал гарган 7 сарын 10-ны өдөр хурандаа цол олгож, Цэргийн түүхийн хүрээлэнд томилж байсан тэмдэглэлт өдрийг би мартдаггүй гэж ярьдаг. Энэ бол эрдмийн ажлыг үнэлж цэргийн цол олгосон хэрэг мөн юм.

Хүрээлэнгийн эрдэм судлалын ажил болон бүтээл туурвилд оролцож, тухайн үед хүрээлэнгийн суурь судалгааны анхны ном “Монгол цэргийн түүхийн товчоо” ном бүтээхэд оролцсон ба социологийн төвийн

⁵ БХЭШХ, Эргэн дурсах эрдмийн хамт олон /Дурсамжийн эмхэтгэл/, УБ., 2009, 69 талд

эрдэм шинжилгээний ажилтнуудтай хамтаар армийн бие бүрэлдэхүүний сэтгэлзүйн байдалд цаг үеийн болон цогц судалгаа хийж, цэргийн удирдлагуудад тухай бүр танилцуулж байсан нь тухайн үеийн олон ургальч үзэл дэлгэрсэн ороо бусгаа цагт армийн командлалын анхаарлыг хандуулж, зохих шийдвэр гаргахад нөлөөлсөн байна. Намайг ажиллаж байхдаа эрдмийн зэрэг хамгаалахад хүрээлэнгийн удирдлага тухайлбал захирал Ш.Паламдорж ихээхэн дэмжлэг үзүүлж, бололцоо нөхцөлөөр хангаж байсныг энд дурдахад таатай байна. Үүнд би ямагт талархаж явдаг юм гэж ярьдаг.

БХЭШХ –ийн захирлаар ШУ-ны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, хурандаа Ч.Эрдэнэчулуун нар ажиллаж байх үед манай хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг «Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал» сэтгүүл 2004 оноос хойш жилд 2 удаа гарч байна.

Хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, хурандаа Ч.Эрдэнэчулууний санаачилгаар 2009 онд хүрээлэнгийн 30 жилийн ойг тэмдэглэх үеэр хүрээлэнгийн мэдээллийн ажилтан Б.Баярмагнайгийн гаргасан загварын дагуу хурандаа Ц.Дэмчигсүрэн хүрээлэнгийн энгэрийн тэмдэг, дурсамж, алтан гэрэгээг хийлгэсэн байдаг.

Дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар социологийн ухааны доктор, профессор, хурандаа Ч.Эрдэнэчулуун хамгийн олон жил буюу эрдмийн гал тогоог барихдаа ёстой донжийг олж хамгийн олон судалгааны ажил, бүтээл туурвигдаж, эрдэмтэд төрөн гарч, хамт олны ажлын өнгө төрх тодорч байжээ. Түүнээс хойших дарга нарын үед эрдэм номын эрч, хүч улам чангарч хүрээлэн үндсэн үүрэгт ажлаа нэр төртэй гүйцэтгэж байна.

Хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Г.Мягмарсамбуу дурсамждаа “Хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга болоод би жил гаруй болохдоо хийж бүтээсэн сүйдтэй юм байхгүй. Гэхдээ би зүгээр суугаагүй, надад гол нь хүрээлэнгийн залуучуудыг дэмжиж, хөгжүүлэх санаа байсан бөгөөд энэ зорилгоор хүрээлэнгийн залуу судлаачдын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, ахмад эрдэмтдээр зөвлөгөө өгүүлэх ажлыг зохион байгуулж байлаа. Тэрээр хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга болсны дараа өдөр тутмын ажилд хамаг цагаа зарцуулаад судалгааны ажил орхигдох шинжтэй болж байлаа. Гэтэл миний сонирхол бол дарга даамал болох биш, харин аль болохоор нам гүмхэн архивт сууж, ганц ч гэсэн ном бичих явдал байв. Ер нь би батлан хамгаалах салбарт ажиллаж байх хугацаандаа ажил албан тушаал дэвших тухай асуудал тавьж дарга нар дээрээ орж байсан удаагүй. Тийм хүсэл сонирхолгүй байсан учраас би өөрөө хүсэлт гарган 2013.08.01 –ий өдрөөр тасалбар болон цэргийн тэтгэвэртээ гарсан юм” гэжээ. Ингэж хүрээлэнгийн “эрдмийн гал тогооны ажил”-аас өөрийн хүсэлтээрээ гарсан тухай бичсэн байдаг. Харин одоо *ШУА-ийн Түүх, угсаатны зүйн*

хүрээлэнгийн Бүс нутаг ба орчин үеийн түүхийн салбарын эрхлэгчээр ажиллаж байна.

Хүрээлэнгийн дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан **доктор, профессор**, хурандаа Ц.Дэмчигсүрэн нь БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэргэдэх Батлан хамгаалахын атташегийн албатай хамтран 2015 онд “Монгол-Хятадын харилцаа”, 2016 онд “Терроризмын аюултай тэмцэх талаар Монгол-Хятадын хамтын ажиллагаа сэдэвт эссэ, эрдэм шинжилгээний өгүүлэл бичлэгийн уралдаан зохион байгуулж, эмхэтгэл гаргасан байна.

Өнөөгийн байдлаар Батлан хамгаалах салбар эрдэмтэн бэлтгэх түвшинд хүртэл эрдмийн чадавх нь өссөөр байгаа бөгөөд Батлан хамгаалах салбарт 30 шахам хүн докторын ажлын сэдэв дээр ажиллаж байгаагийн 4 нь хүрээлэнгийн судлаачид юм.

БХЭШХ-ийн нийт бие бүрэлдэхүүний 10.3 хувь нь шинжлэх ухааны доктор, 51.7 хувь нь цэргийн болон бусад төрөл бүрийн ухааны доктор, 31.0 хувь нь магистрын зэрэгтэй хүмүүс ажиллаж байна. Мөн бие бүрэлдэхүүний дотор профессор, дэд профессор цолтой ажилтнууд 33.3 хувь байна.

БСШУС-ын сайдын 2018 оны А/774 тоот тушаалаар томилсон аттестатчилалын комисс нь БХЭШХ-ийн аттестатчилалд хамрагдсан нийт ажилтнаас 18.5 хувь нь эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар, 14.8 хувь нь ахлах ажилтнаар, 59.3 хувь нь дэд ажилтнаар, 7.2 хувь нь дадлагажигч ажилтнаар зэрэг дэвийг тогтоохоор шийдвэрлэсэн байна.

Дээрх судалгааны үзүүлэлтүүд нь хүрээлэнгийн хамт олны судалгаа шинжилгээний ажил явуулах эрдмийн чадавх дээшилж байгааг харуулж байна. Энэ ажилд цэргийн эрдэм судлалын “эрдмийн гал тогоо баригч” дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нар чухал үүрэгтэй байсан гэж үзэж болно.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны 1979.05.29-ны өдрийн “Батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 13-р тогтоол;
2. МАХН-ын ТХ-ны Улс төрийн товчооны 1989.08.02-ны өдрийн 50-р тогтоол;
3. Монгол Улсын Засгийн Газрын 1999 оны 09 сарын 05 өдрийн 138-р тогтоол;
4. ШУА, Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ., 2008;
5. Паламдорж Ш, Цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдал судлалаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл-20 жил, УБ., 2015;
6. Гомбосүрэн Д нар, Цэргийн эрдэм судлал-50 жил, УБ., 2009;
7. Эрдэнэчулуун Ч, Ред.Эргэн дурсах эрдмийн хами олон (дурсамжийн эмхэтгэл), УБ., 2009.

Шинэ эринд баримтлах Хятадын батлан хамгаалах бодлого

Б.Эрдэнэчимэг

БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа

Хятадын цэрэг, батлан хамгаалах бодлогын нэг онцлог нь залгамж чанарыг хадгалан хөгждөг явдал юм. Тухайлбал, Дэн Сяопин “Зэвсэгт хүчнийг бүрэн шинэчлэх явдал улс ардын аж ахуйн хөгжил дээр бат бэх суурилагдаж чадвал хэрэгжих бололцоотой, улсын эдийн засгийн хүчин чадал өсөх хэмжээгээр Зэвсэгт хүчний шинэчлэлд төдий чинээ их хөрөнгө зарцуулж чадах болно. Бид хилийн чанадаас зэвсэг, техник худалдан авч болох боловч өөрсдийн шинжлэх ухааны ололтод тулгуурлаж, сайн нисэх онгоц зохион бүтээж, тэнгисийн цэргийн хүч, хуурай замын цэргээ сайн зэвсэг, техникээр хангах хэрэгтэй. Хичнээн хүчирхэг эдийн засагтай баймааж нь үүнийг хэрэгжүүлэх бололцоотой болно” гэсэн нь өнөөдөр батлан хамгаалах бодлогынх нь гол хандлага болсоор байна¹.

БНХАУ шинэ нөхцөлд баримтлах цэрэг, батлан хамгаалах бодлого болон Зэвсэгт хүчний хөгжлийн чиг хандлагын талаар батлан хамгаалахын Цагаан номоороо дамжуулан олон улс болон өөрийн орны иргэддээ сурталчилан таниулдаг.

Тус улс 1998 оноос хойш 10 дахь удаагаа батлан хамгаалахын Цагаан номоо хэвлэн гаргаж, дэлхий дахинд Хятадын батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний бүтэц зохион байгуулалтыг танилцуулаад байна. Агуулга талаасаа харвал энэхүү цагаан номууд нь аюулгүй байдлын орчин, батлан хамгаалах бодлого, цэрэг армийн бүтэц зохион байгуулалт, зэвсэг техникийн шинэчлэл, олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаа зэргийг багтаасан байдаг. 2012 онд Хятад Улсын Засгийн газар батлан хамгаалахын Цагаан номоо мэргэжлийн чиг баримжаатай болгон өөрчлөх зөвшөөрөл олгосноор 2013 оны батлан хамгаалахын Цагаан номоо “БНХАУ-ын Зэвсэгт хүчний олон талт хэрэглээ”, 2015 онд “Хятадын цэргийн стратеги”, 2017 онд “Ази, Номхон далайн бүс нутагт баримтлах Хятадын бодлого”, 2019 онд “Шинэ эринд баримтлах Хятадын батлан хамгаалах бодлого” нэртэйгээр гаргаад байна.

2019 оны 7 дугаар сард нийтэд танилцуулсан “Шинэ эрин дэх

¹ “Хоёр хөршийн цэрэг, батлан хамгаалах бодлого, түүний үр дагавар”. Судалгааны ажлын тайлан. БХЭШХ., 2016.

Хятадын батлан хамгаалах бодлого” нь 2013, 2015 оны цагаан номуудад тусгасан гол үзэл баримтлал, зарчмуудыг дахин баталгаажуулсанаас гадна анх удаа батлан хамгаалах төсвийн зарцуулалтыг олон нийтэд мэдээлсэнээрээ онцлог байв.

Шинэ эрин дэх Хятадын үндэсний “хамгаалах” шинж чанар бүхий батлан хамгаалах бодлогын талаар

“Хятад мөрөөдөл”, “Энх тайвнаар цэцэглэн хөгжих”, “Хятад үндэстний агуу их сэргэлт” (Great Rejuvenation of Chinese nation) зэрэг нэр томъёонууд тус улсын бодлогын баримт бичиг, намын удирдлагуудын хэлсэн үг, хэвлэл мэдээллээр олонтаа харагдах болсон нь өнөөгийн Хятадын бодлогын өнгө төрх гэлтэй. Хятадын Батлан хамгаалах бодлогыг ойлгохын тулд эдгээр нэр томъёонуудын цаад утга агуулгыг ойлгох нь чухал юм. Шинэ эрин зуунд Хятад улс цэрэг, улс төр, эдийн засгийн хувьд олон улсын тавцанд нөлөө бүхий “баян, хүчирхэг” улс байгуулж манлайлагч их гүрэн болох “мөрөөдөл”-тэй бөгөөд энэхүү мөрөөдөл биелэлээ олох шинэ эрин “Хятад үндэстний агуу их сэргэлт”-ийн эрин зуун хэмээн нэрлэгдэх ажээ. Энэхүү мөрөөдөлдөө хүрэхийн тулд “энх тайвнаар цэцэглэн хөгжих” зарчмыг мөрдлөг болгоно хэмээн мэдэгдэж буй. Нөгөөтэйгүүр Хятад улс цэрэг армия хүчирхэгжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж буй нь сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчинд явагдаж буй шинэчлэлээс тодхон харагдаж буй бөгөөд энэ нь цэвэр “хамгаалах” зорилготой, түрэмгий сэдэл агуулаагүй хэмээн тайлбарлаж байна.

2019 оны шинэ батлан хамгаалахын цагаан номонд Хятад улс “хамгаалах” шинж чанар бүхий батлан хамгаалах бодлого баримтална хэмээн тусгасан бөгөөд энэ нь 2013, 2015 оны цагаан номонд тусгасан “идэвхтэй хамгаалах” стратегитай зарчмын хувьд ижил буюу “*ямар ч тохиолдолд цэргийн хүч түрүүлж хэрэглэхгүй, харин бусад улс халдан довтолсон тохиолдолд хариу цохилт өгөх нь дамжиггүй*” гэсэн үзэл баримтлал хэвээр байна. Мөн цөмийн зэвсгийн хувьд өөрийгөө хамгаалах стратеги баримтална гэдгээ дурьдаж “*Хятад улс ямарч цед, ямар ч нөхцөлд цөмийн зэвсэг урьтаж ашиглахгүй, цөмийн зэвсэггүй бус, цөмийн зэвсэггүй улсын эсрэг цөмийн зэвсэг ашиглахгүй, ашиглахаар заналхийлэхгүй*”² хэмээн заасныг онцлууштай.

Шинэ эрин дэх Хятадын “хамгаалах” шинж чанар бүхий батлан хамгаалах бодлого нь товчхондоо “Хятад улс Энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг мөрдлөг болгож жанжлах, нөлөөний хүрээгээ тэлэхийг хэзээ ч эрмэлзэхгүй харин бүрэн эрхэт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хөгжил дэвшил, ашиг сонирхлоо ямар ч үнээр хамаагүй хамгаална”³ гэсэн зорилго зарчим дээр тулгуурлаж байна. Батлан хамгаалах бодлогын зорилгын тухайд 2015 оны “Цэргийн стратеги”-тай харьцуулахад ерөнхий агуулгын хувьд ижил төстэй хэдий ч илүү өргөн хүрээг хамарсан, зарим асуудлаар байр сууриа тун тодорхой, хурц үгээр хатуу илэрхийлсэн харагдана.

² 新时代的中国国防. 白皮书-2019 http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm

³ Мөн тэнд

Шинэ эриний Хятадын үндэсний батлан хамгаалах бодлогын зорилгыг дараах байдлаар тодорхойлсон:

- Түрэмгийллийг олж илрүүлж, эсэргүүцэх;
- Улс төрийн аюулгүй байдал, ард иргэдийн аюулгүй байдал, нийгмийн тогтвортой байдлыг сахин хамгаалах;
- “Тайваний тусгаар тогтнол”-ыг эсэргүүцэх, тогтоон барих;
- “Түвдийн тусгаар тогтнол”, “Зүүн Туркестаны үүсгэн байгуулах” санаа бүхий салан тусгаарлах хөдөлгөөнийг дэмжигчдийг нухчин дарах;
- Бүрэн эрхт байдал, эв нэгдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах;
- Далай тэнгис дэх Хятадын эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- Сансар, электрон соронзон болон кибер орон зайд Хятадын аюулгүй байдлын ашиг сонирхлыг хамгаалах;
- Хятадын хилийн чанад дахь ашиг сонирхлыг хамгаалах;
- Улсын тогтвортой хөгжлийг дэмжих⁴ гэжээ.

2015 оны батлан хамгаалах цагаан номонд Хятадын далай тэнгис дэх газар нутгийн маргааны талаар “Хятадын газар нутгийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхэт байдал, далай тэнгис дэх эрх ашиг, ашиг сонирхлын тухай асуудлуудын хувьд эрэг орчмын зарим хөрш орнууд өдөөн хатгах үйл ажиллагаа явуулж мөн Хятадын шүрэн арлууд дээр болон өөрсдийн хууль бусаар эзэмшиж буй арлууд дээр цэргийн оролцоогоо нэмэгдүүлж байна”⁵ гэдгийг онцлон дурьдсан. Улмаар эдгээр өдөөн хатгасан үйлдлүүдэд ямар хариу үзүүлэх талаар шууд тусгаагүй хэдий ч тухайн баримт бичгийн зарим хэсэгт “Хятад улс өөрсдийн ашиг сонирхлоо хамгаалах болон тогтвортой байдлыг хадгалах хэмээх хоёр зорилгын тэнцвэрийг хадгалах болно”⁶ мөн “ хямралаас урьдчилан сэргийлнэ” гэх мэтээр тодорхой бус, хоёрдмол байдлаар тусгасан байдаг.

Харин 2019 оны цагаан номонд “Өмнөд Хятадын Тэнгисийн арлууд болон Диаоюу арлууд нь Хятадын газар нутгийн салшгүй хэсэг” хэмээгээд “Хятад улс үндэсний бүрэн эрхийн хүрээнд Өмнөд Хятадын тэнгисийн арал, хадан хясаанууд дээр дэд бүтэц байгуулж шаардлагатай хамгаалах цэргийг илгээх, мөн Зүүн Хятадын тэнгисийн Диаоюу аралд эргүүл хийх болно”⁷ гэж байр сууриа илэрхийлсэн. Энэхүү ялгаатай байр суурь нь судлаачдын таамаглаж байсанчлан Хятад улс цэрэг, зэвсгийн хувьд хүчирхэгжих тусам арлууд болон Тайваний асуудал дээр урьдын “уян хатан” байдлаас “эрс шийдэмгий” байр суурьтай болсон нь харагдаж байна.

⁴ Мөн тэнд

⁵ 2015中国国防白皮书《中国的军事战略》(全文) http://www.chinadaily.com.cn/interface/toutiao/1138561/2015-5-26/cd_20821000.html

⁶ Мөн тэнд

⁷ 新时代的中国国防. 白皮书-2019. http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm

Тайваний асуудлын тухайд:

Хятад улс “энх тайвнаар эгцлэн нэгтгэх”, “нэг улс- хоёр систем” зарчмыг мөрдлөг болгохын сацуу “улс орныг салган хуваах гэсэн аливаа оролдлого, үйлдэл, ийм санаа зорилго бүхий гадаадын улс орны хөндлөнгөөс оролцох явдлыг шийдвэртэйгээр эсэргүүцнэ”... “Хятад улс эргэн нэгдэх ёстой, нэгдэх ч болно”. “Хятад улсад үндэсний бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлаа хамгаалах зоримог шийдвэр, хүчин чадавх аль аль нь буй тул хэн ч, ямар ч байгууллага, ямар ч улс төрийн нам хэзээ ч ямар ч арга хэрэгслээр газар нутгийн маань аль нэг хэсгийг салгахыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй”. Энэ тохиолдолд **“хүч хэрэглэхээс цааргална гэж амлалт өгч чадахгүй бөгөөд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах сонголт үлдэж байна”**. Энэ нь Тайваний элэг нэгт ахан дүүсээ чичилж буй хэрэг огтхон ч биш бөгөөд харин гадны хөндлөнгөөс оролцогчид, “Тайваний тусгаар тогтонол” гэх цөөн хэдэн салан тусгаарлагчид, тэдгээрийн үйлдэлд хандаж хэлж байна. ХАЧА Хятадаас Тайванийг салгах гэсэн хэнийг ч эргэлзээгүйгээр бут цохих бөгөөд ямар ч үнэ цэнээр хамаагүй үндэсний эв нэгдлээ сахин хамгаалах болно...⁸

Ийм тод томруун, ойлгомжтой хэлж буй тохиолдолд хэнд хандаж ямар утгаар хэлж буйг тайлбарлах нь илүүц бизээ. Нөгөө шинэ эриний Хятадын “хамгаалах” бодлогын нэг мөн чанар нь энд тусгалаа олжээ.

Батлан хамгаалах бодлогын хэтийн төлвийн тухайд “Шинэ эриний Хятадын үндэсний батлан хамгаалах болон цэргийн хөгжлийн стратегийн зорилго” хэмээн боловсруулж дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- 2020 он гэхэд өргөн хүрээнд мэдээлэлжих, стратегийн чадавхиа сайжруулах замаар бүрэн механикжих
- Цэргийн онол, бүтэц зохион байгуулалт, цэргийн албан хаагч, зэвсэглэл, техникийн иж бүрэн шинэчлэлийг улс орны дэвшилттэй хөл нийлүүлэн урагшлуулж 2035 он гэхэд үндэсний батлан хамгаалах, цэргийн шинэчлэлийг үндсэнд нь дуусгах
- 21-р зууны дунд үе гэхэд Зэвсэгт хүчнийг дэлхийн жишигт хүргэх ажлыг бүрэн гүйцэлдүүлэх⁹

Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийн тухайд:

“Шинэ эрин дэх Хятадын үндэсний батлан хамгаалах бодлого” баримт бичигт тусгаснаар Хятадын зэвсэгт хүчин нь:

- Газар нутгийн бүрэн эрхт байдал, далай тэнгис дэх эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- Байлдааны бэлэн байдлыг хангах;
- Байлдааны бодит орчин нөхцөлд цэргийн сургалт бэлтгэл явуулах;
- Аюулгүй байдлын чухал талбаруудад (сансар, кибер орон зай г.м) ашиг сонирхлоо хамгаалах;

⁸ Мөн тэнд

⁹ 新时代的中国国防. 白皮书-2019. http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm

- Терроризмтой тэмцэх, тогтвортой байдлыг хангах;
- Хятадын хилийн чанад дахь ашиг сонирхлыг хамгаалах;
- Гамшгийг бууруулах, аврах ажиллагаанд оролцох зэрэг үндсэн үүргүүдийг гүйцэтгэнэ хэмээн заасан¹⁰.

Газар нутгийн бүрэн эрхт байдлыг хангах, далай тэнгис дэхь ашиг сонирхлыг хамгаалах, байлдааны бэлэн байдлыг хангах үүргийн тухайд:

2015 оны Цэргийн стратегид хамгийн ойрын аюулыг далай тэнгисээс ирж болзошгүй хэмээн тооцоолж, тэнгисийн цэргийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, хүчин чадавхыг сайжруулах, зэвсэг техникийг шинэчлэх тал дээр түлхүү анхаарал хандуулж байсан. Харин 2019 оны цагаан номонд дурьдсанаар Хятадын Зэвсэгт хүчин “*Зүүн Хятадын тэнгис, Өмнөд Хятадын тэнгис, Шар тэнгис дэх гол усан замуудыг хамгаалж, улмаар 2012 оноос хойш Хятадын зэвсэгт хүчин 4,600 удаагийн эргүүлээр усан онгоцнууд илгээж, мөн далай тэнгис дэх эрх, хууль сахиулах 72,000 удаагийн ажиллагаа явуулж энх тайван тогтвортой байдал дэг журмыг сахиулсан гэж тэмдэглэжээ*¹¹. Мөн түүнчлэн “*Үндэсний эв нэгдлээ сахин хамгаалахын тулд Хятадын Зэвсэгт хүчин голчлон далай тэнгист анхаарал хандуулж байлдааны бэлэн байдлаа чангатгах хэрэгтэй*” хэмээжээ.

Байлдааны бодит орчин нөхцөлд цэргийн сургалт бэлтгэл явуулах үүргийн тухайд:

2015 оны Цагаан номны “Зэвсэгт тэмцэлд бэлтгэх нь” бүлэгт “ХАЧА-ийн нэг сул тал болох байлдааны бодит туршлага дутагдалтай байгааг дурьдаад аливаа зэвсэгт тэмцэлд ялалт байгуулахын тулд “бодит орчин нөхцөл”-д сургалт бэлтгэл хийх хэрэгцээ шаардлага тулгарч буйг онцолсон байдаг¹². Тэгвэл шинэ цагаан номонд Шинэ эринд Зэвсэгт хүчин байлдааны бодит орчин нөхцөлд сургалт бэлтгэл хийхийн чухлыг онцолж улмаар цаашид “бодлогын хэрэгжилт, шалгуур үзүүлэлтийг анхаарч онц байдлын үеийн цэргийн сургалт бэлтгэлийн хяналтын систем, сургалт, бэлэн байдлын хариуцлагын системийг сайжруулах”-талаар тусгасан¹³.

Аюулгүй байдлын чухал талбаруудад (сансар, кибер орон зай г.м) ашиг сонирхлоо хамгаалахын тухайд:

2015 оны Батлан хамгаалах цагаан номонд дурьдсанаар “*сансар болон кибер орон зай нь стратегийн өрсөлдөөний чухал талбар болсон бөгөөд Хятад улс энэ хоёр талбарт цэргийн хүчин чадавхаа нэмэгдүүлж, эдийн засгийн болон стратегийн ашиг сонирхлоо хамгаалахыг зорино*”¹⁴

¹⁰ Мөн тэнд

¹¹ 新时代的中国国防. 白皮书-2019. http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm

¹² 2015中国国防白皮书《中国的军事战略》(全文) http://www.chinadaily.com.cn/interface/toutiao/1138561/2015-5-26/cd_20821000.html

¹³ 新时代的中国国防. 白皮书-2019. http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm.

¹⁴ 2015中国国防白皮书《中国的军事战略》(全文) http://www.chinadaily.com.cn/interface/toutiao/1138561/2015-5-26/cd_20821000.html

хэмээсэн. 2019 онд энэ үзэл баримтлалыг дахин бататгаж, улмаар “сансрын технологи, хүчин чадавхаа сайжруулах, сансарт суурилсан мэдээллийн эх үүсвэрийн зохицуулалтыг боловсронгуй болгох, сансрын цагийн байдлын тандалтыг сайжруулах, сансарт буй улсын өмч, байгууламжийг хамгаалах, сансарт чөлөөтэй зорчих, орох гарах гарцыг аюулгүй байлгахад анхаарах”¹⁵ зэргийг чухалчилсан.

Хятадын хилийн чанад дахь ашиг сонирхлыг хамгаалах Зэвсэгт хүчний үүргийн тухайд:

“БНХАУ гадаадад байгаа хуулийн этгээд болон иргэдийн аюулгүй байдал, эрх ашиг нь зөрчигдсөн тохиолдолд шуурхай авран туслах, нүцлэн шилжүүлэх, яаралтай тусламж үзүүлэх нь ХАЧА-ийн хувьд үндэсний ашиг сонирхлыг хамгаалж буй төдийгүй олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж буй хэлбэр мөн”¹⁶ хэмээн 2013 оны Цагаан номонд тусгаж байсан бол шинэ Цагаан номонд “Хилийн чанад дахь Хятадын иргэд, байгууллага, нэгжийн аюулгүй байдал, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг үр дүнтэй хамгаална”¹⁷ хэмээн тусгасан. Цаашдаа “Бүс ба зам” санаачлагын хүрээнд хилийн чанад дахь Хятадын аж ахуй нэгж, байгууллага, хөрөнгө, түрээсэлж буй боомт, эзэмшиж буй байгууламж, улсынхаа иргэдийг хамгаалах асуудал тавигдах нь дамжиггүй бөгөөд хэрхэн шийдвэрлэх, ямар зорилго агуулж буй нь судлаачдын сонирхлыг татсаар буй.

Батлан хамгаалах төсөв

Сүүлийн жилүүдэд Хятадын батлан хамгаалах салбарын төсөв тогтмол нэмэгдэж буй нь цэргийн шинэчлэлд ихээхэн ач холбогдол өгч буйн илрэл юм.

БНХАУ-ын 2018 оны батлан хамгаалах төсөв нь 1,107 тэрбум юань байсан бол 2019 оны төсөв өмнөх оноос 7.5 хувиар нэмэгдэв.¹⁸ Батлан хамгаалах төсөв нь 1989 оноос хойш 30 жилд 51 дахин, 2008 оноос хойш 10 жилд 2.7 дахин өссөн¹⁹.

Батлан хамгаалах шинэчлэлтэй холбогдуулан батлан хамгаалах төсөв 2011-2015 онд 2 оронтой тоогоор өсч байсан бол 2016 онд 7.6 хувь, 2017 онд 7 хувь, 2018 онд 8.1 хувиар тус тус өсчээ.²⁰ Хятадын батлан хамгаалах зардал 2012-2017 оны хооронд 669.192 тэрбум юаниас 1,043.237 тэрбум юань болж нэмэгдсэн.²¹

¹⁵ 新时代的中国国防。白皮书-2019. http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm

¹⁶ 中国的武装力量的多样化运用” 白皮书-2013. “维护海外利益”

¹⁷ 新时代的中国国防。白皮书-2019. http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm

¹⁸ “History proves China’s defense budget growth benefits world” http://www.81.cn/jwywpd/2019-03/07/content_9443095.htm

¹⁹ Japan Ministry of Defense “Defense of Japan”, 2018

²⁰ “History proves China’s defense budget growth benefits world” http://www.81.cn/jwywpd/2019-03/07/content_9443095.htm

²¹ 新时代的中国国防。白皮书-2019. http://www.mod.gov.cn/topnews/2019-07/24/content_4846387.htm.

Тус улс батлан хамгаалах төсвийг сургалт, дадлага, бие бүрэлдэхүүний хангалт, зэвсэглэл, техник гэсэн 3 үндсэн чиглэлд зарцуулжээ. Бие бүрэлдэхүүний хангалт гэдэгт чөлөөнд гарсан цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмж, офицер, ахлагч, байлдагч, гэрээт ажилтныцалин, нөхөн олговор, даатгал, хүнс, хувцас, хэрэгсэлийн зардал багтсан. Сургалт дадлага, өдөр тутмын зардал гэсэн ангилалд цэргийн сургууль дадлага, академик сургалт, анги нэгтгэл, байгууламжийн барилгын болон засварын болон бусад өдөр тутмын хангалтын зардлууд орно. Зэвсэглэл, техникийн зардал гэдэгт зэвсэг техникийн судалгаа, хөгжүүлэлт, туршилт, засвар, арчилгаа, тээвэр, хадгалалтын зардал багтаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад эрдэс баялгийн салбар дах төрийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд

Б.Нэргүй.

БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
докторант, дэд хурандаа

Түлхүүр үг: *Эрдэс, баялаг, уул уурхай, хариуцлагатай уул уурхай, хөгжил, ашигт малтмал, хууль эрх зүй, бодлого.*

Товч агуулга: Эрдэс баялаг, уул уурхайн салбарын үндэсний аюулгүй байдалд үзүүлэх эсрэг нөлөөллийг сайжруулах, түүний төрийн зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаарх сургамж, санал зөвлөмжийг энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд тусгав.

Монгол Улсын Үндсэн хуульд: “Монгол Улсад газар, түүний хэвлий, байгалийн ... баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна... иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг ... төрийн өмч мөн” гэж тунхагласан байдаг.

Иймд ашигт малтмал, газрын доорх баялгийг эрэх, хайх, ашиглахад үндэсний аюулгүй байдал, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, түүх, соёлын өв, хүний эрх, эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалахад үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг хянаж удирдах төрийн болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг онол, арга зүйн өндөр түвшинд, тухайн нөхцөл байдалтай уялдуулж, тал бүрээс нь шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, арга замыг оновчтой тодорхойлох шаардлага урган гарч байна.

Монгол Улсын ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүргийн талаар дүн шинжилгээ хийсэн судалгааны багийн тайланд дурдсанаар байгалийн нөөцтэй буюу гол төлөв газрын тос, эсхүл ашигт малтмалын нөөцтэй улс орнуудад авилга, дээд эрх мэдэл төвлөрөх, иргэний дайн зэрэг сөрөг үзэгдэл газар авах магадлал өндөр байдаг бөгөөд тийм улс орнуудын институцийн чанар дорой байдлыг нотлох хангалттай баримт бий бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлт удаашрах, хямрах, улс төр доройтоход хүргэдэг. Үүнийг “баялгийн хараал”, бас

зарим нь “голланд өвчин” гэж нэрлэж байна. Эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар “баялгийн хараал”-ын гол уршиг нь нийгмийн материал баялгийн хуваарилалтад нийгмийн шударга ёс зөрчигдөх, эдийн засгийн өсөлт саарах, улмаар нийгэм улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал бий болох, авилга газар авах зэргээр илэрдэг байна.

Зарим судлаачдын үзэж байгаагаар баялгийн хараалд өртөж буйн нэг илрэл нь улс орны эдийн засгийн өрөөсгөл, эмзэг байдал өсөх хандлага юм. Учир нь уул уурхайн үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолтод гадаадын ихээхэн хөрөнгө оруулалт, мөнгөний урсгал орж ирснээр эдийн засгийн бусад салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орох, алдагдал хүлээх, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдал алдагдах магадлал өндөр байдаг байна.

Дэлхийн зах зээл дээр үнийн хэлбэлзэл өндөр байдаг бүтээгдэхүүн бол уул уурхай, эрдэс баялаг, газрын тосны гаралтай бүтээгдэхүүн бөгөөд бүтээгдэхүүний үнэ өндөр байхад эдийн засгийн “хөөсөрсөн” өсөлттэй, харин үнэ унахад эдийн засаг хямрал, уналтад ордог байна. Эдийн засгийн буурай хөгжилтэй, ядуурал, ажилгүйдэл газар авсан улс орнууд эрдэс баялгаа барьцаалан зээл тавьсаар өрийн дарамтад ордог байна. Эрдэс баялгийн олборлолтын огцом өсөлтийн үед улсын төсөвт их хэмжээний мөнгөн хуримтлал үүсэх, хэрвээ түүний хуваарилалтад нийгмийн шударга ёсны зарчим алдагдах, улмаар нийгэмд баян хоосны ялгаа туйлдаа хүрэх нийгмийн тогтворгүй байдал үүсэх аюул учирна.

Өнөөдөр эрдэс баялгийн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 22 хувь, экспортын бүтээгдэхүүний 90 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 74 хувь, гадаадын хөрөнгө оруулалтын 72 хувийг дангаараа бүрдүүлж байгаа нь Монгол Улсын эдийн засаг “солонгорч” чадаагүй, өрөөсгөл байдал ажиглагдаж байна.

Эрдэс баялгийн зөв бодлого явуулж хөгжлийн шинэ шатанд гарсан Норвеги, Финланд, Австрали, Чили зэрэг улсууд эдийн засгийн бусад салбаруудаа жигд хөгжүүлж, уул уурхайн үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолтын эрх зүйн орчинг төгс бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг сайтар татаж, төрийн ухаалаг зохицуулалт хийж, олборлолтын дараах нөхөн сэргээлтийг чанартай хэрэгжүүлж, хөгжлийн сан бүрдүүлж, түүнийгээ ухаалаг зарцуулж, хуваарилалтын шударга зарчмыг хэрэгжүүлснээр томоохон ахиц дэвшилд хүрсэн жишээ бэлхэн байна.

Монгол Улс байгалийн баялагтай бусад орныг бодоход Үндсэн хуульт ардчилсан төрийн тогтолцоотой, иргэний нийгмийн тодорхой оролцоо, хяналттай, нэг үндэстэн давамгайлсан хүн амтай буюу баялгаас болж үндэстэн ястны зөрчил тэмцэл үүсэх магадлал багатай, эрт дээр үеэс байгаль эхээ шүтэн дээдлэх, хайрлан хамгаалах ёс заншил, уламжлалтай зэрэг нь баялгийн хараалд өртөхгүй байх давуу талууд юм.

Зарим судлаачдын үзэж байгаагаар төрийн өмчлөлд байгаа

ордын асуудал төр аж ахуйн ажиллагаанд шууд оролцох, бизнест хувь эзэмших үндэс болдог байна. Энэ байдал төрийн үйл ажиллагаа, авилгын нөхцөл байдал, засаглалын чанарт хэрхэн нөлөөлж байгаад дүн шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой юм.

Иймд “баялгийн хараал” тусч улс орны эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөхөөс сэргийлэх, хамгаалах төрийн цогц бодлого, үйл ажиллагаатай байх нь энэ цаг үеийн онцгой шаардлага болж байна. Юуны өмнө гадаадын хөрөнгө оруулалт, шинэ технологийг нэвтрүүлэх хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэхийн зэрэгцээ монополийн аливаа илрэл, зохион байгуулалттай, үгсэн хуйвалдах гэмт хэрэгтэй тууштай тэмцэх, улс орны эдийн засгийн аюулгүй байдал алдагдахаас, гадаадын үндэстэн дамнасан бүлэглэлүүдийн эрхшээлд орохоос хамгаалах тогтолцоог зүгшрүүлэх, (хууль, эрх зүйн зохицуулалт хамгийн оновчтой, тодорхой байх, эрх зүйн актуудын уялдаа холбоог сайжруулах, хийдэл, зөрчлийг арилгах замаар) шаардлагатай байна.

Байгалийн баялгаас олсон орлогыг шударгаар хуваарилах, иргэн бүрт баталгаатай хувь хүртээх эрх зүйн зохицуулалтыг бий болгож хэрэгжүүлэх нь баялгийн хараалаас зайлсхийх нэг гол арга зам бөгөөд зах зээлийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн улс төрийн үндэс нь парламентын засаглалын төлөвшил, түүний институцийн чадавх юм.

Уул уурхайн үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолтод улс төрчид, улс төрийн бүлэглэлүүдийн явцуу ашиг сонирхлоос ангижруулах замаар бизнесийн эрх чөлөөг хангах эрх зүйн тогтолцоо, арга хэрэгсэл чухал байна. Мөн уул уурхайн салбарын удирдлага, менежментийг боловсронгуй болгох, төр, олон нийт, иргэний нийгмийн оролцоо, хяналтыг бодитой хэрэгжүүлэх шаардлага ч байна.

Уул уурхайн үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолтонд хувь хүмүүсийн оролцоо, тэдний бичил олон уурхай, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотойгоор үүсч мэдэх зарим уршигт үзэгдлийг урьдчилан таамаглаагүй бас цаг тухайд нь эрх зүйн зохицуулалт хийж чадаагүйн нэг жишээ бол “Гар аргаар алт олборлогчдын нинжа нарын бүхэл бүтэн арми” бий болсон явдал юм. Тэд “царцааны нүүдэл” адил газар орныг ухаж сэндийчэн ухсан нүх, овоолсон шороо үлдээн сүйтгэж байна.

Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн баталсан. Шинэчилсэн журмаар Иргэний хуулийн дагуу нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орсон хуулийн этгээдийн ашиглах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 7 дахин нэмэгдүүлж, нөхөрлөл, бүртгэгдээгүй нөхөрлөлийг 9-өөс доошгүй гишүүнтэй байхаар журамлаж, тухайн талбай дах ашигт малтмалыг ашиглаж дуусах хүртэлх хугацаагаар олборлолтын гэрээг байгуулахаар тусгасан нь бичил уурхай эрхлэгчдийн бүтээмж, орлого, ажлын байрыг нэмэгдүүлэхээр тооцсон. Мөн бичил уурхайчид ашигт малтмал олборлож, тодорхой хэмжээний орлого олж байгаа Монгол Улсын иргэний хувьд хуулиар ногдуулсан албан татвар төлөх үүргээ биелүүлэх, нийгмийн халамж, хамгааллын болон төрийн үйлчилгээ авах

боломжийг бүрдүүлсэн. Нөхөн сэргээлтийг төлөвлөгөө, аргачлалын дагуу хийснээр бичил уурхайчдын нийгэм болон байгаль орчны хариуцлага сайжирч, иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. Мөн нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орж үйл ажиллагаа явуулах нь хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа “нинжа”, ХАМО буюу хувиараа ашигт малтмал олборлогчдоос ялгарах нөхцөл бүрдэх юм.

Эрдэс баялаг олборлогч орнуудын туршлага, сургамжаас үзэхэд байгалийн баялгаас олох орлогыг удирдан зохицуулах үйл ажиллагааны загварыг сонгох, түүнийг хэрэглэхдээ тодорхой судалгааны үр дүн дээр тулгуурлахгүй бол нэгдсэн төсвийн хүрээг эвдэж, тогтворгүй байдалд оруулах, мөнгөн хөрөнгийн удирдлагын урсгалыг замбараагүй болгож үндсэн горим нь үйлчлэхгүй болгох эрсдэлд хүргэж болох талтай. Түүнчлэн мэдээллийн дэд бүтцийн хөгжлөөс шалтгаалж дээр дурдсан зарим механизм нь сөргөөр үйлчилж, төсвийн санхүүжилтийг эдийн засгийн үр ашиг, нийгмийн үр нөлөө талаас нь үнэлж, өрсөлдөөний горимоор хуваарилах зарчмыг алдагдуулах, улмаар төсвийн тогтсон үр дүн бүхий бүтцэд саад болох тохиолдол үүсч болзошгүй юм.

Тиймээс байгалийн баялгийн ашиглалтаас орох орлогын удирдлагыг сайжруулахад дэмжлэг болохуйц системийг бүрдүүлэхдээ дараах шаардлагыг хангасан байх ёстой гэж үздэг. Үүнд:

1. Эрдэс баялгийн салбараас орох орлогыг нэр төрөл, тоо хэмжээ, эзлэх хувийн жин, түүний өөрчлөлтийг хамруулж дэлгэрэнгүй бөгөөд ил тод байдлаар тайлагнадаг байх, ингэхдээ төсвийн ашигт малтмал / эрдэс баялгийн бус алдагдлыг үнэн зөв тодорхойлж, уг алдагдлыг чухам ямар эх үүсвэрээс хэрхэн санхүүжүүлэх тооцоог тусгайлан тооцдог байх, төсвийн эрдэс баялгийн бус алдагдалд онцгой анхаарч, дунд, урт хугацааны бодлогоор хэрхэн бууруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг байх;
2. Төсвийн урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх стратеги, бодитой тооцсон дунд хугацааны төсвийн төсөөлөл, стандартчилж тогтоосон төсвийн ангилал мөрддөг байх;
3. Төсвийн ашигт малтмалын бус алдагдлыг санхүүжүүлэхэд зориулж төрийн сангаас хийх орлогын шилжүүлэг ил тод, горим нь уян хатан байх;
4. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гаргах үйл ажиллагаа нь тусгайлан тогтоосон бүртгэл, тайлагналын зориулалтын механизмуудыг зөрчихгүй байх, төсвийн мөнгөн гүйлгээний урсгалын зохистой удирдлагыг банкинд төвлөрсөн журмаар байршуулсан төрийн сангийн нэгдсэн дансаар явуулдаг байх;
5. Улсын санхүүгийн удирдлагын шинэчлэлийн хөтөлбөрийг олон улсын шилдэг практикт суурилж боловсруулан бодлогын түвшинд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үздэг байна.

Уул уурхайн үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолтод төрийн бодлого, үйл ажиллагааны өөр нэг чухал зарчим бол байгаль эхдээ

ээлтэй хандаж, ногоон хөгжлийн бодлогыг тууштай баримтлах зарчим гэж үзэж байна.

Монгол Улсын эрдэс баялгийн салбарыг төрийн тууштай бодлого чиглэлтэй, зөв зохистой удирдвал үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхгүй хөгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд энэ байдлыг хангахад төрийн зохицуулалт, эрх зүйн орчинг оновчтой болгох нь тус салбарыг Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөлгүй хөгжүүлэх боломж бүрдэх юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангахад эрдэс баялгийн салбар дах төрийн зохицуулалтыг боловсронгуй болгох, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

1. Төрийн тогтолцоог боловсронгуй болгох /шинэ шатанд гаргах, тогтолцооны шинэчлэл хийх/, төрийн, төрийн бус байгууллага, салбар, салбар хоорондын ажлын уялдааг хангах, засаглалыг сайжруулах.
2. Уул уурхайгаас хамаарах шууд хамаарлыг бууруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг /өсөлтийг/ хангах.
3. Эрдэс баялгийн салбар дах төрийн оролцоог зохистой түвшинд хадгалах /барих/.
4. Монгол Улсын уул уурхайн үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолтод гадаадын нэг улсын хөрөнгө оруулалтын дээд хэмжээг хуульчлан тогтоох.
5. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоог хангах замаар хяналтын тогтолцоог сайжруулах.
6. Ашигт малтмалын шинэ орд газруудыг нээх, уул уурхайн бүтээгдэхүүнийг түүхий эд (хүдэр) байдлаар экспортлохыг хязгаарлах, үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүн (зэс, аранжин зэс, шингэн түлш, баяжмал гэх мэт) үйлдвэрлэх улс орны экспортын хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр өгөөжийг нь сайжруулах чиглэлээр хөгжүүлэх.
7. Уул уурхайн үйлдвэрлэл, эрдэс баялгийн олборлолтын явцад түүх соёл, археологийн үнэт дурсгалын зүйлс эвдрэх, алдагдахаас сэргийлэх, хамгаалах эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, энэ талаарх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх.
8. Уул уурхайн үйлдвэрлэлд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, шинэ техник технологийг нэвтрүүлэхийг дэмжсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаадын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, олон нийтийн хяналт оролцоог идэвхжүүлэх.
9. Бичил уурхай эрхлэх, ялангуяа гар аргаар алт, бусад төрлийн ашигт малтмал олборлох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, тэдгээрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх.
10. Салбарын хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах,

өмнө нь тодорхой бус зохицуулалтаас үүсч байсан хүндрэлтэй асуудлуудыг нэг мөр болгох замаар хуульд олон удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулдаг явдлыг арилгах, улмаар таслан зогсоох.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Ашигт малтмалын тухай хууль;
2. Б.Гүнбилэг, И.Идэш. Эрдэс баялгийн эрх зүйн тойм. УБ, 2012. ХЗҮХ. ISBN 978-99962-57-32-2 ;
3. Байгаль орчин, геологи, уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл. УБ, 2014;
4. Д.Батчимэг. “Уул уурхайн компаниудын татварын эрсдэлийг бууруулах нь” 2017;
5. Ж.Төртогтох, Д.Мягмарсүрэн. “Байгалийн нөөцтэй хөгжиж буй орнуудын улс төрийн харьцуулсан судалгаа” 2015;
6. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан. ҮСХ, 2015-2016 он;
7. П.Очирбат. Хүүгээ номтой хүн болгоорой. УБ, 2012. ISBN 976-99962-0-653-5;
8. Т.Баасанпүрэв. “Монгол Улсын уул уурхайн татварын орчны судалгаа” 2008;
9. Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2011 оны 65 дугаар тогтоол;
10. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоол;
11. У.Дөлгөөн. “Уул уурхайн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналд нийгмийн хариуцлагын тайлагналыг нэвтрүүлэх нь” 2015;
12. ШУА-аас зохион байгуулсан “Монголын археологи-2016” эрдэм шинжилгээний хурал. УБ. 2017 он.;
13. Экологийн дуудлага: Оршихуйн эрх зүйн баталгаа. ОУЭШХ-ын эмхэтгэл. УБ, 2012 он. ISBN 978-99962-2-302-0;
14. Эрдэс баялгийн салбар дах төрийн бодлого, хууль, дүрэм, журмын эмхэтгэл. УБ, 2015;
15. “Уул уурхайн байгаль орчны хамгаалалт, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын тооллого” сэдэвт семинарын тайлан УБ. 2018.4.26;
16. “Эрдэс баялагийн олборлолт ба Үндэсний аюулгүй байдал” сэдэвт суурь судалгааны төсөл (2016-2018). УБ, 2019 он;
17. Ацуци Имий. “Байгалийн хараалаас зайлсхийх нь: Ботсван ба бусад орнуудын туршлага”. ОУВС. 2007 он.

Хүний аюулгүй байдалд насжилт нөлөөлөх нь

Д.Энхчимэг

ҮБХИС-ийн АБС-ийн Эдийн засаг, менежментийн
тэнхимийн багш, доктор (Ph.D)

М.Индрабүд

ҮБХИС-ийн АБС-ийн Эдийн засаг,
менежментийн тэнхимийн багш

Хураангуй: Дэлхийн хэмжээнд хүн төрөлхтөнд нийтлэг тулгарч буй асуудал нь хүн амын насжилт уртсах үзэгдэл юм. Хүн амын насжилтын үр дагавар нь гэр бүл, нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, улс төрийн салбарт болон бие хүний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлов. Ингэхдээ орчин үед хүн амын насралтын хурд харилцан адилгүй байгааг хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудаар нь харьцуулан судалсан. Монгол Улсын хувьд улсын төсөвт 2025-2050 онуудад нийгмийн хамгааллын зардал нэмэгдэнэ. Эцэст нь өндөр настангуудад ирээдүйд технологид суурилсан амьдралын орчин нөхцөлд эрүүл мэнд, эд хөрөнгийнхөө төлөө өөрийгөө аюул заналаас халхлах нийгэм бие хүний чадвар бэлэн байх шаардлага тулгарна.

Түлхүүр үг: Насжилт, дундаж наслалт, өндөр насжилт, хүний аюулгүй байдал.

Оршил

Дэлхийн хүн амын өсөлттэй уялдан хүн төрөлхтөнд тулгарч буй нэг асуудал нь өндөр настангуудын тоо улам нэмэгдэж байгаа явдал юм. НҮБ-ийн мэдээгээр 1950-аад оны эхэнд 70-аас дээш настай дэлхий хүн амын дөнгөж 1%-ийг эзэлж байсан бол 2000-аад оны эхээр 50 хувиас дээш давсан байна. Энэ эрчимээр тэтгэвэрийн насныхны тоо нэмэгдвэл хүн ам зүйчдийн үнэлгээгээр 2050 он гэхэд тэдний тоо 2 тэрбумд хүрч өндөр настнуудын тоо 15 хүртэл насныхныг давж байгаа юм. Дэлхийн өндөр настай хүмүүсийн тоо жил тутам 2-2,8 хувиар өснө гэж зарим шинжээчид таамаглаж байна.

XXI-р зууны дунд үе гэхэд өндөр настай хүмүүсийн тавны нэг нь 80, түүнээс дээш настай болно гэсэн албан бус мэдээлэл байна. Манай улсад 65-аас дээш насны хүн ам ахмад насны бүлгийн нийт хүн амд эзлэх хувь өндөр хөгжилтэй улс орнуудтай харьцуулбал бага боловч цаашдаа насжиж буй нийгэмрүү шилжих урьдчилан шилжих төлөв харагдаж байгаа юм. Статистикийн судалгаа хүн амын 2008-2030 оны хэтийн

тооцооноос үзвэл Монгол Улсын нийт хүн амд эзлэх нийт 60-аас дээш насны хүн амын хувийн жин 2025 оноос эхлэн 10 хувиар өсөх тооцоо гарч, хүн амын насжих үйл явц эрчимтэй явагдаж эхлэх ба 65-аас дээш насны ахмад настан 2030 оноос эхлэн 7,6 хувийг эзлэхээр байна. Түүнчлэн хүн амын төрөлтийн бууралт, дундаж насны өсөлт нь хүн амын бүтэц, тархалтыг ихээхэн өөрчилнө гэж судлаачид үзэж байна. Монгол хүний дундаж наслалт 2011 оны байдлаар 68.35 жил, үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт - 64,8, эмэгтэйчүүдийн дундаж наслалт-71.9, цаашдаа 2020 он гэхэд дундаж наслалт - 71,1-д хүрч, үүнээс эрэгтэйчүүд 68,8 жил, эмэгтэйчүүд 73,4 жил болж уртасах төлөвтэй байна.

XVI-XVIII зууны дунд үед хүн 30-40, XX-р зууны эхэнд 50 жилээр хязгаарлагдаж байсан бол одоо энэ үзүүлэлт 70-д ойртож байна. Энэ давтамж тасралтгүй үргэлжилнэ гэж үзвэл 2001 онд 600 сая орчим өндөр настан байсан бол 2025 онд 1.2 тэрбумд /түүний дотор 80-аас дээш насныхан 137 сая/ улмаар 2050 онд нийт хүн амд эзлэх ахмад настан дийлэнх нь хүүхэд насныханы эзлэх хувиас давж ирнэ гэсэн төсөөлөл байгаа нь хөдөлмөрийн чадвартай хөдөлмөрийн насныхны тоо багасаж, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжууд хязгаарлагдах, ялгаварлан гадуурхалт ихсэх хандлагатай байгаа нь хүний цаашлаад нийгмийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлнэ гэж зарим судлаачид харж байна.

Үндсэн хэсэг

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг гадаадын түрэмгийллээс нутаг дэвсгэрээ хамгаалах, гадаад бодлогод, үндэсний эрх ашиг сонирхлоо хамгаалах, цөмийн сүйрлийн аюулаас дэлхий дахиныг хамгаалах зэргээр ойлгодог. Хүний аюулгүй байдал нь нутаг дэвсгэрийн буюу улс үндэстний аюулгүй байдал төдийгөөр хязгаарлагдахгүй бөгөөд бас хүмүүсийн өдөр тутмын амьдрал дахь аюулгүй байдлын асуудлуудыг ч хамардаг. Үүнийг тодорхой гачигдал зовлонгоос, эсвэл төсөөлөгдөж буй айдас хүйдсээс ангид буюу чөлөөтэй байх явдал хэмээн томёолох болсон. Глобальчлалын үеийн аюулгүй байдлыг янз бүрээр тодорхойлж байна. Тухайлбал:

1. Улс төрийн аюулгүй байдал буюу Монгол Улсын оршин тогтнохын болон нийгэм, төрийн байгууллын аюулгүй байдал;
2. Иргэний эрх, эрх чөлөөний болон бие хүний аюулгүй байдал;
3. Эдийн засгийн аюулгүй байдал;
4. Шинжлэх ухаан, техник технологийн аюулгүй байдал;
5. Мэдээллийн аюулгүй байдал;
6. Соёл иргэншлийн болон нийгмийн байгууллын аюулгүй байдал;
7. Хүн ам, удмын сангийн болон эрүүл мэндийн аюулгүй байдал;
8. Экологийн аюулгүй байдал;
9. Хүнсний аюулгүй байдал гэх мэт.

Хувь хүний аюулгүй байдал гэдэг нь: амьдрал, эрүүл мэнд эд,

хөрөнгийнхөө төлөө, өөрийгөө аюул заналаас халхлах, чөлөөлөх тэрчлэн иргэн хүний суурь үнэт зүйл болох хуульчилсан эрх, эрх чөлөөг хамгаалах улс, нийгэм, бие хүний чадвар, бэлэн байдал юм.

Дундаж наслалт гэдэг нь /Life expectancy/ шинээр төрсөн хүүхдийн үргэлжлэн амьдрах дундаж хугацааг илэрхийлсэн буюу цаашид урт наслах магадлалыг урьдчилан тооцсон ойлголт юм. Өөрөөр хэлбэл хувь хүний насжилт гэдэг нь цаг хугацааны урсгалаа дагаад хувь хүний бие махбодид биологийн өөрчлөлт гарч амьдрах хугацаа уртсах үзэгдлийг хэлнэ.

1951 оны грентологийн олон улсын 2-р их хурлаас “Хөгшрөлтийн үйл явцад илрэн гарч байгаа биологи, сэтгэл зүйн орчны өөрчлөлт ба үйл ажиллагааны өөрчлөлтийн харилцан хамаарлын холимог нөхцөл байдалд байгаа хүн” хэмээн тодорхойлсон бол Английн сэтгэл зүйч J.E.Birren /1959:3-42/ ахмад настны талаарх өргөн хүрээтэй тодорхойлолтыг санал болгосон байдаг. Тэрээр бие махбодь биологийн хувьд доройтож байгаа хүн, нийгмийн шинж чанар талаасаа сэтгэл зүй, зан чанарын төлөв байдал өөрчлөгдөж байгаа хүн, нийгмийн шинж чанар талаасаа нийгмийн байр суурь хувь хүний эрх чөлөө, ур чадвар, нийгмийн үүргээ алдаж байгаа хүн гэж үзжээ. Харин Монгол улсын хувьд 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэйг ахмад настан гэж нэрлэдэг.

Нас ахихын хирээр бие махбодийн гадаад болон дотоод орчинд өөрчлөлт маш ихээр явагдаж байна. Хөгшрөлтийг дагаад тухайн хүний эрхтэн мэдрэхүйн тогтолцоо, цусны даралт, амьсгалах эрхтэн, бодисын солилцооны эрхтэнд өөрчлөлт орж нойргүйдэл амьсгалын үйл ажиллагааны доройтлыг бий болгоно. Мөн бие физиологийн хувьд:

- Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өөрчлөлт
- Амьсгал цусны эрхтэн тогтолцооны өөрчлөлт
- Яс булчингийн тогтолцооны өөрчлөлт
- Нөхөн үржихүй бөөр шээсний замын өөрчлөлт
- Арьсны өөрчлөлт
- Мэдрэхүйн эрхтний өөрчлөлт

Сэтгэл зүйн хувьд:

- Ганихрах шинж тэмдэг
- Идэвхигүй байдал
- Хөшүүн байдал
- Болгоомжтой хянуур байдал
- Бусдын гар харах бусдад түшиглэх байдал
- Удаан хэрэглэсэн эд юмсдаа ижилдэн дасах байдал бий болдог байна.

Насжилтын биологийн шалтгааныг тайлбарладаг онол

	Онол	Гол агуулга
Эсийн ба удамшлын онол	Элэгдлийн онол (Thermomechanic)	Биемахбодь эд эрхтний доройтлоос үүдэлтэй хөгшрөлт
	Хуучин эд хуримтлалын онол (the waste accumulation theory)	Эсийн доторх хортой болон эд эсийн нөхөн үйлдвэрлэл, хуримтлагдсан эсийн тогтмол үйл ажиллагаанаас үүдэлтэй хөгшрөлт
	Огтолцлолын онол (Cross-linkage theory)	Эсийн гадаад дотоод элементүүд харилцан өөр хоорондоо наалдан хөдөлж чадахгүй болсноор химийн хариу урвалд орж бүтэц нь уян хатан байдлаа алдсанаас үүдэлтэй хөгшрөлт
	Удамшлын онол (Gene theory)	Эс нь цацраг туяа зэргээс шалтгаалан гэмтэл авснаар хувирч, хөгшрөлт явагдана.
	Задрал хуваагдлын онол (Hayflick theory)	Эсүүд задарч, цаг хугацаанаас хамааран эсийн хөгшрөлт явагдана.
	Удамшлын зохицуулах онол (Gene theory)	DNA дотор хөгшрөлтийн талаарх урьдчилсан мэдээлэл өгөгдсөнөөс тодорхой цаг хугацааны дагуу явагдаж буй үйл явц

Насжилтын сэтгэл зүйг тайлбарладаг онол

Онол	Гол агуулга
Navighurst-ийн хөгжлийн онол	Ахмад үеийн хөгжлийг: 1. Хөгшрөлтийн үеийн эрүүл мэндийн байдалд дасан зохицох; 2. Тэтгэвэрт гарах буюу орлого буурахад дасан зохицох; 3. Хань ижлээ алдахад дасан зохицох; 4. Үе чацуутан үеийнхэний харлцаа бэхжих; 5. Нийгмийн үүрэг өөрчлөгөдөхөд дасан зохицох байдал; 6. Амьдралд ая тухтай орчин бүрдүүлэх гэсэн үе шатуудад хуваагдана.
Clark&Anderson-ий дасан зохицлын онол	Ахмад настны дасан зохицлыг: 1. Хөгшрөх үзэгдэлтэй хамааралтай үзэл баримтлал, үйл ажиллагааг ухамсарлах; 2. Нийгмийн дэмжлэг үзүүлэх; 3. Сэтгэл ханамжгүй байсан өмнөх байдлыг өөрчилж сэтгэл ханамжтай болоход чиглүүлэх; 4. Ахимаг насны амьдралд тохирсон амьдралын зорилго, үнэт зүйлийг шинээр бий болгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн үзсэн.

<p>Erikson-ий нийгэм сэтгэл зүйн хөгжлийн онол</p>	<p>Ахмад настны хөгжлийн үе шатанд “хэвийн эсвэл гутрах” үзэгдэл илэрдэг хэмээн үздэг бөгөөд энэ нь өнгөрсөн, одоо ирээдүйн үеийн амьдралдаа хүсэж байснаараа амьдарсан хэмээн үзэх сэтгэл ханамжтай байвал ойртон байгаа үхэлтэй эвлэрэх хандлагатай байна, харин өнгөрсөн болон одоогийн амьдралдаа гэмшсэн байдалтай байгаа бол дахин нэг удаа боломж олдвол өөрөөр амьдархсан хэмээн бодож үлдсэн хугацаагаа сэтгэл дундуур, тогтворгүй, түгшиж зовсон байр суурьтай өнгөрүүлэх болдог нэмээн үздэг.</p>
<p>Salthouse-ийн нөөц баялаг буурах онол</p>	<p>Наслалтын үед мэдээллийг цэгцлэх танин мэдэхүйн чадвар буурна хэмээн үздэг.</p>
<p>Miller-ийн зогсонги байдлын онол</p>	<p>Ажил хөдөлмөрийн үүрэг нь хувь хүний зогсонги байдал, хямралыг гаргах үндэс юм. Тэтгэвэрт гарах нь хөдөлмөрийн үүргийг бууруулж, нийгмийн үүрэггүй болгох бөгөөд энэ нь хүн өөрийгөө хөгжүүлэх, өөрийгөө хүндэтгэх байдалд сөргөөр нөлөөлж хямралт байдалд оруулдаг хэмээн үздэг. Ахмад насны үеийн зогсонги байдлыг бууруулахад: 1. Өөрийн үйл ажиллагааг орлуулан хэрэгжүүлэх хэрэгцээ; 2. Нийгмийн тогтвортой байдлыг бий болгож чадах чөлөөт цагийн үйл ажиллагаа ба оролцоо чухал.</p>
<p>Atchey-ийн зогсонги байдлын онол</p>	<p>Зогсонги байдал нь янз бүрийн шалтгаанаас үүдэн гардаг бөгөөд тэтгэвэрт гарсны дараа ч үүрэгтэй холбоотой зогсонги байдал үргэлжилсээр байдаг. Ахмад настанд шинжихтэй зэрэгцэн бодит байдал дээр олон талын өөрчлөлт гардаг бөгөөд энэ өөрчлөлт нь чөлөөт амьдрал, сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.</p>
<p>Tomstam-ийн өтөл насыг даван туулах онол</p>	<p>Ахмад насны үед цаг хугацаа, орон зайн, амьдралын талаарх ойлголт ухамсар өөрчлөгдөж үхлийн талаар айдас үгүй болж түүх, нийгэм, соёл иргэншил, амьдралын утга учрын талаар сонирхол нэмэгдэнэ.</p>

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл.

Насжилтыг тайлбарладаг нийгмийн онол

<p>Онол</p>	<p>Гол агуулга</p>
<p>Үйл ажиллагааны онол (Activity theory)</p>	<p>Ахмад насны үе: биемахбодь нийгэм орчноо дагаад үндсэн үүрэг нь буурах эсвэл алдах болон хижээл насны үе шиг олон төрлийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцоноор өөрийгөө хөгжүүлэх болон хэвээр хадгалах, наслалтанд амархан дасан зохицох боломжтой.</p>
<p>Тусгаарлах онол (Separation theory)</p>	<p>Ахмад насны үед нийгмийн солилцоо буюу үйл ажиллагааны хүрээ хумигдаж нийгэмд тэднийг үл хайхрах, тусгаарлах асуудал үүснэ.</p>

Тасралтгүй үргэлжлэх онол (Continuance theory)	Хүн нас биед хүрч, өөрийн зан чанар, амьдралын дадал зуршлаа хадгалж нас ахисан ч өмнөх үетэй адил сэтгэлгээгээр амьдарч сэтгэл ханамж өснө.
Стрессийн онол (Stress theory)	Ахмад настан хань ижлээ алдах, тэтгэвэрт гарах зэргээс хамааран стресст өртөж, хариу үйлдэл дутмаг бол стрессийн түвшин өндөр болно. Стрессийн талаарх ойлголт, авах арга хэмжээ нийгмийн дэмжлэгийг дагаад стрессийн түвшин өөрчлөгдөнө.
Шошгоны онол (Labeling theory)	Нийгмийн зүгээс ахмад настнуудыг үйлдвэрлэлд оролцуулахгүй, ашиггүй хэмээн үзсэнээр тэд нийгмийн энэхүү хандлагад зохицон үйл ажиллагаагаа чиглүүлэх шаардлагыг үүсгэдэг.

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл.

Наслалт, ажил эрхлэлт

Нас амьдралын давтамж	0-10	11-20	21-30	31-40	41-50	51-60	61-70	71-80	81-90
	Нярай хүүхэд	Өсвөр нас	Насанд хүрэгсэд		Насанд хүрсний дараа		Өндөр настан		
Ажил эрхлэлт	Бэлтгэх	Хэрэгжилт	Ажлаа сонгох	Хамгийн идэвхитэй оролцоо	Тэтгэвэрт гарах бэлтгэл		Тэтгэвэрийн эхэн үе	Тэтгэвэрийн үе	
Гэр бүл	Гэр бүлийн асаргаа		Гэрлэлт бие даах	Хүүхэд өсгөн бойжуулах		Бага хүүхэд бие даах	Гэр бүлийн хүн нас барах ганцаардах		
Эдийн засаг	Түшиж найдах		Бие даасан байдал Санхүүгийн байдал				Түшиж найдах		

Хүн амын насжилт эдийн засаг - нийгэм соёлд нөлөөлөх нь:

Хүн амын насжилтын үр дагаварыг хувь хүнээс гадна гэр бүл, нийгмийн үндсэн нэгжид хамааруулан ойлгох төдийгүй нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, улс төр нийгмийн хамгаалал зэрэг олон салбарт нөлөөлдөг байна.

Хувь хүний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл нь:

1. Эрүүл мэндийн байдал - насны доройтод, өвчлөл, хөгжлийн бэрхшээлтэй болох;
2. Эдийн засгийн байдал - Цалин орлого буурснаар амьдралын өдөр тутмын болон чөлөөт цагийг өнгөрүүлэхтэй холбоотой үүсэх зардлууд;

3. Ганцаардал ялгаварлал - Хань ижлээ алдах, гуньж гутрах

Гэр бүлд үзүүлэх нөлөө нь:

1. Асруулагчийн зардал - ганц бие ахмад настан нэмэгдэх, үр хүүхдээс тусгаар амьдрах, эрүүл мэнд доройтох нь гэр бүлд олон асуудлыг үүсгэдэг;
2. Эмчилгээний зардал - Эрүүл мэндийн үйлчилгээний зардал нь гэр бүлд томоохон үүрэг гүйцэтгэдэг;
3. Амьдрах орчин гэр бүл тогтолцооны үүрэг - ахмад настанд тохирсон орон байрыг бий болгох;
4. Гэр бүлээс гадуурх үйлчилгээний зардал - нийгэмд хамт олонд түшиглэсэн төрөл бүрийн үйлчилгээний зардал нэмэгдэнэ.

Нийгэмд нөлөөлөх байдал:

1. Нийгмийн даатгал тэтгэвэр, тэтгэмжийн үүрэг - ахмад настны тоо нэмэгдэх түүнийг даган тэтгэвэр тэтгэмж авах цаг хугацаа уртасах;
2. Туйлын болон харьцангуй ядуурал - Ядуу, нэн ядуу, ахмад настны тоо эзлэх хувийн жин өсөхөд тэдний орлогын баталгаа, эмчилгээний зардлыг хариуцах нийгмийн халамж дэмжлэгийн үүрэг өсөн нэмэгдэнэ;
3. Амьдралын чанарыг өсгөх, хэрэгцээг хангах зардал - Ахмад настныг хөгжүүлэх, амьдралын ая тухтай байдлыг бий болгох төрөл бүрийн үйлчилгээний зардал өснө;
4. Олон талт хэрэгцээнд тохирсон хариу үйлчилгээ - Ахмад настны үйлчилгээг шийдвэрлэхийн тулд нийгмийн халамжийн үйлчилгээг шинэчлж, төрийн болон төрийн бус байгууллага, салбарын оролцоотой зах зээлийн зарчимд нийцүүлэн хөгжүүлэх хэрэгцээ нэмэгдэнэ;
5. Тогтолцооны өөрчлөлт - Уламжлалт амьдралын мөчлөг, ахмад настны талаарх ойлголт, хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор нийгмийн хамгаалал халамжийн тогтолцоог тухайн цаг үетэй нь уялдуулан өөрчлөн шинэчлэх шаардлагатай.

Нийгмийн салбарт нөлөөлөх байдал:

1. Ганц бие ахмад настан нэмэгдсэнээр хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний тэнцвэр алдагдана;
2. Хуулиар тогтоосон тэтгэвэрт гарах насны хязгаарыг хойшлуулах шаардлага гарч болох эсвэл тэтгэвэрийн нас хэмээх ойлголт заавал хуульчлахгүй байх гээд асуудал гарна;
3. Хүн амын насжилт ба чиг хандлага өөрчлөгдөнө;
4. Ахмад, залуу үеийнхэний зөрчил ихсэж нөгөө талаас ахмад настны бүлгийн нэгдэл сайжирна;
5. Төрөлтийг дэмжих төрөл бүрийн хөтөлбөрийн хэрэгцээ

нэмэгдэнэ;

6. Ахмад настны хувийн болон нийгмийн үүргийг нөхөн сэргээх хэрэгцээ нэмэгдэнэ;
7. Хүрээлэн байгаа орчны зохицуулалт /хөршийн холбоо, сургууль, нийгэм хамт олон, орон нутаг/ гэх мэт;
8. Өдөр тутмын амьдралд шаардлагатай үйлчилгээний хэрэгцээ шаардлагын өсөлт /нийтийн тээврийн асуудал, арүүл мэндийн оношилгоо, үйлчилгээний газар, чөлөөт цагийн үйл ажиллагааг дэмжих байгууллага/ гэх мэт.

Эдийн засгийн салбарт нөлөөлөх байдал:

1. Хөдөлмөрийн зах зээлийг шинэчлэх, уян хатан байлгах шаардлага бий болно;
2. Хуримтлал ба үйлдвэрлэл буурна;
3. Хүн амын санхүүгийн үйл ажиллагааг дэмжих үйл ажиллагаа нэмэгдэнэ;
4. Ахмад настны орон сууцны хэрэгцээ өснө.

Соёлын салбарт нөлөөлөх байдал:

1. Шинэ соёлын үзэгдэл: ахмад үеийн амьдралын утга учир, мэдлэгийн өөрчлөлт;
2. Ахмад настны чөлөөт цаг, соёл, ахуйн хөгжлийг хангах асуудал

Боловсролын салбарт нөлөөлөх байдал:

1. Насан туршийн боловсролыг дэмжих тогтолцоо, хөтөлбөр;
2. Хөдөлмөрийн зах зээлд оролцох, шинэ мэргэжлээр дахин сургах, хөдөлмөр эрхлүүлэх;
3. Мэдлэг мэдээллийн системийн өөрчлөлтөнд дасан зохицох, цахим орчноос мэдээлэл авах ур чадвар, боловсролыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Улс төрийн салбарт нөлөөлөх байдал:

1. Ахмад настан, ахмадын бүлгийн улс төрийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, ахмадын лобби бүлгийн үйл ажиллагааг дэмжих;
2. Нийгмийн асуудлыг бууруулах улс төрийн хүч нөлөө, оролцоог дэмжих гэх мэт.

Одоогийн байдлаар 65-аас дээш насны ахмад настны бүлгийн нийт хүн амд эзлэх хувиас хамааруулан 2 төрлийн нийгмийн ангилалыг улс орнуудад хэрэглэж байна.

1. UN /1956/ 65-аас дээш насны ахмад настан нийт хүн амд 7-оос дээш хувийг эзэлж байсан бол насжсан үндэстэн, 4-7 хувь бол идэр насны хүн амтай үндэстэн, 4 хувиа бага бол залуу хүн амтай үндэстэн;

65-аас дээш насны хүн ам 7-14 хувийг эзэлж байгаа бол насжиж буй нийгэм, 14-21 хувь бол насжсан нийгэм, 21-ээс дээш бол хэт насжсан нийгэм хэмээн 3 хэлбэрт авч үздэг.

№	Нийт хүн ам 65-аас дээш насны хүн амын эзлэх хувь	Нийгмийн ангилал
1	4%-өөс бага	Залуу нийгэм
2	4-7%	Идэр нийгэм
3	7-14%	Насжиж буй нийгэм
4	14-21%	Насжсан нийгэм
5	21%-ээс дээш	Хэт насжсан

Орчин үед хүн амын наслалтын хурд харилцан адилгүй явагдаж байна. Жишээ нь Франц улс 1864 онд анх нийт хүн амын 7% нь ахмад настны бүлэг эзэлж насжиж буй нийгэмд шилжээд-115, Итали улс-61, Англи улс -47, Герман улс -40, БНСУ-18 жилийг тус тус өнгөрөөсөн бол Япон улс 2006 онд, Итали 2007 онд, Герман улс 2012 онд ахмад настны эзлэх хувь 20-д хүрч хэт насжсан нийгэмд шилжиж байна.

Насжилтын хурд (улс орноор)

Улс орнууд	Ахмад настны эзлэх хувьд хүрсэн он			Өсөлт явагдаж байгаа хугацаа	
	7%	14%	20%	7%-14%	14%-20%
Япон	1970	1994	2006	24	12
Франц	1864	1979	2020	115	41
Герман	1932	1972	2012	40	40
Англи	1929	1976	2021	47	45
Итали	1927	1988	2007	61	19
АНУ	1942	2013	2028	71	15
БНСУ	2000	2018	2026	18	8
Монгол	2020	2040	2050	20	10

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл.

Дэлхийн улс орон болон Монгол Улсын хүн амын насны бүтэц, эзлэх хувь

Он	Дэлхийн улс орнууд				Он	Монгол улс				
	Хүн амын бүтэц хувь					Хүн амын бүтэц хувь				Ах.настны ачаалал
	0-14	15-64	65+	Нийт		0-14	15-64	65+	Нийт	
1960	36.9	57.8	5.3	100.0	1960	39.1	54.2	6.1	100.0	-
1970	37.5	57.1	5.4	100.0	1970	43.4	49.3	6.3	100.0	-
1980	35.3	58.8	5.9	100.0	1980	43.8	43.8	6.1	100.0	-
1990	32.6	61.3	6.1	100.0	1990	41.9	41.9	4.0	100.0	10.3
2000	30.3	62.8	6.9	100.0	2000	33.8	33.8	3.4	100.0	5.7

2010	26.9	65.4	7.7	100.0	2010	28.4	28.4	3.8	100.0	5.8
2020	25.1	65.5	9.4	100.0	2020	27.0	27.0	4.7	100.0	8.8
2030	23.0	65.3	11.7	100.0	2030	22.9	22.9	7.6	100.0	11.5
2040	21.0	64.7	14.3	100.0	2040	-	-	-	100.0	-
2050	19.9	36.9	16.2	100.0	2050	-	-	-	100.0	-

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл.

Дээрх баримтаас харахад дэлхийн нийт хүн амд 65-аас дээш насны хүн ам 1950 оны үед 131 сая буюу дэлхийн нийт хүн амын 5.2 хувийг эзэлж байсан бол 2010 онд 529 сая буюу 7.7 хувь, 2030 онд 977 сая буюу 11.7 хувь, 2050 оны үед 1492 сая буюу 16.2 хувийг эзэлж аажмаар өсөхөөр байна.

XX-р зуун гарснаар хүний дундаж наслалт нэмэгдэж 1980-аад онд дэлхий нийтээр энэ хугацаа 60, 2000 онд 66 хүрч уртассан. Тухайлбал: өндөр хөгжилтэй орнуудын хувь хүний дундаж наслалт 2005-2010 оны үед 76.5 жил байсан бол 2045-2050 онд 79.4 жил, хөгжиж буй улс орнуудын хувьд 74.3 жил болох төлөвтэй байна. Цаашдаа зарим улс орнуудын хувьд хүний дундаж наслалт 80 жилээс хол давах боломжтой болохыг доорх тоо баримтаас харж болох юм. Үүнд:

Ангилал	Хүйс	2005-2010	2015-2020	2025-2030	2035-2045	2045-2050
Өндөр хөгжилтэй улс орнууд	Эрэгтэй	72.9	74.7	76.5	78.0	79.4
	Эмэгтэй	80.2	81.6	83.0	84.2	85.4
	Нийт	76.5	78.2	79.8	81.1	82.4
Хөгжиж буй улс орнууд	Эрэгтэй	63.7	66.3	68.5	70.4	72.1
	Эмэгтэй	67.2	70.1	72.5	74.6	76.5
	Нийт	65.4	68.2	70.5	72.5	74.3
АНУ	Эрэгтэй	75.6	76.8	77.9	79.1	80.4
	Эмэгтэй	80.8	82.1	83.3	84.5	85.7
	Нийт	78.2	79.5	80.7	81.8	83.1
Япон	Эрэгтэй	79.0	80.5	81.5	82.4	83.3
	Эмэгтэй	86.1	87.9	88.9	89.9	90.9
	Нийт	82.6	84.2	85.2	86.1	87.1
Итали	Эрэгтэй	77.5	78.8	79.9	81.0	82.1
	Эмэгтэй	83.5	84.6	85.8	86.9	87.9
	Нийт	80.5	81.7	82.9	83.9	85.0
БНХАУ	Эрэгтэй	71.3	73.2	74.8	76.2	77.4
	Эмэгтэй	74.8	76.9	78.6	80.1	81.3
	Нийт	73.0	74.9	76.6	78.1	79.3
Швед	Эрэгтэй	78.7	80.3	81.4	82.4	83.5
	Эмэгтэй	83.0	84.2	85.2	86.1	87.0
	Нийт	80.9	82.2	83.3	84.3	85.2

БНСУ	Эрэгтэй	76.1	78.0	79.8	81.4	82.9
	Эмэгтэй	82.9	84.7	86.3	87.7	88.9
	Нийт	79.6	81.5	83.1	84.7	86.0
Монгол улс	Эрэгтэй	64.1	68.8	-	-	-
	Эмэгтэй	70.7	73.4	-	-	-
	Нийт	67.4	71.1	-	-	-

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл.

Хүн амын дундаж наслалт (улс орноор)

Улс орнууд	Дундаж наслалт			Улс орнууд	Дундаж наслалт		
	эр	эм	он		эр	эм	он
Норвеги	78.2	82.9 83.8	2006 2013	Англи	77.1	81.1 82.9	2005 2013
Канад	78.4	83.0 83.6	2006 2011	Бельги	76.6	82.3 83.2	2006 2013
БНСУ	76.1	82.7 85.1	2007 2013	АНУ	75.4	85.7	2006
Япон	79.4	86.0 86.6	2007 2013	Ирланд	77.3	82.1 83.1	2006 2013
Швед	78.9	83.0 83.8	2007 2013	Люксембург	76.8	81.9 83.9	2006 2013
Исланд	79.4	82.9 83.7	2007 2013	Герман	77.2	82.4 83.2	2006 2013
Швецари	79.2	84.2 85.0	2007 2013	Протугал	75.5	82.3 84.0	2006 2013
Австрали	79.0	83.7 84.0	2007 2013	Финлянд	75.9	83.1 84.1	2006 2013
Грек	77.0	82.0 84.0	2007 2013	Австри	77.3	82.9 83.8	2006 2013
Нидерланд	78.0	82.3 83.2	2007 2013	Франц	77.5	84.4 85.6	2006 2013
Итали	78.4	84.0 85.2	2007 2013	Мексик	72.6	77.4 77.5	2006 2014

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл.

Судалгаанаас харахад 2013 оны байдлаар Япон, БНСУ, Швецари, Итали, Франц, Протугал, Финлянд зэрэг улс орны хувь хүний дундаж наслалтын хугацаа 85.6-84.0 жил болон уртсаж байгааг харж болох юм.

Монгол Улсын хүн амын дундаж наслалт (оноор)

Он	1950	1980	1990	2000	2005	2009	2011	2020
Дундаж наслалт	48	58	63.65	63.18	66.26	67.96	68.35	71.1
Эрэгтэй	-	-	62.3	60.43	63.9	64.33	64.8	68.8
Эмэгтэй	-	-	65	66.13	69.7	71.79	71.9	73.4

Хувь хүний аюулгүй байдлын зорилго нь хүн нэг бүрийн амьдрал, эрүүл мэндэд, хөрөнгө, эрх, эрх чөлөөг хамгаалах юм. Хувь хүний аюулгүй байдлын хэмжүүр нь /үнэлэмж/ амьдралын дундаж наслалтыг хадгалах, нэмэгдүүлэх явдал юм.

Хүн амын дундаж наслалт хүйс (аймаг, нийслэлээр)

№	Аймаг	2015	2016	2017	2018
1	Улсын дүн	69.89	69.57	69.89	70.19
2	Баян-Өлгий	73.33	73.01	73.12	73.11
3	Говь-Алтай	69.37	69.07	69.43	69.95
4	Завхан	69.72	70.03	70.11	70.51
5	Увс	68.81	68.51	68.84	69.26
6	Ховд	72.26	72.58	72.63	72.7
7	Архангай	71.08	70.77	70.81	71.37
8	Баянхонгор	69.42	69.12	69.27	70.01
9	Булган	72.86	73.17	73.4	73.44
10	Орхон	71.38	71.07	71.33	71.91
11	Өвөрхангай	69.85	69.55	69.85	70.46
12	Хөвсгөл	66.3	66.01	66.18	66.71
13	Говьсүмбэр	73.42	73.1	73.01	73.61
14	Дархан-Уул	69.04	68.74	68.67	68.74
15	Дорноговь	70.71	70.4	70.6	71.25
15	Дундговь	73.78	73.46	73.58	73.9
16	Өмнөговь	72.	71.68	71.85	72.34
17	Сэлэнгэ	72.42	72.11	72.08	72.13
18	Төв	72.61	72.93	72.85	72.59
19	Дорнод	68.94	68.63	68.76	69.39
20	Сүхбаатар	72.33	72.02	72.07	72.66
21	Хэнтий	71.49	71.8	71.75	72.39
22	Улаанбаатар	71.79	71.47	71.51	71.65
23	Улсын дүн	66.02	65.58	65.88	66.11

Эх сурвалж: ҮСХ-ны мэдээлэлд үндэслэв.

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгасан байдаг. Дээрх бодлогын хүрээнд Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 416 тоот тогтоолоор “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөр нь 2 үе шаттайгаар хэрэгжиж байгаа бөгөөд 2018-2020 онд хоёр дахь шатны хэрэгжилтийг хангахаар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч дэд зөвлөлийн ажлын албаар Геронтологийн үндэсний төв

ажиллаж байна Энэ хөтөлбөрт 4 зорилт тусгагдсан байдаг.

1. Хүн амын насжилтыг дэмжих хууль, эрх зүй, нийгэм эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх;
2. Настны эрүүл мэндийг дэмжих, өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх;
3. Насны хөгжил хамгаалал, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх;
4. Эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг настны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх

Дээрх зорилтуудын дагуу орон нутагт эрүүл мэндийн сайдын гаргасан тушаалын дагуу сургалт сурталчилгаа, ахмадуудын дунд уралдаан тэмцээн, хөдөлгөөн аян зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж ажилласан байдаг.

Дундаж наслалтаараа тэргүүлэгч хөгжингүй барууны орны иргэд чанартай хоол хүнс хэрэглэхийн зэрэгцээ, амьдралын зөв хэвшлийг баримталж, эрүүл мэндийн өндөр түвшний тусламж үйлчилгээг цаг алдалгүй авч чаддаг нь урт наслах үндэс болдог. Өндөр хөгжилтэй улс орнуудын хувьд хүн амын дундаж наслалт 2005-2010 оны үед 76.5 жил байсан бол 2045-2050 онд 79.4 жил хөгжиж буй орнуудын хүн амын хувьд 74.3 жил болох төлөвтэй байна. Харин энэхүү урт наслах амьдралын хэв маягт өндөр орлого бүхий хуримтлалаас бүрдсэн санхүүгийн тогтвортой, баталгаатай байдал чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Дүгнэлт, санал

Ахмад настнуудын тоо өсөн нэмэгдэж байгаа нь өнөө үед тэдний аж амьдралын хэвийн байдлыг баталгаажуулах, нийгмийн хамгааллыг тэгш хүртээх, аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Монгол Улсын тухайд нийгмийн хамгааллын зардлын өсөлтийг дагаад төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд зарим нэг өөрчлөлтийг хууль эрхзүйн хүрээнд оруулах шаардлага бий болно. Учир нь настныг асран халамжлах, тэтгэх уламжлалт соёлын харилцаа монголчуудын дунд эрт дээр үеэс уламжлан дамжиж ирсэн соёл бөгөөд одоо ч энэ уламжлал хадгалагдаж үр хүүхэд залуу хойч үеийхэний хариуцлагын асуудал, нөгөө талаар нийгмийн тогтолцооны өөрчлөлт болох хүн амын шилжилт, залуучуудын ажил эрхлэлтийн бууралт, эдийн засгийн тогтворгүй байдал зэрэг нь халамжийн бодлогыг алдагдуулахад хүрч байна. Технологид суурилсан амьдралын орчин нөхцөлд эрүүл мэнд, эд хөрөнгийнхөө төлөө өөрийгөө аюул заналаас халхлах нийгэм бие хүний чадвар бэлэн байх шаардлага ирээдүйд өндөр настангуудад тулгарна.

Тиймээс цаашид дараах *санал*д үндэслэн тодорхой ажлуудыг хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Хороо, дүүрэг, орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн бус байгууллагуудын хамтын оролцоотойгоор хувь хүний эрүүл амьдрах, эрүүл хооллох, зөв амьдралын хэвшлийн

талаар үе шаттай сургалт, сурталчилгаа, аян зэрэг компанит ажлуудыг эрчимжүүлэх;

2. Ахмадуудын чөлөө цагаа өнгөрүүлэх, хөнгөлөлт үйлчилгээг сайжруулах, нийгмийн халамжийн бодлогын чанар үр өгөөж, хэрэгжилтийг сайжруулах, таатай орчин бүрдүүлэх нийтийн үйлчилгээний төвүүд байгуулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр зорьж буй засаг захиргааны байгууллага, төрийн бус байгуулагуудыг дэмжиж ажиллахад шаардагдах санхүүжилтын асуудлыг шийдвэрлэх; бодлогын хэрэгжилтийг олон нийтэд тайлагнадаг байх;
3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, хууль хяналтын байгууллагууд аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг улс орон даяар зохион байгуулах тайлан мэдээг олон нийтэд тайлагнадаг байх.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Монгол Улсын эрүүгийн хууль. 2002;
2. Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал. 2010 он;
3. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын үндэс. УБ., 2016 он;
4. С.Туяа. Насжилт - Ахмад настны нийгмийн хамгаалал. УБ., 2016 он;
5. Монгол Улсын статистикийн эмхтгэл. УБ., 2018 он;
6. Т.Намжид, Иргэншилд учирч буй 100 аюул занал.УБ., 2018 он.;
7. З.Төрмандах, С.Гантулга. Хүн худалдаалах гэмт хэрэг. УБ., 2008 он;
8. Хүн худалдаалах гэмт хэрэг. сургагч багшын гарын авлага. УБ., 2009 он;
9. Олон нийттэй ажиллах арга зүй. Нийгмийн хөгжлийн төв. УБ., 2007 он;
10. www.google.com;
11. www.fact.mn.

Умард Солонгосын цөмийн болон баллистик пуужингийн туршилт, түүний хөгжлийн чиг хандлага

Р.Энхболд

ҮАБЗ-ийн Ажлын албаны ахлах референт, хурандаа

2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Умард Солонгосын талаас хоёр нэгж дунд тусгалын пуужинг нийслэл Пёнъян хотын ойролцоох Пёнъян-до дүүргээс харвав. Хоёр пуужин 370 орчим км нисээд Умард Солонгос болон Япон Улс хоёрын дунд тэнгист унажээ. Энэ үйлдлийг хамгийн түрүүнд Япон, Өмнөд Солонгос, АНУ-ын зүгээс буруушаасан мэдэгдэл хийхээс гадна, тус улсын эсрэг улс төр, эдийн засгийн хориг арга хэмжээ авсан. Түүнчлэн Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг зогсоох талаар улс төрийн яриа хэлэлцээр, түүнтэй залгаад пуужинг амдан сөнөөх зорилготой агаарын довтолгооноос хамгаалах системээ сайжруулах ажлыг хийж байна. Ингээд та бүхэнтэй Умард Солонгосын цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөр, туршилт, судалгаа, түүний чиг хандлагын тухай хуваалцаж байна.

Нэг. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын талаар

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс /БНАСАУ/ нь төрийн эв хамт дэглэм, нийгэм журамт эдийн засаг, нэгдмэл төрийн байгууламжтай, нам төвт нэг намын ноёрхолт тогтолцоотой улс юм. Умард Солонгос нь 24 сая хүнтэй, газар нутгийн хувьд 120 мянган км/кв буюу манай Баянхонгор аймгийн нутаг дэвсгэртэй ойролцоо хэмжээний газартай юм. Газар зүйн байрлалын хувьд дорнод азид оршдог, Солонгосын хойгийг хагасыг эзэлдэг. Тус улс нь хойд талаар БНХАУ-тай /ОХУ-тай багахан хэсгээр/, өмнөд талаар Өмнөд Солонгос Улстай хил залгадаг ба 1910 онд Японы ивээл орон болсон ба 1945 онд Япон ялагдахад тусгаар тогтнолоо зарлаж байв.

Солонгосын нутгаас Япончууд гарч явахтай зэрэгцээд зөвлөлтийн цэрэг хойд хэсэг нь орж ирсэн бол америкийн цэргүүд өмнөд хэсгийг нь эзлэж авчээ. НҮБ-ийн шийдвэрээр Солонгосыг 38 дугаар өргөргөөр хоёр хуваан АНУ болон ЗХУ-ын албан ёсны хяналтад оруулав. Зөвлөлтийн хянаж буй хойд хагаст 1948 онд коммунист дэглэмээр замнах Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс /БНАСАУ/ байгуулагдсан. Улсын тэргүүнээр Манжуурт байрлан солонгосын тусгаар тогтнолын төлөө

тэмцэж явсан, зөвлөлтийн холбоотон Ким Ил-Санг сонгогджээ. 1950 оны 6 дугаар сард Умард Солонгосын зүгээс Өмнөд Солонгос руу цэргийн хүчээр довтолсноор Солонгосын дайн эхэлж, 1953 онд гал зогсоосон байдаг.

Умард Солонгос Зөвлөлт, Хятадтай холбоотон хэвээр үлдсэн боловч зай барьдаг болж “Чүчэ”(дотоодын үйлдвэрлэлээр хэрэгцээгээ хангах) үзэл баримтлалыг хөгжүүлсэн. 1960-аад он хүртэл Умардын эдийн засгийн өсөлт Өмнөдөөс илүү байв. 1976 онд хүртэл хоёр солонгосын нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн адил байсан боловч түүнээс хойш умардын эдийн засаг хоцорч эхэлсэн түүхтэй.

Умард Солонгосын арми нь ардын цэргээс бүрдэх ба одоо ойролцоогоор 1,2 сая цэрэгтэй, бэлтгэл хүчинд 6,3 сая хүнтэй, дэлхийн хамгийн цэрэгжсэн улсын нэгд тооцогддог. Армид эрчүүд 10 жил, эмэгтэйчүүд 7 жил цэргийн алба хаадаг байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтын хувьд хуурай замын цэрэг, тэнгисийн цэрэг, агаарын, тусгай ажиллагааны, пуужингийн цэрэг гэсэн үндсэн таван салбарт хуваагдана. Өнөөдрийн байдлаар Умард Солонгосын армид 6000 нэгж танк, 2100 нэгж хуягт техник, 14300 нэгж их буу, 11000 нэгж агаарын довтолгооноос хамгаалах хэрэгсэл, 1600 нэгж нисэх онгоц, 1000 орчим нэгж хөлөг онгоц, ойролцоогоор 70-75 нэгж шумбагч онгоцтой ба ихэнх нь зөвлөлтийн үеийн хуучин зэвсэглэл, техниктэй юм. Умард Солонгос нь олон нийтэд цөмийн зэвсэг болон устөрөгчийн бөмбөгтэй хэмээн зарласан ба гадны цэргийн мэргэжилтнүүд 3000 км зайд тусах чадалтай 1000 гаруй нэгж пуужинтай болсон гэж үздэг.

Хоёр. Умард Солонгосын цөмийн болон пуужингийн хөтөлбөрийн тухай

Умард Солонгосын эрх баригчид тус улсын аюулгүй байдлын баталгааг цөмийн зэвсэг гэж үздэг тул эдийн засгийн доройтол, хямралыг үл тоон цөмийн хөтөлбөрийг хөгжүүлэхэд гойд анхаарч, асар их хөрөнгө, хөдөлмөр зарцуулсаар иржээ. Тус улс нь цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах талаар арвин туршлагатай бөгөөд цөмийн зэвсэг бүтээх туршлага, материал, техникийн бааз суурьтай улсын нэг байв.

Цөмийн зэвсэг гэдгийг хамгийн энгийн үгээр тайлбарлавал цөмийн энергийг ашиглан дэлбэрч буй бөмбөг эсвэл пуужинг хэлж болно. Цөмийн зэвсэг нь үндсэн гурван хэсгээс бүрддэг. Үүнд: нэгдүгээрт цөмийн бөмбөг/пуужин, хоёрдугаарт цөмийн бөмбөгийн удирдлага/хяналтын систем, гуравдугаарт цөмийн зэвсгийг тээвэрлэгч ордог. Цөмийн зэвсгийн тээвэрлэгч нь хөдөлгөөнт, суурин хэлбэртэй байх ба пуужин, нисэх онгоц, хөлөг онгоц, шумбагч завь байж болно.

Түүнчлэн уг зэвсгийн системийг газарт, газар дор, агаарт, сансарт, тэнгист, усан дор суурилуулдаг. Цөмийн бөмбөгийг бүтээх, хөгжүүлэх хөтөлбөрийг даган пуужингийн системийг хөгжүүлэх, хүчин чадал, тусгал, удирдлага, цэцийг нь сайжруулах ажил тасралтгүй хийгдэж ирсэн. Тийм учраас пуужинг ярихын тулд цөмийн хөтөлбөрийн үүсэл гарлын талаар зайлшгүй дурьдах хэрэгтэй болно.



Зураг №01. Умард Солонгосын нийслэл Пёнъян хотын төв талбайд парадд оролцож буй хөдөлгөөнт тив алгасагч баллистик пуужин.

1956 онд ЗХУ нь умард солонгосын эрдэмтэн, инженерүүдэд цөмийн эрчим хүчний талаар анхны ойлголт өгч, тэднийг сургаж эхэлсэн байдаг. Гэтэл 1958 онд умард солонгосын дайсан болох өмнөд солонгосын нутагт америкчууд 280 мм-ийн цөмийн их буу суурилуулсан нь тус улсын аюулгүй байдалд ноцтой заналхийлж эхэлжээ. Ингээд 1959 онд ЗХУ болон Умард Солонгос хоёр цөмийн хамтын ажиллагааны гэрээг байгуулж 1962 онд тус улсын Ёнбён хотод Цөмийн эрдэм шинжилгээ, судалгааны төвийг байгуулж, энэ төвд цөмийн эрчим хүчний болон уран баяжуулах судалгаа, туршилт явуулж эхлэв. 1965 онд Ёнбён дахь хөнгөн усны цөмийн реакторын хүчин чадал 2 мегаватт, 1974 онд 4 мегаватт, 1987 онд 8 мегаваттад хүрчээ. 1970-1980 онуудад тус улсын уурхайчид Санчон, Пёгсан зэрэг газруудад ураны хайгуул, олборлолтын үйл ажиллаа явуулж байсан мэдээ бий.

1980-1985 онд Ёнбён цөмийн эрдэм шинжилгээ, судалгааны төвийн дэргэд “шар нутаг” болон цөмийн реакторын түлш гаргаж авах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулав. “Шар нутаг” нь ураны хүдрээс боловсруулан гаргаж авсан ураны исэл агуулсан химийн нэгдэл юм.

1984 онд умардын эрдэмтэд радиохимийн лаборатори, 1986 онд “плутони” гаргаж авах боломжтой цөмийн реактор барьж ашиглалтад оруулжээ.

тагнуулын алба баталгаажуулсан. Харин 2006 оны 10 дугаар сарын 14-нд НҮБ-ын Аюулгүйн зөвлөл 1718 дугаар тогтоол батлаж Умард Солонгост хоригарга хэмжээ авлаа. Умард Солонгос 2009 оны 5 дугаар сарын 25-нд хоёр дахь, 2013 оны 2 дугаар сарын 12-нд гурав дахь, 2016 оны 01 дүгээр сарын 6-нд дөрөв дахь цөмийн туршилтаа амжилттай хийсэн ба 4 дэх туршилтыг устөрөгчийн бөмбөг байсан гэж зарлав. Өнөөдөр олон улсын зэвсгийн шинжээчид Умард Солонгосыг ойролцоогоор 30-60 нэгж цөмийн зэвсэгтэй болсон гэж үздэг.

Гурав. Умард Солонгосын далавчит болон баллистик пуужингийн хөтөлбөрийн талаар

Цэргийн урлаг үүсэж хөгжсөн тэр цагаас хойш хүн төрөлхтөн бие биенээ алсын зайд устгах зэвсэг бүтээх талаар тасралтгүй бодож, сэтгэж, ажиллаж иржээ. Дэлхийн нэгдүгээр дайны үед их буу нь хөнөөлийн хамгийн чухал зэвсэг болсон хэдий ч буудлагын тусгал нь дөнгөж 30 км хүрч байсан нь шинэ зэвсэг бүтээх зайлшгүй шаардлагатай гэдгийг харуулж байлаа. Улмаар техник, технологи үсрэнгүй хөгжиж сэнсэн хөдөлгүүр нь тийрэлтэт хөдөлгүүрөөр солигдсон явдал нь пуужингийн хөгжилд түрхэц өгсөн чухал явдал болжээ.

Пуужинг хөгжүүлэх талаар олон орны эрдэмтэд, инженерүүд ажиллаж байсан хэдий ч бодит пуужин бүтээж байлдааны ажиллагаанд анх удаа ашигласан хүмүүс бол германчууд байсан юм. 1944 оны 6 дугаар сарын 13-наас германчууд “V-1” загварын 850 кг жинтэй, 640 км/цаг хурдтайгаар 250 км зай туулах боломжтой, анхны тийрэлтэт хөдөлгүүртэй пуужинг ашиглан английн нийслэл Лондон хотод цохилт өгч эхэлжээ.

Орчин үед пуужинг далавчит болон баллистик пуужин гэж хоёр ангилал ба пуужингийн хөдөлгүүр нь шингэн болон хатуу түлшээр ажилладаг. Далавчит пуужинг ихэвчлэн хуурай газарт байрлаж буй “бай” устгах зорилгоор ашигладаг ба нислэгийн өндрийн ихэнх хэсэг нь агаар мандалд тогтмол хурдтай явагддаг. Далавчит пуужин нь том хэмжээтэй хүнд “цэнэг”-ийг холын зайд, өндөр нарийвчлалтай хүргэх чадалтай ба орчин үед пуужингийн нислэгийн хурд нь 1200 км/цагаас илүү болсноос гадна өөрийн удирдлагатай, хэт нам өндөрт чиглэлээ алдалгүй нисэх боломжтой болж хөгжжээ.

Баллистик пуужин нь 5500-16000 км-ийн алс зайд цөмийн болон ердийн цэнэг тээвэрлэх хүчин чадалтай ба өөрийн тээвэрлэж буй нэг цөмийн цэнэгт хошуу нь том хэмжээний бүхэл бүтэн хотыг устгах боломжтой, удирдлагатай том хэмжээний пуужин юм. Уг баллистик пуужинг далавчит пуужингаас ялгах гол онцлог бол нислэг нь 100 км-ээс дээш өндөрт явагддаг явдал юм. Тэгэхээр пуужин нь дээш хөөрөөд дэлхийн тойрог замд ороод сансараас буцаж агаар мандал орж ирэн хэд хэдэн “бай”-д зэрэг цохилт өгөх боломжтой байдаг байна.

3.1. Умард Солонгосын пуужингийн хөтөлбөрийн тухай

Умард Солонгосын пуужингийн хөтөлбөр 1976 онд ЗХУ-аас “Скад” пуужин, Египтээс хөөргөх суурь авсан тэр үеэс эхэлсэн түүхтэй. 1984 онд тус улс нь зөвлөлтийн цэргийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар “Скад-Б” пуужинг анх удаа харважээ. “Скад” буюу “Р-11” нь бол Хүйтэн дайны үед ЗХУ-д боловсруулж хөгжүүлсэн шингэн түлшт нэг хөдөлгүүртэй тактикийн баллистик пуужин юм. “Скад-Б” пуужин нь 5,9 тонн жинтэй, 11 метр урт, 5-80 кТн хүчин чадалтай цөмийн хошууг 300 км зайд тээвэрлэх хүчин чадалтай байв.



Зураг №03. Умард Солонгосын пуужингийн нислэгийн алслалт¹

1988 онд “Скад-Б”, “Скад-С” загварын пуужингийн туршилт дуусаж, зэвсэглэлд хүлээн авч байлдааны жижүүрлэлтэд шилжүүлэв. Ингээд умард солонгосын инженерүүд зөвлөлтийн пуужинг хуулбарлаж “Родонг-1” /Rodong-1/ нэртэй шингэн түлштэй нэг хөдөлгүүртэй пуужинг өөрсдөө бүтээж, 1990 онд анхны туршилтаа амжилттай хийв. Ийм загварын 200-300 нэгж бүтээсэн байдаг ба одоогоор 100 орчим нэгж ийм төрлийн пуужин байлдааны жижүүрлэлтэд үүрэг гүйцэтгэж байгаа гэсэн америкийн тагнуулын мэдээ бий². 1993 оны 5 дугаар сарын 29-нд умардын цэргийнхэн “Нодонг”/Nodong/ загварын пуужингийн туршилтыг амжилттай хийлээ. Энэ пуужингийн хүчин чадлын сайжруулж 650-1200 кг ачааг 1500 км хүртэл тээвэрлэх боломжтой болж өсчээ.

1998 онд тус улс анх удаа “Таеподонг-1”/Taepodong-1/ загварын баллистик пуужинг “Тонгхае”/Tonghae/ хиймэл дагуулын зөөгч пуужин хөөргөх талбай дээрээс хөөргөсөн байна. Энэхүү пуужин нь 3 шатлалтай, 33 тонн жинтэй, 1,8 метрийн диаметртэй, 25,8 метр урт, 1 тонн ачааг 2500 км зайд хүргэх чадалтай дунд тусгалын баллистик юм. Ингээд тус улсын эдийн засгийн нөхцөл байдал дордож хүндэрсэн хэдий ч


¹ Jane’s Strategic Weapons Systems 2015, The Military Balance 2016.

² <http://www.nsic.af.mil>

пуужингийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх ажил тасралтгүй явагдаж байв. 2009 оны 4 дүгээр сарын 05-нд “Унха-2” загварын зөөгч пуужинг ашиглан “Квангмёнгсонг-2”/Kwangmyongsong-2/ загварын хиймэл дагуулыг дэлхийн тойрог зам руу хөөргөсөн боловч амжилтгүй болжээ. Харин 2012 оны 12 дугаар сарын 12-нд “Унха-3” загварын зөөгч пуужинг ашиглан “Квангмёнгсонг-3” загварын хиймэл дагуулыг амжилттай хөөргөж чадсан билээ.

3.2. Умард Солонгосын далавчит болон баллистик пуужингийн тухай

Умард Солонгосын Зэвсэгт хүчинд ойр, дунд, алсын болон тив алгасагч баллистик пуужингууд үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал ойрын зайн баллистик пуужин “KN-02”/120-170 км-ын тусгалтай/, “Hwasong-5, 6, 7, 8”/300-1000 км-ын тусгалтай/, “Scud MaRV”/1000 км-ын тусгалтай/, шумбагч завинаас харвах боломжтой “KN-11”/1000-1200 км-ын тусгалтай/, дунд тусгалын баллистик пуужин “KN-15”/1200-2000 км-ын тусгалтай/, “No-dong”/1200-1500 км-ын тусгалтай/, алсын зайн “Musudan”/2500-4000 км-ын тусгалтай/, “KN-17”/4500 км-ын тусгалтай/, тив алгасагч баллистик пуужин “KN-08”/5500-11500 км-ын тусгалтай/, “KN-14”/8000-14000 км-ын тусгалтай/, “Hwasong-14, 15”/10400-13000 км-ын тусгалтай/, хиймэл дагуул тээвэрлэгч зөөгч пуужин “Unha-3”/10000 км-ын тусгалтай/ зэрэг пуужингууд ашиглагдаж байна.




Зураг №04. Умард Солонгосын Зэвсэглэлд байгаа пуужингийн ангилал³

³ CSIS Missile Defense Project, Nuclear Threat Initiative; Demeshiko Alexandra, David Wright


3.3. Умард Солонгосын пуужингийн хөөргөх талбайн тухай

“KN-08”/5500-11500 км-ын тусгалтай/, “KN-14”/10000 км-ын тусгалтай/ баллистик пуужингууд нь туршилтын шатанд яваа бол бусад пуужингуудын туршилт дуусаж зэвсэглэлд авчээ. 2019 оны байдлаар Умард Солонгост “Ёнгбён”, “Панггүе-ри” гэсэн хоёр цөмийн туршилтын талбайтай байсан боловч 2018 оны 5 дугаар сарын 28-нд “Панггүе-ри” цөмийн туршилтын талбайг буулгасан. “Сохае” хиймэл дагуул хөөргөх сансарын буудал, “Касонг”, “Сакчон”, “Вонсан”, “Синпо”, “Масадан-ри” зэрэг пуужингийн хөөргөх талбайг ашиглаж байв.

“Синпо” нь тэнгисийн цэргийн мэдлийн шумбагч завины боомт бөгөөд энд пуужингийн туршилтыг давхар явуулдаг. “Вонсан” бол нисэх хүчний бааз боловч энд мөн адилхан пуужингийн туршилтыг явуулж байв.



Зураг №05. Умард Солонгосын цөмийн болон пуужин турших, хөөргөх талбай⁴




Зураг №06. Умард Солонгосын пуужингийн туршилтын талбай, удирдлагын төв⁵

Пуужингийн удирдлагын төв хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, энд Умард Солонгос улсын хамгийн шилдэг инженер, эрдэмтэд ажиллаж байна.

3.4. Умард Солонгосын пуужингийн туршилтын тухай

Умард Солонгосын удирдагч “Ким Ил-Санг”-ийн удирдлагад байхдаа 1984 онд 7 удаагийн баллистик пуужингийн туршилт, 1990-1994 онуудад 10 удаагийн баллистик пуужин харваж байв. Их удирдагчийн залгамжлагч болох “Ким Жонг-Ил”-ийн үед 1998 онд нэг удаа баллистик пуужин, 2000-2009 онд 43 удаа баллистик пуужингийн туршилт явуулж байсан ба 2009 онд хамгийн олон буюу 15 удаа пуужин харваж байв. Мөн 2006 болон 2009 онд газар дор цөмийн туршилт хийсэн билээ.

⁵ Paula Hancocks and Jethro Mullen. CNN April 9, 2012.



Зураг №07. Умард Солонгосын пуужингийн туршилтын харьцуулсан судалгаа⁶

Хамгийн сүүлд 2019 оны 10 дугаар сарын 02-нд “Вансон” агаарын цэргийн баазын ойролцоох усанд аялаж байсан шумбагч завинаас шинэ төрлийн “Пакгаксонг-3”/Pukguksong-3/ загварын баллистик пуужинг харваж туршсан ба уг пуужин нь 910 км-ын өндөрт хөөрч 450 км-ын зайг амжилттай туулсан гэсэн мэдэгдэл хийж байлаа.

Умард Солонгосын одоогийн удирдагч “Ким Жонг-Ан”-ийн үед буюу 2012-2019 оны үед 20 гаруй төрөл бүрийн пуужин харваад байна. Түүнчлэн 2013 оны 2 дугаар сар, 2016 оны 1, 6 дугаар сар, 2017 оны 9 дүгээр сард нийтдээ 4 удаа цөмийн туршилт хийсэн. 2017 оны 9 дүгээр сард хийсэн цөмийн туршилтын хүчин чадал нь 140 кило/тонн хэмжээтэй бөмбөг тэсэлсэн гэж үздэг. 2017 онд тив алгасагч баллистик пуужингийн туршилтыг гурван удаа хийсэн нь пуужингийн хүчин чадал үлэмж өссөн гэдгийг харуулж байгаа юм.


Дөрөв. Умард Солонгосын пуужингаас хамгаалах талаар

Умард Солонгос нь цөмийн болон пуужингийн хөтөлбөр хэрэгжүүлсэн эхэлсэн явдлыг АНУ, Өмнөд Солонгос, Япон Улс орнууд аюулгүй байдалд ноцтой заналхийлж буй явдал гэж үзэх болсон. Тийм учраас эдгээр улс орны зүгээс умард солонгосын цөмийн хөтөлбөрийг зогсоох талаар багагүй чармайлт гаргаж ирлээ.

Өмнөд Солонгост АНУ-ын Зэвсэгт хүчний цэргийн бүлэглэл байрладаг. Уг бүлэглэл нь АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлалын

⁶ Center for Strategic & International Studies, Missile Defense Project, USA Today research.

харьяанд үйл ажиллагаа явуулах ба бүтцэд нь Америкийн 8 дугаар арми, агаарын цэргийн 7 дугаар бүлэглэл, тэнгисийн явган цэрэг, тусгай хүчний анги, нэгтгэл багтдаг. Өмнөд Солонгос дахь америкийн цэргийн бүлэглэлд өнөөдрийн байдлаар 23,4 мянган цэргийн алба хаагч алба хааж байна⁷.



Зураг №08. Умард Солонгосын пуужинг амдан устгах америкийн төлөвлөгөө

Америкийн цэргийн хүчин Өмнөд Солонгосын цэрэгтэй хамтран байлдааны дасгал, сургууль тогтмол хийдэг бөгөөд умардаас харвасан пуужинг устгах талаар олон арга, тактик боловсруулж байдаг. Умардын пуужинг илрүүлэх зорилгоор агаарт тагнуулын онгоц тогтмол нислэг үйлдэж байдаг бол сансарт туршуулыг хиймэл дагуул ажиллаж умардын цэргийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж байдаг билээ. Түүнчлэн америкийн тэнгисийн цэргийн хүчний пуужингийн дотолгоог илрүүлэх радар, хөлөг онгоцнууд байнгын байлдааны жижүүрлэлтэд үүрэг гүйцэтгэж байдаг юм.

Хэрвээ ямар нэгэн онцгой тохиолдол болж тив алгасагч баллистик пуужин америкийн эх газрын зүг харвасан тохиолдолд уг пуужинг илрүүлэх радар, дагах төхөөрөмж ажиллаж, мэдээллийг Өмнөд Солонгос, Япон, Гуам болон Хавайн арлууд, америкийн эх газарт даруй дамжуулна. Уг мэдээлэлд үндэслээд америкийн зэвсэгт хүчний агаар, сансарын довтолгооноос хамгаалах хэрэгслүүд уг пуужинг амдан замд нь устгах арга хэмжээ авах юм.

⁷ <http://www.usfk.mil>

Тав. Дүгнэлт

Умард Солонгосын удирдлага, ард түмнийхээ дэмжлэгтэйгээр эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд асар их хөрөнгө, хөдөлмөр зарцуулж байж цөмийн хөтөлбөрөө хэрэгжүүлж чаджээ. Өнөөдрийн байдлаар нь 1000 гаруй нэгж далавчит болон баллистик пуужин, 30-60 нэгж цөмийн зэвсэгтэй болсон гэдэгт олон улсын зэвсгийн шинжээчид санал нэгдэж байна. Амжилтад хүрэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл болох цөмийн эрчим хүчний суурь судалгаа, шинжилгээний ажлыг эрдэмтэд нь аль 1950 оны дундаас эхлэн тасралтгүй явуулж ирсэн тул цөмийн зэвсэг үйлдвэрлэх материал, техникийн бааз суурь сайтай байжээ. Цөмийн зэвсгийг хөгжүүлэн, баллистик пуужинтай болсон явдал нь дараах ач холбогдолтой юм. Үүнд:

1. Одоо америкаас үзүүлж буй улс төр, эдийн засаг, цэргийн дарамтад буй **Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын аюулгүй байдлын цорын ганц баталгаа нь цөмийн зэвсэг болж чадаж байна.**
2. Нэгэнт цөмийн зэвсэгт болсон тул өөрийн улсын нэр хүндийг өргөх, АНУ, Өмнөд Солонгос, Японтой олон улсын тавцанд ижил түвшний яриа хэлэлцээр хийх боломжийг олж авсан.
3. Цөмийн зэвсгээ ашиглан өөрийн ашиг сонирхлыг бусдад тулгах, эдийн засгийн ашиг олох, худалдаа наймааны ашигтай яриа хэлэлцээ, гэрээ хийх боломжийг тус улсад олгож байгаа юм.

Цөмийн хөтөлбөр, пуужингийн зэвсгийг хөгжүүлсний хариуд АНУ тэргүүтэй улс орнуудаас улс төр, эдийн засгийн дарамт шахалтад орох, эдийн засгийн хүндрэлтэй байдал дунд хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна. Энэ хирээр иргэдийн амьдрал улам дордох байдал газар авч болзошгүй ч нөгөө талаар нэгэнт цөмийн зэвсгийг бүтээсэн тул одоо тодорхой хэмжээний хөрөнгийг дотоод зах зээл руу оруулах боломж нээгдэх магадлалтай юм. Олон улсын хориг арга хэмжээнд орсноор цөмийн бөмбөг бүтээх түүхий эд болох ураны хүдэр, баяжмал, пуужингийн өндөр технологи, түлш хийхэд шаардлагатай түүхий эд, газрын тос авахад хүндрэлтэй болох нь тодорхой байна.

Гэвч Умард Солонгос нь цөмийн зэвсэг, түүнийг тээвэрлэгч баллистик пуужинтай болсноор тус улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, дэглэмийн аюулгүй байдал хангагдаж, гадны улс орон цэргийн хүчээр халдах хувилбар хамгийн эхний сонголт биш болж байгаа нь хамгийн чухал ач холбогдол болсон гэж үзэж байна.

Хүчний тэнцвэр, эвсэл холбооны тухай реалист болон либерал үзэл

Б.Баярцэнгэл

МУИС ОУХНУС-ийн багш

Олон улсын харилцааны маш чухал, байнгын асуудал бол хүчний тэнцвэр болон эвсэл холбоо билээ. Энэхүү өгүүлэлдээ би хүчний тэнцвэр, эвсэл холбооны концепцын ач холбогдлыг тодруулахын хамт үүний талаар реалист болон либерал хэрхэн авч үздэгийг харьцуулах болно. Өгүүллийн эхний хэсэгт реалист урсгалын үзэл санааг авч үзэх бол дараагийн хэсэгт либерал урсгалын үзэл санааг авч үзэх юм.

1. Хүчний тэнцвэр, эвсэл холбооны концепцын ач холбогдол

Олон улсын харилцааны системд хамтран ажилласан, харилцан өрсөлдөж, олон улсын харилцаанд давуу талтай болохыг эрмэлзэж буй улс орнууд голлох байр суурьтай байдаг билээ. Эдгээр системийн оролцогч улс орнууд, холбоодын үйл ажиллагаа, ашиг сонирхлыг ойлгох, тайлбарлах, тааварлахад хамгийн хэрэгцээтэй хэрэгслүүдийн нэг бол хүчний тэнцвэр, эвсэл холбооны концепц гэж үзэж болно. Хүчний тэнцвэр, эвсэл холбооны талаар судлаачид харилцан ялгаатай байр суурь баримталдаг бөгөөд хаанаас эхлэлтэй талаар ч санал зөрүүтэй байдаг. Тухайлбал зарим судлаачид хүчний тэнцвэр тухай анхны ойлголт нь Италийн хот улсуудын Макавеллийн үеэс эхлэлтэй, өөр бусад нь эртний Грекийн Пелопонезийн дайны үеэс, зарим тохиолдолд Ромын эзэнт гүрний Пүнийн цуврал дайнаас эхтэй¹ гэж үздэг байна. Орчин үеийн олон улсын харилцаанд хүчний тэнцвэрийн ойлголтыг оруулж ирсэн Ханс Моргентау эл концепцыг тодорхойлохдоо “Хүч нь хэд хэдэн улсад тархсан ойролцоо, тэнцвэртэйгээр тархсан бодит нөхцөл байдал” (Morgenthau 1961:167) гэжээ. Хүчний тэнцвэр нь реалист урсгалын онолчдын анхаарлыг илүүтэй татаж байдгийг энд онцлох хэрэгтэй. Хэдийгээр либерал урсгалын онолчид хүчний тэнцвэрийн концепцыг хүлээн зөвшөөрдөг ч хэрхэн тайлбарлаж байгаа нь, авч үзэж буй өнцөг нь реалист урсгалаас харьцангуй өөр байдаг.

Улс орнууд үргэлж өөрсдийн зорилгыг (ашиг сонирхлыг) биелүүлэх, хэрэгжүүлэхийг зорьж байдаг бөгөөд ингэх үйл ажиллагааны цар хүрээ, далайц нь тухайн улсын олон улсын харилцааны хүч, байр

¹ Thomas Dietz, Ingvild Bode and Aleksandra Fernandes da Costa., (2011). Key Concepts in International Relations. London: SAGE printing. Хуудас 8

сууриас шууд хамааралтай байдаг. Олон улсын харилцааны системийн хегемон улсын хувьд систем дотроо хэзээд аялдан дагалдагч нар болон эсэргүүцэн сэргэлдэгч нартай байдаг билээ. Хүчний тэнцвэрийн концепц нь зөвхөн хегемон болон түүний өрсөлдөгчийн харилцааг төдийгүй бусад бүс нутгийн гүрнүүд болон системийн оролцогчдын үйл ажиллагаа, харилцааг тодорхойлж байдаг.

Олон улсын харилцааны түүх харилцан өрсөлдсөн янз бүрийн эвсэл, холбоодоор дүүрэн байсаар иржээ. НАТО, ЕХ, Варшавын гэрээ, Антант, Тэнхлэгийн орнууд, Холбоотнууд гэх мэт нь эвсэл, холбоод нь олон улсын харилцаан систем дэх аюулгүй байдлыг сахин хамгаалахад чухал ач холбогдолтой байдаг билээ. Реалист эвсэл холбооны талаар Жорж Лиска тодорхойлохдоо улс орнууд эвсэл холбоодод аюулгүй байдал, тогтвортой байдал, статусын төлөө нэгдэж ордог гэж үзсэн байна. Энд дурдагдсан шалтгаанууд нь бүгд аливаа улсын нэн чухал ашиг сонирхлууд юм. Жорж Лиска үзэхдээ улс орнууд аюулгүй байдал, тогтвортой байдал, статусыг эрэлхийлж эвсэл, холбоонд нэгддэг гэжээ². Энд дурдагдаж буй шалтгаанууд нь бүгд аливаа улсын хувьд амин чухал асуудал бөгөөд эдгээр асуудлыг багтааж, гишүүн орнууддаа өгч чаддаг гэдэг нь эвсэл, холбооны ач холбогдлыг харуулж байдаг. Харин орчин үед Патришиа Вайтсман эвсэл холбоодыг тодорхойлохдоо “нэгдэн орсон орнуудаа аюулгүй байдлыг зарим элементээр хангадаг хоёр талт эвсэл олон талт хэлэлцээр” гэж үзжээ (Weitsman 2004:27). Энэ өгүүлэлдээ би эвсэл, холбоог хүчний тэнцвэрийн концепцын хэрэгсэл гэж авч үзэж байгаа болно.

2. Хүчний тэнцвэр болон эвсэл холбооны талаарх реалист онолын үзэл.

Реалист урсгалын судлаачид олон улсын харилцааны анархи байдал нь улс орнууд хегемон хүчний эсрэг стратегийн эвсэл, холбоо байгуулах эсвэл хегемоны гол өрсөлдөгч улстай хамтран ажиллах замаар хүчний тэнцвэр үүсгэхийг оролдоно гэж үздэг билээ. Кэннэт Уолц, Ханс Моргантау, Кэглэй, Мершаймер болон Хаас нарын реалистууд эл концепцыг дээрх байдлаар олон улсын харилцаанд тусгаж авч үздэг.

Хамгийн нөлөө бүхий неореалистуудын нэг болох Кеннет Уолц Хүйтэн дайны үеийн хүчний тэнцвэр болон эвсэл, холбоо (аялдан дагалдах) зэргийн тухайн авч үзсэн байдаг. Түүний үзсэнээр хүчний тэнцвэр нь хегемон үүсэхээс сэргийлж, өргөн хүрээтэй дайн гарахаас сэргийлдэг тул маш чухал ач холбогдолтой байдаг. Гэвч түүний авч үзсэн нөхцөл нь хоёр туйлт систем бөгөөд Уолц үүнийг тайлбарлахдаа хоёр их гүрэн хоорондоо олон их гүрнүүдээс илүү харилцаж, хүчний тэнцвэр үүсгэх боломжтой байдаг (Waltz 1979:173) бөгөөд хоёр туйлтай байх нь “хоёр туйлын системийн энгийн байдал”³ үүдэн энх тайван байдлыг

² James E. Dougherty and Robert L. Pfaltzgraff Jr., (2001). *Contending theories of International Relations: A Comprehensive Survey*. London: Longman. Хуудас 533

³ Kenneth Neal Waltz., (1979). *Theories of International Relations*. London: McGraw-Hill. Хуудас 173-174

дэмжиж байдаг (Waltz 1979:174). Өөрөөр хэлбэр хоёр туйлт системийн хувьд нэг их гүрэн нөгөөгийнхөө хүчин чадлыг мэдэж байдаг тул систем тогтвортой байдаг гэж тэрээр үзсэн байна. Дэйл Копеланд Уолцын энэхүү үзлийг дэмжиж “хоёр туйлт системийн их гүрнүүд өргөн хүрээтэй дайн гаргах магадлал бага байдаг” (Copeland 1996:29) гэж бичжээ. Харин системд хэд хэдэн их гүрэн байх үед олон улсын харилцааны систем илүү тогтворгүй болж харилцан үл ойлголцох магадлал ихэсдэг бөгөөд үл ойлголцол нь дайнд хүргэж болзошгүй байдаг⁴. Үүнтэй ижлээр хэт олон тооны эвсэл, холбоо нь гишүүн орнуудаа хүчээр өргөн хүрээтэй дайнд татан оролцуулах магадлалтай байдаг билээ. Эвсэл, холбоонууд гишүүдээ татан оруулах замаар бүх системийг хамарсан дайнд хүргэсэн тод жишээ бол Дэлхийн нэгдүгээр дайн бөгөөд тус дайн нь Австри-Унгарын эзэнт улс Сербид дайнд зарласнаас үүдсэн бус их гүрнүүд харилцан дайн зарласан гинжин урвалыг эхлүүлж, ялсан, ялагдсан талууд бүгд асар их хохирол амссан үр дүнд хүргэсэн байдаг.

Дээрхтэй харьцуулахад Хүйтэн дайны хоёр туйлт систем нь хагас зуун жил үргэлжилсэн “харьцангуй” тайван, тогтвортой байдлыг хадгалсан билээ. АНУ болон түүний холбоотон Өрнөдийн орнууд цэрэг, зэвсгээ базааж байсан ч тэл бүгд ЗХУ-ын хүчин чадлыг мэдэж байсан бөгөөд холбоотон орнууд өөр хоорондоо өрсөлдөхийн оронд харилцан эвсэл байгуулсан (Уолцын тодорхойлсончлон хэт их гүрэнд аялдан дагалдсан) билээ. ЗХУ ч мөн адил өөрийгөө тойруулж холбоотнуудтай болж АНУ-ын эсрэг хүчний харьцааг тэнцүүлэх, илүү болохыг зорьж байв.

Үүнээс ялгаатай нь Артур Ли Бүрнс болон Р.Харрисон зэрэг онолчид олон их гүрнүүд тэр дундаа хамгийн тохиромжтой нь 5 их гүрэн системд байсан тохиолдолд хүчний харьцааг тэнцүүлж тухайн системийн тогтвортой байдлыг хангаж чадна (Burns 1957: 505) гэж үзжээ. Үүнийг Хүйтэн дайны үеийн нөхцөл байдалд оруулан авч үзвэл тухайн үеийн цөмийн зэвсэгтэй орнууд болох ЗХУ, АНУ, Их Британи, БНХАУ зэрэг улсууд харьцангуй тогтвортой системийг бүрдүүлэхэд нөлөө үзүүлж байсан явдал бөгөөд хэд хэдэн улс орнууд цөмийн зэвсэгтэй байсан нь цөмийн дайны бодит аюулыг харьцангуй бууруулж байсан явдал гэж үзэж болно.

Хүчний тэнцвэрийн концепцыг батжуулж, дэмжиж байсан реалист онолчдоос ялгаатай нь Ханс Моргантау хүчний тэнцвэрт хэд хэдэн сул тал байна гэж үзсэн байдаг⁵. Тэрээр үзэхдээ: нэгт хүчийг хэмжих, харьцуулах бодит харьцуулалт байдаггүй тул хүчний тэнцвэр нь тодорхойгүй, хоёрт нэгэнт тодорхойгүй тул удирдагчид илүү давуу талтай болохыг оролддог тул хүчний тэнцвэр нь бодит бус, гуравт хүчний тэнцвэр нь Европын 1648-1914 оны хоорондох харилцаа, үйл явдлыг бүрэн тайлбарлаж чаддаггүй тул хангалттай сайн тайлбар бус (Dougherty and Pfaltzgraff 2001:43) гэж үзжээ. Нөгөөтээгүүр реалист

⁴ Jack Donnelly., (2002). Realism and International Relations. New York: Cambridge University Press. Хуудас 108

⁵ James E. Dougherty and Robert L. Pfaltzgraff Jr., (2001). Contending theories of International Relations: A Comprehensive Survey. London: Longman. Хуудас 43

судлаач Эрнст Хаасын үзсэнээр хүчний тэнцвэрийн концепцыг гадаад бодлогоо боловсруулахад тусгах нь тухайн улсад сонгох боломжтой олон арга замууд, харьцангуй уян хатан байх боломж олгодог гэж үзсэн байдаг⁶. АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга агсан Хэнри Киссинжер АНУ, Хятадын хоорондох үзэл суртлын, улс төрийн ялгаатай байдлыг үл харгалзан Хятадтай харилцаагаа ойртуулж ЗХУ-ын Азийн эх газарт байсан давуу талыг хязгаарлаж хүчний тэнцвэр үүсгэсэн явдал нь дээр дурдсан хүчний тэнцвэрийн гадаад бодлогод уян хатан байдал олгодгийн нэг жишээ мөн гэж болно.

Хүчний тэнцвэрийн концепцын тухай авч үзэхэд нэгэн ойлголт байнга гарч ирдэг нь “Bandwagoning” буюу аялдан дагалдах явдал юм. Аялдан дагалдах явдлыг онолч Рандалл Швеллер товч бөгөөд тодорхой тодорхойлохдоо “Илүү хүчтэй талтай холбоотон болохыг оролдох бүр төрлийн алхам”⁷ гэсэн байдаг.

Хүчний тэнцвэрийн талаарх реалистуудын үзэл Хүйтэн дайны үед “Швейцар цаг” мэт ажиллаж байсан боловч Хүйтэн дайны төгсгөлд тэдгээр реалист онолчид ЗХУ-ыг түргэн задралыг урьдчилан харж, тайлбарлаж чадаагүй юм. Үүнээс хойш үүсэн бий болсон олон туйлт системд АНУ “идэвхгүй” хегemony үүрэг гүйцэтгэх болсон билээ. Энэ нь 2011 оны 9 дүгээр сарын 11-ний халдлага хүртэл үргэлжилсэн бөгөөд энэ үеэс эхлэн АНУ системийн хегemony статусаа идэвхтэйгээр хэрэгжүүлэх болсон юм. Энэхүү АНУ идэвхэжсэн бодлого, түүний холбоотон улсуудтай хүчний тэнцвэр үүсгэхийн тулд ОХУ, БНХАУ зэрэг бүс нутгийн их гүрнүүд ШХАБ, БРИК зэрэг байгууллагуудаар хамтын ажиллагаагаа зузаатгах болов⁸. Орос, Хятадын энэ үйлдэл нь хегemony эсрэг бусад өрсөлдөгчид нь хүчний тэнцвэр үүсгэхийг оролдоно гэсэн хүчний тэнцвэрийн концепцын жишээ мөн. Энэ мэт хүчний тэнцвэрийг үүсгэх зорилготой бүс нутгийн их гүрнүүдийн идэвхжлийг 2001 онд Мершаймер, 2008 онд Икенберри нар болон Хятад, Бразил тэргүүтэй бүс нутгийн их гүрнүүдийн талаар судалгаа хийсэн онолчид тайлбарлаж зарим талаар урьдчилан таамагласан байдаг.

3. Хүчний тэнцвэр болон эвсэл холбооны талаарх либерал онолын үзэл.

Либералистуудын хувьд хүчний тэнцвэр, эвсэл холбооны концепцын талаар хэд хэдэн байдлаар авч үздэг. Реалистуудаас ялгаатай нь Либералистууд хүн хоорондын харилцаа, дэлхийн худалдаагаар дамжуулан улс орны ашиг сонирхлыг бүх нийтийн сайн сайхны төлөөх үйлсэд шилжүүлэх боломжтой гэж үздэг билээ. Энэхүү үзлийн хүрээнд либералистууд хүчний тэнцвэрийг институтжуулэх боломжтой гэж

⁶ Ernst B. Haas., (1953). The Balance of Power as a Guide to Policy Making. *Journal of Politics*. **15**, 370-398

⁷ Randall. L. Schweller., (1997). New Realist Research on Alliances: Refining, Not Refuting, Waltz’s Balancing Proposition. *American Political Science Review*. 91 (4), 927-930. [Online] Available from: JSTOR <http://www.jstor.org/stable/2952176> [Accessed on 1 November 2012]

⁸ Thomas Dietz, Ingvid Bode and Aleksandra Fernandes da Costa., (2011). *Key Concepts in International Relations*. London: SAGE printing. Хуудас 9

үздэг бөгөөд үүнийг хамтын аюулгүй байдал буюу “collective security” гэж заримдаа нэрлэдэг. Олон улсын харилцааны либерал онолын хувьд улс нь олон улсын харилцааны оролцогч бус “хэн нэгний эзэмшилд эзлэгдэж, ахин эзлэгдэж, зарим тохиолдолд байгуулагдаж, ахин байгуулагдаж байдаг институт”⁹ юм (Moravcsik 2001:5). Хамгийн чухал нь либерал онолчид хэт их гүрэн болон бүс нутгийн гүрнүүдийн хооронд гарч болох дайны тухай чухал асуудлыг хөндсөн байдаг. Тэдний үзсэнээр реалистуудын баримталдаг хоёр эсвэл олон туйлт загвар нь цоорхой талтай. Хоёр туйлт системийн хоёр хэт их гүрэн харилцан өргөн хүрээтэй дайн, эзлэн түрэмгийлэх агресси гарахаас сэргийлж байдаг ч бүс нутгийн гүрнүүд ямар нэг дайн гаргах, түрэмгийлэл үйлдэхээс бүрэн сэргийлж чаддаггүй.

Мөн олон туйлт хүчний тэнцвэрийн концепц нь өрсөлдөгч талыг хязгаарлах зорилгоор түрэмгий дайн эхлүүлэх тухайлбал стратегийн байрлал эзлэж авах стратеги баримтлахыг дэмжиж байдаг¹⁰. Үүний нэг жишээ бол Дэлхийн хоёр дайны аль алинд Германы тал Бельгийг эзэлсэн явдал гэж үзэж болно. Мөн судлаач Дойл үзэхдээ хүчний тэнцвэр нь либерал (ардчилсан) улсуудын хооронд дайн гаралгүй, энх тайван байдал 150 гаруй жилийн турш тогтож ирснийг бүрэн тайлбарлаж чадахгүй гэж үзжээ¹¹.

Сонгодог либерализмаас ялгаатай нь неореализм буюу рационал бүтцийн институционализм нь олон улсын харилцааны анархи байдлыг реализмын адил хүлээн зөвшөөрөхөөс гадна хүчний тэнцвэрийг ч бүрэн хүлээн зөвшөөрдөг. Гэвч реализмаас ялгаатай нь тэд хүчний тэнцвэрийг их гүрнүүд өөрсдөө бус НҮБ, НАТО гэх мэт бусад олон улсын байгууллагууд гүйцэтгэх боломжтой гэж үздэг¹². Энэ нөхцөлд реализмтай харьцуулахад неолиберал үзэл харьцангуй өөр дүгнэлт хийж байдаг. Реалистууд олон улсын харилцааны анархи орчин дахь олон улсын хамтын ажиллагаа нь зөвхөн дүрэм журам, хэм хэмжээг тогтоогч хегемоны дэмжлэг, хамгаалалт дор явагдах боломжтой гэж үздэг бол неолибералистууд олон улсын хамтын ажиллагааны боломж, хүчин чадал нь реалистуудын үзэж байгаагаас хавьгүй илүү байдаг гэж үздэг (Keohane 1989:1-16). Мөн тэд 20-р зуунд гарсан олон улсын хөгжил дэвшил нь улс орнуудын хамтын ажиллагааг, түүхэнд хүрэх явцыг түүхийн бусад үеүдтэй харьцуулахад харьцангуй хялбар болгосон гэж дүгнэдэг¹³. Хүчний тэнцвэрийн талаарх либерал үзэл нь нэгж улс орнуудаас илүү олон улсын хамтын нийгэмлэг руу илүү хэлбийсэн байдаг.

⁹ Paul D. Williams.,(2008). Security Studies: an Introduction. New York: Routledge Хуудас 43

¹⁰ Michael W. Doyle., (1983). Kant, Liberal Legacies and Foreign Affairs. Philosophy and Public Affairs. 13 (3) [Online] Available from: JSTOR < <http://www.jstor.org/stable/pdfplus/2265298.pdf?acceptTC=true>>

¹¹ Michael W. Doyle., (1986). Liberalism and World Politics. The American Political and Science Review. 80 (4) [Online] Available from: JSTOR <<http://www.jstor.org/stable/pdfplus/1960861.pdf>>

¹² Thomas Dietz, Ingvilid Bode and Aleksandra Fernandes da Costa., (2011). Key Concepts in International Relations. London: SAGE printing. Хуудас 133

¹³ Tim Dunne, Milja Kurki and Seteve Smith., (2010). International Relations Theories: Discipline and Diversity. New York: Cambridge University Press. Хуудас 117

Дүгнэлт

Хүчний тэнцвэр бол олон улсын харилцааны чухал концепц юм. Гэвч энэ концепцыг ашиглан бүх төрлийн нөхцөл байдлыг тайлбарлах, ойлгох боломжгүй байдаг.

Реалист урсгалын Хүчний тэнцвэрийн талаарх нь үзэл нь товч бөгөөд үр ашигтай байдаг. Хэдийгээр хүчний тэнцвэрийн концепцыг түүхэн үйл явдлууд, тухайлбал Наполеоны аян дайнууд, Дэлхийн хоёрдугаар дайн, Хүйтэн дайн зэргийг тайлбарлаж, ойлгоход хэрэглэх боломжтой ч бусад үеийн түүхэн үйл явцыг бүрэн тайлбарлаж чаддаггүй. Пелопоннезийн дайны үед Афины хот улс өөрийн уламжлалт гол дайсан Спартын эсрэг олон жил дайтсаны дүнд дайны явцад давамгайлж, ялах байдалтай болж иржээ. Гэтэл үүний дараа Афины хийсэн үйлдлийг хоёр туйлт системийн хүчний тэнцвэрийн концепцын дагуу бүрэн тайлбарлах боломжгүй болно. Афинчуудын хоёр туйлт системийн дагуу Спартуусдаас давуу өөрийн байр сууриа бэхжүүлж системийг өөртөө таатайгаар зохицуулах боломжтой байсан хэрнэ Сицили арал руу цэргийн экспедиц илгээн, тэр нь бүх талаар амжилтгүй болж өөрсдийнх нь давуу байдлыг үгүй хийсэн байдаг. Ийнхүү Афинчууд системийн туйл үүсгэж тогтвортой байдал үүсгэлгүй өөрийгөө тэлэх алхам хийсэн нь хүчний тэнцвэрийн ойлголтоор тайлбарлахад төвөгтэй жишээ болсон байдаг.

Либерал урсгалын хүчний тэнцвэрийг институт хоорондын хөдөлгөөн гэж үзсэн нь сонирхолтой. Үүний дагуу авч үзвэл орчин үеийн олон улсын харилцааны системийн тогтворжуулагч, хүчний тэнцвэр үүсгэгч хүч нь НАТО, ШХАБ, БРИКС зэрэг байгууллагууд болно.

Түүхийн туршид олон улсын харилцаа нь өөр өөрийн онцлог бүхий олон үеүдийг туулж өнгөрүүлсэн билээ. Тус тусад нь хэрэглэсэн тохиолдолд реалист болон либерал онолын урсгалын хүчний тэнцвэрийн талаарх ойлголтын аль аль тэдгээр онцлог бүхий үеүд, үйл явдлуудыг бүрэн тайлбарлаж чадахгүй. Өөрөөр хэлбэл хүчний тэнцвэрийн тухай реалист үзэл Хүйтэн дайны үед хүчээ авч байсан бол энэ үе дууссаны дараа ач холбогдол нь буурсан байдаг. Харин либерал үзэл цаг хугацааны хувьд орчин үеийн үйл явдлыг тайлбарлахад ач холбогдол өндөр ч түүхийн өмнөх үеүдэд болсон үйл явцыг бүрэн тайлбарлаж чаддаггүй. Тэдний хүн хоорондын харилцаа, худалдааны харилцаа холбоонд тулгуурладаг ойлголт нь аж үйлдвэрийн хувьсгалаас өмнөх үеүдийн үйл явц, тэр дундаа дайн ба энхийн асуудлын тайлбарлахад төвөгтэй болгодог. Энэхүү хязгаарлагдмал байдлыг неолибералистууд 20 дугаар зууны олон улсын хамтын ажиллагааг тайлбарлахдаа тусгасан байдаг. Иммануэль Кант Кёнигсберг дэх гэртээ либерал онолын үндсэн санаануудаас дэвшүүлэн сууж байсан тэр үед Европ аль хэдийн эдийн засгийн харилцан хамаарал, хүн хоорондын харилцааг төлөвшүүлээд эхэлчихсэн байв.

Хүчний тэнцвэр, эвсэл холбооны тухай ялгаатай үзэл бүхий эл хоёр онолын үзлийг хавсран судлах нь олон улсын харилцааны өнгөрсөн болоод ирээдүйн явцыг судлах, үндэслэлтэйгээр таамаглахад чухал алхам болох юм.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Thomas Dietz, Ingvild Bode and Aleksandra Fernandes da Costa., (2011). Key Concepts in International Relations. London: SAGE printing.
2. James E. Dougherty and Robert L. Pfaltzgraff Jr., (2001). Contending theories of International Relations: A Comprehensive Survey. London: Longman. Page 533
3. Kenneth Neal Waltz., (1979). Theories of International Relations. London: Mcgrew-Hill.
4. Jack Donnelly., (2002). Realism and International Relations. New York: Cambridge University Press.
5. Ernst B. Haas., (1953). The Balance of Power as a Guide to Policy Making. Journal of Politics. **15**.
6. Paul D. Williams.,(2008). Security Studies: an Introduction. New York: Routledge.
7. Tim Dunne, Milja Kurki and Seteve Smith., (2010).International Relations Theories: Discipline and Diversity. New York: Cambridge University Press.
8. Michael W. Doyle., (1983). Kant, Liberal Legacies and Foreign Affairs. Philosophy and Public Affairs. **13** (3) [Online] Available from: JSTOR < <http://www.jstor.org/stable/pdfplus/2265298.pdf?acceptTC=true>>
9. Michael W. Doyle., (1986). Liberalism and World Politics. The American Political and Science Review. **80** (4) [Online] Available from: JSTOR <<http://www.jstor.org/stable/pdfplus/1960861.pdf>>
10. Randall. L. Schweller., (1997). New Realist Research on Alliances: Refining, Not Refuting, Waltz's Balancing Proposition. American Political Science Review. **91** (4), 927-930. [Online] Available from: JSTOR <http://www.jstor.org/stable/2952176>

Байлдааныг зохион байгуулах үеийн захирагч, штабын ажилд тавигдах шаардлагын судалгаа

Ц.Гандорж

БХЭШХ-ийн Цэргийн урлаг судлалын
төвийн дарга, доктор (Ph.D), хурандаа

Хураангуй: Байлдаанд ялалт байгуулахад түүнийг зөв зохион байгуулах нь чухал бөгөөд үүнд захирагч, штабын ажиллагаа ихээхэн үүрэгтэй байдаг. Иймд захирагч, штабт шийдвэр гаргах аргазүйг эзэмших, байлдааны ажиллагааг оновчтой төлөвлөх, дээд штаб болон зэргэлдээх анги, салбаруудтайгаа харилцан ажиллагааг зөв зохион байгуулах шаардлага тавигддаг.

Түлхүүр үг: Байлдааныг зохион байгуулах, захирагч, штаб, шийдвэр гаргах, төлөвлөх, харилцан ажиллагаа.

Key words: Organization of the combat operation, commander, command post, decision making, coordination and cooperation

Байлдааныг зохион байгуулах нь захирагч, штабын үндсэн үүрэг бөгөөд дараах ажлуудыг журам мэт хэрэгжүүлнэ. Үүнд: шийдвэр гаргах, салбаруудад байлдааны үүргийг хүргэх, харилцан ажиллагаа болон бүх талын хангалтыг зохион байгуулах, байлдааны үүргийг биелүүлэхэд салбаруудын бэлтгэлийг хангах зэрэг ажлууд багтаж байна.

Байлдааны ажиллагаанд бэлтгэх нь ахлах даргаас үүрэг хүлээж авахаас эхлэх бөгөөд дараах асуудлуудыг авч хэрэгжүүлэхэд чиглэнэ. Үүнд:

- Байлдааны ажиллагааг зохион байгуулах, үүнд шийдвэр гаргах, байлдааны ажиллагааг төлөвлөх, өөрийн үүргийг судлах, харилцан ажиллагааг зохион байгуулах, бүх талын хангалт болон удирдлагаар хангах;
- Өгөгдсөн үүргийг биелүүлэхийн тулд салбаруудын бэлтгэлийг хангах;
- Байлдааны журам, тэдгээрийн байрлалыг сонгох, бэлтгэх;
- Соёл хүмүүжлийн ажлыг зохион байгуулж явуулах;
- Захирагдсан салбаруудын захирагч, штабтай дадлага, сургууль явуулах;
- Бусад арга хэмжээ.

Байлдааны тушаал хүлээн авч шийдвэрээ гаргахын тулд захирагч, штаб нь цагийн байдлын мэдээнд дүн шинжилгээ хийх нь хамгийн чухал юм. Иймээс захирагч, штаб нь цагийн байдлын мэдээг дайсны цэргийн, өөрийн цэргийн, зэргэлдээх анги, салбаруудын, газар орны, цаг улирлын, ус, цаг уурын, нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн болон байлдааны үүргийг биелүүлэхэд нөлөөлөх бусад хүчин зүйлүүдийг тооцдог байна. Дээрх бүгдэд дүгнэлт хийснээр захирагч, штаб нь шийдвэр гаргах болон салбаруудын үүргийг тодорхойлоход анхаарлаа хандуулах ёстой байдаг. Дайсны тухай мэдээнд дүн шинжилгээ хийх нь хамгийн чухал асуудлын нэг бөгөөд энэ нь байлдааны ажиллагаанд нөлөөлөх объект төдийгүй дайсны үйл ажиллагаанаас өөрийн цэргийн ажиллагаа ихээхэн шалтгаалах нь тодорхой.

Иймд дайсны цэргийн байдлын үнэлгээнээс эхлэх нь зүйн хэрэг юм. Дайсны цэргийн байдлыг үнэлэхийн тулд захирагч, штаб нь дайсны цэргийн бие бүрэлдэхүүн, байрлал, бүлэглэл, ажиллагааны бодлого, удирдлага, хяналтын байр зэрэг чухал объектууд, байлдааны ажиллагаанд нөлөөлж болохуйц тоноглож, төхөөрөмжилсөн газар, орнуудыг үнэлэх шаардлага тулгардаг. Гэхдээ дайсан өөрийн цэргийн ажиллагааг хууран мэхлэх, нууцлах, төөрөгдөлд оруулахыг эрмэлздэг тул дайсны цэргийн байдлыг үнэн, зөв тогтоох нь тийм ч амар биш юм. Ийм учраас дайсны талаарх мэдээ, мэдээллийг их цуглуулах, түүнд захирагч, штаб үнэн, зөв дүгнэлт гаргах нь чухал ач холбогдолтой байна.

Өөрийн цэргийн байдлыг үнэлэх нь дайсныг үнэлэхээс хялбар байна. Өөрийн цэргийн үнэлэхэд байрлал, орон тооны болон хавсрагдсан салбаруудын байдал, материал, техник хангалтын байдал, бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн байдал, байлдааны тухайн үүргийг гүйцэтгэх боломж, чадавх зэргийг тодорхойлно. Ингэснээр цаашид авах арга хэмжээ болон салбаруудын үүргийг тодорхойлж өгнө. Цаашид авах арга хэмжээнд салбаруудын бэлэн байдал, байлдааны чадавхыг дээшлүүлэх, байрлал, бүлэглэлийг тавигдсан үүрэгт нийцүүлэн шинэчлэх, хүч хэрэгслийн харьцааг тооцож дээд штабаас дэмжлэг хүсэх зэрэг ажил, арга хэмжээнүүд багтана.

Байлдааны ажиллагааны газар орны байдлыг үнэлэхэд газар орны өнгөлөн далдлалт, хамгаалалт болон гадаргуу, зам харгуйн маневр, тээвэрлэлт болон татан гаргалт хийж болохуйц байдал, минны болон бусад саадуудын байрлал, шинж чанаруудыг тогтооно.

Цаг улирлын болон ус цаг, уурын байдалд үнэлгээ хийснээр өвөл, зуны онцлогт тохирсон бэлтгэлийг хангах, цаг агаар, хур тунадас, салхины хурд, чиглэлийг тодорхойлсноор байлдааны үүрэг биелүүлэхэд хэрхэн нөлөө үзүүлж болохуйц байгаа зэргийг тооцно.

Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм, улс төрийн байдалд үнэлгээ хийснээр өөрийн талын байлдааны ажиллагаанд эерэг болон сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлс, эдийн засгийн нөөц хүч бүрдүүлэх боломж зэргийг тогтооно.

Дээрх бүгдэд үнэлгээ, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр захирагч, штаб өөрийн цэргийн хүч, хэрэгслийг хуваарилах, хүч задлах зааг, дамжин өнгөрөх завсар, үзүүр болон байрлалаа эзлэх цаг, хугацаа зэргийг нарийн тодорхойлох үүрэгтэй.

Шийдвэр гаргахад захирагч, штабын ажилд тавигдах шаардлагын судалгаа

Шийдвэр гаргахад захирагч, штабын удирдах урлаг маш олон талтай гэж хэлж болно. Үүний нэг нь цэргийн удирдлагын урлагийн зарчмын шаардлагыг хангаж байх явдал бөгөөд энэ нь цагийн байдалд тохирсон удирдлагаар тасралтгүй хангах, үүний тулд дайснаас өрсөж цаг хожих, гэнэтийн хүчтэй цохилтыг хийх, хүч, хэрэгслийг зөв ашиглах, маневрыг зоримоогоор хийх явдал ихээхэн чухал юм. Эдгээрийг хэрэгжүүлэхэд захирагч, штабт санаачилгыг гартаа авах, мэдлэг, ур чадвартай байх, шийдэмгий, шулуун шударга байх, зүрх зориг, хурц ухаантай, овсгоо самбаатай, шаргуу зантай, үлгэр дуурайлалтай байх гэсэн тусгай шаардлагуудыг хангаж байх ёстой байна.

Захирагч, штаб үүргээ судалж шийдвэрээ гаргахдаа 1 дугаар зурагдахь аргагүйг мөрдлөгө болгох нь зүйтэй. Мэдээж шийдвэр гаргах явц нь амаргүй, маш төвөгтэй үйл ажиллагаа бөгөөд ихээхэн зөрчилдөөн дундаас гарч ирдэг, өөрөөр хэлбэл тодорхойгүй гэж хэлж болохоор алхам юм.


Иймд захирагч, штаб үүргээ хүлээж авсны дараа дараах материалуудыг бүрдүүлсэн байх нь зүйтэй юм. Үүнд: ахлах даргын тушаал, шийдвэр, төлөвлөгөө; ажиллагааны газар орны газрын зураг; шаардлагатай байлдааны дүрмүүд болон штабын тооцоо, өгөгдөхүүнүүд; өөрийн болон ахлах даргын тогтсон ажиллагааны журмууд байна.

Дараагийн нэг чухал асуудал бол цагийн байдлыг үнэлэх бөгөөд 1 дүгээр зурагт заагдсан функцүүдэд үнэлгээ хийхийн тулд дараах алхмуудыг хэрэгжүүлэх ёстой бөгөөд энд юуны өмнө ахлах даргын тушаал, шийдвэрт шинжилгээ хийх буюу үүргээ тодотгох бөгөөд ингэснээр өөрийн анги, салбарыг ахлах даргын болон зэргэлдээ анги, салбартай харилцан ажиллагаатайгаар биелэгдэх нөхцөл бүрдэх; байлдааны ажиллагааны бэлтгэлд тагнуулын мэдээ цуглуулснаар газар орны болон учирч болох аюулыг үнэлэх; өгөгдсөн үүргийг биелүүлэхийн тулд бусад дагалдах үүргүүдийг тодотгох, үүний тулд ахлах даргаас ямар үүргүүдийг зааж өгсөн, эдгээр үүргүүдийг биелүүлэхэд ямар дагалдах үүргүүдийг биелүүлэх ёстой вэ, гэхдээ эдгээр үүргүүд нь ахлах даргын тушаалд дурдагдаагүй байх зэрэг байна.

Захирагчийн шийдвэр гаргах ажиллагаа нь математик үндэслэлтэй, логик гаргалгаатай, сайтар тунгаан бодсон байх шаардлагатай бөгөөд энэ талаар Макиавелли “Цэргийн хэргээс өөр хаана ч ийм нарийн тооцоо шаардахгүй” гэж онцолж хэлсэн байдаг¹. Үүнээс гадна цэргийн техник, технологийн дэвшил нэмэгдсэнээр байлдааны ажиллагааг төлөвлөх явц сайжирч ердийн нүдэн баримжаагаар баримжаалах явдал баталгаагүй


¹ Сандалов Л.М. Трудные рубежи. -М.: Воениздат. 1965. –С.18;

болоод байна.



2. Цагийн байдалд үнэлгээ хийх, бодлого тодорхойлох ерөнхий санааг бий болгох

3. Бодлого тодорхойлох



4. Байлдааны үүргийг тодорхойлох



5. Харилцан ажиллагаа, бүх талын хангалт зохион байгуулалт

6. Улирлага, зохион байгуулалт

1 дүгээр зураг. Захирагчийн байлдааны шийдвэр гаргах аргазүй

Шийдвэр гаргахад таамаглаагүй, гэнэтийн тохиолдол 1:3 харьцаатай байж болно гэж Наполеон үзэж байжээ². Хэрэв ийм харьцаатай байвал сайн учрыг ойлгосон байна гэж үзэх талтай байна. Гэхдээ автоматжуулсан тооцоог ашигласан үед энэхүү харьцаа нь 1:7 байх ёстой байна. Хэрэв ийм харьцаатай шийдвэрийг гаргаж чадвал ихээхэн оновчтойд тооцох

² Русская военно-теоретическая мысль XIX и начале XX веков. М., 1960. -С.389;

бөгөөд үүнд өөрийн болон дайсны цэргийн байлдааны боломжийг зөв үнэлэх, байгаа хүч, хэрэгслээ ихдүүлж, багадуулалгүй харьцуулж үзэх нь цагийн байдлыг үнэлэхэд хамгийн хүндрэлтэй асуудлын нэг юм.

Шийдвэр гаргахад мэдээлэл олзворлох явдал ихээхэн чухал бөгөөд нийт мэдээний 50 хувь дайсны тухай, 30 хувь өөрийн цэргийн тухай, 15 хувь газар орны талаар, 5 хувь радиаци, хими, биологийн цагийн байдлын талаарх мэдээнүүд байвал зохимжтой гэж үздэг³.

Мөн цаг хугацааны хүчин зүйлийг зөв үнэлэх нь чухал бөгөөд байлдааны үүргийг биелүүлэх, түүний зохион байгуулалтаас ихээхэн шалтгаалах нь тодорхой юм. Цаг, хугацааг ухаалагаар зөв тооцсоноор цэргийн хүчний хүчин зүйлсэд шилжих нөхцөлийг олгодог. Цаг хугацаа хожих нь дайсныг түрүүлж дарах боломжийг олгох бөгөөд өөрийн байлдааны журмыг эмхлэх, хөдөлгөөн, маневрыг цаг тухайд нь хийх, байлдааны чадавхаа сэргээх нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Түргэн, динамик аргаар цэргийг удирдах нь ихээхэн чухал, цаг хугацааг бодитоор тооцсоноор минут, секундыг үнэлж, цэгнэх, богино хугацаанд хөдөлгөөний явцад шийдвэрээ гаргах, байлдааны үүргийг салбаруудад хүргэх, харилцан ажиллагааг зохион байгуулах, дайсанд галын хөнөөл үзүүлэх, байлдааны явцад бүх талын хангалтыг хийхэд ихээхэн нөлөөтэй юм. Гэхдээ түргэн байх нь удирдлагын ганц, чухал чанар биш энэ нь бодит, үнэн зөв тооцоон дээр суурилагдаж шуурхай, өндөр зохион байгуулалт болон бүх салбар, нэгжүүдийн итгэлцэл, зөвшилцлийн үр дүнд явагдана.

Цаг, хугацааны төлөөх тэмцэл нь хоёр талын шинж чанартай бөгөөд үүний төлөө дайсан ч өөрийн хүч бололцоогоо дайчлах нь тодорхой. Иймээс дайсны үйл ажиллагаанд хүндрэл учруулахын тулд тогтоох, чиг баримжааг алдагдуулах, хууран мэхлэх, бэлэн бус байдлаа харуулах, сандралд оруулах, хөдөлгөөн, маневр бүрийг нь хүчтэй сөрөг маневраар хариу барих зэрэг байж болно. Цаг хугацаа хожих энэхүү тэмцэл нь идэвхи, санаачлагатай үйл ажиллагаа болон гэнэтийн байх хүчин зүйлсийг ашигласнаар үр дүнтэй байна.

Цаг, хугацаа хожих гэдэг нь дайснаас өрсөж цохилт өгөх, түүний темп, динамик зэргийг бий болгосноор дайснаа ялах үндсийг бий болгоно.

Иймээс дарга, захирагчийн шийдвэр гаргах арга зүйг уламжлалт, хэвшмэл (рутинной) болон бүтээлч (творческий) гэсэн хоёр системийн нэгдэлээр авч үзэх нь зүйтэй. Бүтээлч арга зүйд захирагч, даргын хувийн оюун ухаан, бодол, байлдааны бодлогыг тодорхойлох түүний үр дүнгээс шийдвэрийн үндэс урган гарна. Харин хэвшмэл арга зүй нь зорилго агуулсан байх бөгөөд бүтээлч арга зүйг бий болгох таатай нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

Байлдааны ажиллагааны бодлогыг тодорхойлж салбаруудыг байлдааны үүргээр хангахад удирдлага, харилцан ажиллагаа, бүх талын хангалтыг зохион байгуулах бөгөөд үүнд юуг, хэзээ, хэрхэн хамгийн бага хүчин чармайлт, хохиролтойгоор даван гарах нь чухал асуудлын

³ Воробьев И.Н. “Тактика –искусство боя”. Москва.2002. - С.334;

нэг байна. Гэхдээ захирагч, даргын энэхүү шийдвэр бүгдийг тодорхой харгалзан үзэхэд бэрхшээлтэй бөгөөд ямарваа нэг эрсдэлийг дагуулдаг.

Эрсдэлийн талаар Клаузевиц бичихдээ “ Эрсдэлийг тооцохдоо өөрийн мэргэн ухаан, болгоомжлолоос гадна тодорхой масштабаар хэмжигддэг”⁴ гэсэн байдаг бол армийн генерал С.М.Штеменко “Эрсдэлийн түвшинг бууруулахын тулд бүх талын арга хэмжээг авах хэрэгтэй, гэхдээ захирагч, дарга түүнийг бүрмөсөн арилгахыг эрмэлзвэл амжилтад хүрэх нь юу л бол гээд энэхүү эрмэлзлэл нь шийдвэргүй байдал, сандрал болон санаачлагаа алдах зэрэг аюултай байдлын эх үүсвэрийг бий болгон, захирагч, дарга нь эрсдэлийн цар хүрээг мэдэж, түүнийг ямагт нягталж байх шаардлагатай” гэжээ.

АНУ-ын байлдааны дүрэм FM 90(01)-д захирагчийн эрсдэлийг бууруулах хамгийн чухал хүчин зүйл бол дайсны талаарх тагнуулын мэдээ гэж үзсэн байдаг бөгөөд аль хэр их мэдээлэлтэй байна тэр хэмжээгээр эрсдэл бага байна гэж үзжээ.

Байлдааныг төлөвлөхөд захирагч, штабт тавигдах шаардлагын судалгаа

Байлдааныг төлөвлөх нь салаа, түүнээс дээшхи салбаруудын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ бөгөөд цэргийг байлдаанд удирдах ажиллагаанд чухал байр эзэлдэг. Тэрээр салбаруудын байлдааны үүрэг, галын хөнөөлийн журам, салбаруудын харилцан ажиллагаа, ёс суртахуун, сэтгэл зүйн бэлтгэл, байлдааны, техникийн, ар талын хангалт болон удирдлага зохион байгуулалтын ажлууд багтаж байна. Байлдааны ажиллагааны төлөвлөлт нь дараалсан болон зэрэгцээ аргаар явагдах ба хосолсон аргыг ч мөн хэрэглэж болно.

Дараалсан аргад цэргийн дээд шатны нэгж байлдааны ажиллагааг төлөвлөж дуусаад, доод шатны нэгжид дараалан төлөвлөх буюу дээрээс доошоо дараалан төлөвлөх ажиллагаа юм. Энэхүү аргын давуу тал нь төлөвлөлт бүрэн хийгдэж, дээд шатны штаб доод шатны штабын ажилд тусалж, дэмжсэнээр чанартай төлөвлөлт явагдагт байна. Харин дутагдалтай тал нь цаг хугацаа их шаардахаас гадна доод шатны штабын бие даасан байдал, санаачлага, идэвхтэй байдлыг алдагдуулахад хүргэж болзошгүй байдаг байна.

Зэрэгцээ аргаар төлөвлөх гэдэгт дээд шатны штаб төлөвлөлтийг доод шатны штабтай нэгэн зэрэг боловсруулах үйл ажиллагааг хэлж байгаа бөгөөд цаг хугацааг хэд дахин хэмнэх, байлдааны ажиллагаанд бэлтгэх хугацааг доод шатанд олгодгоороо давуу байна. Гэхдээ энэхүү зэрэгцээ аргаар төлөвлөхөд тодорхой нөхцөлүүд, өөрөөр хэлбэл анхны өгөгдөхүүнүүд байх шаардлагатай юм.

Байлдааныг төлөвлөхөд ямар заавар ашигласан болон цаг хугацааны боломжоос шалтгаалж төлөвлөлт нь чанартай, чанаргүй боловсруулагдах магадлалтай юм. Практик, дадлага, туршлагаас байлдааныг төлөвлөхөд нэгдүгээрт, дайсны цэргийн бүлэглэлийн боломжит хувилбар, түүний

⁴ Клаузевиц. О войне. Т.1. Москва.: Воениздат, 1937. С.52;

арга, ажиллагаа; хоёрдугаарт, байлдааны үүргийг биелүүлэхэд дайсныг дарах, устгах арга, ашигтай байлдааны журмын байгуулалтыг тодорхойлох, хүч, хэрэгслийн хуваарилалтыг үндэслэлтэй бий болгох; гуравдугаарт, төлөвлөлтийн бичиг, баримтыг боловсруулах, захирагдсан анги, салбаруудад байлдааны үүргийг хүргэх; дөрөвдүгээрт, анги, салбаруудыг байлдаанд бэлтгэхэд хяналт, шалгалт хийж дэмжлэг үзүүлэхэд чиглэгддэг байна.

Байлдааныг төлөвлөх ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэлтэй, объектив, олон талт, оновчтой, цогц гэсэн ерөнхий зарчим, байлдааны бодлоготой уялдаатай, дайсны байлдааны журмын бүх гүнд нэгэн зэрэг нөлөөлөх, тактикийн байлдааны ажиллагаа нь операцын үүргийг биелүүлэх боломжийг олгох, байлдааны үүргийн бүх шатанд санаачлагыг гартаа авахад дэмжлэг үзүүлэх зэрэг тусгай зарчмыг баримталдаг.

Байлдааныг төлөвлөхөд хүндрэлтэй асуудлын нэг нь талуудын байлдааны боломжийг тодорхойлох явдал юм. Тиймээс энэ зорилгын үүднээс урьдчилан тооцоо хийх шаардлага гардаг бөгөөд тооцооны хувилбарыг 1 дүгээр хүснэгтэд харуулав.

1 дүгээр хүснэгт

Байлдаанд талуудын хохирлын тооцоололт⁵

Хориглолтод байгаа хүчний боломжит хохирлын хэмжээ	Давшилтад байгаа хүчний боломжит хохирлын хэмжээ				
	30%	35%	40%	45%	50%
50	1,2	1,14	1,08	1,04	1,00
55	1,25	1,18	1,12	1,07	1,02
60	1,28	1,21	1,15	1,10	1,06
65	1,31	1,23	1,17	1,12	1,08
70	1,34	1,28	1,19	1,14	1,10

Энэхүү хүснэгтийн тусламжтай захирагч, штаб нь байлдааны ажиллагааны явцад богино хугацаанд байлдааны чадавхаа сэргээхэд шаардлагатай тооцоо хийхэд ихээхэн дөхөмтэй байна.

Харилцан ажиллагааг зохион байгуулах үеийн захирагч, штабт тавигдах шаардлагын судалгаа

Харилцан ажиллагаа зохион байгуулах нь байлдааныг зохион байгуулах үеийн нэгэн хариуцлагатай шат юм. Тэр нь байлдааны төрөл, цагийн байдлын нөхцөлөөс хамааран, байлдаан болгонд өөр өөр онцлогуудтай байна.

Байлдааны үеийн харилцан ажиллагааны үндэс нь гурван үе шаттай явагддаг. Үүнд, нэгдүгээр үе шатанд харилцан ажиллагаанд шаардлагатай анхны өгөгдөхүүнүүдийг тодорхойлох, хоёрдугаар үе шатанд харилцан ажиллагааг зохион байгуулах байлдааны баримт бичгийг боловсруулах, гуравдугаар үе шатанд боловсруулсан бичиг

⁵ Воробьев И.Н. “Тактика –искусство боя”. Москва.2002.-С.357;

баримтыг захирагч баталснаар хэрэгжүүлэхэд бэлэн болгодог байна⁶.

Харилцан ажиллагаанд шаардлагатай анхны өгөгдөхүүнийг тодорхойлоход юуны өмнө дээд штабын харилцан ажиллагааны зохион байгуулалтын талаарх заавар, цель заах, таниулах, удирдлага, харилцан ажиллагааны зарлан мэдээлэх сигнал, дохио болон харилцан ажиллагааг зохион байгуулах үндсэн байлдааны баримт бичгүүдийг боловсруулах ажил багтана.

Харилцан ажиллагааны байлдааны баримт бичгийг боловсруулах, харилцан ажиллагааны бэлтгэлийг хангахад удирдлага, харилцан ажиллагаа, бүх талын хангалтыг зохион байгуулах үндсэн асуудлууд, байлдааны тушаал, тагнуул, галын хөнөөлийн төлөвлөгөө зэргийг боловсруулах, офицеруудыг газар орон болон газар орны үзүүлэн материалууд дээр бэлтгэл хангах, удирдлага, хяналтын байруудыг төхөөрөмжлөх зэрэг ажлууд хийгдэнэ.

Боловсруулсан баримт бичгийг захирагч баталснаар 2-3 доод шатанд тушаал хүргэгдэх, байлдаанд анги, салбараа удирдах, харилцан ажиллагааг зохион байгуулахын тулд удирдлага, хяналтын байр руу хөдөлгөөн үйлдэх, анги, салбаруудын болон холбоо, мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг нягталж, шалгах зэрэг ажлууд хийгдэнэ.

Харилцан ажиллагааг амжилттай явуулахад газар орон дээр артиллери, танкийн салбаруудтай байлдааны ажиллагааны талаарх нэгдсэн ойлголт, зөвшилцөлд хүрэх явдал чухал бөгөөд мотобуудлагын батальонд артиллерийн дивизион, танкийн рот хүртэлх нэгжтэй харилцан ажиллагааг бүх байлдааны явцад тасралтгүй явуулж байх ёстой. Алдагдсан тохиолдолд цаг алдалгүй түүнийг сэргээж, цагийн байдлын өөрчлөлттэй уялдуулан байнга тодотгож байвал зохино.

Харилцан ажиллагааг зохион байгуулах үндсэн арга нь газар орон дээр захирагч биечлэн зааж, заавар өгөх явдал юм. Харин тийм боломжгүй, цаг хугацаа бага үед газар орны дүрслэл, бүдүүвч, зураг дээр харилцан ажиллагааг зохион байгуулдаг. Харилцан ажиллагааг зохион байгуулахад нэгдүгээрт, анги, салбаруудад байлдааны журам, байлдааны үүрэг, зааг, цаг хугацаа, ажиллагааны хувилбар, чиглэл болон арга хэрэгслийг, хоёрдугаарт, байлдааны ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анги, салбаруудын байр, журмыг нарийн тодорхойлоход оршиж байна⁷.

Харилцан ажиллагааг зохион байгуулах үндсэн зарчимд дараах асуудлуудыг авч үзэж болно. Үүнд:

1. Харилцан ажиллагааг зохион байгуулах гол үндэс нь орон тооны болон хавсрагдсан анги, салбарууд болон бусад элементүүдийн цөмийн зэвсэг, авиацийн цохилт, артиллерийн гал зэргийг тавигдсан үүргийг биелүүлэхийн тулд шийдвэртэй, хүчтэй явуулах.

⁶ Воробьев. И.Н. “Тактика – искусство управления”. Военная Мысль. №1 2003: -С 34;

⁷ Шавлов А.В., С.И.Ковалёв, Кузнецов В.М.” Взаимодействие подразделений в общевойсковом бою”. Челябинск. 2010. –С.8;

Энэхүү зарчим нь юуны өмнө ахлах даргын шийдвэрээр цөмийн зэвсэг хэрэглэх үндсэн хөнөөлийн хэрэгслийг ашиглах эсэхийг тодорхойлоход орших бөгөөд үүний тулд анги, салбарууд, тусгай хүчин болон бусад элементүүдэд ямар хэмжээтэй, хаана, хэзээ цөмийн зэвсэг хэн хэрэглэх талаар тодорхой заавар өгөх;

2. Анги, салбарууд харилцан ажиллагааг зохион байгуулахдаа байлдааны үүрэг, чиглэл, зааг, цаг хугацаагаар зохицуулах;
3. Бүх төрлийн байлдаанд хүч хэрэгслийг зөв ашиглах;
4. Өөр хоорондоо болон зэргэлдээх анги, салбаруудад харилцан туслалцах;
5. Байлдааны туршид тасралтгүй зохион байгуулах гэсэн зарчмуудыг баримтална⁸.

Орчин үед байлдааны ажиллагаа явагдах газар орон, объектын дуураймал талбай, объект, полигон байгуулан, тэдгээр дээр байлдааны бэлтгэл, сургалт дадлага хийх, түүний явцад харилцан ажиллагааг зохион байгуулах нь элбэгшиж байна.

Харилцан ажиллагааг зохион байгуулахад холбоо, мэдээллийн хэрэгсэл чухал бөгөөд ерөнхий байлдааны үүргийг биелүүлж байх явцад бүх төрөл мэргэжлийн цэргүүдтэй холбоо, харилцаа тогтоож ойлголцлоо тодотгоход оршино. Авиацийг ерөнхий цэргийн анги, салбарын байлдааны ажиллагаанд ашиглаж байгаа тохиолдолд харилцан ажиллагааг дээд штаб, командлалаас шийдвэрийн дагуу зохион байгуулна.

Зарим онцгой тохиолдолд нэгтгэл, анги салбаруудын гол цохилтын чиглэл дэх харилцан ажиллагааг дээд штабын хүч хэрэгслээр холбооны ахлах даргын удирдлага дор явуулах тохиолдол гардаг байна.

Орчин үед харилцан ажиллагааг зохион байгуулах ур чадварыг эзэмшихийн тулд офицеруудад дайн, байлдааны ажиллагааны шинж чанар, байлдааны зэвсэглэл, техникийн хүчин чадал, байлдаанд тэдгээрийг хэрэглэх арга болон операц, тактикийн түвшний тооцоололт зэргийн талаар гүнзгий мэдлэгтэй байх, цагийн байдлын талаарх мэдээнд тулгуурлан харилцаа, холбоог тогтоохоос гадна харилцан ажиллагааны системийг бий болгох чадварыг шаардах болоод байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Ц.Дашзэвэг. “Цэргийн удирдлагын үндэс” УБ 2003 он;
2. Сандалов Л.М. Трудные рубежи. –М.: Воениздат. 1965;
3. Русская военно-теоретическая мысль XIX и начале XX веков. М., 1960;
4. Воробьев И.Н. “Тактика –искусство боя”. Москва.2002;
5. Клаузевиц. О войне. Т.1. Москва.: Воениздат, 1937;
6. Шавлов А.В., С.И.Ковалёв, Кузнецов В.М.” Взаимодействие подразделений в общевойсковом бою”. Челябинск. 2010.

⁸ Мөн тэнд;

“Зэвсэгт хүчний тусгай томилгоот анги, салбарын террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны сургалтын туршлага, сургамж”

С.Пүрэвдорж.

БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
доктор (Ph.D), дэд професор

Агуулга:

1. Террорист зэвсэгт бүлэглэл;
2. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны сургалт бэлтгэлжилт;
3. Туршлага, сургамж;

Түлхүүр үг: Терроризм, террорист үйлдлийн, террорист зэвсэгт бүлэглэл, сөрөг тусгай ажиллагаа, сөрөг тусгай ажиллагааны сургалт бэлтгэл, туршлага, сургамж.

Үндсэн хэсэг

Зэвсэгт хүчний цэргийн анги, салбарыг терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагаанд ашиглах, түүний сургалт бэлтгэлжилтийн тухай асуудлыг судлан үзэхийн тулд, юуны өмнө терроризм¹, террорист зэвсэгт бүлэглэл гэж юу болох, түүний үүсэх нөхцөл, шалтгаан, ажиллагааны зорилго, шинж чанар, арга тактик, туршлага, сургамжийг судлан үзэх шаардлага урган гарч байна.

XX зууны сүүлч, XXI зууны эхэн үед хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжлийн түвшин урьд өмнө байгаагүй дээд хэмжээнд хүрч, шинжлэх ухаан, техник, технологийн эрчимтэй дэвшил, ирээдүйн хандлагыг тодорхойлох болж, даяаршлын эрэн үе, мэдээллийн технологийн үе нэгэнт эхэлсэн билээ.

Олон улсын терроризмын аюул хувьсан улс бүс нутгийн түвшингээс дэлхийн хэмжээнд тогтвортой байдлыг хангах асуудал болон хувирсан.

2018 оны эхний 5 сарын байдлаар дэлхийн 61 улсад 2038 удаагийн террорист халдлага гарч 15779 хүн амь үрэгдэн, 14360 хүн хөнгөн болон хүндэвтэр бэртжээ.

¹ “Терроризмтой тэмцэх тухай” Монгол Улсын хууль. УБ. 2004 он. 3.1.1 дэх заалт;

Тухайлбал, Ирак, Сири, Афганистан зэрэг улсад нийт халдлагын 50 орчим хувь, Нигер, Сомали, Ливи зэрэг улсад халдлагын 20 орчим хувь нь үйлдэгдсэн байна.

2018 оны байдлаар дэлхийн улс орнуудын терроризмын эрсдэлийн индексийг авч үзвэл эхний 10 байранд Ирак (96), Афганистан (44), Нигери (314), Пакистан (613), Сири (587), Йемен (076) аюулын түвшин хэт өндөр; Турк (7.738), Филиппин (7.098), БНХАУ (6.108) аюулын түвшин өндөр; ОХУ (5.43) аюулын түвшин дунд орнуудад оржээ.

Аюулын түвшин бүхэл индексээр эрс өссөн орнуудад Турк, Швед, Япон, Кувейт гэсэн улс орнууд багтсан бөгөөд Монгол Улсад визгүй зорчдог Турк Улсын эрсдэлийн индекс 14 дүгээр байрнаас эрс өсөж 9 дүгээр байрт орж ирсэн нь дотоодын зөрчил болох Күрдүүд, мөн төрийн эргэлт хийхээр оролдлого хийсэн төрийн алба хаагчид зэргээс хамаарч 2017 онд эрсдэлтэй 10 орны нэг болсон.

Улс орнуудад гарч буй террорист үйлдэл, түүнтэй төстэй халдлага, дайралтуудын зорилго, санаа нь харилцан адилгүй болж, тухайн бүс нутгийн зөрчил, эрх мэдлийн төлөөх тэмцэл, үндэс угсаа, газар нутгийн маргаан, шашны урсгал хоорондын таарамжгүй байдал зэрэг нь гол шалтгаан, нөхцөл болж байна.

Олон улсын терроризмын чиг хандлага өөрчлөгдөж, үйлдэж буй арга хэрэгсэл, зорилго зэрэг нь өөр түвшинд очиж байна. Террорист халдлага үйлдэж буй арга хэрэгсэл нь илүү ахуйн чанартай болж, том оврын тээврийн хэрэгсэл, хутга, шатах материал зэрэг олдоц ихтэй хэрэгсэл ашиглах болсон байна.

Терроризмын давтамж сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, 2011-2018 онд дэлхийн 140 орчим улсын 50 мянга гаруй иргэн эх орноо орхин явж, 2014 оноос хойш 30 орчим улсад 150 удаагийн террорист халдлага үйлдэгдэж, 2018 оны 5 сарын байдлаар “Исламын улс” террорист бүлэглэлийн 27000 гадаад террорист дайчид устгагдсан мэдээ байгаа бөгөөд 8200 орчим гадаад террорист дайчид 41 улс руу буцсан байна.

Нэг. Террорист зэвсэгт бүлэглэл

“Терроризм бол өөр арга хэрэгслээр явуулж буй улс төрийн тэмцлийн үргэлжлэл мөн” гэж терроризм судлаач, доктор, профессор Стивен Слоун хэлсэн байдаг².

Терроризмтой тэмцэх тухай Монгол Улсын хуульд “Террорист зэвсэгт бүлэглэл гэж террорист ажиллагаа, террорист үйлдэл явуулах зорилгоор нэгдсэн бүлэг этгээдийг хэлнэ”³ хэмээн тодорхойлсон.

Судлаачдын тооцоолсноор, түүхэнд XVII зуунд 33, XVIII зуунд 144, XIX зуунд 22, XX зуунд 560 гаруй төр, засгийн тэргүүн, улс төрийн зүтгэлтэн, сүм хийдийн их хамба нар террорист зэвсэгт бүлэглэлийн

² Е.П.Кожушко. Современный терроризм. Анализ основных направлений. Минск. 2000 он. -448 х. ISBN 985-433-723-5;

³ Терроризмтой тэмцэх тухай” Монгол Улсын хууль. 2004 он. 3.1.6 дахь заалт ;

халдлагын объект болж байжээ⁴.

Террорист бүлэглэл үүсэн гарч үйл ажиллагаа явуулж ирсэн түүхэн нөхцөл байдлыг зарим нэг террорист зэвсэгт бүлэглэлүүдээр төлөөлүүлэн авч үзвэл⁵:

1 дүгээр хүснэгт

Террорист бүлэглэлийн үүссэн нөхцөл, шалтгаан

Террорист бүлэглэлийн нэр (улс орны харьяалал)	Үйл ажиллагаа явуулж байсан хугацаа	Террорист бүлэглэл үүссэн нөхцөл, шалтгаан
“Ассасинчууд” (Ойрх Дорнодод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан загалмайны шашны үзэл, зэвсэгт аллага хоёрыг хослуулдаг)	XI-XIII зуун	-Нийгмийн дунд баян хоосны ялгаа эрс хурцадсан; -Гадаад улсын зүгээс харгис бурангуй бодлого явуулж түүнтэй баян дээдсүүд сүлбэлдэх болсон; -Нийгмийн байгууллын бурангуйг олон нийт ойлгож, түүнийг өөрчлөх нийгмийн сэтгэлгээний элемент бүрэлдсэн;
“Боомилогчид” (Энэтхэг)	XVII-XVIII зуун	-Нийгмийн дунд ядуурал газар авч, төр хүчгүйдэж, нийгмийн удирдлага суларсан; -Шашны хэт бурангуй үзэл дэлгэрч анархист нөхцөл байдал ноёрхсон;
“Зэвсэгт дээрэмчдийн бүлгүүд” (Хятад)	XIX зууны эцэс XX зууны эхэн	-Баян хоосны ялгаа эрс хурцадсан; -Засаг, төрийн удирдлага, нийгмийн харилцааны зохицуулалт алдагдсан; -Манжийн түрэмгийлэл хурцдаж, ард түмний аж байдал хүндэрсэн; -Нийгэмд танхай балмад бүлэглэл үүсч, тодорхой байр суурь эзлэх болсон;
Ажилчин - тариачин - цэргийн улаан гварди (Орос)	XX зууны эхэн үе	-Хаант төр өөрийн засаглах чадавхаа алдахад хүрсэн; -Ард түмэн аргагүй ядууралд орсон; -Нийгмийн байгууллалыг өөрчлөх марксист-ленинист онол дэлгэрэн социалист хувьсгал гарах нөхцөл бүрдсэн;

⁴ Гребин М.П. “Терроризм в XXI веке” Минск. 2004 он. -816 х. ISBN 985-13-1503-6;

⁵ Ганбат.А. “Хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэхэд хуурай замын цэргийн анги, салбарыг ашиглах нь”. УБ. 2016 он. докторын диссерац., х-101;

“Ирландын бүгд найрамдахчуудын арми” (Англи)	Эртний уламжлалтай, 1916 он болон, 1989 онуудаас үлэмж идэвхижсэн	-Англичууд Ирландыг эзлэн түрэмгийлснээс улбаатай; -Католик ба протестант шүтлэгтний хоорондын тэмцэл;
“Тупоаморос” (Уругвай)	1960-аад он	-Коммунист, социалист үзэл суртлын нөлөөнд орсон; -Социалист хувьсгалыг экспортлох оролдлого гарсан; -Нийгмийн тэгш биш байдлын хурцдалттай тулгарсан;
“Зэвсэгт нууц байгууллага” (Франц)	1960-аад он	-Алжирт үндэсний тусгаар тогтнол олгосныг эсэргүүцсэн; -Францын колонийн системийг хэвээр хадгалах болсон;
“Баскчуудын эх орон ба эрх чөлөө” (Испани)	1962 он	-Салан тусгаарлах, Басконы Эускадын тусгаар улсыг байгуулах;
“Сикхийн зэвсэгт бүлэг” (Энэтхэг)	1980 он	-Пенжаб мужийг биеэ даасан Халистан улс болгон салган тусгаарлах;
“Тамил Эламаг чөлөөлөх барсууд” (Шри-Ланк)	1983 он	-Сингалчуудаас Тамилчуудыг шахан гадуурхахын эсрэг тэмцэх; -Тамил үндэсний тусгаар улс байгуулах;
“Курдыг чөлөөлөх үндэсний фронт” (Турк)	1984 он	-Курдын тусгаар тогтносон улс байгуулах;
“Дорнод Туркестаны үндэсний чөлөөлөх фронт” (Хятад)	1984 он	-Уйгурын биеэ даасан тусгаар улс байгуулах;
“Хезболлах” (Иран)	1982 он	-Сөрөг хүчинтэйгээ тэмцэх; -Исламын ёс журмыг хамгаалах; -Израйлийн эсрэг тэмцэх; -Барууны амьдралын хэв маягийг эсэргүүцэх;
“ХАМАС”	1987 он	-Израйлийн эсрэг тэмцэх; -Палестины бүх нутаг дэвсгэрт Аллахын тугийг мандуулах;

“Аль-Кайда”	1989 он	-Исламын бүх орнуудад барууны дэглэм тогтоохыг эсэргүүцэх; -Шариатын хэм хэмжээнд тулгуурласан “Ислам улс”-ын дэглэм тогтоох;
Био алан хядах ажиллагаа (АНУ, Исламын зарим орон)	XX зууны эцэс	-Хүнийг үзэн ядах үзэл дэлгэрсэн; -Хими, биологийн хөнөөх хэрэгслээр үй олноор хөнөөх;
Экологийн алан хядах ажиллагаа (АНУ бусад хөгжингүй орнууд)	XX зууны эцсээс эхлэлтэй. Ирээдүйн болзошгүй өргөн цар хүрээтэй хууль бус үйлдэл	-Байгаль экологийг түүнд учирсан “хорт хавдар”-аас хүн төрөлхтнийг аврах; -Аж үйлдвэрлэлийг чулуун зэвсгийн үед ортол нь устгах;


Дээрх хүснэгтээс харахад, террорист зэвсэгт бүлэглэл үүсэх нөхцөл шалтгаанаар нь дараах үндсэн хэсэгт ангилан үзэж болох байна. Үүнд:

- эрүүгийн гэмт хэрэгтний зэвсэгт террорист бүлэглэл;
- төрийн эрхийн төлөөх зэвсэгт террорист бүлэглэл;
- үндэсний сэдэлтэй зэвсэгт террорист бүлэглэл;
- шашин шүтлэгийн сэдэлтэй зэвсэгт террорист бүлэглэл;
- даяаршлын шинж төлөвтэй зэвсэгт террорист бүлэглэл зэрэг болно.

“Терроризмтой тэмцэх тухай” Монгол Улсын хуульд “...Терроризм гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсвэл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөл бүрдүүлэх ажиллагааг ...” ойлгоно гэж заажээ.

Аливаа террорист ажиллагаа, хууль бус зэвсэгт үйлдэл нь ямагт дээд зэргээр нууцлагдсан байдаг учраас түүнийг нийгэм, улс төрийн өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлагын болзошгүй хувилбараар таамаглан тодорхойлохоос өөр аргагүй байна. Судалгаанаас үзэхэд, манай улсад зэвсэгт террорист бүлэглэл үүсэх гадаад ба дотоод хоёр үндсэн хүчин зүйл байна хэмээн үзэж байна.

Монгол Улсад хууль террорист бүлэглэл үүсэх болзошгүй хүчин зүйлийн нөхцөл, шалтгаан



Монгол Улсад 2019 оны эхний 6 сарын байдлаар 131 орны 28268 гадаадын иргэн хувийн хэргээр оршин сууж байгаагийн 1633 нь гэмт хэрэг зөрчилд холбогдсон, 373 иргэнийг албадан гаргасан.

2016 онд Улаанбаатар хотод хийсэн сүм хийд, шашны байгууллагын тооллогоор 372 сүм хийд, шашны байгууллага үйл ажиллагаа явуулдгаас бурхны шашны 106, христын шашны 228, исламын шашны 4, бөө мөргөлийн 22, католик шашны 7, бусад (бахай, мүүн, шинто, хиндү) шашны 5 байна. 2019 оны эхний 6 сарын байдлаар 1000 гаруй сүм хийд, шашны байгууллагын байгаагаас 800 нь зөвшөөрөлтэй, 200 нь зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг. Шашин мөнгө олох хэрэгсэл, бизнес болох хандлага өсч байгаа, санваартнуудын ёс зүйгүй ааш авир, хууль бус үйлдэл, сүсэгтэн олны сэтгэл зүйгээр тоглох зэрэг нь

нийгмийн ухамсарт улам бүр хүчтэй нөлөөлж, хохирол эрсдэл ч гарч болзошгүй байна.

Ийм байдал нь шашин хоорондын ба шашин-шашингүйн үзэл хоорондын санал зөрөлдөөнийг нэгэнт бий болгож, шашинаас сэдэлтэй зөрчил болон өрнөж, улмаар хууль бус хүчирхийлэл, үйлдэлд хүргэж шашны сэдэлтэй хууль бус зэвсэгт бүлэглэл үүсч болохыг ч үгүйсгэх аргагүй.

Ажилгүйдэл, ядуурал улам бүр өргөжиж, албан ёсны статистик судалгаагаар ядуурал 50,0 хувьд хүрчээ.

Монгол Улсад төр, засгийн зүгээс олон арга хэмжээ авч байгаа ч авлигал, хээл хахууль мэдэгдэхүйц буураагүй бөгөөд «Транспэрэнси Интэрнэшнл» байгууллагын зүгээс Монгол Улс 2015 онд 39 оноогоор 168 орноос 72 дугаар байрт, 2016 онд 38 оноогоор 176 орноос 87 дугаар байранд, 2017 онд 36 оноогоор 176 орноос 103 дугаар байранд, 2018 онд 37 оноогоор 176 орноос 93 дугаар байранд орсон байна. Өөрөөр хэлбэл 15-30 байраар ухарсан байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин “Ямар ч засаглал байхгүй болсон цагт тэнд хоосон орон зай бий болдог. Эмх замбараагүй байдал хоосон орон зай нь маш хурдан терроризм болж хувирдаг” гэж хэлсэн байдаг.

Хууль, хяналтын байгууллагын мэдээллээр сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улсад терроризмын шинжтэй 19 удаагийн гэмт хэрэг бүртгэгджээ. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоол, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан 2004 оны 231, 2005 оны 150, 252, 2007 оны 24, 223, 2008 оны 227 дугаар тогтоолуудаар 19 нэр төрлийн 120 орчим объектыг Цагдаа, Дотоодын цэргийн хамгаалалтад авсан байдаг.

Түүнчлэн 2017-2018 онуудад Улсын онц чухал объектын жагсаалтад 11 чиглэлээр 300 орчим объектыг оруулжээ.

Монгол Улсад 1200 гаруй шатахуун түгээх станц байгаагийн 300 гаруй нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг

Террорист зэвсэгт бүлэглэлийн аливаа ажиллагааны арга, хэлбэр нь түүний зорилго, оролцож буй бүрэлдэхүүн, тэдгээрийн бэлтгэлжилт, хэрэглэж буй зэвсэг, хэрэгсэл, халдлагын объектын шинж чанар, хамгаалагдсан байдлаас шалтгаалан янз бүр байж болох бөгөөд улам бүр шинэ, шинэ арга хэлбэрээр баяжсаар байх зүй тогтолтой юм.

Террорист зэвсэгт бүлэглэлүүд өнөө үед олон улсын шинжтэй болж, хорт үйл ажиллагаагаа дэлхийн аль ч өнцөг буланд явуулах боломжтой болсноор зогсохгүй, зэвсэгт бүлэглэлийн ажиллагаа, үйлдлийн болзошгүй арга тактик маш олон төрөл, хувилбарт шилжсэн байна.

Монгол Улсад террорист хууль бус зэвсэгт бүлэглэл үүсэх буюу гаднаас нэвтрэн орох дараахь үндсэн хэд хэдэн нөхцөл шалтгаан байна.

Дотоод нөхцөл шалтгаанд:

- төр, засгийн эрхийн төлөөх улс төрийн тэмцэл хуулийн хүрээнээс хальж, хэт даврагч шинжтэй болох;
- ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, ард түмний амжиргааны түвшин эрс унаж, цаашид тэсвэрлэн тэвчих аргагүй болох;
- хүний эрх, эрх чөлөөг боомилон хязгаарлаж, төрийн дарангуйллын механизм бий болгох;
- оюуны хоосрол гүнзгийрч, нийгэмд эмх замбаагүй, адал балмад байдал бий болох, төр хүчгүйдэх, нийгмийг удирдан жолоодох чадавхаа алдах;
- байгаль-экологийн тэнцвэрт байдал алдагдан, нийгэм-эдийн засгийн байдалд хүчтэй нөлөөлөх;
- эрүүгийн нөхцөл байдал хүндэрч, зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээ үүсч (хар тамхи, хүн болон зэвсэг худалдаалах г.м) бий болох.

Гадаад нөхцөл шалтгаанд:

- олон улсын террорист бүлэглэлүүд Монгол Улсын терроризмын эсрэг идэвхтэй байр суурь, үйл ажиллагаанд дургүйцэн, айлган сүрдүүлэх, залхаан цээрлүүлэх, өшөө авах зорилгоор хууль бус зэвсэгт халдлага үйлдэх;
- Монгол Улсад гадаадын иргэдийн цагаачлан ирэх, гадны ажиллах хүч импортлох явдал хэт ихсэх, тэднээс Монгол Улсын хууль, тогтоомж, ёс заншлыг гажуудуулах нь нийгмийн дүргүйцлийг төрүүлж хууль бус хүч хэрэглэсэн үйлдэл хийх нөхцөл бүрдэх;
- уламжлалт бус шашны тархалт газар авч, тэр нь нийгмийн ухамсарт сөргөөр нөлөөлөх;
- дотоодод үүссэн улс төрийн хэт даврагч бүлэглэл гадны террорист байгууллага, бүлэглэлтэй үгсэн сүлбэлдэх;
- гадаадын хөрөнгө оруулалт Монгол Улсын эдийн засагт ноёрхож, хараат байдалд оруулах, тэр нь ард түмний аж амьдралд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг болно.

Монгол Улсад хүч хэрэглэсэн зэвсэгт халдлага дайралт хийх тохиолдолд, юуны өмнө, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэж, хорлон сүйтгэх, тонон дээрэмдэх, галдан шатаах, төр, засаг, улс төрийн намын сонгож авсан өндөр албан тушаалтныг хороох, барьцаалах, чухал объектуудыг дэлбэлэх, хордуулах, хүн, малын халдварт өвчин тараах, техник, технологийн гамшгийн нөхцөл бүрдүүлэх, осол сүйрэл гаргах арга тактикийг хэрэглэж болзошгүй юм. Мөн мэдээллийн цахим сүлжээнд дайралт хийх, хорлон сүйтгэх ажиллагаа явуулахыг үгүйсгэх аргагүй байна.

Хоёр. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны сургалт бэлтгэлжилт

Терроризмтой тэмцэх хамгийн үр дүнтэй боломжит арга нь түүний гарах нөхцөл шалтгааныг урьдчилан харж арилгах явдал юм. Нэгэнт террорист бүлэглэл үүссэн тохиолдолд, тэднийг эрс шийдэмгий устгах, алан хядах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах боломжийг нь таслан зогсоох шаардлагатай. Энэ нь түүний эсрэг сөрөг тусгай ажиллагаа явуулах томилгоот хүчний чадавхыг нэмэгдүүлэх, сургалт бэлтгэлжилтийг нь дээшлүүлэх, ажиллагааны тактик, арга хэлбэрийг байнга боловсронгуй болгож байхыг өнөөгийн нөхцөл байдал шаардах боллоо.

Үүний тулд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарыг террорист үйлдэлтэй тэмцэх (хууль бус зэвсэгт бүлэглэл) сөрөг тусгай ажиллагаанд ашиглах онол, аргазүй зайлшгүй шаардагдаж байна.

Хуулиар террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг зохион байгуулж явуулах үндсэн хүч хэрэглэл нь цагдаа, тагнуулын төв болон орон нутгийн байгууллага юм.

Аюулгүй байдлыг хангах тусгайлсан үүрэгтэй байгууллагуудын хүч хэрэгсэл дийлэхгүй шаардлага гарсан тохиолдолд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрлөөр Ерөнхий зориулалтын цэргийн томилогдсон анги, салбарыг хууль бус зэвсэгт бүлэглэлийн сөрөг тусгай ажиллагаанд татан оролцуулж болохыг “Терроризмтой тэмцэх тухай” Монгол Улсын хуульд заажээ.

Зэвсэгт хүчний цэргийн анги, салбарыг террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцуулж болох тухай хууль-эрх зүйн орчинг “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг болон “Зэвсэгт хүчний тухай”, “Онц байдлын тухай”, “Терроризмтой тэмцэх тухай” Монгол Улсын хуулиудад тусган тодорхойлсон. Тухайлбал, Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт “Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, үй олноор устгах зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой байна”, “тусгайлан бэлтгэгдэж”, зэвсэглэсэн хүмүүсийг зохион байгуулалттайгаар Монгол Улсад нэвтрүүлэх, улмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт террорист ажиллагаа явуулах, нийтийг хамарсан үймээн самуун дэгдээхийг Монгол Улс өөрийн эсрэг чиглэсэн зэвсэгт түрэмгийлэл гэж үзнэ, “эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлийг хангах, агаарын орон зай, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах, улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх, гамшигийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд туслах, улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх болон хуулиар тогтоосон бусад үүрэг гүйцэтгэхийг зэвсэгт хүчний тайван цагийн үүрэг байхаар тодорхойлсон” байна.

Мөн “зэвсэгт хүчний үндсэн чиг үүргээ биелүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох, терроризмтой тэмцэх” чадавхыг нэмэгдүүлэх нь Зэвсэгт хүчнийг терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагаанд оролцуулах чиглэлүүдийн нэг байхаар тодорхойлжээ.

Энэ нь террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцуулах зэвсэгт хүчний тусгай томилгоот анги, салбарын сургалт, бэлтгэлийг өндөр түвшинд хүргэх, түүнийг болзошгүй хууль бус зэвсэгт үйлдлийн арга, тактиктэй уялдуулан байнга чадавхжуулж байхын чухлыг харуулж байна.

Монгол Улсын төр, засгаас “мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлэх” бодлого баримталж байна. Цэргийн бие бүрэлдэхүүн нийтээрээ цэргийн мэргэжил эзэмшиж, тэрхүү мэргэжлээрээ цэргийн алба хаах нь тэдгээрийн эрхлэх алба, ажлын үндсэн төрөл болж байдаг армийг мэргэжлийн арми гэж үзээд байна.

Монгол Улсын Төрийн батлан хамгаалах бодлого нь зэвсэгт хүчний цэргийн анги, салбарын бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, бие бүрэлдэхүүний нөхөн хангалтыг мэргэжлийн армийн жишигт ойртуулан өөрчлөн шинэчлэхээс гадна байнгын бүрэлдэхүүний цэргийн сургалт бэлтгэл, албаны үйл ажиллагааг мэргэжлийн цэрэгт суурилсан тэрхүү тогтолцоонд шилжүүлэхийг шаардаж байгаа болно.

Өнөө үед мэргэжлийн цэрэгт суурилсан армитай улс орон нэлээд олон болсон төдийгүй бас мэргэжлийн цэргийн чиг баримжаатай, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчинтэй улс ч олон болж байна.

ЗХЖШ, хуурай замын цэргийн анги, салбарын террорист болон хууль бус зэвсэгт бүлэглэлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцуулах томилгоожуулалтыг 2003 оноос эхлэн хийж, тэдний бэлэн байдал, сургалт бэлтгэлийг хангах чиглэлээр дараахь арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал:

-хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэх онолын судалгаа явуулах;

-хуурай замын цэргийн зарим ангиудын стратеги-тактикийн томилгоо, чиг үүрэгт өөрчлөлт оруулж, бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх;

-зарим анги, салбарын зэвсэглэл, байлдааны техник тусгай хэрэгслийн табельд өөрчлөлт оруулж, шинэ зэвсэг, техникийг цэргийн зэвсэглэлд нэвтрүүлэх;

-цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагын зохион байгуулалтад зарим тодотгол хийж, болзошгүй зарим үүргийг гардан хариуцах нэгж бий болгох;

-стратегийн штабын бэлтгэлийн тогтолцоонд уламжлалт бус олон талт үүрэг биелүүлэх, түүний дотор, террорист зэвсэгт бүлэглэлийн үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны стратегийн төлөвлөлт, удирдлагын асуудлыг үе шаттайгаар боловсруулах болсон;

-удирдах тушаалын генерал, офицеруудын олон талт үүрэг

биелүүлэх бэлтгэлийг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх;

-хуурай замын цэргийн анги, салбарыг олон талт үүрэг гүйцэтгэх томилгоотой болгож, тэдгээрийн сургалт бэлтгэлийн тогтолцоог тодотгох;

-хуурай замын цэргийн ангиудын штабын бэлтгэлийн тогтолцоонд олон талт үүрэг биелүүлэх сургалтын шинэ хэлбэрийг бий болгож, тэдэнтэй команд-штабын, команд-штабын хээрийн сургуулийг тодорхой бодлогоор системтэй явуулах;

-олон талт үүрэг, түүний дотор, террорист болон хууль бус зэвсэгт бүлэглэлийн үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах сэдвээр хээрийн сургууль, дадлага тогтмол хийх;

-тусгай үүрэг биелүүлэхэд шаардагдах материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх;

-террорист болон бусад хууль бус зэвсэгт бүлэглэлийн үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулах төлөвлөлт, харилцан ажиллагааг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн бусад байгууллагатай хамтран боловсруулж мөрдүүлэх;


-мэдээллийн сантай болох зэрэг арга хэмжээг дэс дараатайгаар авч байгааг дурдаж болох юм.

Ер нь терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны сургалт, бэлтгэлийн тогтолцоог урьдчилсан бэлтгэл сургалт, ажиллагааны өмнөх сургалт гэж хоёр үндсэн хэсэгт хуваан авч үзэж болох юм.

Зэвсэгт хүчний тусгай томилгоот анги, салбар, бүлэгтэй явуулах терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны сургалтын тогтолцооны урьдчилсан төлөвлөгөөт сургалт нь нийтлэг зорилгот сургалтын дэд тогтолцоог бүрдүүлэх бөгөөд болзошгүй халдлага, үйлдлийн бүх төрөл хэлбэрийг хамран явагдана. Харин ажиллагааны өмнөх сургалт нь чиглэгдсэн зорилтод сургалтад хамааруулан авч үзэж болохоор байна.

Офицер, ахлагч нарын сургалтын тогтолцоо нь цэргийн их, дээд сургуулийн хөтөлбөрт сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалт, анги, сарбарын даргын бэлтгэл сургалтаас бүрдэнэ. Үүний дотроос их, дээд сургуулийн хөтөлбөрт сургалт нь хамгийн чухал ач холбогдолтой, суурь сургалтын шинжтэй байхаар төлөвлөх нь чухал юм.

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны сургалтын нэгдсэн тогтолцооны хувилбар



Тухайлбал, ҮБХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөнд терроризмтой тэмцэх сэдэв нь стратегийн бэлтгэл хичээлийн сургалтын багц цагт багтаж байна. Гэтэл энэ хичээлийг 332 цаг буюу 8.3 кредитийн багтаамжтай үздэг боловч дөнгөж 10 цаг буюу нийт цагийн 3.0 хувь нь терроризмтой тэмцэх сургалтад оногдож байх жишээтэй байна.

Энэ нь олон улсын терроризм, түүнтэй тэмцэх сөрөг тусгай

ажиллагааны тойм мэдээлэлтэй танилцахад л хүрэлцэх хугацаа байсан бөгөөд өнөөгийн байдлаар сургалтын хөтөлбөрийг хассан байгаа юм.

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн 1.5-2.0 жилийн сургалттай Цэргийн нэгдсэн сургуулийн цэргийн ангид ерөнхий тактикийн хичээлийг 400-аад цаг (10 кредит), тусгай мэргэжлийн ангиудад нь 80-160 цаг (2-4 кредит)-ийн багтаамжтай судалдаг боловч, терроризмтой тэмцэх (хууль бус зэвсэгт бүлэглэл) сөрөг тусгай ажиллагааны тактикийг огт судалдаггүй байна. Энэ нь ерөнхий “цэргийн командын офицер” цэргийн мэргэжлийн боловсролын стандарт байхгүйтэй холбоотой юм.

Мөн энэ сургуулийн төрөл, мэргэжлийн цэргийн сургалтын ангиудад 20-40 цаг (1.0 кредит), Батлан хамгаалах удирдлагын академид 60-80 цаг (2.0 кредит)-ийн багтаамжтайгаар терроризмтой тэмцэх (хууль бус зэвсэгт бүлэглэл) сөрөг тусгай ажиллагааны тактикийг судлуулах нь зүйтэй байна. Сургалтын хөтөлбөрт байгаа бусад хичээлүүдийн агуулгыг ч гэсэн терроризмтой тэмцэх (хууль бус зэвсэгт бүлэг) сөрөг тусгай ажиллагааны сургалтын онцлогтой нийцүүлэн тодотгол оруулж бэлтгэлжилтийг хангах нь зүйтэй юм.

Түүнчлэн Зэвсэгт хүчний даргалах бүрэлдэхүүний хувьд терроризмтой тэмцэх (хууль бус зэвсэгт бүлэглэлтэй) тэмцэх, сөрөг тусгай ажиллагааг зохион байгуулан удирдаж явуулах мэргэшил олгох, дээшлүүлэх, мэргэшлүүлэх сургалтын тогтолцоо зайлшгүй хэрэгтэй гэж үзэж байна.

Зэвсэгт хүчний хэмжээнд 2 жилд явагдаж байгаа командлалын шалгалтын дүнгээс үзэхэд, тактик, тусгай тактикийн бэлтгэлээр шалгагдсан офицеруудын дийлэнх нь терроризмтой (хууль бус зэвсэгт бүлэглэлтэй) тэмцэхтэй холбогдсон онолын асуудалд хангалтгүй үнэлгээ авсан жишээ байна. Энэ нь офицер бэлтгэх тогтолцооны явцад өөрөөр хэлбэл, цэргийн сургуульд суралцаж байхад нь суурь онолын мэдлэг олгоогүй, анги, салбаруудад мэргэшсэн багш, мэргэжилтэн дутмаг, захирагч, дарга нараас терроризмтой болон бусад хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэх асуудалд төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаатай холбоотой байна.

Цаашид энэхүү сургалтыг албан тушаалын ангиланаар явуулах нь илүү үр дүнтэй байж болох юм. Офицер, ахлагч нартай терроризмтой тэмцэх буюу хууль бус зэвсэгт бүлэглэлийн үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны сургалтыг гарагийн сургалт, богино хугацааны цугларалт, хэсэгчилсэн судалгааны ажил явуулах, төсөл боловсруулан хэрэгжүүлэх, онолын хурал, семинар зохион байгуулах, бие даан судлуулах, эссэ, илтгэл бэлтгүүлэн хэлэлцүүлэх зэрэг олон арга хэлбэрээр явуулж болох боловч одоогоор ийм ажиллагаа явагдахгүй байна.

Тухайлбал, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны бэлтгэл сургалт 20 цаг (нийт цагийн 10,0 хувь), 150 дугаар ангид тусгай үүргийн бэлтгэл хичээл 52 цаг (нийт цагийн 7,2 хувь), харин хугацаат болон гэрээт цэрэгтэй 016 гэх мэт ангиудад олон

талт тусгай үүргийн бэлтгэл хичээлийг ойролцоогоор 200 орчим цаг, энэ нь нийт цагийн 30,0 хүрэхгүй хувийн багтаамжтай судлахаар төлөвлөсөн байх жишээтэй байгаа юм.

Офицер, ахлагч нарын терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны бэлтгэл сургалтын түвшинг дээшлүүлэхийн тулд даргын бэлтгэлийн сургалтын тогтолцоонд зарим өөрчлөлт, тодотгол оруулах шаардлагатай.

2003, 2008, 2015 онуудад терроризмтой болон хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэх сөрөг тусгай ажиллагаа сэдвээр стратегийн команд-штабын сургууль хийсний зэрэгцээ ЗХЖШ-аас 2014 онд Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний Стратегийн цугларалтыг “Терроризмтой тэмцэхэд төрийн байгууллагуудын харилцан ажиллагаа ба Зэвсэгт хүчин” сэдвээр зохион байгуулсан нь цэргийн байгууллагууд терроризмтой тэмцэх арга ажиллагаанд анхаарч, энэ чиглэлд зарим ахиц дэвшил олж буйн илэрхийлэл юм.

Сүүлийн үед явагдсан зарим команд-штабын сургууль, команд-штабын хээрийн сургууль, штабын дадлагуудын дүнгээс харахад, терроризмтой тэмцэх сөрөг тусгай ажиллагааны стратеги, операц, тактикийн үндсэн ажиллагааны бодлого, зарим арга хэлбэр нэг мөр болон жигдрээгүй, террорист үйлдэлийн учир шалтгаантай айдсын саадыг даван туулж чадаагүй байгаа нь ажиглагдаж байна.

Гурав. Туршлага, сургамж

Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны тусгай хүчнийг байгуулан тэдгээрийн бэлэн байдал, сургалт бэлтгэлийг хангаж байгаа гадаад орнуудын туршлагаас харахад, үндсэн хоёр чиг хандлагатай байна.

Нэгд, улс орон бүр өөрийн цэрэг, армид тусгай хүчинтэй болж улс үндэстнийхээ эдийн засаг, улс төрийн тайван байдлыг сахин хамгаалах, нөгөө талаар цэргийн тусгайлсан чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж иржээ.

Ийм анги, салбарын тоонд АНУ-ын “Дельта” бүлэг, ОХУ-ын “Вымпел”, цагдаагийн тусгай үүрэг биелүүлэх “ОМОН” бүлгүүд, Английн нисэх-десантын тусгай алба (НДТА), ХБНГУ-ын холбооны хил хамгаалах албаны тусгай бүлэг ГСГ-9, Израйлийн “Мивцах эвлохим”, “Саерэт Маткал” бүлэг зэргийг нэрлэж болно. Тэдгээр нь терроризмтой болон хууль бус зэвсэгт бүлэглэлийн үйлдлийн сөрөг тусгай ажиллагаатай тэмцэл явуулах мэргэшсэн хүчин болж байна.

GSG-9 нь Германы цагдаагийн холбооны тусгай үүргийг гүйцэтгэгч. Терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулах зорилготойгоор 1973 онд албан ёсоор байгуулагдсан бөгөөд өдгөө хүн барьцаалах, алан хядах ажиллагаа, хүүхэд барьцаалах гэмт хэрэг болон эдийн засгийн гэмт хэргийн эсрэг үйл ажиллагааг явуулдаг. Зарим үед онцгой байрлалыг хамгаалах, оргодол, гэмт хэрэгтнийг мөрдөж илрүүлэх, мэргэн буучдын ажиллагаа зэргийг явуулдаг байна.

АНУ-ын Дельта хүчин байгуулагдсан цагаасаа эхлэн онцгой үүрэг даалгаврыг хүлээж, терроризмын эсрэг нууц ажиллагаа, шууд дайралт, үндэсний хэмжээний нууц даалгавар зэрэг олон янзын ажиллагааг гардан гүйцэтгэдэг бөгөөд аврах, довтлох даалгаврыг ч гүйцэтгэнэ.

ОХУ-ын “Альфа” баг терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулах чиг үүрэгтэйгээр хуучин ЗХУ-ын үед буюу 1974 онд байгуулагдсан хэдий ч нэг талаар цагдаагийн үүргийг гүйцэтгэхийн зэрэгцээ хагас цэрэгжилтийн байдалд нууц ажиллагааг дотооддоо болон олон улсад гүйцэтгэдэг.

Израилийн «Саерэт Маткал» бүлэг маш нууц даалгаврыг гүйцэтгэх бөгөөд зарим тохиолдолд дайсны галын шугамд ч ажиллагааг явуулдаг. Мөн тэд терроризмын эсрэг ажиллагаа, хүн хулгайлах гэмт хэрэг дээр ажилладаг.

Хоёрт, хуурай замын хүчин, өөрөөр хэлбэл байлдааны анги, салбарыг сөрөг тусгай ажиллагаа явуулах нэмэгдэл чиг үүрэгтэй болгон томилгоожуулж ашиглах явдал юм. Тэдгээр нь үндсэн зориулалтаасаа гадна, томилгоот үүргийг биелүүлэх бэлтгэлийг ханган, тусгай хүчний анги, салбаруудад дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хүлээдэг байна. Ийм анги, салбарын сургалт нь хоёрдмол шинж чанартай, өндөржүүлсэн бэлтгэлийг хангахад чиглэгддэг байна.

Сөрөг тусгай үүрэг биелүүлэх томилгоот салбар, бүлгийн сургалт нь мэргэжлийн өндөр ур чадвар олгох, мэргэн буудах чадвар эзэмшүүлэх, бие бялдарын өндөр хөгжилтийг хангах, үүргээ хуулийн хүрээнд биелүүлэх чадвар олгох, бий болсон цагийн байдлын янз бүрийн хувилбарт зохицсон олон талт тусгай ажиллагаа явуулах чадвар олгоход тус тус чиглэгдсэн байх нь тодорхой байна.

Томилгоот салбарын бие бүрэлдэхүүнийг сонгон авахдаа тэдгээрийн онцлог чадавхын түвшинг харгалзан үзэхээс гадна, IQ-г нь дээшлүүлэх сургалтыг тусгай хөтөлбөрөөр явуулдаг байна.

Дүгнэлт

Олон улсын терроризмын аюул улам бүр нэмэгдэж, террорист болон хууль бус зэвсэгт бүлэглэлийн үйлдэл даяаршиж байгаа орчин үед түүнийг сэрэмжлэн зайлуулах, уг үйлдэл гарсан тохиолдолд хохирол, эрсдэл багатайгаар туулан гарах бодлого төлөвлөлт, сургалт бэлтгэлжилтийг төгөлдөржүүлэх нь өнөөгийн тулгамдсан зорилтуудын нэг болж байна.

Орчин үеийн терроризм, хууль бус зэвсэгт бүлэглэлийн ажиллагааны нэг онцлог шинж нь шинжлэх ухаан, техник технологийн дэвшлийн үр дүнг үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглах чиг хандлагатай болж байгаа явдал юм.

Монгол Улс нь терроризмын аюул, хууль бус зэвсэгт бүлэглэлийн халдлага дайралтаас харьцангуй ангид орон юм. Гэвч энэ нь амгалан

тайван байдлын баталгаа биш юм.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Монгол Улсын аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын тогтоол №48. 2010 он;
2. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УИХ-ын тогтоол №10. 2011 он;
3. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс. УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт;
4. “Зэвсэгт хүчний тухай” Монгол Улсын хууль.УБ., 2016 он;
5. “Батлан хамгаалах тухай” Монгол Улсын хууль. УБ. 2016 он;
6. “Гадаадын цэргийг хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай” Монгол Улсын хууль;
7. “Терроризмтой тэмцэх тухай” Монгол Улсын хууль. УБ. 2012 он;
8. Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг. Олон улсын терроризм, түүнтэй тэмцэх онол, арга зүйн үндэс. Улаанбаатар хот. 2006 он. -233 х. ISBN-99929-4-024-7;
9. Лерой Томпсон “Террористуудтай тэмцэх тактик”.Ц.Сангарагчаагийн орчуулга Улаанбаатар хот 2007 он;
10. Ш. Паламдорж “Терроризм түүнээс сэргийлэх”. УБ. хот. 2003 он. 96 х;
11. Пүрэвдорж. С. “Олон улсын терроризмоос сэргийлэх, болзошгүй хөнөөлийн хохирлыг арилгах арга зам”. БХИС. 2016 он., -184 х; ISBN 978-99962-76-40-8;
12. Ганбат.А “Хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэхэд хуурай замын цэргийн анги, салбарыг ашиглах нь” . УБ. 2016 он. докторын диссерац., х-160;
13. Требин М.П. “Терроризм в XXI веке” Минск. 2004 он. -816 х. ISBN 985-13-1503-6;
14. Ц.Дашзэвэг, Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. Улаанбаатар хот. 2004 он. -164 х;
15. Д.Мягмар, Б.Түмэн. Хууль бус (террорист) зэвсэгт бүлэглэлтэй тэмцэхэд цэргийн анги салбарыг ашиглах нь. Улаанбаатар хот. 2002 он. -88 х.

Радио цахим тэмцлийг зохион байгуулах нь

Б.Далайбаатар

БХЭШХ-ийн Байлдааны зэвсэглэл, техник, технологи, инноваци судлалын төвийн дарга, доктор (Ph.D), хурандаа

Г.Эрдэнэбаатар

ҮБХИС-ийн БХУА-ийн Цэргийн стратегийн төвийн дарга, докторант, хурандаа

Түлхүүр үг: радио цахимын тэмцэл, радиотехникийн тагнуул, радио нэвтрүүлэгч, радио цахимын хэрэгслүүд, радио саатуулга, радио чиглүүлэг, радиоэлектроны хамгаалалт.

Key words: electronic warfare, electronic intelligence, radio transmitter, electronic equipments, radio interference, radio navigation, electronic protection.

Хураангуй: Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага сургамжаас харахад радио, радиотехникийн тагнуулыг өргөн цар хүрээнд идэвхтэй явуулж, радио цахимын тэмцэл (РЦТ)-ийг сайтар зохион байгуулж тасралтгүй явуулснаар эсрэг талынхаа цэрэг, зэвсгийн удирдлагыг алдагдуулж, радио цахимын чухал объектуудыг артиллер, авиацийн галын цохилтын хүчээр устгасны дараа байлдааны ажиллагаа явуулж үр дүнд хүрдэг болоод байна.

Иймд энэхүү өгүүлэлдээ РЦТ-ийг явуулах, командлагч, захирагч ба албадын дарга нарын үүрэг, зохион байгуулах үндэс, агуулга, РЦТ-ийн төлөвлөгөө болон захирамжуудад тусгагдах зүйл, түүнийг явуулах талаар цэгцтэй нэгдсэн мэдээлэл хүргэхийг зорилгоо.

Бүх төрлийн байлдааныг ямар хүчээр явуулахаас үл хамааран зайлшгүй хийгдэж байх байлдааны хангалтын нэгтөрөл бол радио цахимын тэмцэл юм. Өндөр хөгжилтэй зэвсэглэл сайтай орнуудын Зэвсэгт хүчин радио цахимын тэмцлийн хангалтад ихэвчлэн хангалтын үндсэн төрөл болгон хөгжүүлж, шинэ техник хэрэгслээр байнга хангаж радио цахимын тэмцлийг явуулах тактик, арга хэлбэрээ улам боловсронгуй болгож байна.

Дайнд радио, радиотехникийн тагнуулыг өргөн цар хүрээтэй явуулж радио цахимын тэмцлийг сайтар төлөвлөж, тасралтгүй явуулсны үр дүнд эсрэг талынхаа цэрэг, зэвсгийн удирдлагыг алдагдуулж, радио цахимын чухал объектуудыг устгасан тохиолдолд дайсны эсэргүүцэл үзүүлэх

чадвар суларч бие бүрэлдэхүүн нь сэтгэл зүйн тогтворгүй байдалд орж байна. Энэ нь түргэн хугацаанд эсрэг талаа ялахад дөхөм болгодог.

Нөгөө талаар өөрсдийн цэрэг, зэвсгийн удирдлагын тогтвортой ажиллагааг хангаж, радио цахимын хамгаалалт, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааг байнга зохион байгуулж, бололцоотой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байх нь дайн зэвсэгт мөргөлдөөнийг амжилттай явуулах үндэс болдог.

Одоогийн байдлаар манай зэвсэгт хүчинд радио цахимын тэмцлийг бүрэн хэмжээгээр зохион байгуулж явуулах нөхцөл боломж бүрдээгүй байгаа хэдий ч бид энэ талаар мэдэж, радио саатуулгаар дарахаас бусад радио цахимын хамгаалалт, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааг төлөвлөж зохион байгуулж сурах нь тулгамдсан асуудал болсоор байна.

Дайн байлдааны нэгонцлог нь байлдааны ажиллагаа эхлэхийн өмнө радио цахимын тэмцлийг эрчимтэй явуулж эсрэг талынхаа цэргийн удирдлагын хэрэгслүүд, радиолокац, агаарын довтолгооноос хамгаалах хэрэгслүүд, мөн өндөр цэцтэй зэвсгийн удирдлагын хэрэгслүүдийг радио саатуулгаар дарах ба устгасны дараа хуурай замын цэрэг /ХЗЦ/-ийн анги салбаруудын байлдааны ажиллагаа амжилттай явагдаж үүргээ богино хугацаанд хохирол багатайгаар биелүүлж байгаа нь сүүлийн үеийн дайны туршлага сургамжаас харагддаг. Энэ байдлаас харж дараах дүгнэлтийг хийж болно:

1. Эсрэг талын эсэргүүцэх чадвар суларсан учир зэвсэглэл техник, амьд хүчний хохирол бага гарна.
2. Байлдаан, операц явуулах хугацаа богиносно.
3. Хугацаа богино учир шатахуун, сум галт хэрэгсэл, хүнс хэмнэгдэж эдийн засгийн үр ашиг дээшилнэ.

Манай зэвсэгт хүчинд радио цахимын тэмцлийн техник хэрэгсэл, анги салбар нь байхгүй ч нийт бие бүрэлдэхүүн, офицеруудынхаа сургалтанд РЦТ-ийн тухай зайлшгүй онолын үндэссуурийг үзэж, академийн сонсогчдын хувьд РЦТ-ийг төлөвлөх, зохион байгуулах талаар бүрэн мэдлэг олгох нь зүйтэй санагддаг.

Радио цахимын тэмцлийг зохион байгуулах үндэс

ОХУ-ын цэргийн академийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ордог хичээл сонгомол утгаа ордог нь манай нөхцөлд тохирно гэж үздэг. Зарим үг өгүүлбэрийг өөрийн орны онцлогт тохируулан орууллаа.

Радио цахимын тэмцлийг Монгол Улсын ЗХЖШ, төрөл мэргэжлийн цэргийн командлагч, захирагч, штабууд, төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, албадын дарга нар удирдан зохион байгуулна. РЦТ нь командлагч, захирагчийн шийдвэр, штабын даргын РЦТ-ийн заавар, дээд штабын РЦТ-ийн захирамж дээр үндэслэн зохион байгуулагдана.

Командлагч /захирагч/-ийн шийдвэрт операц, байлдаанд РЦТ-ийн зорилтуудыг шийдвэрлэхээр томилсон хүч хэрэгсэл, хөнөөх зэвсэг, радио цахимын даралтын үндсэн чармайлтыг төвлөрүүлэх чиглэл, чухал объектууд мөн радио цахимын хамгаалалт, дайсны тагнуулын техник

хэрэгслийн эсрэг ажиллагааны үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлно.

Штабын дарга нь РЦТ-ийг гардан зохион байгуулагч бөгөөд радио цахимын цагийн байдлыг үнэлэх, санал боловсруулах, төлөвлөлт хийх, байлдааны үүргийг цэрэгт хүргэх ажлуудыг удирддаг.

Мөн газар хэлтэс, албад, төрөл, тусгаймэргэжлийн цэргийн хооронд РЦТ-ийн харилцан ажиллагааг зохион байгуулна.

Ажиллагааны удирдлагын газар, хэлтсийн дарга нар дайсны удирдлагын байр, радио цахимын объект /РЭО/-ыг хөнөөх авиац, артиллерын хүч хэрэгслүүдийг хуваарилан РЦТ-ийн анги, салбаруудын хөдөлгөөн үйлдэх маршрут, хүч хуралдуулах район, байруудыг тогтоож операцынөнгөлөн далдлалтын төлөвлөгөө, харилцан ажиллагааны төлөвлөгөөнд РЦТ-ийн арга хэмжээнүүдийг төлөвлөн тусгана.

Монгол Улсын ЗХЖШ-т РЦТ-ийн тусгай алба зайлшгүй байгуулагдах шаардлагатай бөгөөд тэр нь Зэвсэгт хүчний РЦТ-ийн бодлого зорилтуудыг нэгтгэн шийдвэрлэж, радио цахимын тэмцэлд бэлтгэх, үйл ажиллагааг удирдаж, явуулах арга хэмжээнүүдийг төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, албадын хооронд уялдуулан зохицуулж удирдан зохион байгуулах ажлыг хэрэгжүүлж, РЦТ-ийн албаны үүргүүд нь ЗХЖШ-ын РЦТ-ийн албаны дүрмээр тодорхойлогдоно гэж үзлээ.

Анги, салбаруудын захирагч штаб, РЦТ-ийн албаны дарга нар нь операц, байлдаанд РЦТ-ийн арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлэх ажлыг шууд хариуцана. РЦТ-ийн албаны дарга өөрийн ажлыг төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, албадын дарга нартай харилцан уялдаатайгаар зохион байгуулж дайсны удирдлага, тагнуул, РЦТ-ийн хүч хэрэгслүүдийн байлдааны боломжийг үнэлж, РЦТ-ийн саналыг боловсруулж төлөвлөх, РЦТ-ийн үүргийг цэрэгт хүргэх, операц, байлдааны төлөвлөгөөний боловсруулалтанд оролцох, РЦТ-ийн анги салбаруудыг шууд удирдах, радио цахимын хамгаалалт, цахилгаан соронзон нийцлийн арга хэмжээнүүдийг төлөвлөх, байлдааны үүргийн биелэлтэнд хяналтгавих шалгалт хийх үүрэгтэй байдаг манай зэвсэгт хүчний үйл ажиллагаанд тохирох юм.

- *Тагнуулын дарга* нь операц байлдаанд дайсны цэргийн болон зэвсгийн удирдлага, тагнуул, РЦТ-ийн системийг судлан үзэж, султалуудыг тодорхойлон удирдлагын байр, радио цахимын объектуудыг илрүүлэн устгах ажиллагаанд тагнуулын анги салбаруудыг ашиглах саналыг боловсруулна.

РЦТ явагдах нөхцөлд тагнуулын хүч хэрэгслийн тогтвортой удирдлагыг хангах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны үрдүнг тодорхойлоход оролцоно. Төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, албадын дарга нар дайсны тагнуул, РЦТ-ийн хүч хэрэгсэл, тэдгээрээс өөрийн цэрэгт нөлөөлөх боломжийг судлан үнэлж, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн анги салбаруудын удирдлагын тогтвортой байдлыг хангах, радио цахимын хамгаалалтыг зохион байгуулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

РЦТ-ийн төлөвлөлтөнд хамаарах асуудлаар төрөл, тусгай

мэргэжлийн цэргийн дарга нар оролцож эдгээр арга хэмжээнүүдийн биелэлтэд хяналт тавина.

- *Холбооны цэргийн дарга*, анги салбаруудын холбооны албадын дарга нар радио холбооны хэрэгслүүдийн цахилгаан соронзон нийцлийн шаардлага, РЦТ явагдах нөхцөлд холбооны системийн тогтвортой ажиллагааг хангах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, тогтоосон үелзлэлийн зурваст радио холбооны хэрэгслүүдийн ажлын үелзлэлүүдийг хуваарилан, радио цахимын хамгаалалт, радио өнгөлөн далдлалтын арга хэмжээнүүдийн биелэлтэд хяналт тавина.

- *Артиллерын дарга* нар нь РЦТ-ийг зохион байгуулж явуулах санал боловсруулахад дайсны удирдлагын байрууд, радио цахимын объектуудыг галаар хөнөөх асуудлаар биечлэн оролцоно. Галын цогцолбор хөнөөлийн төлөвлөгөөний дагуу РЦТ-ийн анги салбаруудтай харилцан ажиллагаатайгаар дайсны удирдлагын байр, РЦО-ыг хөнөөх ажиллагааг удирдаж, өөрийн объектуудын радио цахимын хамгаалалтын ажлыг зохион байгуулна.

- *Инженерийн цэргийн дарга*, анги салбаруудын инженерийн албаны дарга нар нь цэргийн бүлэглэлүүдийн байрлал объектуудын дайсанд илрэгдэж болзошгүй шинж тэмдгүүдийг тодорхойлон дүгнэж, тэдгээрийг дайсны тагнуулын техник хэрэгсэл, /фото зураг, радиолокац, хэт ягаан туяаны/-ээс хамгаалах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлнэ. Дайсны удирдлагын байрууд, РЦО-уудыг тэсрэх бодисоор хөнөөх, радиолокац, дулаан ойлгогчид, өнгөлөн далдлалтын хэрэгслүүдийг ашиглах, цэргийн бүлэглэлийн байрлал, объектуудыг дуурайлган үзүүлэх макет, дүрс ашиглах, дайсныг хуурч төөрөгдөлд оруулах зэрэг ажлуудыг РЦТ ийн даргатай хамтран төлөвлөж явуулна.

- *Химийн цэргийн дарга*, анги салбаруудын химийн албаны дарга нар цэргийн бүлэглэл, объектууд, байлдааны зэвсэг техникийг дайсны тагнуулын гэрэллэг цахим хэрэгслээс хамгаалах, түүний зэвсгийн удирдлагын гэрэллэг цахим системийн байлдааны боломжийг алдагдуулах зорилгоор химийн цэргийн анги салбаруудаас утаат хөшиг /мананцар/ хэрэгсэл ашиглах арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлнэ.

- *Агаарын цэргийн албаны дарга* нар захирагдсан анги салбарууддаа дайсны радио техникийн тагнуул, радио цахимын даралтын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулна. Тактик техникийн нууц өгөгдөхүүнтэй зэвсэг техникийн радио цахимын хамгаалалтын ажлыг төлөвлөж зохион байгуулна гэсэн үүргүүд нь манай анги, салбаруудад хэрэгжих боломжтой.

РЦТ-ийн зохион байгуулалтын агуулга:

ОХУ-ын Агаар сансраас хамгаалахын цэргийн академид үзсэн агуулгын хүрээнд РЦТ-ийн зохион байгуулалт нь дараах агуулгатай байна.

- РЦТ-ийн үүргийг судлах;
- Радио цахимын цагийн байдлыг үнэлэх;
- РЦТ-ийн саналыг боловсруулах, оператив-тактикийн тооцоо хийх;

- РЦТ-ийн хүч хэрэгслийг байлдаанд бэлтгэх;
- РЦТ-ийн удирдлага харилцан ажиллагааг зохион байгуулах зэрэг асуудлууд орно.

РЦТ-ийн үүргийг судлах нь операц, байлдааны болон радио цахимын цагийн байдал, дээд штабаас ирүүлсэн РЭТ-ийн захирамж, заавруудтай танилцах явдал байдаг.

Үүрэг судлахад: РЦТ-ийн зорилтуудыг шийдвэрлэхэд анги, салбаруудын гүйцэтгэх үүрэг, эзлэх байр, тэдгээрийг биелүүлэх нөхцөл, арга журмыг мэдэж өөрийн зурвас дахь ахлах дарга, зэргэлдээ анги, салбаруудаас РЦТ-ийн ашиг сонирхлынүүднээсгүйцэтгэх үүргүүд, харилцан ажиллагааны журам, РЦТ-д бэлтгэх хугацаа зэргийг тодотгодог.

Радио цахимын цагийн байдлыг үнэлэхэд: дайсны тагнуул, холбоо, чиглүүлгийн, зэвсгийн удирдлагын радио цахимын системийн байрлал, байдлын тухай бүх мэдээллийг судлаж энэ судалгааны болон операц байлдааны зорилтуудын үндсэн дээр дайсны цэргийн удирдлагын зохион байгуулалтыг алдагдуулах арга хэмжээг тодорхойлж, мөн өөрийн цэрэг, зэвсгийн удирдлагын системийн тогтвортой ажиллагааг хангах арга замыг тодорхойлох зорилгоор цагийн байдлыг сайтар үнэлдэг нийтлэг үнэлэмжтэй.

Шаардлагатай тохиолдолд байлдааны ажиллагаа явагдаж буй газар орны физик газар зүй, ус цаг уурын нөхцөлийг РЦТ-ийг зохион байгуулж явуулахад нөлөөлөх талаас нь үнэлж болдог.

Операц, тактикийн тооцоо нь: дайсны цэргийн удирдлага, радиоэлектроны хэрэгслүүд /РЦХ/-ийн системүүдийг үнэлэх, РЦТ-ийн үндсэн чармайлтыг төвлөрүүлэх чиглэл, объектуудыг тодорхойлох, хөнөөлийн хэрэгслүүдийг дайсны удирдлагын байр, РЦО-уудад зөв оновчтойгоор хуваарилах зорилгоор хийгдэх тооцоо юм. Операц, тактикийн тооцоо хийхдээ радио цахимын саатуулгын нэвтрүүлэгчийн ажлын горим, чиглэл, бүс, секторуудыг тодорхойлох, саатуулгын үр дүнг тооцоолох, ижил төрлийн станцуудын харилцан саатуулгыг зохицуулах, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны арга хэмжээнүүдийг оновчтой төлөвлөх зорилгоор уламжлалт аргаар хийгддэг .

Командлагч, захирагчийн операц, байлдааны шийдвэрт оруулах РЦТ-ийн саналд дараах асуудлыг оруулахыг онол арга зүйгээр зөвлөмжилдөг. Үүнд:

- Операц, байлдааны болон РЦТ-ийн цагийн байдлаас хийсэн товч дүгнэлт;
- операц, байлдааны РЦТ-ийн үүрэг, зорилт;
- дайсны удирдлагын байрууд, РЦО-уудыг хөнөөх, эзлэн авах, радио цахимын саатуулгаар дарах журам;
- РЦТ-ийн анги, салбаруудын бүлэглэл, байлдааны үүргүүд, тэдгээрийн хөдөлгөөн үйлдэх, байлдааны журамд шилжих, маневрлах журам, РЦТ-ийн анги, салбаруудын байлдах чадварыг дээшлүүлэх арга хэмжээнүүд;

- Радио цахимын хамгаалалт, харилцан саатуулгыг зохицуулах, төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, албадаас хэрэгжүүлэх арга хэмжээнүүд;
- Дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны үүрэг, зорилтууд;
- РЦТ-ийн удирдлага, харилцан ажиллагааны зохион байгуулалтын үндэс зэрэг болно.

РЦТ-ийг операц, байлдааны бүх үе шатуудад анги, салбаруудын байлдааны үүрэг, ажиллагааны хувилбаруудтай зохицуулан төлөвлөдөг бөгөө төлөвлөгөөг зураг дээр тайлбар бичиглэлтэйгээр үйлдэхийг зөвлөмж болгодог.

РЦТ-ийн төлөвлөгөө нь операц, байлдааны төлөвлөлтийн үндсэн баримт бичгүүдийн нэг бөгөөд штабын дарга, РЦТ-ийн албаны дарга нар гарын үсэг зурж, командлагч, захирагч батална. Зарим тохиолдолд РЦТ-ийн төлөвлөгөөн дээр үндэслэн РЦТ-ийн хүч хэрэгслүүдийг байлдаанд ашиглах график, төлөвлөгөө боловсруулдаг. Операц, байлдааны төлөвлөгөөний операц, байлдааны ерөнхий хэсэг, төрөл, тусгай мэргэжлийн цэргийг байлдаанд ашиглах болон операц, байлдааны өнгөлөн далдлалт, удирдлага, холбооны төлөвлөгөөнүүдэд РЦТ-ийн холбогдох зарим асуудал тусгагдана гэж зөвлөдөг.

Галын цогцолбор хөнөөл, төрөл, тусгай мэргэжлийн цэргийг байлдаанд ашиглах төлөвлөгөөнүүдэд дайсны удирдлагын байр, РЦО-уудад цохилт өгөх арга хэмжээнүүд тусгагдаж, хүч хэрэгслийн хуваарилалт, галт хэрэгслийн тооцоо, цохилт хийх хугацаа, радио цахимын хамгаалалт, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны зорилтуудыг тодорхойлно.

Тагнуулын төлөвлөгөөнд дайсны цэргийн болон зэвсгийн удирдлагын системийн үнэлгээ, тагнуул, РЦТ-ийн хүч хэрэгслийн байрлал, бүлэглэл, өөрийн цэргийн тагнуулын анги, салбаруудаас РЦТ-ийн ашиг сонирхлын үүднээс гүйцэтгэх үүргийг цэрэгт хүргэх журам, радио, радио техникийн тагнуулын салбарын болон РЦТ-ийн анги, салбаруудын харилцан ажиллагааны арга хэмжээнүүд тусгадаг.

Төлөвлөгөөнд тагнуулын удирдлагын радио цахимын системийн радио цахимын хамгаалалт, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны арга хэмжээнүүд оруулдаг байна.

Операц, байлдааны өнгөлөн далдлалт, цэргийн удирдлагын зохион байгуулалт, холбооны төлөвлөгөөнд дайсны тагнуул, РЦТ-ийн хүч хэрэгслийн бүлэглэл, байдал, байлдааны боломжийн судалгаа, тэдгээрийн эсрэг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ, өнгөлөн далдлалтын ашиг сонирхолд төрөл, тусгай мэргэжлийн цэрэг албадын радио цахимын хэрэгсэл, РЦТ-ийн анги, салбаруудын гүйцэтгэх үүргийн үндэс болдог.

Инженерийн болон химийн хангалтын төлөвлөгөөнүүдэд дайсны тагнуул, зэвсгийн удирдлагын радиолокац, лазер, хэт ягаан туяаны аппарат хэрэгслүүдийн байлдааны боломжуудыг тодорхойлон тэдгээрийн эсрэг тэмцэх арга хэмжээ, дулаан, радиолокац, гэрэллэг цахимын

өнгөлөн далдлалт, хуурамч объект, бүлэглэлүүдийг байгуулах, утаа, мананцар ашиглах журмуудыг тусгана.

Төлөвлөгөөнд мөн инженер, химийн цэргийн удирдлагын РЦХ-ийг дайсны тагнуулын техник хэрэгсэл, удирдлагатай зэвсгийн хөнөөлөөс хамгаалах арга хэмжээнүүдийг тусгана.

Анги, салбаруудад РЭТ-ийн үүрэг нь удирдамж, захирамж, байлдааны захирамж, тушаалын хэлбэрээр хүргэгдэнэ. РЭТ-ийн үүрэг зорилтыг анги салбаруудын штабт урьдчилан хүргэх, РЭТ-ийн төлөвлөлтийн цагийг ихэсгэх зорилгоор РЦТ-ийн урьдчилсан захирамж өгнө. Анги, салбаруудын РЦТ-ийн захирамж, РЦТ-ийн анги, салбаруудын байлдааны захирамжинд штабын дарга, РЦТ-ийн албаны дарга нар гарын үсэг зурна. РЦТ-ийн үүрэг зорилтуудын биелэлт, бий болсон радио цахимын цагийн байдлын тухай мэдээг тогтоосон цагт шат дараалан өгдөг.

РЦТ-ийн зорилтуудыг шийдвэрлэх үүднээс РЦТ-ийн анги салбаруудыг тогтоосон районд гаргаж, радио цахимын хангалт, байлдааны жигдрэлтийн сургуулийг зохион байгуулж явуулна. Шаардлагатай үед хүн хүч, автомашин, тусгай техникээр нөхөн хангана. РЦТ-ийн удирдлага, зохион байгуулалт нь РЦТ-ийн анги, салбаруудад байлдааны үүргийг цагт нь хүргэж, тэдэнд дайсны тухай мэдээг саадгүй дамжуулах, хүч хэрэгслийн тасаралтгүй харилцан ажиллагаа, маневр хийх бололцоог бүрдүүлэн, цэргийн далдуур удирдлагын шаардлагыг биелүүлэх нөхцөлийг хангасан байх нь амжилтын үндэс болдог. Энэ нь удирдлага, холбооны техник хэрэгслүүдийг цогцоор ашиглаж, радио цахимын хамгаалалт, цэргийн далдуур удирдлага, холбооны аюулгүйн албаны шаардлагуудыг дагаж мөрдсөнөөр хангагдахыг зөвлөдөг.

РЦТ-ийн харилцан ажиллагаа нь РЦТ-ийн болон төрөл, тусгай мэргэжлийн анги, салбаруудын үндсэн чармайлтыг тэдгээрийн зорилго, байр, хугацаагаар нь уялдуулан зохицуулахад оршдог. Операц, байлдаанд радио цахимын хамгаалалт, ижил төрлийн станцуудын харилцан саатуулга, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны арга хэмжээг уялдуулан зохицуулах нь чухал асуудал юм.

Анги, салбаруудын хамтарсан операц, байлдаанд РЦТ-ийн удирдлага харилцан ажиллагааг зохион байгуулахад дараах онцлогуудыг тооцож үзэх нь чухал юм. Үүнд:

- РЦТ-ийн хүч хэрэгслүүд нь МУ-ын зэвсэгт хүчний командлалуудын харьяалал хамаарахгүйгээр, операц, байлдааны шийдвэрээр РЦТ-ийн нэгдсэн төлөвлөгөөгөөр ажиллах;
- РЦТ-ийн байгууллага, анги, салбаруудын холбоо нь төвлөрүүлэн удирдах зарчим дээр үндэслэгдэн зохион байгуулагдаж, РЦТ-ийн бүх хүч хэрэгслүүдийг нэгтгэн удирдах бололцоогоор хангагдах;
- РЦТ-ийн зохион байгуулалт, төлөвлөлтөнд цэргийн далдуур удирдлага, харилцан ажиллагаа, операц, байлдааны баримт бичгүүдийн нэгдсэн загваруудыг ашиглах;

РЦТ-ийг зохион байгуулж явуулах

Операц, байлдаанд РЦТ нь дайсны цэрэг, зэвсгийн удирдлагын болон зарим радио цахимын объектуудыг илрүүлж, радио саатуулгаар дарах, тэдгээрийг галын цохилтын хэрэгслээр устгах, өөрийн цэрэг, зэвсгийн удирдлагын тогтвортой ажиллагааг хангахаар зохион байгуулагдана.

РЦТ-ийг артиллерын гал, авиацын цохилттой хавсран явуулна.

Мөн багавтар боловч чухал үүрэгтэй зарим объектуудыг тагнуул, хорлон сүйтгэх бүлгийн хүчээр устгах, эзлэн авах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дайсны удирдлагын байр, РЦО-ыг галаар хөнөөх, эзлэн авах, устгах арга хэмжээнүүдийг авиац, артиллер, агаарын десант, тагнуулын болон ХЗЦ-ийн салбаруудын хүч хэрэгслээр гүйцэтгэнэ.

Манай Зэвсэгт хүчний хувьд ОХУ-тай төстэй бүтэцтэй мотобуудлагын дивизүүдэд РЦТ-ийн тусгай рот байх бөгөөд бие дааж тусгай чиглэлд үүрэг гүйцэтгэх боломжтой болох юм.

Радио цахимын даралтын зорилтыг шийдвэрлэхэд зэвсэг хүчинд радио саатуулгын газрын хэрэгслүүдийг дарах зориулалттай “Г” / газрын/ маягийн тусгай батальон, нисэх онгоцны удирдлагын радио цахим хэрэгслүүдийг дарах “О” /онгоцны/ маягийн тусгай батальонууд байх бөгөөд эсвэл “ГО” маягийн холимог батальон байж болно.

РЦТ-ийн «Г» маягийн газрын батальон нь дайсны ерөнхий цэргийн болон пуужин, нисэх хүчин, агаарын довтолгооноос хамгаалах цэрэг, тагнуул, РЦТ-ийн анги, салбаруудын богино ба хэт богино долгионы радио станцууд, радио релейний холбоо, нисэх онгоцны радио чиглүүлгийн системүүдэд радио саатуулга тавих зориулалттай. Мөн удирдлагын байр, холбооны зангилгаа, артиллерын холбооны системүүдийг радио тэсрүүлэгчтэй сумнаас хамгаалах арга хэмжээг авна.

РЦТ-ийн «О» маягийн онгоцны батальон нь нисэх онгоцны бүхээгт байрлуулсан жолоодлого, зэвсгийн хараалал, удирдлагын холбооны хэрэгсэл, радио цахим тагнуулын системүүдэд радио цахимын идэвхтэй саатуулга тавьж, өөрийн удирдлагын байрууд, цэргийн томоохон бүлэглэл, зарим чухал объектуудыг агаарын дайралтаас халхлана.

“О” батальон нь ихэвчлэн командын байрууд, цэргийн бүлэглэл, зарим чухал объектуудыг халхлах бөгөөд энэ батальоны байрлалыг халхлаж байгаа объектуудын ойролцоо дайсны авиацын болзошгүй дайралтын чиглэлд сонгож авдаг. Батальоны байлдааны журам нь халхлах аргаасаа шалтгаалан объектын, бүсийн, объект-бүсийн гэж байх бөгөөд энэ нь саатуулгын хүч хэрэгслүүдийн бэлэн байдал, байлдааны боломж, газар орны нөхцөлөөр тодорхойлогдоно.

Чухал чиглэлд үүрэг гүйцэтгэж байгаа мотобуудлагын анги, салбаруудад дайсны удирдлага холбооны хэрэгслүүд, авиац, радиолокацын станцуудын ажиллагааг дарах зориулалттай РЦТ-ийн салбарыг хүч нэмэгдүүлэн өгч болох юм.

Гол чиглэлд ажиллаж буй анги салбаруудын байлдааны ажиллагааг

дэмжих зорилгоор РЦТ-ийн нисдэг тэрэгний салбаруудаар хүч нэмэгдүүлэх боломжтой.

РЦТ-ийн нисдэг тэрэгний эскадриль нь байлдааны үүргийг дайсантай зах нийлсэн заагаас 5-25км-т ганц нэгээр, хосоор, хэсгээр жижүүрийн нислэгийн районоос гүйцэтгэнэ. Инженерийн цэргийн анги, салбаруудын зэвсэглэлд байлдааны цогцолбор, объектуудыг дайсны тагнуулын техник хэрэгслүүдээс хамгаалах зорилгоор тэдгээрийг нууцлах, дуурайлган хийхэд шаардагдах өнгөлөн далдлалтын хэрэгслүүд байна.

Химийн цэргийн анги, салбаруудын байлдааны объектууд, техник хэрэгслүүдийг дайсны гэрэллэг цахим тагнуулын хэрэгслээс халхлах утаан (мананцар) хөшиг тавих хэрэгслээр зэвсэглэсэн тусгай анги, салбаруудтай байх боломжтой. Энэ зорилгоор байлдааны техник дээр байрлуулсан утаат хэрэгслүүдийг мөн ашиглана. Операц, байлдаанд РЦТ нь командлагч, захирагчийн шийдвэр дээр үндэслэгдэн зохион байгуулагдаж төрөл бүрийн төлөвлөгөө, баримт бичгүүдэд тусгагдана.

Давшилтад РЦТ нь операц, байлдааны үүрэг, орон зай, хугацаагаар зохион байгуулагдана. Энэ нь ойрын үүргийн гүнд нарийвчлан, дараагийн үүргийн гүнд тойм байдлаар төлөвлөгддөг.

Операц, байлдааны явцад бий болсон цагийн байдлаас шалтгаалан РЦТ-ийн зорилт, үүргийг тодотгож болно.

Хориглолтод РЦТ нь операц, байлдааны үүрэг, дайсны ажиллагааны болзошгүй чиглэлүүдээр зохион байгуулагдана.

Операц, байлдаанд РЦТ-ийн төлөвлөгөөг газрын зураг дээр хийж, түүнд дараах асуудлуудыг тусгадаг. Үүнд:

- хязгаарлах шугамууд, дайсантай зах нийлсэн зааг, анги, салбаруудын байлдааны үүрэг, удирдлагын байрууд;
- дайсны удирдлагын байрууд, РЦО-ууд, РЦХ-үүдийн бүлэглэл, дайсны тагнуул, РЦТ-ийн анги, салбаруудын байрлал, бүлэглэл, арми, дивизийн РЦХ-ийг тагнаж тэдэнд радио цахимын саатуулга тавьж болзошгүй чиглэл, бүс, гүн;
- РЦТ-ийн анги, салбаруудын байрлал, тэдний байлдааны үүргүүд, байлдаанд бэлэн болох хугацаа, операц, байлдааны явцад шилжилт хийх журам;
- Авиаци, артиллерын хүч хэрэгслээр устгах дайсны удирдлагын байрууд, РЦО-ууд;
- Ахлах даргын хүч хэрэгслүүдээр анги, салбаруудын сонирхолд гүйцэтгэх РЦТ-ийн үүрэг;
- Газар болон агаарын саатуулгын харилцан ажиллагааны бүс, саатуулга тавих сектор, зааг, хугацаанууд;
- РЦТ-ийн анги, салбаруудын халхлах объектууд, халхлалтын бүс;
- Харилцан саатуулгын хүчтэй нөлөөллийн болон РЦХ-үүдийг байрлуулахыг хориглосон районууд г.м.

РЦТ-ийн дарга нь РЦТ-ийн төлөвлөгөөг операц, байлдааны болон тагнуулын газар, хэлтэс, алба, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн

дарга нар, цэргийн нисэх хүчин, Агаарын цэргийн анги, салбаруудын штабуудтай харилцан зохицуулж боловсруулдаг.

РЦТ-ийн төлөвлөгөөний тайлбар бичиглэлд:

- дайсны удирдлага, РЦХ-ийн системийг үнэлсэн товч дүгнэлт;
- РЭЦ-ийн үндсэн зорилтууд, тэдгээрийг операц, байлдаанд ашиглах арга, журам;
- дайсны болон өөрийн цэргийн тагнуул, РЦТ-ийн анги, салбаруудын байлдааны боломж;
- операц, байлдааны үндсэн чармайлтыг хуралдуулах чиглэл дэхь дайсны РЦХ-ийн тоо, төрөл;
- РЦТ-ийн өөрийн анги, салбаруудын хүч хэрэгслүүдийн хуваарилалт;
- РЦТ-ийн удирдлага, зохион байгуулалт, төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, зэргэлдээ анги, нэгтгэлүүдтэй харилцан ажиллах журам;
- дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагаа, өөрийн цэргийн РЦХ-үүдийн ажлын горимд цогцолбор хяналт тавих журам;
- удирдлагын дохионууд зэрэг болно.

РЭТ-ийн захирамжид:

- дайсны удирдлагын байр, РЦО-уудын тухай мэдээ;
- ахлах даргын хүч хэрэгслээр дайсны удирдлагын байр, РЦО-уудыг хөнөөх, дарах үүрэг, түүнийг биелүүлэх хугацаа;
- РЦТ-ийн үндсэн хүчийг төвлөрүүлэх чиглэл;
- Төрөл, тусгай мэргэжлийн цэрэг, зэргэлдээ анги салбаруудын сонирхолд гүйцэтгэх үүрэг;
- Радио цахимын хамгаалалт, дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны арга хэмжээнүүд;
- РЦТ-ийн хүч нэмэгдүүлсэн анги, салбаруудын ирэх район, хугацаа, тэдгээрийн удирдлагыг зохион байгуулах журам;
- РЦТ-ийн харилцан ажиллагааны зохион байгуулалт, удирдлагын дохионууд;
- РЦТ-ийн мэдээ өгөх журам, хугацаа зэргийг заана.

РЦТ-ийн анги, салбаруудын байлдааны захирамжид:

- дайсантай зах нийлсэн зааг, түүний РЦО-уудын тухай мэдээ;
- дайсны РЦХ-үүдийг тагнах, хянах тэдэнд саатуулга тавих тухай;
- үндсэн болон бэлтгэл байр, зааг, аэродромууд операц, байлдааны явцад шилжилт хийх журам;
- саатуулга тавихыг хориглосон үелзлэлийн жагсаалт;
- РЦТ-ийн удирдлагын зохион байгуулалт, харилцан ажиллагааны журам;
- Мэдээ өгөх журам, хугацаа зэргийг заана.

РЦТ-ийг удирдлагын байраар дамжуулан анги, салбаруудын командын байрнаас удирдана.

Биеэ даасан чиглэлд ажиллах анги салбарт РЦТ-ийн анги салбаруудыг хүч нэмэгдүүлж өгсөн бол тэдгээрийг энэ анги, салбарын командын байрнаас удирддаг байна.

РЦТ-ийн удирдлагыг төвлөрсөн болон нэг бүрчилсэн зарчим дээр үндэслэн зохион байгуулна. РЦТ-ийн үүргийг анги, салбаруудын хооронд хуваарилах, дайсны РЦО-уудыг тагнаж илрүүлэх, тэдэнд саатуулга тавьж артиллер, авиацийн тусламжтайгаар хөнөөх журмыг тодорхойлох, анги, салбаруудын хамтарсан ажиллагааны радио цахимын хамгаалалт, цахилгаан соронзон нийцлийг хангах асуудлаар РЦТ-ийн харилцан ажиллагааг зохион байгуулж, харилцан мэдээллийн арга, хүч хэрэгслүүдийг тодорхойлдог. Операц, байлдааны бэлтгэл, дайчилгаа өргөтгөн зохион байгуулалтын арга хэмжээнүүдийн явцад РЦТ-ийн үндсэн чармайлтыг дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны үүргүүдийн биелэлтэнд чиглүүлнэ.

Энэ үед анги салбаруудын хүч хуралдуулах районууд, гүнээс хөдөлгөөн үйлдэх чиглэл, маршрутыг нууцлах, халхлахад онцгой анхаарна.

Маршийн үед хүч хуралдуулах, эхлэх районууд, хөдөлгөөний маршрутад РЦХ-ийн нэвтрүүлгийг бүрэн буюу хэсэгчлэн хориглоно. Дайсныг төөрөгдүүлж хуурах арга хэмжээг зохион байгуулж, тагнуулын онгоцны нислэгийн тухай зарлан мэдээлж байх ажиллагааг амжилттай зохион байгуулах үндэс болдог.

Анги, салбаруудын РЦХ-үүдийн ажлын горимд хяналт тавьж нарийн хуваарийн дагуу шалгалтыг тогтмол явуулах нь тулгамдсан асуудал болж байна.

Дайсны РЦХ-үүдийн ажиллагааг тагнан илрүүлж, түүний пуужин, цөмийн зэвсэг, авиацийн удирдлагын системийг хянахад гол анхаарлаа чиглүүлнэ.

Дайсны түрэмгийлэл, анхны цохилтыг няцаах явцад түүний удирдлагын байр, холбооны зангилгаа, бусад РЦХ, РЦТ-ийн объектуудыг авиаци, артиллер, тагнуулын болон тусгай томилогдсон салбаруудын хүчээр хөнөөж устгахад нөлөөлнө.

РЦТ-ийн анги, салбаруудын үндсэн чармайлтыг тагнуул, зэвсгийг хараалж, чиглүүлэх радио цахим хэрэгслүүд, онгоцны бүхээгийн цахим системүүд, дайсны пуужин, артиллерын ангиуд, гол удирдлага харилцан ажиллагааны радио холбоонд саатуулга тавихад чиглүүлнэ. Үүнд ялангуяа дайсны 1 дүгээр цуврааны анги, салбаруудын удирдлагын холбооны хэрэгслийн ажиллагааг тасалдуулахад радио саатуулгын гол хүчийг төвлөрүүлдэг.

Дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлснээр дайсны тагнуулын ажиллагааны үр дүн илт буурч авиацийн цохилтын нөлөө багасна.

Давшилтад шилжиж байгаа анги, салбарууд нь давшилтын гол чиглэлд байгаа дайсны цэргийн удирдлагын зохион байгуулалтыг алдагдуулж, өөрийн цэргийн удирдлагын тогтвортой ажиллагааг хангаж

ажиллана.

РЦТ-ийн анги, салбарууд нь дайсны пуужин, артиллер, 1 дүгээр цуврааны анги, нэгтгэлүүдийн радио холбоо, зарлан мэдээллийн радио тор, радио чиглүүлгийн систем, агаарын тагнуул, нам өндрийн нислэгийг хангах радиолокацын станц зэргийн ажиллагаанд саатуулга тавьж тасалдуулна. Цөмийн зэвсэг зөөгч онгоц, пуужин, тактикийн авиациы радио холбоонд саатуулга тавихад анхаардаг байна.

Тулгарах байлдаан болон дайсны сөрөг цохилт, давшилтыг няцаах үед пуужин, артиллерын ангиуд, авиац, дайсны хөдөлгөөн үйлдэж байгаа резервийн удирдлагын холбоо, түүний холбооны зангилгаа, радиолокацын хэрэгслүүдэд саагуулга тавих, устгах арга хэмжээнүүдийг авна.

РЦТ-ийн хүч хэрэгслүүд нь сөрөг цохилт, атакийн бүлэглэлийн удирдлага, харилцан ажиллагаа, авиац, зарлан мэдээллийн радио холбоонд саатуулга тавина.

РЦТ-ийн «О» маягийн батальон нь өөрийн удирдлагын байр, цэргийн гол чиглэлд байгаа томоохон бүлэглэл, артиллерын бүлэглэл, ар талын удирдах байр зэрэг объектуудыг дайсны агаарын дайралтаас халхладаг.

РЦТ-ийн «О» батальоны саатуулгын станцууд нь дайсны онгоцны бүхээгийн радио холбоо, түүний зэвсгийн удирдлагын радио цахим системүүд, радиолокац зэргийн ажиллагааг идэвхтэй саатуулгаар дарж, тухайн онгоц өөрийн зэвсэг, холбоог ашиглах боломжгүй болгох юм.

Операц, байлдааны ажиллагааны явцад РЦТ-ийг зохион байгуулж явуулах төлөвлөгөөнд тусгагдсанаар дайсны бүх төрлийн удирдлагын байрууд, үүнээс ялангуяа өндөр цэцтэй зэвсэг, артиллер, авиацин удирдлагын байрууд, бусад РЦО-уудыг илрүүлж хөнөөхөд гол анхаарлаа чиглүүлэх нь тухайн ажиллагааг амжилттай явуулах үндэс юм.

Дайсны гүнд ажиллаж байгаа манай тагнуул, хорлон сүйтгэх бүлэг нь дайсны холбооны зангилгаа, радиолокацын пост, чиглүүлгийн станц, холбооны шугам гэх мэт жижиг боловч чухал үүрэг гүйцэтгэдэг объектуудыг устгах, эзлэн авах үйл ажиллагааг явуулна.

Байлдааны ажиллагааны гол чиглэлд байгаа болон энэ чиглэлд хөдөлгөөн үйлдэж болзошгүй нэгтгэл, ангиудын бүх радио холбоонд саатуулга тавина. Гол чиглэлд байлдааны ажиллагаа явуулж байгаа анги, нэгтгэлүүдийг РЦТ-ийн станц техник, радио тэсрүүлэгчтэй сумнаас хамгаалах салаа зэрэг маневрлах өндөр хүчин чадалтай РЦТ-ийн техник хэрэгслүүдээр хүч нэмэгдүүлж болно.

Хоёрдугаар цуврааг байлдаанд оруулах үед дайсны авиац, артиллер, тагнуулын хүч хэрэгслүүд болон удирдах байруудад хөнөөл учруулж, РЦХ-үүдэд саатуулга тавьж, байлдаанд орох чиглэлд байгаа дайсны тагнуулын болон радио чиглүүлгийн систем, нэгтгэл ангиудын радио холбоог тасалдуулах ажлыг зохион байгуулна.

РЦТ-ийн онгоцны «О» батальон нь агаарын цэрэг, хими, инженерийн цэрэгтэй харилцан ажиллагаатайгаар командын байр, ар талын болон артиллерын бүлэглэл мөн хоёрдугаар цуврааны анги салбаруудыг агаарын дайралт, тагнуулын техник хэрэгслүүдээс халхлана. Дайсны цэргийн

бүлэглэл, анги, салбаруудыг бүсэлж устгах байлдаанд дайсны артиллер, танк эсэргүүцэх хэрэгслүүдийн удирдлагын системүүдийг бүслэлтийг цөмлөж болзошгүй чиглэлд тагнан илрүүлж, тэдэнд идэвхтэй саатуулга тавина. РЦТ-ийн анги салбарууд нь бүслэгдсэн дайснуудаас бүслэлтийн гадна байгаа нэгтгэл ангиудтай барьж байгаа холбоонд радио саатуулга тавина. Дайсныг бүслэлтээс гарах оролдлогын үед түүний холбоо, удирдлагын системүүдэд хүчтэй бөөгнөрүүлсэн идэвхтэй саатуулга тавьж удирдлага зохион байгуулалтыг алдагдуулахыг зөвлөмжилдөг.

Хориглолтод РЦТ-ийн үндсэн чармайлтыг дайсны гол цохилтын чиглэлд хориглох анги, нэгтгэлүүдийн байлдааны ажиллагааг дэмжихэд төвлөрүүлнэ.

Дайсны удирдлагын байрууд, 1 дүгээр цуврааны анги, салбаруудын удирдлагын системүүд, зарим чухал радио цахим объектуудад галын цохилт хийж, бусад удирдлагын радио цахимын хэрэгслүүдийн ажиллагаанд радио саатуулга тавьж удирдлагыг алдагдуулна.

Дайсны өндөр цэцтэй зэвсэг, авиац, артиллерын удирдлагын байруудын радио цахимын хэрэгслүүдийг тагнан илрүүлж устгах, радио саатуулга тавихад онцлон анхаарахыг зөвлөмж болгодог.

Сөрөг цохилт, атакийн үед РЦТ-ийн үндсэн чармайлтыг цөмөрсөн дайсны удирдлагын зохион байгуулалтыг алдагдуулахад чиглүүлнэ.

РЦТ-ийн анги, салбарууд нь цөмөрсөн дайсны нэг, хоёрдугаар цуврааны анги, салбарууд, резервийн ангиудын радио, радио релейний холбоо тэдгээрийн харилцан ажиллагаа, авиац, чиглүүлгийн систем, бусад удирдлагын системүүдэд радио саатууга тавина.

Сөрөг цохилт, атакийн үед РЦТ-ийн зорилтуудыг шийдвэрлэхэд сөрөг цохилтын ба урьд ажиллаж байгаа болон зэргэлдээ анги, салбаруудын хүч хэрэгслүүд оролцоно.

Операц, байлдаанд радио цахимын хамгаалалтын асуудлууд тасралтгүй зохион байгуулагдана.

Радио цахимын хамгаалалтын ажиллагаанд үелзлэлүүдийг оновчтой хуваарилан тэдгээрээр чөлөөтэй маневрлах, удирдлага, тагнуул, радио чиглүүлгийн системд төрөл бүрийн царын радио цахимын хэрэгслүүдийг цогцоор нь ашиглах, холбооны нууцлагдсан, орлон гүйцэтгэх, тойрох чиглэлүүдийг зохион байгуулах, дайсны радио саатуулгын хэрэгслүүдийг илрүүлэн олж устгах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Радио цахимын хамгаалалтыг зохион байгуулахад дайсны өөрийгөө чиглүүлэгч сум, удирдлагатай зэвсгийн хөнөөлөөс хамгаалах, өөрийн радио цахимын хэрэгслүүдийн харилцан саатуулгаас хамгаалах зэрэг ажиллагаанд анхаарахыг зөвлөмж болгодог байна.

Дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааг зохион байгуулахдаа операц, байлдааны бодлого цэргийн бүлэглэл, бүрэлдэхүүн, гол цохилтын болон үндсэн чармайлтын чиглэл, галын цогцолбор хөнөөлийн хүч хэрэгслийг ашиглах журам, хугацааг нууцлахад анхаардаг.

Дайсны тагнуулын зарим чухал объектуудыг хөнөөхийн тулд авиацийн цохилт, артиллерын галыг хуваарилан ашиглана. Мөн дайсны тагнуулын

холбоо, удирдлагын радио цахимын хэрэгслүүдийн ажиллагааг радио саатуулгаар дарах нь тулгамдсан асуудал хэвээр байна.

Дүгнэлт

Манай зэвсэгт хүчинд радио цахимын тэмцлийг бүрэн хэмжээгээр зохион байгуулж явуулах нөхцөл боломж бүрдээгүй ч өнөөгийн нөхцөл боломжоороо дараах зүйлүүдийг хийх хэрэгтэй гэж дүгнэж байна.

1. Бүх чиглэлүүдэд радио цахимын цагийн байдлыг нарийвчлан судалж, орчин үеийн цэргийн болон зэвсгийн удирдлагын систем, тагнуул, РЦТ-ийн хүч хэрэгслийн өнөөгийн байдал, хөгжлийн хэтийн төлвийг судлан дүгнэж, тэдгээрийг байлдаанд ашиглах онцлогийг тодорхойлох;

2. Зэвсэгт хүчний сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу төрөл, тусгай мэргэжлийн цэргийн командлагч, анги, салбаруудын захирагч, штабуудын РЦТ-ийн бэлтгэлийг системтэйгээр явуулах;

3. Дайсны тагнуулын техник хэрэгслийн эсрэг ажиллагааны шаардлагыг хангахын тулд Зэвсэгт хүчний анги, салбаруудын радио цахимын хэрэгслүүдийн ажлын горим, радио сахилга, холбооны аюулгүй байдал, шинэ техник хэрэгслийн нууцлалт зэрэгт тавих хяналтыг чангатгах;

4. Зэвсэгт хүчний хэмжээнд явагддаг команд штабын сургуулиар РЦТ-ийн цагийн байдлыг бий болгон түүнийг зохион байгуулж явуулах арга хэлбэрийг төлөвлөн хэрэгжүүлж, цаашид төгөлдөржүүлэх;

5. РЦТ-ийн анги, салбар постуудыг ээлж дараатайгаар бий болгож бүтэц орон тоо, техник зэвсэглэлийн хангалтыг системтэйгээр хийж бэхжүүлэх, түүнд сургагдах, дадлагажих;

6. Анги, салбарууд, штабуудын байлдааны бэлэн байдал, байлдааны бэлтгэл сургуулийн баримт бичгүүдэд РЦТ-ийн асуудлуудыг тусган төлөвлөж, байлдааны ажиллагааны төрлүүдэд РЦТ-ийн хүч хэрэгслийг ашиглах журмыг тодорхойлох;

7. ОХУ-ын цэргийн их, дээд сургууль, академиудад РЦТ-ийн мэргэжлээр боловсон хүчнээ бэлтгэхэд шийдвэртэй алхам хийх;

8. ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн сургуулийн бүх тэнхимүүдийн хичээлийн хөтөлбөрт РЦТ-ийн асуудлыг тусган төлөвлөж онолын мэдлэг заавал олгох зэрэг болно.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Машбаатар Ж., “Радиоэлектронны тэмцэл”-УБ., “Батлан хамгаалахын их сургууль” 2010. 265х., т.171, ISBN978-99929-873-5-9;
2. Бурмистров С.К., Аношко Ю.Н., Морозов А.Г., ...”Справочник офицера воздушно-космической обороны”-г.Тверь., “Военная академия воздушно-космической академий” 2006. 556х., т.528, ББК 68.65я2-С74-УДК 629(3);
3. Гантөмөр С., Отгонбаяр С., “Радиоэлектронны тэмцэл”-УБ., “Цэргийн их сургуулийн хэвлэх цех” 1995. 48х., т.24;

“Өнгөт хувьсгал” ба гибрид дайны мөн чанар, онцлог

Т.Намсрай

Доктор (Ph.D), профессор

Summary: The essence and content of the strategies and counterstrategies of the opposing sides when preparing and holding hybrid warfares. Recommendations are given for neutralizing hybrid threats and organizing counteraction when unleashing a hybrid warfare.

Keywords: hybrid warfare, hybrid threat, color revolutions, counterstrategies

Ерөнхий зүйл: Даяаршил ба мэдээлэл-харилцааны хувьсгалаас үүдэлтэй онцлог нэг хандлага нь олон улс, бүс нутаг болон улс үндэстний аюулгүй байдалд учрах дайны бус аюул занал нэмэгдэж байгаа явдал болж байна. Дайны философи ба хууль хувьсан өөрчлөгдөж, байна. Улс төр ба цэргийн шинжлэх ухаанаар цэргийн хэргийн хувьсалын (эволюци) түвэгтэй, зөрчилт үйл явцыг онол ба практикийн дотоод зүй тогтлыг тайлах, тайлбарлахыг хичээн оролдож байна.

Цэргийн хэргийн хувьсалын хүчин зүйлс зуун зууны турш өөрчлөгдөж байв. Өдгөө даяаршил ба мэдээлэл-харилцааны хувьсгалын үйл явц нь орчин үеийн цэргийн мөргөлдөөний стратегийн хөгжил, шинж чанарын өөрчлөлт болон агуулгад гүнзгий нөлөө үзүүлэх болж байна. Энэ зөрчилт, хөдөлгөөнт үйл явц дэлхийн эдийн засаг, улс төр, цэргийн хэрэг, холбоо харилцаа, шинжлэх ухаан, соёл урлагийг хамаарч, орчин үеийн нийгмийн амьдралын бүх хүрээг хөндөх болж байна.

Өдгөө дэлхий ертөнцөд байгаа янз бүрийн төрлийн дайн, зэвсэгт мөргөлдөөнийг өмнөх үеийн онолчдын томъёолсон дайны зарим хуулиар тайлбарлах боломжгүй болж байна. Өмнөх зуун ба XXI зууны дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж төрх эрс ялгаатай болж, улмаар дайны хуулийн илрэх хэлбэрт өөрчлөлт оруулж байна. Дайны хуулийн өөрчлөлтөд түлхэц өгсөн чухал хүчин зүйл нь Зөвлөлт Холбоот Улсын задрал ба социалист системийн нуралт болж, улмаар нэг туйлт дэлхий ертөнц тогтоход хүргэсэн явдал гэж үзэж байна.

Сүүлийн арваад жилд дэлхийн нөхцөл байдалд олон улсын байгууллагуудаас нөлөөлөх чадвар үлэмж суларсчээ. Жишээлбэл, 2018 оны 4 дүгээр сард НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн гурван гишүүн Сирийн эсрэг түрэмгийлэлд оролцсон нь олон улсын харилцаанд хүч хэрэглэх асуудлаар НҮБ-ын хориг тавих эрхийг үл хайхарсан хэрэг

болсон гэж үздэг юм.

Өнөө үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж төрх өөрчлөгдсөн гэх үзэл бодол нэлээд түгээмэл болж байгаа нь явган цэрэг, танкаар цөмрөн орохын оронд “өнгөт хувьсгал”, бөмбөг, пуужингийн цохилтын оронд эдийн засгийн хоригоор “багалзуурдах” хандлага ажиглагдаж байгаатай холбоотой юм.

Шинжээчид болон улс төрчид өнгөрсөн зууны сүүлчээс, ялангуяа Ирак, Югослав, дараа нь Ливи, Сири зэрэг улсад өрнөсөн цэргийн ажиллагаанаас эхлэн дайны шинэ төрлийн хандлагын тухай хүчтэй ярих боллоо. Олон улсын аюулгүй байдлын хурлууд дээр “мэдээллийн операц”, “өнгөт хувьсгал”, “гибрид аюул занал”, “удирдлагат хаос (эмх замбараагүй байдал)” зэрэг ажиллагааны хувилбаруудыг хэлэлцдэг болжээ. Сүүлийн жилүүдэд дэлхийд болж буй үйл явдлыг зарим судлаач “дэлхийн дайн” гэж ч нэрлэсэн байна.

Дэлхийн улс орнууд, юуны өмнө, улс төр, эдийн засаг, мэдээлэл зэрэг бүх төрлийн аюул занал, эрсдлийг шинжилсэний үндсэн дээр үндэсний аюулгүй байдлын стратегтаа өөрчлөлт оруулах хандлага ажиглагдаж байна.

“Өнгөт хувьсгал” гибрид дайны угтал болох нь: “Өнгөт хувьсгал” нь гибрид дайны угтал болж байгааг онцгой аюултай гэж үзэх боллоо. “Өнгөт хувьсгал”-ын явц дахь мэдээллийн нөлөөлөл үр дүнгийн хувьд цэргийн ажиллагаатай дүйцэхүйц болж байна. Үүний сацуу улс төрийн үйлдэл, эмбарго (хориг), худалдаа-эдийн засгийн хязгаарлалт, квот (хувь хэмжээ тогтоох) зэрэг арга хэмжээг дараа дараагийн хүчирхийллийг дэмжих хэрэгсэл болгож байна. АНУ “өнгөт хувьсгал”-ыг Хойд Африкт, Ойрх Дорнодод өдөөсөн. Бараг шууд хүчирхийлэлгүйгээр 2004 онд Гүржид, Украйнд засаг солигдсон. “Арабын хавар” үйл явцад Тунис, Египет, Алжир, Йемен зэрэг улсад “өнгөт хувьсгал”-аар ялалт байгуулсан.

“Өнгөт хувьсгал” нь улс төрийн өөрчлөлтийн үнэмлэхүй хэрэгсэл бус, өргөн царааны цэргийн ажиллагаа болон хувирч болзошгүйг “Арабын хавар”-ын цаашдын өрнөл харуулсан. Үүний тод жишээ нь Ирак, Ливи болон Сири дахь үйл явдал бөгөөд энэ нь “Исламын улс” террорист бүлэглэлийг байгуулахад дэмжлэг болсон гэж үздэг юм. Ихэнх тохиолдолд сөрөг хүчин, гаднын хүчин тухайн онилсон улсын төр засагт шахалт дарамт үзүүлж, эхлээд хязгаарладмал, дараа нь өргөн царааны хүчирхийллийн арга хэмжээнд шилжсэн байдаг юм. “Өнгөт хувьсгал”-ын бэлтгэл болон явцад улс орныг тогтворгүй болгох, удирдлагат хаосын технологийг амжилттай хэрэглэх зохих нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Сөргөлдөөнт байдлын эцсийн үе шатанд онилсон улсын төр засгийн үйл ажиллагаа ба элит (дээд) давхаргын улс төрийн зориг эрмэлзэл алдагдаж, улс орны аюулгүй байдал байж боломгүй түвшинд хүртэл буурч, улмаар засаглалын эрх гаднын ивээл доорх сөрөг хүчинд шилжүүлэх асуудал аргагүй тавигддаг байна. .

“Өнгөт хувьсгал”-ыг эхлүүлэхийн тулд эрх зүйн (легитим) шалтгаан

байх хэрэгтэй болдог байна. Украин, Словак, Серби, Гүрж улсад ийм шалтгаан нь сонгууль болсон байдаг юм. “Өнгөт хувьсгал” хийх шалтгаанд сонгуулийг ашиглах сөрөг хүчний ажиллагаа нь: нэгд, мэдээлэл-сэтгэл зүйг суурь дэвсгэр болгон улс төрийн зорилтыг тодорхойлох(эрх барьж буй засаглал сонгуулийг будлиантуулж байгаа тухай цуурхал тараах, улс орны дотоод болон гадаадад буй сөрөг хүчний төлөөлөгчид ардчиллын үйл явц, сонгуулийг будлиантуулах боломжийн тухайд сэтгэл зовнилоо илэрхийлэх гм); хоёрт, цуурхал, худал мэдээлэл тараах (сөрөг хүчин өөрийнгөө ялсан гэж зарлах, өгөгдөхүүн, мэдээллийг буруу гэх цуурхал тараах, сонгуулийг будлиантуулж болзошгүй талаар сэтгэл зовнилоо илэрхийлэх гм); гуравт, эсэргүүцлийн хөдөлгөөний чадавхийг зузаатгаж олон нийтийг дайчлах (нийслэл рүү сөрөг хүчний талыг баримтлагчдыг бусад газраас татан авчрах, эсэргүүцлийн цуглааны хүрээг өргөтгөх гм), дөрөвт, сөрөг хүчний эсэргүүцлийн ажиллагааг идэвхжүүлэх зэрэг арга хэмжээг багтааж байна.

Монгол Улсад сонгуулийн үр дүнтэй холбоотой үймээн самуун гарч байсан гашуун сургамж бий. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Сонгуулийн дүнг албан ёсоор хараахан гаргаагүй байхад МАХН-ын сонгуулийн штабаас “манайх илт ялалт байгууллаа” гэсэн мэдэгдэлд дургүйцсэн иргэд болон иргэний хөдөлгөөнөөс жагсаал цуглаан хийсэн бөгөөд уг жагсаал цуглааныг дэг журамтай зохион байгуулалтанд оруулж чадаагүйгээс нөхцөл байдал хүндэрч, эмх замбраагүй байдал үүссэн. Энэ үеэр таван хүний амь эрсдэж, соёлын үнэт зүйлс, байгууллага ба иргэдийн өмч хөрөнгө устаж, олон хүнийг түр саатуулан шалгах шаардлага гарч байжээ.

Энэхүү онцгой нөхцөл, үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор Монгол Улсын Үндсэн хууль ба Онц байдлын тухай хуулийн холбогдох хэсгүүдийг баримтлан нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2008 оны 7 дугаар сарын 01-ний 24.00 цагаас эхлэн 4 хоногийн хугацаанд “Онц байдал тогтоох тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг гаргаж хэрэгжүүлж байсан удаатай.

Зарим судлаач (А.Галич, Д.Лушников) “Эрх барьж буй дэглэм цагдаа болон цэргийн арга хэрэгслээр эсэргүүцлийн хөдөлгөөнийг нухчин дарахад зүрхлэхгүй байх нь “өнгөт хувьсгал”-ын амжилтад чухал нөлөөтөй” гэж үзсэн байна [1].

Улс төрийн дэглэмийг өөрчлөх орчин үеийн технологи болох “өнгөт хувьсгал” хэд хэдэн онцлогтой байна. **Нэгдүгээрт**, “өнгөт хувьсгал”-ын технологи “ард иргэдийн дургүйцэл”-ийг алгуур хөөрөгдөн дэвэргэж, улмаар тухайн онилсон улсын засаглалыг устгах явдлыг агуулдаг. Өөрөөр хэлбэл, улс төрийн тогтворгүй байдлыг хиймлээр бий болгон төрийн эргэлт зохион байгуулж, тухайн онилсон улсыг гадаад улсын нөлөө доорх удирдлагад шилжүүлэх технологи аж. Гаднын нөлөөллийг сайтар нууцалдаг учраас хорлон сүйтгэх технологийг хэн, хэзээ, хаана төлөвлөж хэрэгжүүлэх санаархалтай байгааг мэдэхэд хүндрэлтэй байдаг байна. Украин, Серби, Гүрж, Киргиз, Тунис ба Египетэд 1-2 сарын

дотор “өнгөт хувьсгал” болсон учраас мэдээлийг өрсөн шуурхай олж авах шаардлага онцгой ач холбогдолтой байдаг байна. “Өнгөт хувьсгал”-ыг зохион байгуулагчид хүмүүсийн сэтгэл зүй, мэдээллийн өрсөлдөөнд ихээхэн найдлага тавьдаг байна. Улс орны гадаад ба дотоод бодлогыг мушгин гуйвуулахад чиглэсэн мэдээллийн урсгал нь улс хоорондын зөрчил мөргөлдөөний гарцаагүй байх бүрдэл хэсэг болж байна

Хоёрдугаарт, “Өнгөт хувьсгал”-ыг бэлтгэх нөхцөлийг дийлэнхдээ дотоодын хүчин зүйлд тулгуурладаг байна. Ингэхдээ хүн амын дийлэнх хэсгийн бодол санааг эзэмдэж, улс орны дотоод нөхцөл байдлыг хурцатгаж, дотоодын зэвсэгт мөргөлдөөн, засаглалын хямралыг өдөөн турхирч, улсын дотоод бодлогод эмзэг байдлыг бий болгодог байна.

Гуравдугаарт, “Өнгөт хувьсгал”-ын явцад сөргөлдөөнт байдлыг лавшруулахад хорлон сүйтгэх ажиллагааг санхүүгийн ба мэдээллийн хувьд дэмжихтэй холбоотой гадаад хүчин зүйл үлэмж чухал үүрэгтэй байдаг байна. Чухамдаа гадаадын мэдээллийн суваг ба дотоодын сөрөг хүчний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь “өнгөт хувьсгал”-ын технологийг хэрэглэх чиглэл, хөдөлгөөнд шуурхай нөлөөлөх боломжийг түрэмгийлэгч талд олгодог байна.

“Өнгөт хувьсгал” ба гибрид дайнд түрэмгийлэгч тал нөгөө талынхаа нутаг дэвсгэрт цөмрөн орж эзлэн авахгүйгээр уг онилсон улсын нутаг дэвсэрт операц явуулдаг. Сирийн хямралыг “өнгөт хувьсгал”-ын сонгодог өрнөлийг хэрэгжүүлэхээс эхэлсэн гэж үздэг юм. Тухайн үед байсан засаглалыг эсэргүүцсэн ердийн жагсаал цаашдаа уг жагсаалд оролцогчид засгийн газрын цэрэг ба хууль сахиулах хүчнийхэнтэй тэмцэлдсэн зэвсэгт мөргөлдөөн болж даамжирсан. Янз бүрийн зандалчин бүлгийг сайтар зэвсэглэсэн, сургаж бэлтгэгдсэн алан хядах отряд болгон хувиргахад барууны орнуудын оролцоо чухал байсан бөгөөд уг отряд 2015 онд засгийн газрын хүчинтэй тэмцэх нэгдсэн фронт “Исламын улс” бүлэглэлийг бий болгосон байна.

“Өнгөт хувьсгал”-ын үргэлжлэл нь гибрид дайн болох нь: “Өнгөт хувьсгал”-ын дараах үе шат нь гибрид дайн бөгөөд түүнд нэлээд хүч хэрэгсэл ашигладаг байна. Зэвсэглэн дайтах уламжлалт дайныг бодвол гибрид дайн онилсон улс орны дотоод дахь урьдчилан бэлтгэсэн хөрсөнд эхэлдэг онцлогтой байдаг байна. Лондонгийн олон улсын институтээс гаргадаг “The Military Balance-2015” судалгааны эмхэтгэлд гибрид дайн “hybrid warfare” гэсэн хэллэг анхлан бий болсон. *“Гибрид” гэх үг нь латин хэлний “hibrida” гэсэн үгнээс гаралтай бөгөөд монголчилбол эрлийз, холимог, холилдон орсон гэсэн утгатай аж.*

ОХУ-ын БХЯ-ны сайд С.Шойгу “ Барууныхан гибрид дайны тусламжтайгаар Крым дахь нөхцөл байдлыг тогтворгүй болгох ородлого бүтэлгүйтсэний дараа Барууны олон нийтийн мэдээллийн хэрэгслээр Оросыг “гибрид дайн”-д буруутгаж эхэлсэн” гэжээ [2].

Гибрид дайны аргыг АНУ, Их Британи 1991 онд Персийн булан дахь дайны үеэр Иракт туршин хэрэглэсэн. Өнгөрсөн зууны 90-ээд оноос

эхлэн уг аргыг АНУ хуучин Югослав, Ливи, Чечень, бүр саяхан Сирид өргөн хэрэглсэн. Гибрид дайны хэрэглээний бүх шинж тэмдэг 2014 оны 2 дугаар сард Украинд болсон зэвсэгт үймээний өмнөх нөхцөл байдалд тод ажиглагдсан байна. Эдгээр гибрид ажиллагаанд европын улс орнууд дам байдлаар оролцсон гэж оросын тал үздэг юм.

Оросын тусгай хүчний салбарууд 2014 оны 2-3 дугаар сард Крымын статусын тухай бүх нийтийн санал (референдум) авах ажлыг бэлтгэн явуулах үед аюулгүй байдал (крымчуудын саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэт үндсэрхэг үзэлтнүүдийн зүгээс саад хийх аюул байсан)-ыг хангасан байна. Буун дуу гаргалгүйгээр стратегийн бүх объектыг эзэлж, крымын хойгт байрладаг Украины цэргийн ангиудыг бүслэн хааж, цус гаргалгүйгээр буулгаж авсан.

2015 оны 1 дүгээр сарын 15-нд Украин дахь нөхцөл байдлын талаар гаргасан НҮБ-ын тогтоолд Орос улс Украины эсрэг гибрид дайн явуулж байгаа тухай тэмдэглэсэн байна. Мөн оны 1 дүгээр сарын 20-нд А.Яценюк (хожим Украины Ерөнхий сайд болсон) “Оросын цэргийн түрэмгийллийн эхний үе шат нь гибрид дайны шинжтэй байсан. “Эелдэг хүмүүс” Крымыг эзлэн авч, Дорнод Украины нутагт хууль бусаар цөмрөн орсон. Ийм дайны шинж төрөлд хэн ч, мөн дэлхий даяар бэлэн байгаагүй” гэжээ.

Сүүлийн жилүүдэд орчин үеийн сөргөлдөөний шинэлэг төрөл болох “өнгөт хувьсгал” болон “гибрид дайн” гэх нэр томъёо шинээр гарсан, албан ёсоор хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй, шинжээчдийн дунд нэгдсэн ойлголт төлөвшөөгүй учраас онолын маргаан мэтгэлцээний сэдэв болсоор байна. Гибрид дайныг орчин үеийн цэргийн хэргийн практикт хүчтэй нөлөөлөх онолын шинэлэг зүйл, тэгэх тусмаа “операц”-ын гэх ойлголт боломжгүй гэж зарим мэргэжилтнүүд үзсэн байна. Бас нөгөө зарим цэргийн мэргэжилтнүүд нэгдсэн бодлогын хүрээнд тавигдсан зорилгод хүрэх хүч хэрэгсэл, аргыг цогцлон нэгтгэдэг гибрид дайны онцлогийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэдэг байна

Дэлхийн цар хүрээний сунжирсан мөргөлдөөний жишээ нь өдгөө дахин сэргэж буй “хүйтэн дайн” гэсэн хандлага ч яригдаж байна. Өнгөрсөн зууны “хүйтэн дайн” жинхэнэ дайн байсан, эсхүл өөр зүйл байсан талаар одоо хүртэл нэгдсэн ойлголт байхгүй байна. Сүнз “зэвсэгт хүчний тэмцэлгүйгээр ялалт байгуулсан дайныг шилдэг дайн” гэж үзэж байжээ [3].

Хүйтэн дайн дахин сэргэж буй стратегид “өнгөт хувьсгал” болон гибрид дайны хорлон сүйтгэх ажиллагаа багтах болж байна.

Судалгааны ном бүтээл, нийтлэлээс үзэхэд гибрид дайны онцлог нийтлэг шинж нь **нэгд**, мэдээллийн сөргөлдөөний арга хэмжээтэй хамтруулан цэргийн болон дайны бус хэрэгслийг хэрэглэх; **хоёрт**, шууд бус ажиллагааны ач холбогдлыг өсгөх; **гуравт**, тусгай операцийг хүн амын дургүйцлийн байдалтай хамтруулан далд шинжтэй хүчний ажиллагаа болгоход оршдог байна.

Уламжлалт дайнд удирдлагын бүтэц босоо (пирамид) хэлбэртэй

байдаг бол гибрид дайнд хэвтээ олон төвт сүлжээлэг хэлбэртэй бөгөөд сүлжээлэг зохион байгуулалтын чухал шинж чанар нь суурь бүтцийн нэгжүүдийн хөдөлгөөнт, шуурхай байдал, стратегийн чухал объектод хүч чармайлтаа шуурхай төвлөрүүлэх явдал байдаг байна. Мөн нэлээд онцлог шинжид хүч хэрэгслийг дайчлах, удирдахад орчин үеийн мэдээлэл-холбооны технологи, төр засгийн гол бүтцийг задлан бутаргах технологи хэрэглэх, хүн амын сэтгэл зүйд нөлөөлж үйл хөдлөлийг нь өөрийн сонирхолд ашиглах явдал хамаардаг байна.

Гибрид дайныг зарлаагүй дайн, далдуур хорлон сүйтгэх ажиллагаа, түүний явцад түрэмгийлэгч улс гаднын санхүү, зэвсгийн болон дотоодын зарим бүлэглэл (олигархи, зохион байгуулалттай гэмт хэрэг, хэт үндсэрхэг болон шашны байгууллага)-ийн дэмжлэг авсан босогчид, хэт даврагч үзэлтнүүдийн тусламжтайгаар онилсон улсынхаа төр засгийн удирдлагын бүтэц, хууль сахиулах хүчин, байнгын армийн эсрэг тэмцэл явуулдаг гэж үзэх хандлага ч байна.

Гибрид дайны стратегийн чухал зарчим нь улс орны төр засгийн болон цэргийн удирдлагыг тогтворгүй байдалтай болгох эмзэг газарт байгаа хүч хэрэгслээ дээд зэргээр төвлөрүүлж, улмаар олон улсын эрх зүйн бие даасан субъект болох улс орныг задлан бутаргагч, гаднын удирдлагын нөлөө доорх хүчинд шилжүүлэх явдал болдог байна.

Уламжлалт дайныг бодвол гибрид дайны стартеги хэд хэдэн онцлогтой байгааг тэмдэглэсэн байна. **Нэгдүгээрт**, гибрид дайнд хүчний тэмцлийн сацуу мэдээллийн, кибернетикийн, дипломатын ба эдийн засгийн өрсөлдөөний арга, тусгай операцийн хүчин чухал үүрэгтэй аж. **Хоёрдугаарт**, гибрид дайныг зохион байгуулагчид аль болох богино хугацаанд онилсон улсынхаа оршин байгаа төр засгийг устгаж, сөрөг хүчний засаглалын хяналтыг тогтоохыг эрмэлздэг. **Гуравдугаарт**, гибрид дайнд цохилтын гол хүч нь дайны объект болох улс орны хүн ам болдог бөгөөд уг ажиллагаандаа олон улсын террорист байгууллагын ивээлийн зэвсэгт бүлэглэл, цэргийн хувийн компани зэрэг гаднын нөлөө дэх бүрэлдэхүүнийг татан оролцуулдаг, бас тусгай операцын хүчийг ашигладаг байна.

Гибрид дайнд илэрхий гаднын түрэмгийлэгч гэх дайсан-субъект байхгүй байдаг нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэлбэр төдий баримтлан уг дайныг бэлтгэн явуулах хэрэг гардаг байна. Олон улсын эрх зүйн баримт бичгийн тодорхойлолтын тухайд 1974 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн 29 дүгээр чуулганы тогтоолд “Түрэмгийлэл гэдгийг алив нэгэн улс нөгөө улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн халдашгүй байдал буюу улс төрийн тусгаар байдлын эсрэг зэвсэгт хүчнээ ашиглах явдал юм” гэжээ. Гибрид дайныг эхэлсэн улсын үйлдэл уг тодорхойлолтын агуулгад хамаарахгүй байдал ажиглагдаж байна.

Гибрид дайны стратегийг боловсруулах ба хэрэгжүүлэх нь хэд хэдэн үе шатыг тухайлбал, дайны зорилго, агуулгыг тодорхой томъёолох; онилсон улсынхаа дотоод ба гадаад аюулгүй байдлыг хангах хүрээ дэх сул ба эмзэг талуудыг илрүүлэн гаргах; онилсон улсынхаа

онцлогийг харгалзан гибрид аюул заналын цогцыг бий болгох; онилсон улсынхаа улс төр-засаг захиргаа, санхүү-эдийн засаг ба соёл-ертөнцийг үзэх үзлийн хүрээ дэх эмзэг хэсэгт нөлөөлж болохуйц хүч хэрэгслийг харгалзан тооцох, мөн онилсон улсаас учирч болзошгүй сөрөг стратегийг шинжилсэний үндсэн дээр өөрийн стратегийн төлөвлөлтийг хийх; онилсон улсын цэргийн аюулгүй байдлыг хангадаг хамгийн эмзэг хүчин зүйлд (эдийн засаг, санхүү, зэвсэгт хүчний бүрэлдэхүүн ба хүн амын санаа сэтгэл, ёс суртахууны байдал) үндсэн хүчээ төвлөрүүлж, удирдлагын голлох объектод эвдэн бусниулах нөлөөллийг ээлж дараалан үзүүлэх; түрэмгийлэгч улс зарлаагүй цэргийн ажиллагаа явуулж, уг ажиллагааны явцад гаднаас зэвсэг, санхүүгийн тусламж дэмжлэг үзүүлж, онилсон улсын босогчид ба салан тусгаарлагчдын тусламжтайгаар төр засгийн бүтцүүд ба байнгын армид хохирол учруулах; онилсон улсад бүрэн бууж өгөх тулган шаардлага тавих зэрэг арга хэмжээг багтаадаг байна.

Онилсон улсын улс төрийн манлайлагчдыг хулгайлах ба устгах, сөрөг хүчний байнгын бус бүлэглэлд дэмжлэг үзүүлэхийн тулд стратегийн чухал объектын эсрэг тусгай операцын хүчийг, харин энхийг албадан тогтоох “хүмүүнлэгийн операц” гэх шалтагаар гибрид дайны төгсгөлийн үе шатанд байнгын зэвсэгт хүчнийг татан оролцуулах болдог байна. Мөн хэд хэдэн “өнгөт хувьсгал”-ын явцад онилсон улсын оршин байгаа засаглалд хохирол учруулахын тулд “тав дахь цуврааны” (улс төрийн нэр томьёо бөгөөд өөрийн улсын засаглалын эсрэг гуравдагч улсын сонирхолд үйлчилдэг хүмүүс гэж ойлгодог аж) гэх хэт даврагч шинжтэй үйлдэлд чухал ач холбогдол өгч байсан байна.

Гибрид аюул занал бий болоход олон улсын аюулгүй байдлын хүрээ дэх тогтворгүй ба тодорхой бус байдал; хууль бусаар эдийн засгийн хориг хэрэглэх; санхүү-эдийн засгийн хямралыг өдөөн турхирах; кибернетик ба өндөр технологийн хүрээ дэх хууль бус ажиллагаа; үндсэрхэг, үзэн ядах ба хэт даврах үзэл; даяаршсан терроризм; хяналтгүй ба хууль бус дүрвэлт; мансууруулах бодис ба хүний наймаатай холбоотой гэмт хэрэг; байгалийн нөөц баялгийн төлөөх тэмцэл; тухайн орны улс төрийн тогтворгүй байдал; нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлын доройтол, хүн амын ажилгүйдэл ба ядуурал, төрийн байгууллагын систем дэх авлига; төр захиргааны байгууллагуудын чадвар сул байх; хүн амын элит хэсгүүдийн хоорондох эв түнжингүй байдал; янзбүрийн сэдэлтэй гэмт хэргийн өсөлт; хүн амын соёл-иргэншлийн хөгжлийн доройтол; үндэстэн ястан ба шашны сэдэлтэй зөрчил зэрэг хүчин зүйл нөлөөлдөг байна.

Монгол Улсын тухайд дээр дурдсан аюул заналын зарим хүчин зүйл эмзэг байдалтай байгааг мэдээ баримт нотлон харуулдаг юм. Жишээлбэл, Сүүлийн үед мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх зорилготой олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага /ФАТФ/-аас Монгол Улсыг олон улсын санхүүгийн хоригт орох “саарал жагсаалт”-д оруулсан гэх мэдээ онцгой анхаарал татах болж байна.

Дэлхийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллагаас Монгол Улсыг “саарал жагсаалт”-д оруулах болсон дөрвөн

шалтгаанд “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай” хуулийн төслийг ойрын үед УИХ-аар хэлэлцэн батлах; Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн зүйл, заалтыг хянаж үзэх; Оффшор, авлига, албан тушаалын гэмт хэргийн асуудлаар сүр дуулиантай мэдээлэл гаргадаг, тэгсэн хэрнээ шүүхээр шийдсэн асуудал бараг байхгүй байгаад дүгнэлт хийж ажлаа бодитой, үр дүнтэй хийх; хар тамхи зөөвөрлөх, наймаалах хэрэгт төрийн албан хаагчид нь холбогддог, хил гаалиар алт зэрэг хориотой бараа бүтээгдэхүүн нэвтрүүлдэг байдлыг зогсоох зэрэг хугцаатай өгөгдсөн үүргийн хэрэгжилт хангалтгүй байсаныг дурдсан байна

Мөн уг жагсаалтад оруулах нэг үндэслэлийг манай улсын арилжааны банкууд өөрийн хөрөнгөө 700 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсний 200 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг тодорхой гаргаж танилцуулсан, харин 500 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг тодорхой нотолж чадаагүй явдал гэх мэдээлэл цацагдаж байв. Ер нь Монгол Улсыг мөнгө угаах ба терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй гэж дүгнэсэн байна.

Уг жагсаалтад орж олон улсын эдийн засгийн хоригт багтаснаар хөрөнгө оруулагчид орж ирэх боломжгүй болж, гадаад худалдаа ба гадаад төлбөр тооцооны урсгал доголдож, улмаар эдийн засгийн өсөлтийг сааруулах нэг хүчин зүйл болдог гэж эдийн засагчид үзсэн байна. Гаднын хөрөнгө оруулагчид тухайн улсын зах зээлийн боломж, зээлжих зэрэглэл, өрсөлдөх чадвар, бодлого, улс төр ба хууль эрх зүйн орчныг тогтвортой байдлыг онцгойлон хардаг байна. Гаднын хөрөнгө оруулагчид ВВВ түвшнөөс дээш ангилалтай улс оронд л хөрөнгө оруулдаг, гэтэл Монгол Улс нь өнөөдөр В зэрэглэлтэй бөгөөд дайн дажин, үймээн самуунтай улс оронтой адил байгаа талаар хөгжиж буй орнууд, тэр дундаа АСЕАН орнуудад том төсөл санаачлан хэрэгжүүлж байсан эрдэмтэн Хассан Какаая дурдсан байна [4].

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад мансууруулах бодисын хэрэглээтэй холбоотой гэмт хэргийн гаралт улам нэмэгдэж, ялангуяа залуу үеийнхэн хамрагдаж байгаа талаар хууль хяналтын байгууллагаас анхааруулах болж байна.

Монгол Улсын тухайд хяналтгүй ба хууль бус дүрвэлт гэсэн асуудал бараг байдаггүй, харин гадаадын иргэдийн асуудлыг зохицуулах шаардлага гардаг байна. 2019 оны 10 дугаар сарын байдлаар хувийн хэргээр 126 улсын 25419 гадаадын иргэн оршин сууж байгаа нь Монгол Улсын харьяат хүн амын 0,8 хувийг (Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар хүн амын 3 хувь байж болох аж), үүний дотор БНХАУ-ын 13248 иргэн байгаа нь хүн амын 0,4 хувийг (Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар нэг улсын иргэд хүн амын 1 хувь байж болох аж) эзэлдэг байна.

2019 оны 10 дугаар сарын байдлаар эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан, визийн хугацаа хэтрүүлсэн, тус улсын шүүхээр ял шийтгүүлж, ялаа эдэлж дууссан, оршин суух зөвшөөрлийн хугацаа нь

дууссан боловч тус улсаас гарч явахаас зайлсхийсэн зэрэг шалтгаанаар 22 улсын 372 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргасан байна. Албадан гаргасан гадаадын иргэдийн дийлэнхийг БНХАУ-ын иргэд (267) эзэлсэн байна [5].

Гадаадын иргэдтэй холбоотой зөрчлийн хамгийн сүүлийн үеийн жишээ гэвэл манай улсад ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан болох нь тогтоогдсон (жуулчин ба бизнесийн визээр орж ирж, хууль зөрчин ажил хөдөлмөр эрхэлсэн, мөнгө угаах үйл ажиллагаа явуулсан байж болзошгүй гэж үзсэн) БНХАУ-ын 800 орчим иргэдийг Монгол Улсаас албадан гаргасан явдал юм. Уг зөрчлийг шалгах явцад хятад иргэдээс өндөр хүчин чадалтай 1000 гаруй компьютер, 10 мянга орчим гар утас хураан авсан байна [6].

“Transparens international” байгууллагаас жил бүр гаргадаг дэлхийн улс орнуудын Авлигын индексийн 2018 оны жагсаалтаас харахад Монгол Улсад 100 онооноос 37 оноо өгч, 180 орноос 93 дугаарт эрэмбэлсэн байна. Манай улсын авлигийн асуудалд доривтой ахиц гарахгүй байгааг төрийн институцууд болох аудит, шүүх, хууль хэрэгжүүлэх байгууллагууд нь хараат байдалд орсоноос хээл хахууль газар авсан, авлигын томоохон хэргүүд шийдэгдэхгүй замхарч, ял шийтгэлгүй өнгөрдөг, авлигын улмаас улсад учирсан хэдэн зуун тэрбум төгрөгийн хохирол эргэн төлөгддөггүй, төрийн өндөр тушаалын албан хаагчид бүлэглэн авлигын хэрэг үйлдэх болсон, авлига нь гааль, татвар, мэргэжлийн хяналтын байгууллагад системийн шинж чанартай болсон зэрэг хүчин зүйлтэй холбон тайлбарласан байдаг юм [7].

Авлигын эрсдэлт байдал нь гадаадын хөрөнгө оруулагчдыг болгоомжлох, бизнесийн салбарт чөлөөт өрсөлдөөнийг хязгаарлах байдалд хүргэж, улмаар эдийн засгийн өсөлт ба улсын өрсөлдөх чадвар буурахад нөлөөлдөг гэж үздэг байна.

Монгол Улсад 2019 оны 9 дүгээр сарын байдлаар нийт ажилгүй иргэд 131,1 мянга байсан бөгөөд үүний 56,7 хувийг эрэгтэйчүүд, 43,3 хувийг эмэгтэйчүүд эзэлж, ажилгүйдлийн түвшин 10,1 хувьтай, 2018 оны байдлаар улсын дунджаар ядуурлын хамралтын хүрээ 28,4 хувь, ядуурлын гүнзгийрэлт 7,2 хувь, ядуурлын мэдрэмж 2,7 хувь, ядуу хүн амын тоо 904,9 мянга байжээ. Улаанбаатар хотод нийт ядуу хүмүүсийн 41,8 хувь нь амьдардаг байжээ [8].

Мөн Дэлхийн өрсөлдөх чадварын төвөөс гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан-2019” баримт бичигт Монгол Улсын өрсөлдөх чадварыг 63 орноос 62 дугаарт Венесуэлийн өмнө эрэмбэлсэн байна. Монгол Улсын өрсөлдөх чадварын оноо буурахад хэрэглээний үнийн индекс, ил тод байдал, тэтгэврийн сан, хөдөлмөр эрхлэлт, бизнесийн эрх зүй, хөдөлмөрийн зах зээл, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, боловсролын бүтэц, өрийн эргэн төлөлт, бодлого, улс төр ба хууль тогтоомжийн тогтворгүй байдал зэрэг нөлөөлдөг гэж үздэг байна.

Түүнчлэн Монгол Улсад болсон жагсаал цуглаанд оролцогчид,

хэвлэлийн хурлыг зохион байгуулагчдаас авилга хээл хахууль, ядуурал ба ажилгүүдэл, цалин ба тэтгэврийн хүрэлцээгүй байдал, эдийн засаг-нийгмийн оновчгүй төлөвлөлт, улс төрийн бодлого ба хууль тогтоомжийн тогтворгүй байдал, байгаль орчны бохирдол зэрэг асуудлыг хөндөж шаардлага тавьдаг нь нийгэмд бугшсан шудрага бус явдалд бухимдсан нийгмийн тодорхой хэсгийн дургүйцлийн илрэл юм. Шинжлэн үзвэл эдгээр шаардлага нь дэлхийн зарим улс оронд болсон “өнгөт хувьсгал”-ын өрнөлийн эхний үйл явдлын зарим хэсэгтэй төстэй байна.

Сүүлийн жилүүдэд зарим улс орон хийгээд дэлхий даяар нийгэм – улс төрийн амьдралд хүний хүчин зүйлийн үүрэг улам нэмэгдэх хандлага ажиглагдаж, ингэхдээ улс төр дахь хүний хүчин зүйлийн дотор олон нийтийн санаа бодол чухал байр эзлэх болж байна.

Системийн хандлага, сэтгэл зүй, логикийн талаас авч үзвэл олон нийтийн улс төрийн санаа бодол **нэгд**, оршин байгаа нийгэм-улс төрийн системд хандах байдлын субъектив үнэлгээ болдог; **хоёрт**, олон нийтийн зүгээс эсэргүүцлээ илэрхийлэх улс төрийн илрэл болдог; **гуравт**, улс төрийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн субьектын улс төр-сэтгэл зүйн бэлтгэлийг ханган хэрэгжүүлдэг; **дөрөвт**, улс төр-сэтгэл зүйн интеграцад нэгдэж, аливаа улс төрийн ажиллагааг өдөөж, дараа нь “зохицуулагч” болдог байна. Олон нийт өөртөө захируулж, ямар ч шинжтэй зорилтыг шийдвэрлэж болдгийг Украины Майданы үйл явдал нотлон харуулсан юм.

Олон нийтийн субьектын улс төрийн үйл ажиллагааг бэлтгэн явуулах эхний үе шатанд хүнийг иргэн, улс төрийн амьдралын субьект, оюун санааны болон үнэг зүйл бүхий ертөнцийг үзэх үзлийг “тээгч” гэж авч үздэг. Төр засагтай харилцах ухамсарт субьект болох иргэн тухайн улсынхаа төр засагт аль хэр итгэж буйгаа өөрийн үзэл бодлоор илэрхийлдэг. Төр засагт итгэх итгэл нийгэмд иргэний биеэ авч явах гол “хөшүүрэг” болдог байна. Итгэлийг олж авах нь төр засгийн улс төрийн гол зорилт бөгөөд үүний тулд өөрийн мэдэлд байгаа мэдээллийн бүх хэрэгслийн тусламжтайгаар иргэдэд нөлөөлөх явдал байдаг. Нийгмийн ашиг сонирхолд иргэний биеэ авч явах байдал нийцэхгүй байх нь төр засгийн оршин байх улс төрийн тэнцвэрт байдалд заналхийлж, заримдаа нийгмийн үндсийг бусниулах, улс төрийн хэт даврагч шинжтэй болж болзошгүй байдаг байна.

Хоёрдахь үе шатанд хүнийг мөн чанарын хувьд янз бүрийн мэдээллийн “төөрөгдүүлэх” нөлөөлөлд автах ухамсартай хувь хүн гэж авч үздэг бөгөөд ийм нөлөөллийн үр дүн хүний бие мах бодь буюу сэтгэл зүйн эрүүл мэндэд шууд аюул учруулж болзошгүй байдаг байна. Олон жилийн турш ийм нөлөөлөл нийгмийн зарим давхаргын хүмүүст зан суртахуун-сэтгэл зүйн сөрөг уур амьсгалыг бий болгож, гэмт хэргийн орчинг “өөгшүүлэх” хөрс болж, нийгэмд сэтгэл зүйн “өвчин” өсөхөд түлхэц болдог байна.

Гуравдахь үе шатанд зохион байгуулалттай буюу эмх цэгцгүй хүмүүсийн бүлэглэлд үзүүлэх мэдээллийн нөлөөллийг шинжилдэг.

Нөлөөллийн гол зорилго нь хурцадмал (улс төрийн, цэргийн, онцгой байдлын) нөхцөлд зөрчилт байдлыг дэвэргэн даамжруулах (замбраагүй байдлыг өдөөн турхирах, олзлон авахыг албадах, жагсагчдыг идэвхтэй ажиллагаанд уриалах) явдал аж.

Дөрөвдэх үе шатанд улс орон буюу бүс нутгийн хэмжээнд хүн амын мэдээлэл-сэтгэл зүйд нөлөөлөх асуудлыг анхаардаг байна. Ингэхдээ юуны өмнө нийгмийн хамгааллын хувьд дорой буурай хүн амын тэр хэсэг уг нөлөөнд өрөмтгий байдаг байна. Чухамдаа хүн амын тэр хэсэг ядуурал ба амьдралын тух тохьгүй байдлын улмаас ёс суртахуун болон сэтгэл зүйн хүчтэй бухимдалд байдаг байна.

Мэдээлэл-сэтгэл зүйн нөлөөллийн объектод улс орны цэрэг-улс төрийн удирдлага, цэргийн алба хаагчид, энгийн хүн ам; үндэсний болон шашны цөөнх; сөрөг хүчин; нийгмийн тодорхой бүлэг (сэхээтэн, бизнесмен, гэрийн эзэгтэй г.м) хамаардаг. Олон нийтийн улс төрийн үйлдэл өрнөлийнхөө тодорхой үе шатанд өөрийнхөө тавьсан шаардлагыг шийдвэрлэхэд хүргэдэг.

Олон нийтийн улс төрийн үйлдлийг өдөөн зохицуулах ажиллагааны эхний үе шат нь олон нийтийн эсэргүүцлийн хөдөлгөөнийг зохион байгуулах, сургах (олон нийтийг удирдах технологи), хоёрдахь үе шатанд олон нийтийн улс төрийн хөдөлгөөнийг өдөөх турхирах ажиллагааг зохион байгуулах, эсэргүүцлийн хөдөлгөөнийг өрнүүлэх арга хэмжээг тус тус багтааж байна.

Зохион байгуулах үе шатанд нийгэм-улс төрийн янз бүрийн нам, бүлэг, хөдөлгөөн сөрөг хүчний холбоог бүрдүүлдэг бөгөөд ингэхдээ залуучуудын эсэргүүцлийн хөдөлгөөн “буулгах гохны” үүрэг гүйцэтгэдэг байна. Ихэнх “өнгөт хувьсгал”-ын зүтгүүр нь залуучуудын хөдөлгөөн байсаныг Серби, Украин, Гүрж дэх хэрэг явдал харуулсан.

Сөрөг хүчний хөдөлгөөнийг бий болгохдоо зохион байгуулалт, сурталчилгаа болон ажиллагааны сүлжээлэг зарчим, далд удирдлагын зарчмыг баримталдаг. Энэ зарчим нь дарамт шахалт, залхаан цээрлүүлэхээс зайлсхийх, олон нийтийн гүнд нэвтрэх боломж олгож, хөдөлгөөний уян хатан байдлыг хангадаг байна. Эрх баригч дэглэмийн зүгээс удирдлагагүй болгож болзошгүй учраас манлайлагчийг нуугдмал байлгах шаардлага гардаг байна.

ОХУ-д гэхэд “Хэт даврагч чиглэлтэй гэмт хэргийн тоо тогтвортой өсөх хандлагатай болж, уг хэргийн дийлэнхийг залуучууд, түүний дотор насанд хүрээгүй хүмүүс үйлдэж байна, Түйвээн бусниулах үйл ажиллагаа явуулдаг залуучуудын бүлэглэлийн 2 мянга гаруй ороцлогч байгааг илрүүлсэн” гэжээ [9]. Уг бүлэглэлийн үйл ажиллагаа нь улсынхаа сөрөг хүчний бүтцээр дамжуулан гадаадын тусгай албад, байгууллагын зорилго чиглэлтэй ажилд дэмжлэг үзүүлж, иргэдийн зан суртахууны хэв шинж, эх оронч үзлийн үндэс, үндэсний соёл ба оюун санааны үнэт зүйлсийг бусниулахад чиглэдэг байна.

Одоо “гибрид ажиллагаа” нь мэдээллийн хэрэгсэлд хяналт тавих,

эдийн засгийн хориг, кибер орон зай дахь үйл ажиллагаа, дотоодын үймээн хөдөлгөөнийг дэмжих, эцэст нь алан хядах, хорлон сүйтгэх ба хясан боогдуулах ажиллагаа явуулахад тусгай салбар, мэргэжилтнүүдийг ашиглах явдал болж байна. Сургалтыг хурал, семинар, хээрийн лагерь хэлбэрээр олон улсын хүмүүнлэгийн бүтэц, улс төрийн байгууллага, түүнчлэн сургагдсан зохион байгуулагчид, өнгөт хувьсгалд ялалт байгуулсан практик туршлагатай хүмүүс явуулдаг байна.

Гибрид дайны стратеги нь олон талт шинж байдлын, хугацааны ба орон зайн гэсэн гурван хүчин зүйлээр нөхцөлддөг байна. Олон талт шинж байдал нь бодит цагаар сөрөг талд үзүүлэх мэдээллийн, цэргийн, санхүүгийн, эдийн засгийн ба дипломат нөлөөллийн хослол юм. Хугацааны хүчин зүйл нь тамирдуулах стратегийг хэрэгжүүлэх явцад сөрөг талд үзүүлэх нөлөөллийн үргэлжлэлтэй холбоотой байдаг. Харин орон зайн хүчин зүйл нь онилсон улсын нутаг дэвсгэр бүхэлдээ стратегийн хүрээнд хамаардагтай холбоотой байдаг байна. Эдгээр хүчин зүйл нь гибрид дайны сөрөг стратегийн цар хүрээ ба агуулгыг тодорхойлдог байна.

Гибрид дайнд зөвхөн зэвсэгт хүчнийг дайснаа ялахад хүргэх заавал байх ганц нөхцөл гэж үздэггүй нь сонгодог дайны стратегиас онцгойрох гол ялгаа болдог байна. Мөн гибрид дайныг зарладаггүй учраас удаан хугацааны турш цэргийн ажиллагаа явагддаггүй, удирдлагын нэгдсэн төв, фронт ба ар тал байдаггүй, түрэмгийлэгч улс тодорхой хугацааны турш өөрийгөө илчилдэггүй, өргөн царааны дайчилгааны арга хэмжээ явуулдаггүй, дайныг харийн хүмүүсээр (хөлсний хүмүүс, цэргийн хувийн компани гм) хийлгэхийг эрмэлздэг, онилсон улсын сөрөг хүчний болон тагнуулын нөлөөллийн ажиллагааг идэвхжүүлдэг.

Дэд бүтцийн хөгжил, даяаршсан холбоо харилцааны тэлэлттэй уялдан орчин үеийн хямралын онцлог хүчин зүйл нь сөрөг талдаа үзүүлэх мэдээлэл-сэтгэл зүйн нөлөөлийг урьд өмнө байгаагүй цар хүрээнд хэрэгжүүлэх явдал болж байна. Энэ зорилгоор дэлхийн нэгдүгээр дайнд олон нийтийн холбоо харилцааны 11 төрлийн, дэлхийн хоёрдугаар дайнд 13, Персийн булан дахь дайнд(1991) 25, Украин дахь үйл явдалд 40 төрлийн хэрэгсэлийг тус тус хэрэглэсэн байна [10].

Гибрид дайнд түрэмгийлэгч улсын (эвсэлийн) зүгээс явуулж буй зохисгүй үйлдлийн аюулаас урьдчилан сэргийлэх буюу саармагжуулахын тулд хэлбэр, агуулгын хувьд өөр өөр байж болох харилцан уялдаат улс төр, дипломат, цэрэг, эдийн засаг, мэдээлэл, техникийн зэрэг цогц арга хэмжээг багтаасан сөрөг стратегийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага гардаг байна. Ийнхүү хорлон сүйтгэх технологийн эсрэг тэмцэх асуудал (сөрөг стратеги) нь улс орны болон холбоотны түвшинд олон арга хэмжээг багтааж байна. Үүнд:

- орчин үеийн хорлон сүйтгэх технологийг стратегийн түвшинд ашиглахыг гаргуулахгүй байх;
- улс орны улс төрийн болон цэргийн удирдлагын систем, нийгэм-эдийн засгийн бүтэц, хүн амын сэтгэл зүйг тортворгүй болгох

аюул заналыг шуурхай тодорхойлох боломж олгох механизмыг боловсруулах;

- гибрид аюул заналын эмзэг газрыг цаг алдалгүй илрүүлэх, болзошгүй бүрэлдэхүүнийг тодорхойлох;
- үндэсний болон хамтын аюулгүй байдлыг хангах байгууллагын хууль эрх зүйн баримт бичигт орчин үеийн хорлон сүйтгэх технологи ашиглах түрэмгийллийн эх сурвалжийг шуурхай тодорхойлж, уг түрэмгийлэлд хариу үйлдэл хийх талаар зүйл заалт тусгасан байх;
- “өнгөт хувьсгал” болон гибрид дайн гарахаас урьдчилан сэргийлэх талаар төрийн бодлого (үзэл баримтлал) боловсруулах;
- шинэ төрлийн аюул заналаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах чадвартай бүтэц, бүрэлдэхүүнийг бэлтгэх;
- зэвсэгт хүчнийг бэлтгэх төлөвлөгөөний хүрээнд “өнгөт хувьсгал” ба гибрид дайны асуудлыг авч үзэж тусган хэрэгжүүлэх зэрэг болно.

“Өнгөт хувьсгал”-аас гибрид дайнд шилжих үе шатны эмзэг хүчин зүйл нь эсэргүүцлийн хөдөлгөөн хүчирхийллийн бус хэрэгслээр төр засгийн унагах чадваргүй байж болзошгүй гэж үзсэн байна.

Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нийгмийн зөвшилцлийг хангах ажиллагааг холбоотон, түншүүдтэйгээ хамтран хэрэгжүүлэх, олон улсын аюулгүй байдлыг хангах байгууллагуудын чадавхыг ашиглах, олон улсын харилцааны хүрээнд сөрөг нөлөөлөх аливаа оролдлогод шийдвэртэй хариу арга хэмжээ авах замаар улсынхаа үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтыг амжилттай шийдвэрлэж чадна гэж үзэх боллоо.

Дүгнэлт: 1. Харьцангуй бага эрчимтэйгээс өргөн цар хүрээнд хямралыг өдөөх явцад хүчирхийллийн түвшинг шатлан өргөжүүлж, онилсон улсаа тамирдуулан туйлдуулахад тулгуурласан гибрид дайны логик нь байнгын бус бүлэглэлийг ашиглаж, сөрөг талынхаа эдийн засгийг доройтуулах, улс орны нэгдмэл байдлыг сулруулах, удирдагчдыг “шулам” болгон хувиргах, цэргийн хүчний нөлөөллийг хадгалж кибер орон зайд операц явуулахад оршдог байна. Ингэснээр тодорхой бус байдал бий болж, сөрөг талын маневрлах боломж хязгаарлагдаж, эсэргүүцэх хүсэл зоригийг мохоож, улмаар стратегийн санаачилгыг гартаа авч, түрэмгийлэгчийн хүсэл зорилгод онилсон улсыг бүрмөсөн захирагдах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

2. Сөргөлдөгч талууд цэргийн ажиллагаа явуулахдаа өөртөө байгаа бүх хүч хэрэгсэл, аргыг зайлшгүй хэрэглэхийг эрмэлздэг явдлыг “гибрид шинж” гэж ойлгодог байв. Одоо “гибрид шинж” гэдгийг янз бүрийн байдлаар явагддаг орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний онцлог шинжийн өөрчлөлт, харин өндөр технологи бүхий дайсантай мөргөлдөх тохиолдолд газар, тэнгис ба агаар гэх уламжлалт орчин, сансар ба кибернетикийн шинэ орчинд явагдах цэргийн ажиллагаа гэх агуулгаар ойлгох болж байна.

3. “Өнгөт хувьсгал”, гибрид дайныг зэвсэгт тэмцлийн хэлбэр болгож, цэргийн урлагын дүрмээр боловсруулж байгаа, нэр томъёоны

хувьд цэгцтэй ойлголт тогтоогүй зэрэг шалтгаанаас үүдэн тэдгээр үзэгдлийг онолын талаар судлахад олон мэргэжлийн шинжээчдийг татан оролцуулах шаардлага тавигдаж байна. XXI зууны эхнээс АНУ, НАТО-гийн орнууд, ОХУ, БНХАУ зэрэг улс гибрид дайныг улс хоорондын сөргөлдөөний шинэ төрөл гэж авч үзэж, уг дайны стратегийг судлахад ихээхэн анхаарах болжээ. Монгол Улсын тухайд ч зарчмын хувьд цоо шинэ шинжтэй “өнгөт хувьсгал” ба гибрид дайн гэх үзэгдлийг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах хүрээнд судлах шаардлагатай гэж үзэж байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Галич А., Лушников Д. Технология цветных революций. М., издат. РИОР, 2019. 126с;
2. Веб сайт: <https://www.iz.ru> Дата обращения 11.07.2016;
3. Сунь-цзы. Искусство войны. М., издат. АСТ. 2019. 224ст;р
4. Веб сайт: <https://www.news.mn> Хандалтын огноо 2019.10.15);
5. Веб сайт: <https://www.immigration.gov.mn> Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газар;
6. Веб сайт: <https://www.news.mn> Хандалтын огноо 2019.11.02);
7. Веб сайт: <https://www.iaac.mn> Монгол Улсын Авлигатай тэмцэх газар;
8. Веб сайт: <https://www.nso.mn> Монгол Улсын Үндэсний статистикийн хороо;
9. Александров А. В России растёт число проявлений экстремизма. Красная звезда. 16.05.2018);
10. Бартош А. Хаос вооруженного противоборства. Независимое военное обозрение, 12.07.2019.

Эмэгтэй алба хаагчдын хууль эрхзүйн байдал болон энхийг дэмжих ажиллагаан дахь оролцоо

Б.Баатарсүрэн

БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

Салбартаа цөөнх болж буй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй алба хаагчдын эрх зүйн орчин, тэдний энхийг дэмжих болон олон улсын ажиллагаанд оролцож буй байдлын талаар судлан дүгнэхийг зорилоо. Энэ өгүүлэл нь эмэгтэйчүүдийн тэгш эрхийн талаарх дэлхий нийтийн хандлага, өөрийн орны онцлог, эмэгтэй алба хаагчдын эрх зүйн орчин, тэдний энхийг дэмжих ажиллагаанд оруулж буй хувь нэмэр гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын тухай 1325 дугаар тогтоол батлагдсаны 20 жилийн ой 2020 онд болно. Энэхүү тогтоолын гол агуулга нь энхтайван аюулгүй байдал (WPS)-ын өргөн хүрээний хөтөлбөрт эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах явдал юм. Мөн тус зөвлөлөөс дээрх тогтоолыг бүрэн хэрэгжүүлэх зорилгоор цогц үйл ажиллагааг тодорхойлсон 2122 дугаар тогтоолыг 2013 онд баталсан байна. Энэхүү хоёр тогтоолыг үндэслэн НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны хэлтсээс Жендэрийн стратеги (2014-2018)-ийг баталжээ. Уг стратеги нь Энхийг сахиулах болон аюулгүй байдлыг хангах ажиллагаатай холбоотой бодлого, төлөвлөлтөд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг тусган нэвтрүүлэх олон улсын эрх зүйн үндэслэл болж байна.

Өнөөдөр дэлхийн олон улс оронд, түүний дотор Монгол Улсад жендэрийн тэгш бус байдал нийгэм соёл, улс төр, эдийн засгийн хүрээнд оршсоор байгаа бөгөөд энэхүү асуудалд ач холбогдол өгч анхааран ажиллаж байгаагийн нэг тод илрэл нь 2015 онд НҮБ-ын 193 гишүүн орны удирдагч нар хамтран баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-д жендэрийн эрх, тэгш байдлыг хангахыг арвандолоон зорилгын нэг зорилго болгон оруулсан явдал юм.

Монгол Улсын хувьд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлд тодорхой ахиц дэвшлийг гаргасаар ирснийг Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай олон улсын гэрээ, конвенц, санаачилгуудад нэгдэж, жендэрийн тэгш байдлыг бий болгоход шаардлагатай хууль, эрх

зүйн орчинг бүрдүүлж, энэ чиглэлийн төрийн байгууллагуудын бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхойлж өгснөөс харж болно.

Харин эдгээр баримт бичгүүдэд тавьсан зорилго, зорилтууддаа хүрэх, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго 2030, Монгол Улсын урт хугацааны Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал (2016-2030), Жендэрийн тэгш байдлыг хангах тухай үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг хэрэгжүүлэх, салбарууд жендэрийн стратегийг амжилттай боловсруулж, хэрэгжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэхэд жендэрийн дүн шинжилгээ хийх туршлагыг нэмэгдүүлэх ач холбогдлыг оролцогч талуудад ойлгуулах, тэднийг чадавхжуулах бодит хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Учир нь жендэрийн дүн шинжилгээ нь бодлогын үнэлгээний салшгүй хэсэг ба аливаа бодлого, хөтөлбөр эрэгтэй, эмэгтэй хүмүүст хэрхэн ялгаатайгаар нөлөөлж болох талаар баримт нотолгоог бий болгох, хөгжлийн асуудлууд руу чиглэсэн интервац, бодлого, хөтөлбөрийг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаатай хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлыг харгалзаж жендэрийн мэдрэмжтэй боловсруулах, төсөл, хөтөлбөрийн ахиц, үр дүн, нөлөөг хэмжихэд чухал ач холбогдолтой¹.

Эмэгтэй алба хаагчид ба тэдний эрх зүйн орчин

Эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулсан олон төрлийн баримт бичгүүд байгаа хэдий ч бодит байдал дээр эмэгтэйчүүдийг алагчлах үзэл, хэлбэр дэлхийн өнцөг булан бүрт байсаар байна² хэмээн Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлд дурджээ.

Монгол Улсын хувьд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орж түүний биелэлтийг хангах хүрээнд эрх зүйн болон нийгэм, эдийн засгийн шинжтэй олон олон арга хэмжээг хэрэгжүүлсээр байна. Эрх зүйн зохицуулалтын хувьд эмэгтэйчүүдийн эрхийг баталгаажуулсан тусгайлсан хууль байхгүй ч нийгмийн гол гол харилцааг зохицуулсан органик хуулиудад эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг тусгайлан авч эрх зүйн өвөрмөц зохицуулалтыг бий болгосон байна. Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зэргийг нэрлэж болно.³

Эдгээрээс эмэгтэйчүүдийн нийгмийн баталгааны эрх зүйн зохицуулалтыг тусгайлан авч үзвэл:

Нэг. Олон улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах баталгааг хангахаар заасан байна. Үүнд:

- Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх;

¹ Gender Team, UNDP, How to conduct Gender Analysis, Guidance, 2016.

² Хүний эрхийн үндэсний комисс, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”, УБ., 2007.

³ “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгааны тайлан”, УБ., 2007.

- Цалин хөлсийг шударгаар тогтоох, аливаа ялгаваргүйгээр адил үнэлгээтэй хөдөлмөрт тэгш цалин хөлс олгох, чингэхдээ, тухайлбал, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс доргүй хөдөлмөрлөх нөхцөлийг бий болгох, тэдний адил хөдөлмөрт нь тэгш цалин хөлс олгох;
- Эмэгтэйчүүдийг алагчилах аливаа үйлдэл, үйл ажиллагаанаас татгалзах, төрийн байгууллага, алба энэхүү үүргийн дагуу ажиллахыг хангах;
- Аливаа хүн, байгууллага буюу аж ахуйн нэгжийн зүгээс эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгахад чиглэсэн зохистой бүх арга хэмжээг авах;
- Төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, төрийн алба хаах, түүнчлэн төрийн захиргааны бүх түвшинд үүрэг гүйцэтгэх;
- Ажлын сонгон шалгаруулалтын адил шалгууртай байх;
- Мэргэжил, ажлын төрлийг чөлөөтэй сонгох, албан тушаал дэвших, ажлын байр баталгаатай байх, ажлын бүхий л тэтгэмж, нөхцөлийг эдлэх, түүнчлэн мэргэжлийн сургалт болон давтан сургалтад хамрагдах, түүний дотор дагалдан сурах, мэргэжил дээшлүүлэх болон давтан суралцах;
- Нийгмийн баталгаатай байх, ялангуяа тэтгэвэрт гарах, ажилгүй болох, өвчлөх, тахир дутуу болох, өндөр настай болох хийгээд хөдөлмөрийн чадвараа алдах бусад тохиолдолд, түүнчлэн цалинтай амралт авах;
- Эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрлөх аюулгүй нөхцөлд ажиллах, түүний дотор үр удмаа залгамжлуулах үүргээ хамгаалах;
- Жирэмсэн, эсхүл жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөөнд байгааг үндэслэн ажлаас халах, ажлаас халахад гэрлэлтийн байдлаар алагчилахыг хориглож, шийтгэл оногдуулах;
- Ажлын байр, албан тушаал, нийгмийн тэтгэмжийг нь хадгалан жирэмсний болон хүүхэд төрүүлэх чөлөөг цалинтай, эсхүл түүнтэй дүйх хэмжээний нийгмийн тэтгэмжтэй олгох;
- Эмэгтэйчүүдийг жирэмсэн, төрөх, төрсний дараах үед зохих үйлчилгээгээр хангаж, шаардлагатай тохиолдолд төлбөргүй үйлчилгээ үзүүлж, жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй үед нь хүрэлцэхүйц хоол тэжээлээр хангах;
- Гэрлэх тэгш эрхтэй байх.

Хоёр. Төрийн албанд ажиллахтай холбоотой дараах баталгаагаар хангагдахаар зохицуулсан байна⁴. Үүнд:

- Чадахуйн зарчим /үнэлэх, урамшуулах/;
- Карьерийн систем;
- Сул орон тоо /жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд

⁴ Төрийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл, 2018 №1.

асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэлх хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх/;

- Дээд албан тушаалтны хууль бус үйлдлээс хамгаалагдах эрх, шийдвэрийн сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулах;
- Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах;
- Төрийн албан хаагчид олгох тусламж;
- Нийтлэг болон нэмэгдэл баталгаа;
- Цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатны албан хаагчид бичгээр тавих эрх;
- Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх, аж ахуйн нэгжийнхээ үйл ажиллагааг өөрийн итгэмжлэгдсэн хүнээр хөтлүүлэх зэргээр орлого олох.

Гурав. Хөдөлмөрлөхтэй холбоотой баталгааг⁵ тусгайлан авч үзвэл:

- Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно;
- Адил цалин хөлс олгоно;
- Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүнийг /Хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөхөөр эмнэлгийн дүгнэлт гарсан бол жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүний ажлын цагийг хорогдуулах буюу эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно/ эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлсэн хугацаанд цалин хөлс нь буурсан бол түүний урьд авч байсан болон одоо авч байгаа цалин хөлсний зөрүүтэй тэнцэх олговор олгоно.

Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд “Эмэгтэй хүний хөдөлмөр” гэсэн бүлэг зохицуулалтыг тусгайлан оруулжээ. Үүнд:

- Ажил олгогч нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эхийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан болон энэ хуулийн 40.1.4, 40.1.5-д зааснаас бусад тохиолдолд ажлаас халахыг хориглоно;
- Жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү агаар, түүнчлэн албан томилолтоор

⁵ Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн мэдээлэл, 1999 №25.

ажиллуулахыг хориглоно;

- Амрах, хооллох, нийтийн завсарлагаанаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно;
- Эхэд жирэмсний болон амаржсаны 120 хоногийн амралт олгоно;
- Нярай хүүхэд үрчлэн авсан эхэд хүүхдийг нь 60 хоногтой болтол хугацаагаар амаржсан эхийн нэг адил чөлөө олгоно;
- Хүүхэд асрах чөлөө дууссан, эсхүл дуусаагүй боловч эх эцэг өөрөө хүсвэл ажил олгогч нь түүнийг ажил, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв орон тоо нь хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн бол түүнд өөр ажил олж өгнө.

Харин төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй алба хаагчдын нийгмийн баталгааны эрх зүйн зохицуулалтыг тусгайлан авч үзвэл:

Дөрөв. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай⁶ хуулиар дараах баталгаа зааж өгсөн байна. Үүнд:

- 20-иос доошгүй жил алба хаасан эмэгтэй тэтгэвэр тогтоолгох эрх
- Цагдаагийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд цагдаагийн бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь 47 нас байна хэмээн тусгажээ⁷.

Тав. Цагдаагийн албаны тухай⁸ хуульд:

- Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно;
- Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно гэж тус тус заасан байна.

Дээрх хуулийн зохицуулалтууд нь эмэгтэй алба хаагчдад нэгэн адил үйлчлэх боловч зарчмын хувьд зарим заалт зөрчилдөж байгаа юм. Тухайлбал, төрийн албаны тухай хуульд заасан: Жирэмсэн, хөхүүл

⁶ Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Төрийн мэдээлэл, 1994 №8.

⁷ Н.Мөнхзул, “Хууль сахиулах салбарын эмэгтэй алба хаагчдын нийгмийн баталгаа, түүний эрх зүйн зохицуулалт”, ХСИХ “Хууль сахиулахуйн удирдлага” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл, УБ., 2018 №4 (10)

⁸ Цагдаагийн албаны тухай хууль, 2017.

хүүхэдтэй эмэгтэй хүнийг /Хөдөлмөрийн нөхцөлийг хөнгөлөхөөр эмнэлгийн дүгнэлт гарсан бол жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүний ажлын цагийг хорогдуулах буюу эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлж болно/ гэсэн заалт, Хөдөлмөрийн тухай хуульд заасан: Жирэмсэн эмэгтэй, найм хүртэлх насны хүүхэдтэй эх, 16 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү агаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулахыг хориглоно гэсэн заалтууд зөрчигдөж эмэгтэй алба хаагчид жижүүрийн үүргийг 24 цагаар гүйцэтгэдэг. Хөдөлмөрийн тухай хуульд заасан: Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1,5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно гэсэн заалт нь цэргийн алба хаагч төдийгүй, анги байгууллагад ажиллаж байгаа эмэгтэй ажилтан, алба хаагчдад үйлчилдэггүй. Мөн үндсэн хуулинд заасан зарим эрхээ тодорхой хэмжээгээр хязгаарлуулдаг зэрэг болно.

Энхийг сахиулах ажиллагаа дахь эмэгтэй алба хаагчдын оролцоо

Энхийг дэмжих ажиллагааны бүхий л орчинд эмэгтэйчүүд цагдаа, цэрэг болон иргэний байгууллагын салбарт томилогдон энх тайвныг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлэн ажилласаар байна. Тэд энэ талбарт эрэгтэй энхийг сахиулагчдын нэгэн адил хүнд нөхцөлд, ижил жишигт нийцсэн, ижил үүрэг даалгаврыг гүйцэтгэж чадна гэдгээ нотолсоор байна. Иймээс ч НҮБ болон олон улсын байгууллагууд эмэгтэй энхийг сахиулагчдыг элсүүлж, дэмжих нь үйл ажиллагааны зайлшгүй нэгэн шаардлага гэж үзэж байна⁹.

1993 онд үүрэг гүйцэтгэсэн эмэгтэйчүүд дүрэмт хувцастай хүмүүсийн 1 хувийг эзэлж байсан бол 2014 онд ойролцоогоор 125000 энхийг сахиулагчдаас эмэгтэйчүүд цэргийн алба хаагчдын 3%, НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн алба хаагчдын 10%-ийг бүрдүүлж, 2019 он гэхэд ойролцоогоор 87000 энхийг сахиулагчдаас цэргийн алба хаагчдын 5%, цагдаагийн алба хаагчдын 15%-ийг бүрдүүлэх болсон байна¹⁰.

НҮБ нь эмэгтэйчүүдийг дүрэмт хувцастай ажиллуулахыг дэмжин уриалж, сурталчилж байгаа ч цэрэг, цагдаагийн алба хаагч эмэгтэйчүүдийг томилон оролцуулах нь гишүүн орнуудын мэдэлд байна. НҮБ-ын Цагдаагийн хэлтэс нь олон улсын эмэгтэй цагдаагийн алба хаагчдыг үндэсний цагдаагийн албанд, НҮБ-ын цагдаагийн үйл ажиллагаанд элсүүлэх зорилгоор “Глобал хүчин чармайлт” (“The Global Effort”) санаачлан эхлүүлсэн байдаг. НҮБ-ын ажилтнуудын дунд жендэрийн тэгш байдлыг хангах нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд нэн тэргүүний зорилт юм. НҮБ-ын төв байранд 2012 онд ажиллагсдын 48 хувь нь эмэгтэйчүүд, 52 хувь нь эрэгтэйчүүд байсан бөгөөд дунд болон ахлах албан тушаалын түвшинд хамгийн их ялгаатай

⁹ <https://peacekeeping.un.org/en/women-peacekeeping?fbclid=IwAR0odgKov7CCo3O7i11WeGAW4HU7Tj3hezGUh4LEZAOIJds3scPb7Fo-RkM>

¹⁰ https://peacekeeping.un.org/sites/default/files/7_gender_report_13.pdf

байгаа дүн байна. Энхийг сахиулах үйл ажиллагаа болон улс төрийн тусгай ажиллагаанд энэ үзүүлэлт эмэгтэйчүүд олон улсын ажилтнуудын дөнгөж 29 хувийг, үндэсний ажилтнуудын 17 хувийг эзэлж байна.

Эдгээр статистикууд сүүлийн хэдэн жилийн хугацаанд бараг өөрчлөгдөөгүй хэвээр байна. НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаа, улс төрийн асуудал эрхэлсэн алба нь энэ салбарт эмэгтэй ажилтнуудыг татах, тогтвортой ажиллуулах, дэвшүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг илүү сайн ойлгох үүднээс “Энхийн үйл ажиллагаанд иргэний зөрчлийг арилгах” төслийг хэрэгжүүлэн тайланг нийтлүүлж, 2014 онд болон түүнээс цааш хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөмж боловсруулсан бөгөөд НҮБ-ын Тамгын газрын нийт ажилтнуудын 53 хувийг төлөөлж иргэний салбарын ажилтнууд, энх тайвны ажиллагаанд оролцож буй энгийн эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх нь НҮБ-тай хамтран ажиллаж буй эмэгтэй ажилчдын тоог нэмэгдүүлэхэд тусална гэсэн дүгнэлтэд хүрсэн байна¹¹.

2019 оны 7 дугаар сард зохион байгуулсан НҮБ-ын ЭСА-д цэрэг илгээгч орнуудын Жанжин штабын дарга нарын хурлын үеэр яригдсан үндсэн 3 сэдвийн нэг нь Аюулгүйн Зөвлөлийн 1325 дугаар бүхий “Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал” тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд НҮБ-ын “франц хэлтэй энхийг сахиулагчид болон эмэгтэй энхийг сахиулагчдын тоог нэмэгдүүлэх” юм. Иймд цаашид Зэвсэгт хүчнээс өөрийн цэргийн багуудад эзлэх эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

НҮБ-аас мөн дээрх тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд тусгайлан “НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх холбооны эмэгтэй офицер”, “НҮБ-ын цэргийн эмэгтэй офицер” зэрэг дамжаануудыг НҮБ-ын гишүүн орнуудад сүүлийн жилүүдэд удаа дараа зохион байгуулж байгаа бөгөөд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс сүүлийн 2 жилд 5 эмэгтэй ЦАХ-ыг суралцуулаад байна. Энэ нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тогтоолыг хэрэгжүүлэхэд хүчин зүтгэл гаргаад зогсохгүй, цаашид тэдгээр эмэгтэй цэргийн алба хаагчид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагч, штабын офицер болон тэр тусмаа цэргийн холбооны мэргэжлийн офицeroор үүрэг гүйцэтгэх боломж бүрдэж байна¹².

Эмэгтэй энхийг сахиулагчидтай байх нь яагаад чухал вэ?

Эмэгтэй энхийг сахиулагчид нь тухайн орчиндоо үлгэр дуурайл болж, эрэгтэйчүүд давамгайлж буй нийгэм дэх эмэгтэйчүүд, охидыг өөрсдийн эрхийг хамгаалах, энх тайвны үйл явцад оролцохыг уриалдаг. Дараах ач холбогдол байгаа учраас эмэгтэй энхийг сахиулагчдыг элсүүлэх шаардлага нэмэгдэж байгаа юм. Үүнд:

- Ажиллагаа явагдаж буй тухайн улс орны эмэгтэйчүүдийг

¹¹ Timo Smit & Kajsa Tidblad-Lundholm, “Trends in women’s participation in UN, EU and OSCE Peace Operations”, Stockholm International Peace Research Institute (SIPRI), Policy Paper, Oct. 2018, 47.

¹² “Эмэгтэй цэргийн алба хаагчид” судалгаа, ЗХЖШ-ын Энхийг дэмжих цэргийн хамтын ажиллагааны хэлтэс, УБ., 2018.

чадавхжуулах;

- Цэргийн албанд байсан эмэгтэйчүүдийг дайчилгаанд хамрагдах иргэний амьдралд орох зэрэгт нь тэдний тодорхой хэрэгцээ шаардлагыг мэдэрч шийдвэрлэх;
- Нийгэм дэх эмэгтэйчүүдэд энхийг сахиулах үйл ажиллагааг ойртуулахад туслах;
- Жендэрт суурилсан хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүстэй ярилцлага хийх;
- Цагдаа, цэргийн академид эмэгтэй оюутнуудад багшлах;
- Эмэгтэйчүүдийг эрэгтэй хүнтэй ярихыг хориглосон нийгэмд эмэгтэйчүүдтэй харилцах.

Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн оролцоотойгоор дараах зүйлийг хийх боломжтой гэж үзэж байгаа юм. Үүнд:

- Мөргөлдөөн, сөргөлдөөнийг багасгахад туслах;
- Орон нутгийн эмэгтэйчүүдийн идэвх, дэмжлэгийг сайжруулах;
- Орон нутгийн хүн ам, түүний дотор эмэгтэйчүүд, хүүхдүүдэд үлгэр дуурайлал үзүүлэх;
- Эмэгтэйчүүдийн энхийг дэмжих ажиллагаанд хамрагдах ур чадварыг өргөжүүлэх¹³.

Тухайлбал, мусалман шашинт улсуудын нутаг дэвсгэр дээр америк цэргүүд эсрэг этгээдийг илрүүлэн устгах төдийгүй, дипломат яриа хэлэлцээр хийх тохиолдолд эмэгтэйчүүдийн оролцоо зайлшгүй хэрэгтэй болдог байна. Ирак болон Афганистанд гэхэд эмэгтэйчүүдэд нэгжлэг хийх, өөр бусад ажилд америк цэрэг-эмэгтэйчүүд л гардан хийх болдог. Ингэснээр орон нутгийн хүн амтай тулгарч болзошгүй мөргөлдөөнийг зөөлрүүлэх боломж гардаг гэж үздэг байна.

Монгол Улсын хувьд төрийн цэргийн байгууллагуудын эмэгтэй алба хаагчид, тэдний нийгмийн байр суурь, нийгмийн болон хууль эрх зүйн талаар тодорхой дорвитой судалгаа хийгдээгүй байна.

Түүх сөхвөөс Монголын эмэгтэйчүүд нам, улс төр, батлан хамгаалах үйлсэд идэвхтэй оролцож байжээ. 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын үйл хэрэгт эмэгтэйчүүд анхнаас нь идэвхтэй оролцож, гадаад, дотоодын дайсны эсрэг зэвсэг барин тэмцэхээс эхлээд цэргийн аж ахуй, ар талын хангалт (хоол хүнс, агт морь, зэвсэг залгуулах, холбоо барих, мэдээ сэлт хүргэх, цэргийн хувцас хэрэглэл оёх г.м)-ыг амжилттай зохион байгуулахад нэр төртэй хүчин зүтгэсэн түүхтэй. Энэ үест Н.Янжмаа (1893-1962), Ц.Бадамжав, Д.Пагмадулам тэргүүтэй нам, төрийн зүтгэлтэн, эх оронч тэргүүний эмэгтэйчүүд цөөнгүй төрөн гарч, үлгэр дуурайл болж байсныг онцлон тэмдэглүүштэй юм. 1942 оны 7 дугаар сарын 7-ны өдөр ЦЯЯ-ны сайд, бүх цэргийн жанжин,

¹³ Timo Smit & Kajsa Tidblad-Lundholm, “Trends in women’s participation in UN, EU and OSCE Peace Operations”, Stockholm International Peace Research Institute (SIPRI), Policy Paper, Oct. 2018, 47.

маршал Х.Чойбалсангаас “МАХЦ-т эмэгтэйчүүдээс цэргийн албаныг хаах тухай” зааврыг батлан гаргасан нь монголын эмэгтэйчүүдийн цэрэг, батлан хамгаалах үйл хэрэгт гарсан онцлог өөрчлөлт байжээ¹⁴. Монголын эмэгтэйчүүд өөрсдийн сайн дурын үндсэн дээр анх удаа цэргийн албыг биеэр хаах болсон нь улс орны цэрэг, батлан хамгаалах үйлс тэмцлийн түүхнээ нэн чухал ач холбогдолтой үйл явдлын нэг болсон юм.

1990 оноос дэлхий нийтийн цэрэг, улс төрийн нөхцөл байдал хурцдан, олон улсын цэргийн хамтын хүч, хэрэгслийг онцгойлон авч үзэх болсонтой уялдан Монгол Улсын Зэвсэгт хүчин түүний дотор цэргийн алба хаагч эмэгтэйчүүд зөвхөн дотоодод төдийгүй НҮБ-ын “Энхийг дэмжих ажиллагаа”-д тогтмол оролцож, нэр төртэй үүрэг гүйцэтгэх болсноор улс орны цэрэг, батлан хамгаалах үйлсийн нэгэн шинэ үеийг эхлүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсаар иржээ¹⁵.

Монгол Улсын хэмжээнд салбар тус бүрээр нийт бүрэлдэхүүнээс эмэгтэй алба хаагчид Зэвсэгт хүчинд-17%, Цагдаагийн албанд-14%, Хил хамгаалах албанд-19,8%, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд-28.6%, Онцгой байдлын албанд-19%¹⁶-ийг тус тус эзэлж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн эмэгтэй алба хаагчид мэргэжил нэгт гадаадын цэргийн алба хаагчидтай ажиллагааны газар оронд мөр зэрэгцэн ажиллаж, харилцан туршлага солилцож, өөрсдийн мэргэжлийн ур чадвараа байнга нэмэгдүүлж байна.

Эмэгтэй цэргийн алба хаагчид цэргийн багт ротын ажиллагааны офицерын туслахаас эхлэн мотобуудлагын батальоны штабт тагнуулын офицер, хүний нөөцийн офицер зэрэг албан тушаалуудад үүрэг гүйцэтгэн улмаар ротын захирагч, цэргийн багийн захирагч хүртэл албан тушаалуудыг нэр төртэйгээр гүйцэтгэсээр байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийнхээ зэрэгцээ энхийг дэмжих ажиллагаанд оролцсоноос хойших харьцангуй богино хугацаанд мотобуудлагын салаанаас рот, батальон хүртэлх хүч хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэж, байрын хамгаалалтаас бүхэл бүтэн сектор хариуцах хэмжээнд хүрч мэргэжлийн өндөр түвшинд хүрсэн ба 2002 оноос хойших 17 жилийн хугацаанд 3 тивийн 10 гаруй оронд тухайлбал Конго, Баруун сахар, Ирак, Афганистан, Сьерра-Леоне, Косово, Чад, Этиоп, Гүрж, Судан, Өмнөд Судан, Йемен улсуудад давхардсан тоогоор 17000 гаруй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсний дотор 2006 оноос хойш 644 эмэгтэй офицер, ахлагч нар НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагч, штабын офицер болон цэргийн багт үүрэг гүйцэтгэж НҮБ-д цэрэг хандивлагч дэлхийн 126 гаруй улсаас нийт энхийг сахиулагчдын тоогоор 25, эмэгтэй цэргийн алба хаагчдын

¹⁴ И.Чинбат, “Монголын эмэгтэйчүүдийн цэрэг, батлан хамгаалах үйлсэд оруулсан хувь нэмэр, байр суурийг тодруулахуй (1921 оноос өнөөг хүртэл)”, “Цэргийн шинэчлэл” сэтгүүл №2,3, ЗХЖШ, УБ., 2017.

¹⁵ Мөн тэнд

¹⁶ А.Гантуул, “Хууль сахиулах салбарын шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах асуудал”, “Хууль сахиулахуйн удирдлага” сэтгүүл №4 (10), ХСИС, ХСУА, УБ., 2018.

тоогоор 17 дугаарт бичигдэж байна¹⁷.

Зэвсэгт хүчний цэргийн эмэгтэй алба хаагчид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэснээр төрийн энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэх, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх асуудалд өөрсдийн тодорхой хувь нэмрийг оруулж байна. Цаашид энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлбэл Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.4-т заагдсан “жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх” асуудалд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 онд 2 цэргийн ажиглагч офицерыг БНАКУ-д НҮБ-ын ажиллагаанд илгээснээс хойш өнгөрсөн 17 жилийн хугацаанд Конго, Баруун Сахар, Афганистан, Ирак, Судан, Этиоп-Эритрей, Сьерра Леон, Косово, Гүрж, Чад-Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Өмнөд Судан, Абией муж зэрэг 12 улс, мужид явагдсан 17 ажиллагаанд нийт 16800 гаруй цэргийн алба хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд илгээж, мандатаар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж байна.

Энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсаас эмэгтэй нийт 577 цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн байдаг ба өдгөө Өмнөд Судан, Афганистан, Баруун сахарт явагдаж буй энхийг сахиулах ажиллагаанд 78 монгол бүсгүй үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэж байгаа явдалд Монгол Улсын Зэвсэгт хүчин, нийт албан хаагчид, тэдний гэр бүл, найз нөхөд бид бүгд бахархах зүйл мөн.

Монгол Улсаас үүрэг гүйцэтгэсэн эмэгтэй цэргийн алба хаагчдын анхдагчдаас дурдвал НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2006 онд анхны эмэгтэй ажиглагч офицeroор ЗХЖШ-ын Энхийг дэмжих цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Н.Нямжаргал (тухайн үед ахмад цолтой байсан) үүрэг гүйцэтгэснээс хойш эмэгтэй энхийг сахиулагчдын оролцоог жил бүр үе шаттайгаар нэмэгдүүлсээр ирсэн. Улмаар 2008 онд анхны эмэгтэй цэргийн алба хаагчид цэргийн багт, 2010 онд цэргийн хүчний штабт анх удаа штабын офицeroор, 2013 онд анх удаа хүчний төв штабт хэлтсийн даргаар, 2015 онд НҮБ-ын Нью-Йорк хот дахь төв штабын энхийг сахиулах ажиллагааны газарт анх удаа мэргэжилтнээр, 2015 онд анхны цэргийн багийн захирагчаар, 2018 онд хүчний штабт анхны эмэгтэй цагдаагаар, 2019 онд Афганистан улсад явагдаж буй НАТО-гийн эвслийн тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтарсан цэргийн багт анх удаа эмэгтэй бүрэлдэхүүн тус тус үүрэг гүйцэтгэсэн байна.

Энхийг сахиулах ажиллагаанд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас 2013 оноос хойш нийт 8 энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэсэн ба ХХЕГ-аас 3, ЦЕГ-аас 1, ОБЕГ-аас 2, ШШГЕГ-аас 2 тус

¹⁷ Эмэгтэй цэргийн алба хаагчид” судалгаа, ЗХЖШ-ын Энхийг дэмжих цэргийн хамтын ажиллагааны хэлтэс, УБ., 2018.

тус байна.

Энэ үзүүлэлтээр эмэгтэй энхийг сахиулагчдын тоог нэмэгдүүлэх үйл хэргийг манлайлж, нэг хүнд ногдох хамгийн их энхийг сахиулагчдаараа Азид тэргүүлдгээрээ бид бахархдаг. Монгол Улсын хувьд Энхийг сахиулах ажиллагаан дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр Монгол Улсын энэхүү хүчин чармайлтыг НҮБ болон олон улсын хамтын нийгэмлэгээс өндрөөр үнэлж, цаашид энхийг сахиулах ажиллагаанд оролцох оролцоогоо улам бүр өргөжүүлж, энэ чиглэлээр Ази тив болон бусад улсыг манлайлахыг уриалсан байдаг.

Салбарын цөөнх боловч гүйцэтгэх үүрэг өндөртэй байгаа тэдний талаарх зарим судалгааны дүнгээс үзэхэд, Зэвсэгт хүчний хувьд, анги, байгууллагад ажиллаж, алба хааж буй эмэгтэйчүүдийн талаар баримтлах төрийн бодлого тодорхойгүй. Нийгмийн болон, хууль эрх зүйн, төрийн бодлогын зохицуулалт, хамгаалалтууд сул байгаагаас тэдний хувь хүний эрхийн асуудлууд зөрчигдөж, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдөөд байгаа жендерийн харилцааны тэгш эрхийн асуудлууд зөрчигдөж байна. Төрөөс Зэвсэгт хүчин дэх эмэгтэйчүүдийн талаар баримтлах бодлогын томоохон хэсэг бол нийгмийн хамгааллын асуудал юм. Нийгмийн хамгааллын чиглэлд шийдвэрлэх шаардлагатай цалин хангамж, орон байр, сууцны асуудал хамгийн ихээр дурдагджээ¹⁸.

Цэргийн алба хаагчдын цалин хангамж, орон байрны асуудал нь тулгамдсан асуудал болсон бөгөөд энэ байдлаас гарах гарцыг янз бүрийн хөнгөлөлттэй зээл олгох, газар олгож хашаа байшин барихад нь хөнгөлөлт үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулах хэрэгтэй юм.

Мөн эмэгтэй алба хаагчдын хувьд дүрэмт хувцасны хангалт, чанар, өнгө, үзэмжийн байдал, биед таарамжтай байх зэрэг асуудалд анхаарах нь чухал байна. Тэдний үзэж байгаагаар бол өвлийн зарим төрлийн хувцас олгогддоггүй, маш хүйтэнд хүйтэн байдаг ба зуны улиралд маш халуун учир эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлдөг байна¹⁹.

Анги, байгууллага дахь эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал мөн сэтгэл зовоосон асуудлын нэг бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, тогтмолжуулж, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлүүдээс хамгаалах шаардлагатай байна. Анги, салбаруудын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн эсрэг дарамт, шахалт их, аливаа сурч боловсрох, ахиж дэвших гэх мэтэд хүйсээр ялгаварлах байдал гардаг байна²⁰. Аливаа олон улсын болон энхийг сахиулах ажиллагаанд оролцоход хүйсээр ялгаварлаж шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байсан ч олон улсын цэргийн үйл ажиллагаанд хамруулдаггүй байна. Нэгэнт цэргийн албанд цэргийн үүрэг гүйцэтгэж байгаагийн хувьд бүх төрлийн үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлтүүдийг хангаж чадаж байгаа л бол хүйс харгалзахгүйгээр оролцуулж байхыг ихээхэн чухалчилж байна.

¹⁸ “Батлан хамгаалах салбар дахь жендерийн нөхцөл байдлын үнэлгээ” судалгааны ажлын тайлан, УБ., 2018.

¹⁹ “Мөн тэнд.

²⁰ “Мөн тэнд.

Цагдаагийн эмэгтэй алба хаагчдын талаарх сонирхолтой судалгааны үр дүн байна. Үүнд, эрэгтэй цагдаагийн алба хаагчид өөртөө итгэх итгэл нь эмэгтэй цагдаагийн алба хаагчдаас 0,24%-аар илүү, ой тогтоолтын хувьд 0,8%-аар илүү байна. Харин тэсвэр тэвчээрийн хувьд эмэгтэй цагдаагийн алба хаагчид эрэгтэй цагдаагийн алба хаагчдаас 0,44%, хамтрах чадвар нь мөн эрэгтэй цагдаагийн алба хаагчдаас 0,44%-аар илүү, мэдрэмжийн оноо нь эмэгтэй цагдаагийн алба хаагчид эрэгтэй цагдаагийн алба хаагчдаас 0,17% -аар илүү гарсан байна. Мөн нийгмийн орчныг таних чадвар 0,2%-аар, арга ухаан 0,2%-аар, хошин шогийн мэдрэмжийн тухайд мөн л эмэгтэй цагдаагийн алба хаагчид 0,27%-аар илүү байна гэсэн үзүүлэлтүүд гарчээ²¹.

Энэ бүхнээс дүгнэн үзэхэд эмэгтэй хүний нарийн мэдрэмжтэй, аливаа зүйлд нягт нямбай ханддаг давуу талыг ашиглан удирдах болон шийдвэр гаргах албан тушаалд ажиллуулах хэрэгцээ шаардлага байгаа юм. Олон улсын хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жигд оролцоог дэмжсэнээрээ хөгжлийг хурдасгаж болдог гэж үздэг. Мөн эмэгтэйчүүдийн ажилтай орлоготой байх, ажлын байран дээрээ сурч хөгжих, мэргэших үйл ажиллагааг дэмжсэнээр гэр бүлийн хүчирхийллийг шийдэх талтай гэсэн судалгаа ч байдаг. Харин ажлын байран дээрх сургалтад жендэрийн асуудал нөлөөлдөг байдал төрийн тусгай байгууллагуудад хамгийн өндөр хувьтай гарсан бөгөөд нөлөөлдөг шалтгаан нь эмэгтэй хүн хүүхэд гаргах, нялх хүүхэд, настай аав ээжээ асрах зэрэг шалтгаанаар сургалтад хамрагдахад хүндрэлтэй, боломж муутай байдаг. Мөн төрийн тусгай байгууллагуудын хувьд эмэгтэй алба хаагчид цол, ажилласан жил, хүйс заасан тусгай сургалтуудад хамрагдах боломж хомс байдаг байна²².

Харин эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажиллах орчны судалгаагаар²³ төсөвт байгууллагад илүү цагаар ажилласан эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс 2,6 дахин их байжээ. Энэ нь төсвийн байгууллагуудад эмэгтэйчүүд гол төлөв гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаагаас улбаатай боловч мөн ажлын ачааллын хуваарилалт жигд бус, “хийж чадаж байгаа ажилтанд илүү их ажил хуваарилах” бичигдээгүй дүрэм үйлчилж байгаатай холбоотой²⁴ хэмээн дүгнэжээ.

Эмэгтэйчүүдийн төлөөлөл иргэний албан хаагчдын дунд өндөр боловч жендэрийн тэгш байдлаас хол байна. Байгууллагууд үйл ажиллагаандаа хүйсийн тэнцвэрийг сайжруулахыг эрмэлзэж байна. Энэ чиглэлийг өөрчлөхөд ил тод, хариуцлагатай байх нь чухал юм. Олон байгууллагууд байршуулалтад нь хүйсээр нь ангилсан өгөгдлийн систем боловсруулж, хадгалдаггүй байсаар байна. Ийм өгөгдөл нь эмэгтэйчүүдийн оролцоонд байгаа албан болон албан бус саад бэрхшээлийг (мөн хаана) үнэн зөв

²¹ Ш.Доржханд, Цагдаагийн алба хаагчийн нийгмийн оюун ухаан болон дотоод баримжааг судалсан нь, УБ, 2015.

²² Б.Баатарсүрэн, “Ажлын байран дээрх сургалт ба жендэрийн тэгш байдал”, “Жендэр судлал” сэтгүүлийн тусгай дугаар, УБ., 2018.

²³ ҮСХ, НХХЯ, ОУХБ. “Цалин хөлсний бүтцийн туршилтын судалгаа”, УБ., 2010.

²⁴ ХНХЯ, ЖҮХ, АХБ, ЯБЯС. “Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж”, УБ., 2019.

тодорхойлох, жендэрийн тэнцвэргүй байдлын шалтгаан, үр дагаврыг илүү нарийвчлан судлахад шаардлагатай байдаг.

Хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх зорилгоор аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогод эмэгтэйчүүдийг оролцуулахын тулд Засгийн газар аюулгүй байдлын бодлогод хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх үүднээс үнэлэлт өгөх шаардлагатай. 1995 онд Бээжин хотноо НҮБ-аас зохион байгуулсан Дэлхийн Эмэгтэйчүүдийн 4 дүгээр зөвлөгөөн дээр НҮБ нь хүйсийн эрх тэгш байдлыг бий болгох гол стратеги нь хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх гэж заасан байдаг. Хүйсийн нөлөөллийг тэнцвэржүүлэх гэдгийг НҮБ дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: Аливаа төлөвлөж байгаа үйл ажиллагаанд эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн оролцоог үнэлэх үйл явц байх ба үүнд хууль тогтоомж, улс төрийн бодлого төлөвлөлт, хөтөлбөр хамрагдана гэжээ²⁵. Ингэснээр улс төр, эдийн засаг нийгмийн аль ч салбарын бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, хэв загварт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн сонирхол, туршлагыг харгалзан нэгтгэн тусгаж, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд нэгэн ижил ашигтай байхаар үйлдэнэ.

Дүгнэлт, зөвлөмж

Улс орон бүрийн хувьд салбарын хүрээнд зохицуулагдах олон ижил төсөөтэй асуудлууд гарч байна. Олон улсын түвшинд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын эмэгтэй алба хаагчдын тоог өсгөх төдийгөөр хязгаарлахгүй, иргэн-цэргийн харилцааг хөгжүүлсэн, иргэдэд үйлчилдэг хууль сахиулах байгууллагыг бий болгоход эмэгтэйчүүд чухал үүрэгтэй болохыг баталж, тэднийг албанд элсүүлэх, үндсэн чиг үүргээрээ тогтвортой ажиллахыг дэмжих, цол ахих, албан тушаал дэвшихэд нь дэмжлэг үзүүлэх тодорхой стратеги хэрэгжүүлэн эмэгтэй алба хаагчдын эзлэх хувийг нэмэгдүүлж байна.

Монгол Улсын хувьд төрийн цэргийн байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын нийгмийн болон, хууль эрх зүйн чиглэлээр төрийн бодлогын зохицуулалт, хамгаалалтууд тодорхойгүй байна. Зөвхөн тэтгэвэр тэтгэмжийн тухайд хүйсийн хувьд нас, ажилласан жилийг тодорхой хэмжээгээр багасгаж заасан байна. Цаашид хувь хүний эрхийн асуудлууд, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдөөд байгаа жендерийн харилцааны тэгш эрхийн асуудлуудыг эмэгтэйчүүдийн алба хаах хууль эрх зүйн орчин, албанд шалгаруулж авах шалгуур үзүүлэлтүүд, тэдний албанд гүйцэтгэх үүрэг зэргийг тодорхой болгон тусгах шаардлага чухал байна. Мөн эдгээр байгууллагуудад ажиллаж буй энгийн эмэгтэй ажилчдын нийгмийн хамгааллын болон тэтгэвэр, тэтгэмжийн асуудлуудад холбогдох зүйлсүүдийг шийдвэрлэх, тэдний харъяаллыг тодорхой болгох асуудал байна.

Ижил төрлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын хувьд салбар хоорондын жендэрийн чиглэлээрх хамтын ажиллагааг бүх түвшинд хөгжүүлэх, хүний нөөцийн хувьд хүйсээр ангилсан өгөгдлийн

²⁵ “Батлан хамгаалах салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн нийгмийн дүр төрх” төслийн ажлын тайлан, БХЭШХ, УБ., 2004.

систем боловсруулж хадгалах, сайжруулах шаардлагатай байна.

Эмэгтэй алба хаагчдын нийгмийн асуудал, нийгэмд эзлэх байр суурийн талаар үндэсний хэмжээний судалгаа байхгүй байгаа нь тэдний хувь хүний эрх аль ч шатанд зөрчигдөх үндэс болж байгаа тул энэ төрлийн судалгааг салбарын байгууллагууд хамтран хийх хэрэгцээтэй юм гэж үзэж болохоор байна.

Мөн эмэгтэй алба хаагчдын хувьд дүрэмт хувцасны хангалт, чанар, өнгө, үзэмжийн байдал, биед таарамжтай байх (ялангуяа хээрийн хувцас) зэрэг асуудалд анхаарах нь чухал байна.

Энхийг сахиулах ажиллагаанд эмэгтэй алба хаагчдын үүрэг манай улсын хувьд төдийгүй олон улсад өндөр үнэлэгдэж байгаа нь тэд эрэгтэйчүүдийн нэгэн адил үүрэг гүйцэтгэх чадвартайг нотлон харуулсаар байна. Эмэгтэй алба хаагчид ойр, дунд, холын эргүүлийн үүргийг гүйцэтгэхээс гадна иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон газар орны аюулгүй байдалд нүүрлэж буй асуудлуудын тухай ярилцлага хийх, мэдээлэл цуглуулах, ажиллагааны орон нутгийн охид эмэгтэйчүүдэд үлгэр дуурайлал үзүүлэх, охид, хөвгүүдэд өөртөө итгэх итгэл үнэмшлийг бий болгох, зоригжуулах, ирээдүйдээ итгэлтэй болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүйсийн тэнцвэртэй байдлыг бий болгох, бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хохирогчид туслах, хүнсний хөтөлбөрийг хүргэх, хүнс тараалтад хяналт тогтоох зэрэг үүргийг давхар гүйцэтгэдэг.

Монгол цэргүүд эх орноо хамгаалах үндсэн үүрэг дээр нэмэгдэн дэлхийн цэрэг болсныг олон улсад хүлээн зөвшөөрч, манай цэнхэр дуулгатнуудын мэргэжлийн ур чадвар, мэдрэмж, сонор соргог байдлыг олон улс, хамтын нийгэмлэгийнхний өмнө өндрөөр үнэлүүлж, хүлээн зөвшөөрүүлж чадлаа. Дэлхийн цэрэг болсон манай энхийг сахиулагч цэрэг эрсийн эгнээ жилээс жилд нэмэгдэхийн зэрэгцээ хатуу хөтүү бүхнийг хатан ухаанаар ялдаг эмэгтэйчүүдээрээ эгнээгээ өргөжүүлэн тэдний энхийг сахиулах оролцоог нэмэгдүүлэх үйлсэд тэргүүн эгнээнд явж байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. “Батлан хамгаалах салбар дахь жендэрийн нөхцөл байдлын үнэлгээ” судалгааны ажлын тайлан, УБ., 2018.
2. “Батлан хамгаалах салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн нийгмийн дүр төрх” төслийн ажлын тайлан, БХЭШХ, УБ., 2004.
3. “Жендер судлал” сэтгүүлийн тусгай дугаар, УБ., 2018.
4. “Монгол Улсын Батлан хамгаалах салбарт мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж ирсэн түүхэн уламжлал, шинэчлэл, менежментийн тулгамдсан асуудал”, төслийн ажлын тайлан, УБ., 2009.
5. “Монголын эмэгтэйчүүдийн холбооны стратегийн баримт бичиг”, УБ., 2016.
6. “Салбаруудын жендерийн бодлогын эмхэтгэл”, УБ., 2018.
7. “Хууль сахиулахуйн удирдлага” сэтгүүл, УБ., 2018 №4 (10)
8. “Цэргийн байгууллагад ажиллаж байгаа энгийн албан хаагчдын эрх зүйн

- байдлын судалгаа” төслийн ажлын тайлан, БХЭШХ, УБ., 2015.
9. “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгааны тайлан”, УБ., 2007.
 10. Gender Team, UNDP, How to conduct Gender Analysis, Guidance, 2016.
 11. <https://peacekeeping.un.org/en/women-peacekeeping?fbclid=IwAR0odgKov7C Co3O7i11WeGAW4HU7Tj3hezGUh4LEZA0IJds3scPb7Fo-RkM>
 12. https://peacekeeping.un.org/sites/default/files/7_gender_report_13.pdf
 13. Timo Smit & Kajsa Tidblad-Lundholm, “Trends in women’s participation in UN, EU and OSCE Peace Operations”, Stockholm International Peace Research Institute (SIPRI), Policy Paper, Oct. 2018, 47.
 14. Б.Баатарсүрэн, “Ажлын байран дээрх сургалт ба жендэрийн тэгш байдал”, “Жендэр судлал” сэтгүүлийн тусгай дугаар, УБ., 2018.
 15. Б.Нацагдорж, Цагдаагийн алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь, УБ., 2010.
 16. Б.Түмэнжаргал, Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаан дахь Монгол Улсын оролцоо, УБ, 2015.
 17. Бодлогын судалгаа, шинжилгээ-IX, УБ., 2015.
 18. Г.Оюунтуяа, Энхийг дэмжих ажиллагаанд оролцож буй цэргийн алба хаагчдын нийгэм сэтгэл зүйн асуудалд, УБ., 2011.
 19. ЗХЖШ, “Цэргийн шинэчлэл” сэтгүүл №2,3, УБ., 2017.
 20. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
 21. МУИХТГ судалгааны төв, “Бодлогын судалгаа шинжилгээ-XXVIII”, УБ., 2019.
 22. Н.Мөнхзул, “Хууль сахиулах салбарын эмэгтэй алба хаагчдын нийгмийн баталгаа, түүний эрх зүйн зохицуулалт”, ХСИХ “Хууль сахиулахуйн удирдлага” онол, арга зүйн улирал тутмын сэтгүүл, УБ., 2018 №4 (10)
 23. О.Анар, “Олон улсын Энхийг дэмжих ажиллагаа ба Монгол Улс”
 24. Судалгааны эмхэтгэл боть-XXVIII, УБ., 2014.
 25. Төрийн албаны тухай хууль, 2017.
 26. ХНХЯ, ЖҮХ, АХБ, ЯБЯС. “Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж”, УБ., 2019.
 27. Хүний эрхийн үндэсний комисс, “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”, УБ., 2007.
 28. Хүний эрхийн үндэсний комисс, “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”, УБ., 2007.
 29. Цагдаагийн албаны тухай хууль, 2017.
 30. Цэргийн албаны тухай хууль, 2016.
 31. Ш.Доржханд, Цагдаагийн алба хаагчийн нийгмийн оюун ухаан болон дотоод баримжааг судалсан нь, УБ., 2015.
 32. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай, 2010.
 33. Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журам, 2011.

Офицерын ёс суртахууны асуудал

Ч.Улаанхүү

доктор (Ph.D)

Н.Орхон

докторант

Офицер хүнд байвал зохих онцгой ёс суртахуун нь офицерын мэргэжил, мэргэшлээс эх сурвалжтай юм. Офицерын ёс суртахууны хэм хэмжээ нь түүхэн урт хугацааны туршид цэргийн мэргэшсэн хүмүүс, захирагч нарын дунд бүрэлдэн бий болж, энэхүү хэм хэмжээг мөрдөж биелүүлээгүй офицер, цэргийн хэргийн мэргэжилтнүүдийг юу юуны туханд хүрэлгүй ёс суртахуунтайд тооцох боломжгүй юм.

Үүний зэрэгцээ нийт иргэдийнхтэй харьцуулахад офицер хүний онцгой ёс суртахуун нь түүний давуу чанарыг илтгэх нэг үзүүлэлт болж өгдөг.

Энэ бүхнээс үүдээд бусдыг байлдаанд уриалан дуудах, тушаал өгөх үүрэг, хариуцлага буй болж, бусдыг болон өөрийгөө үхэлд үл хүргэх офицер хүний ёс суртахууны “онцгой” мэргэжил, хариуцлага бий болсон нь офицерын эрхэм дээд чанарын илрэл болж өгдөг.

1. Офицерын албаны ёс журам, нэр хүнд. Хүмүүс хоорондын харилцаа гэнэтийн асуудал байдаггүй. Энэ харилцаа захиргаадалтын аргаар ёс төдий байдлаар болоод ч байдаггүй. Хүмүүс хоорондын харилцаа нь нийгэм дэх соёл, ёс зан заншлын баялаг өв уламжлалын нэг бүрэлдэхүүн болохын хувьд урт удаан хугацааны туршид бүрэлдэж бий болдог жамтай.

Цэргийн албаны үүрэг хариуцлагын ёс зүйг баримжаа болгосон зан суртахууны үзэл баримтлал, дэг журам үгүйлэгдэж байгаа нөхцөлд офицер хүний ёс журам, нэр хүндийн асуудлыг онолын үүднээс авч үзэх нь оновчтой гэж үзэж байна.

Бидний үзэж байгаагаар, батлан хамгаалахын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар монгол офицерын албаны ёс суртахууныг илэрхийлсэн мэргэжлийн ёс журам, шаардлагуудыг тусгасан хэм хэмжээ, дэг журмын баримт бичиг шаардлагатай байгаа юм. Офицер хүний хэрэгжүүлж байвал зохих ёс суртахууны нэг үнэт зүйлсийн цогц болох хэм хэмжээ, дэг журмын асуудлыг энд хөндөж байгаа юм. Энэхүү амьдралын шаардлага, хэм хэмжээг ёсчлон хэрэгжүүлдэг цэргийн хүний тоо, бүрэлдэхүүн өсөхийн хэрээр орчин үеийн цэрэг, офицерын бодит

дүр төрх бий болох зүй тогтолтой байна.

2. Офицерын албаны ёс суртахууны тухай. Офицерын ёс суртахуун нь Монгол Улсын иргэний эрх зүй, нийгмийн категори, ухагдахууны бүрэлдэхүүн бөгөөд офицер хүний ёс зүйн сэтгэлгээ, цэргийн мэргэжил, үзэл санаа, ёс журмын шинж төрх бүрэлдэн бий болоход тодорхой нөлөө үзүүлж байгаа албаны зан байдал, зарчмуудын хэм хэмжээг зохицуулж өгдөг цэргийн ёс суртахууны бүрэлдэхүүн хэсэг юм. Офицерын ёс суртахууны онцлог, бусдаас ялгарах байдал нь Монголын нийгэм, цэргийн уламжлалыг илэрхийлэгч байхын хувьд юуны өмнө, монголын нийгмийн ёс журмын нийтлэг зарчмууд хийгээд үнэт зүйлсийг илэрхийлж байдаг /Монгол Улсын цэргийн тангараг, цэргийн дүрмүүдэд тусгалаа олсон/ Хоёрдугаарт, офицерын мэргэжлийн ёс суртахуун нь “цэрэг хүний, офицерын нэр хүнд” гэдэг ухагдахуунаар илэрхийлэгдэж байдаг өөрийн албаны үйл ажиллагааг зохион байгуулах байдлаар тод томруун илэрч байдаг. Үүнд, тухайлбал, эх орондоо өргөсөн тангарагийн ёсоор амь биеэ зориулахад бэлэн байх г.м /Цэргийн дүрмүүдийн заалтаас ялгарах онцлог нь гэвэл, офицерын ёс суртахуун нь зан суртахууны шинж чанарын тухай төсөөлөл үүссэн нөхцөл байдалд хэрхэн тусгалаа олсныг мөрдлөг болгохыг зорих болдог/.

Офицерын албаны ёс суртахууны хэм хэмжээ, дүрэм нь дараах байдлаар хэрэгжиж байдаг. Үүнд:

- Цэргийн алба хаагчдын албаны болон албан бус харилцааны үед;
- Цэргийн алба хаагчид өөр хоорондоо харилцах үед;
- Цэргийн ёслол, уламжлалт үйлдэл, үйл ажиллагааны үед;
- Бусад хүмүүстэй харилцах үед.

Цэргийн албаны ёс суртахууны тухай зан үйлийн баялаг ойлголт нь цэргийн албанд татагдах, цэргийн сургуульд элсэн орсон үеэс зэвсэгт хүчний албаны жилүүдэд цэргийн идэвхитэй алба, бусад үйл ажиллагааны хугацааны туршид үргэлжилдэг. Цэргийн мэргэжлийн үнэ цэнтэй зүйлс нь шулуун дардан замаар олдоод байдаггүй, үе үеийн ахмад дайчдын үеэс залуу үеийнхэнд уламжлагдаж ирдэг зүй тогтолтой байдаг. Гэвч “офицер хүний нэр хүнд”-ийн учир утга, агуулгын мөн чанарыг ухамсарлаж ойлгох явцдаа тухайн хүн насан туршдаа энэ нэр хүндийг тээгч нь байх болдог юм. Энэ байдал нь офицерыг үе улиран залгамжлах, энэхүү мэргэжлээр бахархан дуурайх заншилд хүргэж өгдөг ажээ.

3. Офицерын албаны ёс суртахууны үндсэн зарчмууд. Монгол Улсын зэвсэгт хүчний хууль тогтоомжид тусгагдсан цэргийн албаны ёс суртахууны нийтлэг ойлголт, хэм хэмжээ, дүрэм журмыг сахиж мөрдөхийн зэрэгцээ офицер хүний дагаж мөрдвөл зохих ёс суртахууны үндсийг бүрдүүлж өгч байгаа зарчмуудыг ёсчлон хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй байдаг. Тухайлбал:

- эелдэг зан төлвийг эрхэмлэдэг байх;
- даруу төлөв, ёс жудагтай байдлыг эрхэмлэж байх;

- бусдад хүндэтгэлтэй хандаж, санал хүсэлтийг нь барагдуудахад санаа тавьж, анхаарал халамж үзүүлэх;
- Даруу зан төлөв, ил тод байдлыг эрхэмлэж байх;
- Зорилгодоо тууштай байдлыг илэрхийлдэг байх;
- Үнэнч шударгыг эрхэмлэж, за гэвэл, ёгүй байх.
Офицер хүнд тавигдах мэргэжлийн ёс суртахууны шаардлагууд:
- Өндөр ёс суртахуунтай байх;
- нийтийн соёл, офицерын мэргэшил эзэмшсэн байх;
- ажил хэрэгч чанарыг эзэмшсэн байх;
- мэргэжилдээ үнэнч, итгэлтэй байх;
- чанд хатуу сахилга баттай байх;
- төлөвлөснөө цаг хугацаанд нь хэрэгжүүлдэг, үүргээ ягштал гүйцэтгэдэг, амласандаа заавал хүрдэг байх;
- шударга зарчмыг эрхэмлэх;
- захирагсад болон бусадтай эелдэг даруу дотно харилцааг эрхэмлэдэг байх;
- олон нийтийн газар үйл ажиллагаанд оролцох, гардан зохион байгуулахдаа тогтоосон журам дүрмийн түвшинд үүргээ чанд гүйцэтгэдэг байх.

4. Офицерын нэр хүнд, давуу чанарын тухай. “Нэр хүнд” гэх ойлголтыг дэлгэрэнгүй тайлбар тольд өгсөн тодорхойлтыг авч үзье. Даль-ийн дэлгэрэнгүй тайлбар толинд тодорхойлохдоо: “Нэр хүндтэй байна гэдэг нь тухайн хүний дотоод сэтгэлгээ, ёс суртахууны нандин чанарын илэрхийлэл болж өгдөг, тухайн хүн өндөр нэр хүндтэй, гавъяа зүтгэлтэй, оюун санаа ариун байхын зэрэгцээ тунгалаг оюунтай /хиргүй ариун нэр хүндтэй хүн/, итгэл хүлээсэн, үйлдэл, үйл ажиллагаа нь баталгаажсан /нэр хүндтэй байхад харш үйлдэлгүй/, өндөр нэр төр, алдар цолтой байхын илэрхийлэл болж өгдөг ажээ.

Монгол офицеруудын үндсэн үнэт зүйлсийн дотроос **офицер хүний нэр хүнд, давуу чанарын асуудал** байнгын хүндтэй байр суурийг эзэлж байдаг. Энгийн мэргэжлийн хэн нэгэн хүн ямар нэгэн алдаа дутагдал гаргавал, түүний энэ үйлдэл тодорхой нөхцөлд бусдад ажиглахгүй байдлаар өнгөрдөг байхад харин офицерын гаргасан дутагдал доголдол нийгмийн дотор ихээхэн дургүйцлийг бий болгож, хүмүүсийн сэтгэл санаанд сөргөөр нөлөөлж байдаг. Иймээс офицер байна гэдэг нь нийгэм, хамт олны дунд ёс суртахууны найдвартай, итгэлийг хүлээсэн мэргэжлийн нэр хүндийг илэрхийлэгч байна гэсэн үг юм.

Офицерын нэр хүнд гэдэг нь офицер хүний өдөр дутмын амьдрал, үйл ажиллагаандаа мөрдөж байвал зохих, нийгэм хамт олны дотор итгэл хүндэтгэлийг хүлээсэн, өргөсөн цэргийн тангарагтаа үнэнчээ илэрхийлж байгаа офицер хүний чанар, чансааны цогц юм. Офицерын нэр хүндийг илэрхийлж байгаа үйлдлийг дараах асуудалд багтааж үзэж болох юм.

Үүнд:

- үзэл бодолдоо зөв тунгалаг зарчмыг баримталж, ажил үйлсдээ үнэнч шудрагыг эрхэмлэх;
- дайсны эсрэг амь биеэ зориулахад бэлэн, айж хулчийхийг үзэн яддаг байх;
- өргөсөн тангарагтаа үнэнч, баатарлаг тэмцэлд бэлэн байх;
- офицерын албаараа бахархаж, итгэл төгс байх;
- хувийн нэр хүндээ “нүдний цөцгий мэт хайрлах”, эрхэмлэх;
- эмэгтэй болон захирагдагсаддаа эелдэг, зөөлөн харилцааг эрхэмлэх.

Офицерын нэр хүндийг тээгч нь бодит хүн байна. Офицерын нэр хүндийн асуудал нь аливаа хүний давуу чанарын ойлголтоос ялгаатай байдаг нь офицер хүний албаны болоод нийгмийн байр суурь, үйл ажиллагааных нь онцлог, түүний бүтээж байгаа гавьяат үйлстэй холбоотой байдаг. Нэр хүндтэй байна гэдэг нь офицер хүн ёс жудагтай, өөрийн ажил үйлсээрээ бусдын талархал, хүндэтгэлийг хүлээж байгаагийн илэрийлэл, үнэлэмж юм. Офицерын нэр хүндийг өв тэгш дагаж мөрдөнө гэдэг нь өөрийн итгэл үнэмшилдээ үнэнч байж, ажил үйл үйлсээрээ байнга харуулна гэсэн үг юм.

Офицерын нэр хүндийг өв тэгш дагаж мөрдөнө гэдэг нь офицер хүний гүйцэтгэвэл зохих алба ажлыг мадаггүй, найдвартай хийж байна гэсэн үг юм. Офицерын нэр хүндийг өндөрт авч явна гэдэг нь тухайн офицер өөрийн үүргийг бүтээлч хэрэгжүүлж байгаа нь зэвсэгт хүчний офицерын бүрэлдэхүүнд тавигдаж байгаа бүхий л эрэлт шаардлагыг нэгэн адил хэрэгжүүлнэ гэсэн үг юм.

Хариуцсан ажил албаа нэр төртэй гүйцэтгэж, офицер хүний цолны нэр хүндийг өндөрт өргөж явахдаа ёс суртахууны хэм хэмжээ, зааг хязгаарыг бодолцож, сайн үйлсийг бүтээхдээ ямар үнэ цэнээр хийх гэж байгаагаа харгалзан үзэж байх нь чухал юм. Хууран мэхлэх, зусардаж бялдуучлах, муу үйлдэл хийх нь эрт орой нэгэн цагт олны хараанд өртөж, офицерын үйл ажиллагаа, цаашлаад армийн нэр хүндийг сэвтгүүлэх, хар толбо үлдээх муу үр дагавартай.

Офицерын бүрэлдэхүүний түүхэн уламжлалд ахлах даргын албан ажил, өөрийн захирагч, цэргийн командлалын үүрэг, чиглэлийг шүүмжлэх, шүүн тунгаах асуудал ямар ч тохиолдолд байх учиргүй. Асуудлын мөн чанарыг ойлгож мэдэлгүйгээр шүүмжлэх, ил далд байдлаар бусдыг муучлах нь нэр хүндээ гутаасан, тэнэг алхам байдаг. Нэр хаяггүй захиадал, бичээс илгээх зэргээр авирлах нь офицерын нэр хүндэд харш үзэгдэл юм.

Харин офицерууд өөрийн нэр хүндийг хамгаалахын төлөө баттай байр суурьтай байж, түүнийгээ бусдад зарлан мэдээлэх, шаардлагатай тохиолдолд байр сууриа найдвартай хамгаалахын төлөө байх учиртай. Офицерын нэр хүнд гэдэг нь өөрийн хэлсэн үгний эзэн байхыг хэлдэг. Албан ёсны яриа, үүрэг даалгаврын баталгаа болгож, ажил хэргийг

гүйцэтгэсний дараа илтгэж, мэдэгдэх журмыг цэргийн дүрэм зааварт тусгаж өгдөг.

Өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн тухай хариу илтгэж мэдэгдэх нь үйл ажиллагаа үнэн зөв, цаг үеэ олсон байгаагийн баталгаа болж өгдөг. Энэ тохиолдолд офицер хүний хэлсэн үг бол үнэний эцсийн баталгаа болж өгдөг. Үгээсээ буцах, няцах нь офицерын хүнийг гутааж доромжлох, офицерын бүрэлдэхүүний нэр хүндийг унагаахад хүргэдэг.

Армид офицерын цолны илэрхийлэл болох цолны **мөрдөс** нь түүний нэр хүндийн бэлгэ тэмдэг болж байдаг. Ийм учраас офицер хүн дүрэмт хувцасаа дүрэм, зааврын дагуу цэвэр цэмцгэр өмсөж эдэлж байх нь түүхэн уламжлалдаа хүндэтгэж байдгийн илэрхийлэл болж байдаг. Нэр хүндтэй, даруу төлөв байна гэдэг нь бага зүйлээс эхэлдэг жамтай. Цэргийн алба хаагчдын бие биендээ үзүүлдэг ёслол хүндэтгэл, цэргийн ёслолын ажиллгаа нь ёс суртахууны гүн гүнзгий учир агуулгатай байдаг. Цэргийн цол, албан тушаалаар ахлаж байгаа нөхөр, үе тэнгийн цол, зэрэгтэн, бага тушаалтантай харилцах үедээ ёсолж хүндэтгэл үзүүлнэ гэдэг нь бусдыг хүндэтгэж, цэргийн нөхөрлөлдөө үнэнч байгаагийн баталгаа болж байдаг.

Албаны ёс зүйгээр бол бага тушаалын зэрэг, цолтон нь ахлах цолтонд эхэлж ёсолж хүндэтгэл үзүүлдэг журамтай. Цэргийн цол, албан тушаалаар нэг түвшинд байгаа цэргийн албан хаагчдаас хэн нь түрүүлж харсан, хэн нь өндөр соёл хүмүүжилттэй нь эхэлж хүндэтгэл үзүүлэх журамтай.

Хэрэв ахлах цолтон нь бага тушаалын офицерын ёсолж хүндлэхэд нь хариу хүндэтгэл үзүүлэхгүй бол тэрээр цэргийн ёс суртахуун, хүндэтгэлийн журамд болгоомжгүй хандаж, алдаатай үйлдэл хийж байгаа хэрэг юм. Уулзалт, ярилцлагын төгсгөлд харилцан “баяртай” хэмээн салах ёс гүйцэтгэх нь цэрэг, офицер хүний өндөр ёс суртахуун, хүмүүжилттэй байгаагийн баталгаа болж өгдөг юм.

5. Офицерын ёс зүй. Нийгмийн тогтолцоо шинэчлэгдэхийн хэрээр орчин үеийн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, офицеруудын үүрэг, харицлагын хэм хэмжээ өндөржиж, энэ хэрээр офицер хүний албаны ёс суртахуунд тавигдах шаардлага, хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Ийм учраас “офицерын ёс зүй”-н асуудлыг мөрдөж хэрэгжүүлэхийг цаг үе шаардах боллоо. Офицерын албанд томилогдсоны баталгаа болдог батлан хамгаалахын сайдын тушаалаар офицерын цолны мөрдөс гардан авч байгаа мөчөөс эхлэн офицерын ёс зүйн дүрэм, журмыг эгнэгт дагаж мөрдөх нь офицерын нэг ёсны тангарагтаа үнэнч байгаагийн илэрхийлэл болж байдаг.

1992 онд Монгол Улсын Үндсэн хууль батлагдан мөрдөгдөж эхлэснээр батлан хамгаалах, зэвсэгт хүчний хууль, тогтоомжууд шинээр бий болж, зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлого, үйл ажиллагаа хэрэгжих шатандаа явж байгаа өнөө үед “офицерын ёс зүй”-н дэглэм журмыг албан ёсны болгож дагаж мөрдөх нь ардчилал, эрх зүйт төрийг

байгуулж байгаа нийгмийн хувьд зайлшгүй хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ юм.

Монголын Зэвсэгт хүчний дайчин уламжлалын хүч чадал нь цэргийн бүрэлдэхүүний сэтгэл санааны бат тогтвортой байдалд тулгуурласан байдаг. Ийм ч учраас цэргийн хүний ёс суртахуун тэрчлэн, офицерын нэр хүнд, давуу чанарын тухай хууль эрх зүйн асуудал нь Зэвсэгт хүчний дүрэм, заавар, тушаалуудад тусгалаа олсон байдаг. Өнөөдрийн өндөрлөгөөс авч үзэхэд батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тухай хууль эрх зүйн баримт бичгүүд, цэргийн алба хаагчдын эрх зүйн хэм хэмжээ, цэргийн албаны бусад асуудалд агуулга, чанарын үндсэн өөрчлөлт бий болж байна.

Монголын армид офицерын ёс зүйн уламжлал ихээхэн чухал байр суурийг эзэлсээр ирсэн юм. Нэр хүндээ дээдлэх үзлээр хүмүүжсэн офицерууд өөрийн нэр төрөө өндөрт өргөх, офицер хүнийхээ цол, зэргийг хамгаалж, анги хамт олны түүхэн уламжлалыг нандигнаж, баяжуулахын төлөө бие сэтгэлээ зориулж байдаг. Ингэхийн тулд офицер хүн ёс суртахууны тодорхой дэглэм, журмыг мөрдөхийг эрхэм болгож ирсэн байна.

Офицерын ёс суртахууны судалгаа шинжилгээний ач холбогдол өсөн нэмэгдэх болоод байна. Арми, зэвсэгт хүчний түүхэн уламжлалд офицерын гүйцэтгэх үүрэг, байр суурь нэн чухалд тооцогдож ирсэн байдаг. Офицерын нэр хүндийг өндөр өргөж явах хүмүүжлээр хүмүүжсэн ахмад үеийнхэн өөрийн нэр хүнд, офицер хүний цол, зэргийг хайрлаж хамгаалахын төлөө бүхнээ зориулж ирсэн уламжлалтай юм. Ийм учраас офицерын дунд нэр хүнд, цол зэргээ хамгаалахын төлөө үүрэг гүйцэтгэх тодорхой дэг журам, дүрмийг дагаж мөрдөхийг эрхэм болгож иржээ. Цэрэг хүний нэр хүндийг түүхэн уламжлалын үүднээс судалж, энэ асуудлын хууль, эрх зүйн зохицуулалтыг цэргийн алба, аж ахуйн салбарт хэрхэн хангах явцад цэрэг хүний ёс суртахууны асуудалд ихээхэн анхаарал хандуулж ирсэн байдаг. Ардчилсан нийгмийг байгуулж буй Монголын Зэвсэгт хүчин, түүний цэргийн бүрэлдэхүүний нэр хүндийг өндөр өргөж явахын ач холбогдол нь шинэ шинэ агуулгаар баяжиж байна.

Цэрэг хүний нэр хүнд, үүрэг хариуцлага, үерхэл нөхөрлөл, давуу чанарын тухай асуудлаар өөрийн гэсэн зарчмын нэгдмэл байр суурьтай байхыг офицерын уламжлал, түүхэн байдал нөхцөлдүүлж өгсөн байдаг. Офицер хүний хувьд цэвэр, хиргүй тунгалаг, ариун нэр хүндтэй, бусдаас дээгүүр, бусдыг манлайлж байх нь түүний эрхэм чанар юм. Цэргийн хүний зан суртахуун, ёс зүйн тухай ойлголтын төвд офицерын нэр хүндийн асуудал байнга тэргүүн эгнээнд явж ирсэн байдаг.

Офицер хүн өндөр нэр хүндтэй байснаар дайчид, цэргүүдийн сэтгэл санаа нэг чиглэлтэй, тодорхой зорилго, зорилттой байхыг бүрдүүлж өгч байдгийг түүх сургамжилж иржээ.

Нэр хүндийн тухай ойлголт нь тухайн хүний үйл ажиллагаа,

бусадтай харилцах үйлдэл, үйл ажиллагаа, шийдвэрлэх мөчид түүний байгуулсан гавъяа, зүтгэлийн үр дүнгээр илэрхийлэгддэг юм. Хүмүүс нэр хүндтэй нэгнийг “өндөр нэр хүндтэй” хүн хэмээн өргөмжилж байдаг. Судалгааны үр дүнгээс үзэхэд “Захирагч, даргынхаа ямар зан чанарыг бүхнээс илүү гэж үнэлдэг вэ?” гэсэн судлаачийн асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх нь эхний гурван байранд, захирагч, дарга нарын шудрага зан, нэр хүнд, мэдлэг чадвар хэмээн хариулсан байна. “Нэр хүндтэй хүн” гэж хэнийг нэрлэх вэ? гэсэн асуултанд цогц хариулт өгөхөд хүндрэлтэй юм. Олонх судлаач, эрдэмтэд “нэр хүнд” гэх ойлголтын агуулгыг тайлбарын тулд өөрийн амьдралын төлөвшил, үнэт зүйлсийн талаар баримталж ирсэн итгэл үнэмшилд тулгуурласан тал харагддаг байна. Нэр хүндийн мэдрэмж бүрэлдэж хөгжихөд амьдралын орчин, ээж аавын төлөвшил, хүүхэд ахуй наснаас хамт амьдарсан хүмүүсийн нэр хүнд, амьдралын туршид эзэмшсэн мэргэжил мэдлэгийн түвшин ихээхэн нөлөө үзүүлдэг байна. Энэ бүхний дараа нэр хүндийн тухай ойлголт олон янзаар бүрэлдэж буй болох талтай. Хэрэв хэн нэгэн нь хууран мэхлэх нь шудрага бус, нэр хүндгүй зүйл хэмээн үзэж байхад өөр нэгэн нь байж болох л зүйл хэмээн төсөөлдөг. Хүний давуу зан чанарыг авч үзэхдээ хүрээлж байгаа орчин, хүмүүсийн харилцаанд даруу, эелдэг зөөлөн харилцааг эрхэм болгодог хүнийг нэр хүндтэйд тооцдог бол зарим хүмүүсийн хувьд захирагдагсдаас өөрийн зан чанарыг дээгүүрт тавихыг хичээдэг нэгнийг хувийн зан чанар өндөртэй нэгэн хэмээн үзэх нь бий.

Хэн нэгэн үерхэл нөхөрлөлд үнэнч байна гэдгийг хүнд хэцүү нөхцөлд ямар нэгэн эргэлдээ, тээнэгэлзлэлгүйгээр найз нөхөртөө туслаж, дэмжихийн төлөө байхыг хэлнэ хэмээн үзэж байхад зарим хүмүүсийн хувьд үерхэл нөхөрлөл гэдэг нь “бүлэг хүмүүсийн явцуурал”, зан авирыг өөгшүүлэх, зоргоор нь тавихыг ойлгох нь бий. Зарим нэгний хувьд ажил албандаа үнэнхүү дур сонирхолтой байхыг ажил албандаа амжилт гаргахын төлөө хичээн зүтгэх, хамт олны нэр хүндийг өндөрт өргөхийг чармайн хөдөлмөрлөхийг ойлгодог байхад өөр бусдын ойлголтоор албандаа дур сонирхолтой байна гэдэг нь албан тушаалын төлөө цуцалтгүй зүтгэж, засаглалын өндөрлөгт ямар ч үнээр болов гарахыг хэлнэ хэмээн үзэх нь бий.

“Нэр хүнд” гэх ойлголтыг дэлгэрэнгүй тайлбар толиудад өгсөн тодорхойлтыг авч үзье. Даль-ийн дэлгэрэнгүй тайлбар тольд тодорхойлохдоо: “Нэр хүндтэй байна гэдэг нь тухайн хүний дотоод сэтгэлгээ, ёс суртахууны нандин чанарын илэрхийлэл болж өгдөг, тухайн хүн өндөр нэр хүндтэй, гавъяа зүтгэлтэй, оюун санаа ариун байхын зэрэгцээ тунгалаг оюунтай /хиргүй ариун нэр хүндтэй хүн/, итгэл хүлээсэн, үйлдэл, үйл ажиллагаа нь баталгаажсан /нэр хүндтэй байхад харш үйлдэлгүй/, өндөр нэр төр, алдар цолтой байхын илэрхийлэл болж өгдөг” гэжээ.

Батлан хамгаалах боловсролын сургах зүй ба сэтгэл зүйн зарим асуудал

Б.Өлзийхуяг

ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтсийн
дарга, доктор (Sc.D), профессор, хурандаа

Товч утга: Эх орон, үндэс угсаагаа тэргүүн зэрэгт тавьж, түүнийг хайрлах, хамгаалах ухамсар санаачилгатай монгол хүнийг үе шаттайгаар төлөвшүүлэн бэлтгэх нь төрөөс боловсролоор дамжуулан ард иргэдээ соён гэгээрүүлэх үйл явц хэмээн ойлгож, энэхүү үйл хэргийг “Батлан хамгаалах боловсрол” гэсэн нэгдмэл тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх боломжтой гэж үзэн батлан хамгаалах боловсролын сургах зүй болон сэтгэл зүйн үндсийг сурган хүмүүжүүлэх ухаан, цэргийн удирдахуйн ухаан, сэтгэл судлалын ухааны уулзвар зааг дээр судлан тодорхойлсныг энэ өгүүлэлд товчлон авч үзэв.

Удиртгал

Боловсрол нь нийгмийн хөгжил, хүмүүсийн оюуны хэрэгцээтэй уялдан байнга хөгжиж байдаг нарийн нийлмэл тогтолцоо бүхий үйл явц юм. Шинэ зууны хөгжлийн хөдөлгөгч хүчин зүйл нь нийгмийн иргэн төлөвшүүлэх боловсрол, түүний агуулга болон арга зүйтэй салшгүй холбоотой. Орчин үед боловсролыг сургуулийн хүрээнд биш жинхэнэ хүн төлөвшүүлэх нийгмийн хүрээгээр нь ойлгож түүнд шинэ байдлаар хандаж, өргөн утгатай томъёолох хэрэгцээ шаардлага бий болсон.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид болон иргэдийн боловсрол, хүмүүжил төлөвлөөс шууд хамаарч байдаг. Өнөө үед улс орны батлан хамгаалах хүч чадавхид нөлөөлж байдаг үндсэн хүчин зүйлүүдийн нэг цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлийн боловсролыг нэгдсэн тогтолцоонд оруулан боловсронгуй болгож, түүний чанар, үр дүнг дээшлүүлэх явдал тулгамдсан зорилт болж байна.

Батлан хамгаалах боловсрол нь иргэдэд цэргийн боловсрол, эх оронч хүмүүжил олгох, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, батлан хамгаалах болон зэвсэгт хүчнийг мэргэжлийн бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах, цэргийн дайчилгааны нөөцийн бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, төрийн албан хаагчдад аюулгүй байдал, цэрэг

стратегийн мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн олон түвшинтэй, шаталсан үйл ажиллагаа юм. Энэхүү үйл ажиллагааг “**Батлан хамгаалах боловсрол**” гэсэн нэгдмэл тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж, батлан хамгаалах боловсролын сургах зүй ба сэтгэлзүйн зарим асуудлыг боловсруулсан харьцуулсан судалгааны үр дүнг танилцуулж байна.

Батлан хамгаалах боловсролыг өргөн утгаар нь “**хүн төрөлхтөний цэргийн эрдэм, амьдрах ухаан, соёлыг нэг цеэс нөгөө цед өвлүцлэн дамжуулах хэрэгсэл**” гэж тодорхойлов. Батлан хамгаалах боловсролын судалгааны гол асуудал бол үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр цэргийн эрдэм, аюулгүй амьдрах арга ухаанд суралцсан, монгол хүний үнэт чанар, соёлыг хөгжүүлэх чадвартай, эх орон үндэс угсаагаа эрхэмлэн дээдлэх үзэл санаа баттай тогтсон ухамсартай монгол хүнийг нийгэмд төлөвшүүлэн бэлтгэхэд чиглэгдэнэ.

Батлан хамгаалах боловсролын сургах зүйн үндэс

Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтоо шийдвэрлэхэд монголчууд бидний оюун санааны чадавх буюу эх оронч үндэсний үзэл, ёс суртахууны чанар, үндэсний эв нэгдлийн асуудал ямар ч үед чухал ач холбогдолтой байдаг. Энэ талаар судлаач Б.Шагдар “Монголчууд нэн эрт үеэс эх орноо батлан хамгаалж, өөрийнхөө аюулгүй байдлыг хангаж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн билээ. Энэ нь тоогоор хэдий цөөн ч гайхалтай өндөр хөгжсөн цэргийн урлаг, стратеги-тактикийн цагийн байдлыг зөв үнэлэн тогтоох чадвар, улс орон, газар нутгийнхаа талаархи гүн гүнзгий мэдлэгтэй нь зайлшгүй холбоотой байлаа”¹ гэжээ. ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг “Цэрэг хүний үндсэн хөдөлмөр бол сургалт бэлтгэл бөгөөд энэхүү хөдөлмөр нь цэргийн алба хаагчийн хөгжих, мэргэших хэрэгцээг хангахад чиглэгдэх ёстой”² гэж Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд илгээх захидалдаа онцлон тэмдэглэсэн байна.

Ийнхүү Монгол Улсын аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, орчин үеийн Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүч хэрэгсэл нь батлан хамгаалах боловсрол, түүний олон талт үйл явц гэж үзэх үндэслэлтэй. Батлан хамгаалах боловсрол судлалд бие хүнийг төлөвшүүлэх онол, арга зүйн асуудал, ерөнхий ба хичээлийн сургах зүйн асуудал чухал байр суурийг эзэлдэг. Энэ салбар ухаан нь улс орноо батлан хамгаалах чадвар бүхий монгол хүний хөгжин төлөвших зүй тогтлыг судалж, хүний төлөвшлийн тулгуур багана болсон олны ашиг тус (улс, нийгэм)-ыг эрхэмлэсэн ёс суртахуун (моральность хандлагатай)³, амьдрах ухаан, сэтгэл зүй, бие бялдрын хүмүүжил, соёлыг эзэмшүүлэх

¹ Шагдар Б. Өөрийгөө хамгаалах эрх ашгийн үүднээс монгол орноо судлах нь. БХЭШХ-ийн ЭШ-ний хуралд тавьсан илтгэл. УБ., 2014.т.2

² Ганзориг Д. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд илгээх захидал. “Соёмбо” сонин. 2019.10.24. №43(10668).

³ Паламдорж Ш. Батлан хамгаалах боловсрол судлал, түүний онол арга зүйн асуудал. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. УБ.,2019. №27. х126.

ажлын зорилго, агуулга, арга зүйг авч үзнэ. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалах боловсролын судлах зүйлүүд нь цэргийн алба хаагчид, иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа (суралцагчдын сэтгэл зүйд зорилго, чиглэлтэйгээр нөлөөлөх), түүний зүй тогтолууд болно.

Хүмүүжил гэдэг нь цэргийн алба хаагч болон иргэнийг төлөвшүүлэх тодорхой зорилготой үйл ажиллагаа бөгөөд хүн төрөлхтөний амьдрах ухаан, урлаг соёлын нөлөөллийг өөртөө багтаасан хүний хувийн чанар бүрэлдэх үйл явц юм. Тухайлбал, хүмүүжил нь аливаа зүйлд хандах шинжлэх ухаанч хандлага, ёс суртахууны эрхэм чанар, цэргийн болон мэргэжлийн өндөр түвшин, бие бялдрын хөгжлийг төлөвшүүлэх зорилгоор цэрэг дайчид, иргэдийн ухамсар, сэтгэл санаанд сурган сэтгэл зүйн үүднээс нөлөөлөх үйл явц юм.

Залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангахын тулд ард түмэн үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлалт арга барилд тулгуурлана. Хүн бол бие, оюун ухааны нэгдэл учраас биеийн боловсрол, оюуны боловсрол хоёр салшгүй холбоотой, нэг нь нөгөөтэйгээ харилцан шүтэлцсэн шинжтэй боловч манай уламжлалт ухаанд биеийн боловсрол буюу бие махбодийн өсөлт, чийрэгжилт, биеийн хүчийг тэргүүн зэрэгт тавьж иржээ. Хүүхдэд багаас нь практик үйл, туршлагын мэдлэг, чадварыг амьдрал, хөдөлмөрийн явцад олгож, биед нь тамир тэнхээ суулгахыг “Эрүүл биед саруул ухаан оршино”, “Дайнд баатар далайд усч”, “Ажил хийвэл ам тосдоно”, “Гарын дүйтэй болгох” гэсэн онч мэргэн үгээр илэрхийлсэн нь биеийн тамир тэнхээ буюу бие махбодийн эрүүл чийргийг эрхэмд үзсэн сэтгэлгээ юм. Биед тамир тэнхээ суухыг дагаад ухаан билэг нээгдэх бөгөөд улмаар ухаанаар өөрийгөө удирдан хөгжүүлж “Би” гэдгээ мэдэхтэйгээ болох нь монголчуудын уламжлалт хүмүүжлийн гол үзэл баримтлал болно.

Ерөнхий сургах зүйгээр сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалтын хэлбэр, түүний мөн чанарыг тайлбарлана. Батлан хамгаалах боловсролын үндсэн агуулгыг үе шат бүрээр томъёолж, тэдгээрийг эзэмших түвшин түүнд тавих шаардлагыг нарийн тодорхойлж өгнө. Батлан хамгаалах боловсролын тогтолцоо, үзэл баримтлал үүсэн бий болох үндсэн нөхцөл нь боловсрол олгох сургалтын хөтөлбөрүүд, түүний агуулгаас ихээхэн хамааралтай билээ. Хүн төрөлхтөн олон зууны турш хуримтлуулсан оюуны болон материаллаг өв баялгаасаа хойч үедээ сургалтын агуулгаар дамжуулан өвлүүлэн үлдээсээр иржээ.

Аливаа сургалтын агуулгыг тодорхойлон тогтоохын тулд тухайн шинжлэх ухааны түвшин, нийгмийн хэрэгцээ шаардлага, суралцагчдын сурах чадвар, сургалт явуулах багш нараа бэлтгэсэн байдал, олон улсын жишиг болон сургалтын агуулгыг боловсронгуй болгоход баримтлах зарчмуудыг харгалзан үзэх шаардлагатай юм. Сургалтын зарчмыг янз бүрээр авч үзэх боловч ихэвчлэн хичээл сургалтад тавигдах шаардлагуудын цогц гэж үздэг. Зарчим нь юмс үзэгдэл, ухагдахууны

мөн чанарыг шинжлэх ухааны үүднээс тодорхойлон тогтоохын үндэс болдог. Шинжлэх ухааны гол зарчим бол тухайн ойлголт, ухагдахууны ерөнхий агуулгыг урьдчилан зөв харж тогтооход чиглэж байх учиртай.

Хөрш орнууд аюулгүй байдал, цэргийн мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, үр дүндээ ихээхэн анхаарах боллоо. ОХУ-ын Зэвсэгт хүчний сургалтын зарчмууд “Сайтар сургаж бэлтгэгдсэн цэргийн мэргэжилтэн нь ... тавигдаж буй цаг үеийн шаардлага, хэрэгцээнд нийцсэн, ирээдүй рүү хандсан байх хэрэгтэй”⁴ гэсэн үзэл санааг удирдлага болгон шинэчлэгдэж эхэлсэн. БНХАУ-ын “Улсын батлан хамгаалах боловсролын тухай хууль”⁵-д батлан хамгаалах боловсрол олгох зарчмын онцлогийг үе үеийн удирдагч, манлайлагчдын явуулсан батлан хамгаалах үзэл санаагаар баяжуулж, бүх нийтэд улс орноо хамгаалахын чухлыг ойлгуулж, байнга сайжруулж байх тухай зааж, улсын байгууллага, төрийн албанд ажиллах иргэнийг зөвхөн батлан хамгаалах боловсролоор дамжуулан бэлтгэдэг санаагаа улам баталгаажуулсан байна.

Батлан хамгаалах нь цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал судлалыг өөртөө агуулсан судлагдахуун харин боловсролын онол тэр дундаа сурган хүмүүжүүлэх ухаан нь бусад шинжлэх ухааны ойлголтуудыг багтаадаг тул батлан хамгаалах боловсрол нь нэлээд өвөрмөц байдлаар илрэх хандлагатай. Орчин үед цэргийн боловсролыг сургуулийн хүрээнд биш жинхэнэ эх оронч сэтгэлгээтэй хүн төлөвшүүлэх нийгмийн хүрээгээр нь ойлгож, системчлэн шинжлэх ухааны түвшинд авч үзэх, боловсролын зүй тогтлыг тайлбарлах шинжлэх ухааны шинэ зарчим бий болгохыг шаардаж байна.

Батлан хамгаалах боловсролын сэтгэл зүйн үндэс

Батлан хамгаалах боловсролын сэтгэл зүйн асуудал нь цэргийн алба хаагчид, хүүхэд залуучуудыг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааны агуулга, арга хэлбэрийг тэдний нас бие, сэтгэцийн хөгжлийн түвшинд зохицуулан явуулах ажлын сэтгэл зүйн үндсийг судлахад гол анхаарлаа хандуулна.

Сэтгэл зүйн боловсрол нь байгаль дэлхий, эх орон, элгэн саднаа хайрлах, хамгаалах зэргээр оршин байгаа ахуй руу ханддаг тул залуу үеийн хүмүүжил боловсролд ач тусаа өгсөөр ирсэн. Гэтэл улам бүр хувьсан өөрчлөгдөж буй эрин үед уламжлалт ахуйгаас холдож байгаа нөхцөлд энэхүү хүмүүжил боловсролыг зайлшгүй албан ёсоор олгохоос өөр аргагүй гэдгийг бид ойлгох цаг нэгэнт болжээ.

Сэтгэл зүйн асуудал батлан хамгаалах боловсролд чухал. Ирээдүйд улс орноо авч явах, эх орон, ард түмнийхээ язгуур эрх ашгийн төлөө хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэх залуу үеийн цэрэг эх оронч үзэл, сэтгэхүйг нь илүү бадрааж, зоригжуулж өгөх үүрэгтэй. Монгол хүн гэсэн бахархал, мэдрэмжийг батлан хамгаалах боловсрол олгох ёстой хэмээн үзэж байна.

⁴ Путин В.В. Быть сильными: гарантии национальной безопасности для России. Российская газета. №5708 (35) 17 фев.2012г.

⁵ 全民国防教育. 读本. 2009, 页87-90

Хүний сэтгэл зүйд чухал нөлөөлж байдаг маш хүчтэй зүйл бол мэдрэмж юм. Хүмүүний мөн чанар, өвөрмөц шинжийг мэдрэмжтэй холбон үздэг сэтгэл судлалыг үндэслэгчийн хувьд С.Л.Рубинштейн “Хүний мэдрэмжүүд бол байгалийн хамгийн яруу илэрхийлэл бөгөөд хүний жинхэнэ мэдрэмжээс урган гардаг сэтгэл догдлуулам тэр татах хүч чухамхүү үүнтэй л холбоотой”⁶ гэжээ. “Монголын сурган хүмүүжүүлэх уламжлалын дагуу сургах ёсон нь хөвгүүдийн сэцэн мунхаг хийгээд чийрэг буурай ба хурц хийгээд мохоо хийгээд чадалтай үхээнц, жич түүний авьяасыг шинжлэн савыг үзэж сургаваас зохимуй хэмээсэн аж сэтгэлгээтэй нийцнэ”⁷. Эндээс харахад боловсролыг нийтээр хавтгайруулан нэг хэв загвараар олгох гэж зүтгэх нь нэгэнт өнгөрсөн бөгөөд хүүхэд бүрийн сэтгэл зүйн хэв шинж мэдрэмж дээр тулгуурлан хүмүүжил боловсролыг олгох, монгол хүнийг бэлтгэх шинэ загвар боловсруулах хэрэгтэй болж байна. Өөрөөр хэлбэл, мэдээлэл технологийн эрин зуунд монгол хүнийг бэлтгэх батлан хамгаалах боловсролын нээлттэй олон загварт тогтолцоо хэрэгтэй гэсэн үг.

Монголчууд хүний оюун ухаан, бие махбодийг сэтгэл нь удирддаг гэж үздэг бөгөөд Чингис хаан нэгэнтээ “Хүний сэтгэлийг эзэмдвээс бие хааш одох” хэмээн айлджээ. Сэтгэлийн гол цөм нь сэтгэхүй юм. Сэтгэхүй бол хүний уураг тархины үйл ажиллагааны хамгийн дээд хөгжингүй хэлбэр мөн. Өөрөөр хэлбэл, хүн сэтгэж танин мэдсэн зүйлээ дахин тархиндаа боловсруулж, өөрөө болон бусдад итгэл үнэмшил төрүүлэхүйц мэдлэг гэгчийг үйлдвэрлэн энэхүү мэдлэг нь хүнд шингэснээр тухайн хүний үзэл санаа, итгэл үнэмшил болж тогтдог. Хүн бүрийн үзэл санаа хуримтлагдан нийгэмд тухайн ард түмний өвөрмөц сэтгэлгээний хэв маяг, онцлог бий болж энэ нь хүнд өөрийгөө нэг улс үндэстний хэсэг гэсэн мэдрэмжийг хүчтэй төрүүлдэг байна. Ийнхүү монгол хүний мэдрэмжийг чухалд авч үздэг шинж чанарыг батлан хамгаалах боловсролын сэтгэл зүйд авч үзэх боломжтой юм.

“Хүний сэтгэж танин мэдэх үйл ажиллагааны анхдагч хэлбэр буюу түгээмэл арга нь ажиглах арга бөгөөд энэ аргын сэтгэл зүйн үндэс нь ажигч гярхай чанар болно. Ажиглах чадвар нь монгол ахуй амьдрал, аж төрөх хэвшлээс үүдэлтэй ажиллах, хөдөлмөрлөх хэрэгцээнээс үүссэн сэтгэхүйн үйлийн анхдагч арга юм. Ажиглах явцад нэгийг нөгөөгөөс ялгах, тодлох, бас хооронд нь жиших харьцуулах зэрэг оюуны үйлдлүүдийг хийдгээрээ онцлог ач холбогдолтой”⁸. Иймээс батлан хамгаалах боловсролын олон талт асуудлыг монгол хүнд илүүтэй хөгжсөн сэтгэхүйн энэ чадварт суурилан шийдэх нь зохистой бөгөөд бүтээлч байж болох юм. Монгол хүн ямар онцлогтойг судлан үзэж бие махбодь, сэтгэл зүйн хэв шинжид ямар хүмүүжил боловсролын тогтолцоо тохирохыг үндэстэй тогтоох шаардлагатай.

Монгол хүний сэтгэхүйн онцлогийг логикийн зарим мөрдөлгөөнөөс

⁶ Рубинштейн.С.Л. Основы общей психологии. В двух томах.Т.2.М.,1989.стр 147.

⁷ Дэмчигдорж.Ч. Эрдэнэт толь хэмээх шаштир оршвой. УБ.,1995.т.30.

⁸ Баттогтох Д. Монголын уламжлалт боловсролын онол түүхийн судалгаа. Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци.УБ.,2019.т.64

гаргаж болох юм. Логик мөрдөлгөөний хуулиуд дотроос дедукцид буюу ерөнхийгөөс хэсэгт чиглүүлж оюун дүгнэлт хийх чадвар сайн байдаг нь монгол хүний байгалийн нэгэн онцлог шинж юм. Тухайлбал, монголчууд дээрээс доош тэрлэсэн унаган бичигтэйгээс гадна жилийн дотор сар, өдрийг багтаан ерөнхийгөөс хэсэгт шилжүүлэн ярьж, бичдэг нь дээрх санааг тодотгох нэгэн баримт болж байна. Өрнөдийнхөн хэсгээс ерөнхийд чиглэсэн индукц гаргалгааг зонхилон хэрэглэдэг бөгөөд манай улсын боловсрол яг ийм зарчмаар зохиогдсон хичээлийн агуулга үзэж, сурах бичиг гарын авлага ашиглаж ирсэн байдаг билээ.

Дээрх онцлогуудыг харгалзан батлан хамгаалах боловсролын тогтолцоогоор цэргийн алба хаагч, оюутан сонсогч, иргэдэд өгөх мэдээллийн хэмжээг нягтруулж, сургалтын агуулгыг ерөнхийлөн багцлах зүй ёсны шаардлага дэвшигдэж байна. Тухайлбал, аль ч шатны батлан хамгаалах боловсролын агуулгыг хөндлөн ба босоо чиглэлээр нэгээс нөгөө нь урган гарахуйцаар учир зүйн эрэмбэд оруулж хөлгөн мэдээллийн маягаар оновчтой цомхон болгох хувилбарыг боловсруулах нь зүйтэй юм.

Ийм зарчмаар боловсруулсан дидактик нь монгол хүний сурах байгалийн онцлогт сайн тохирч улмаар сурах, сургах цйл ажиллагааг хамтын бүтээлч хөдөлмөр болгож, шинэ зууны иргэдийн зайлшгүй эзэмших чадварууд (аливаа асуудлын учрыг олдог, зөв шийдэл гаргаж чаддаг, хамтран ажиллах чадвар, харилцааны чадвар)-ыг хялбар олгох боломжийг бүрдүүлнэ. Нөгөө талаас дур мэдэн хичээлийн тоо, цагийг нэмэгдүцлдэг үр ашиг багатай, идэвхгүй арга барилаас салж, мэдээлэл боловсруулах дэвшилтэт аргыг хэрэглэн сургалтын хөтөлбөрийн агуулгыг төгөлдөржүүлэх боломж бий.

Дүгнэлт

Батлан хамгаалах боловсролын сургах зүй ба сэтгэл зүйн зарим асуудлаас түүний нийгэмд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тодруулан авч үзвэл:

1. Батлан хамгаалах боловсролын нийгмийн үүрэг нь Монгол Улсын иргэнийг эх орон, төр, ард түмнээ дээдлэн хүндэтгэх, газар нутаг, байгаль дэлхийгээ хайрлах, үндэс угсаа, түүх, соёл иргэншил, үнэт зүйлсээрээ бахархах эх оронч үзэл бодол, итгэл үнэмшлээр хүмүүжүүлж, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг хангах үйл явцад чиглэгдэнэ.

2. Батлан хамгаалах боловсрол нь хүн амын доторхи бүлэг нийтлэгийн нийгмийн ялгааг багасгах, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа болох, нийгмийн харилцааг боловсронгуй болгох зэрэгт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

3. Монгол орны түүх, соёлын онцлог, үндэсний өв уламжлал, цэрэг эх оронч сэтгэлгээ, өнөөгийн нийгэм эдийн засгийн хөгжил, боловсролын гүйцэтгэх үүрэг зориулалтаас үзэхэд бие хүнийг нийгмийн иргэн болгон

төлөвшүүлэх нарийн төвөгтэй үйл явцыг судалдаг батлан хамгаалах боловсрол нь цэргийн ухааны нэгэн хэсэг мөн болохын хувьд улс орны хөгжил, түүнтэй зэрэгцэн өөрчлөгдөн шинэчлэгдэж эхэлсэн.

4. Батлан хамгаалах, аюулгүй байдлын мэдлэг, ур чадварыг эзэмшсэнээр хувь хүний авьяас чадвар хөгжих, зан суртахуун, үзэл бодол төлөвших, нийгмийн харилцаанд оролцох, өрх гэрээ төвхнүүлэх, аюулгүй амьдрах зэрэг боломжууд нэмэгдэх болно.

5. Монгол хүний сэтгэхүйн өвөрмөц онцлогуудыг батлан хамгаалах боловсрол, сургалтын үйл ажиллагаанд туршин хэрэгжүүлэх нь залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангах ажлын сэтгэл зүйн үндсийг бүрдүүлэхэд ач тустай гэж үзэв.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Шагдар Б. Өөрийгөө хамгаалах эрх ашгийн үүднээс монгол орноо судлах нь. БХЭШХ-ийн ЭШ-ний хуралд тавьсан илтгэл. УБ., 2014.т.2
2. Ганзориг Д. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд илгээх захидал. “Соёмбо” сонин. 2019.10.24. №43(10668).
3. Паламдорж Ш. Батлан хамгаалах боловсрол судлал, түүний онол арга зүйн асуудал. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. УБ.,2019. №27. х126.
4. Путин В.В Быть сильными: гарантии национальной безопасности для России. Российская газета. №5708 (35) 17 фев.2012г.
5. 全国防教育.读本.2009,页87-90.
6. Рубинштейн.С.Л. Основы общей психологий. В двух томах.Т.2.М.,1989.стр 147.
7. Дэмчигдорж.Ч. Эрдэнэт толь хэмээх шаштир оршвой. УБ.,1995.т.30.
8. Баттогтох Д. Монголын уламжлалт боловсролын онол түүхийн судалгаа. Боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци. УБ.,2019.т.64

Цэргийн эмнэлгийн сургалтын ТОГТОЛЦООНЫ ЗАРИМ АСУУДАЛД

С.Юндэн

Доктор (Ph.D), бэлтгэл хурандаа

Т.Соронзонболд

Доктор (Ph.D), профессор, хурандаа

XXI зууны цэргийн эмч нарыг бэлтгэхийн тулд, мэдлэг, ур чадвар, мэргэжлийн үнэт зүйлс зэргийг зөв хослуулж, нэгтгэсэн анагаах ухааны болон цэргийн боловсролыг эзэмшсэн их эмч, эмнэлгийн мэргэжилтэнт бэлтгэхийн тулд юу хийх ёстой вэ?

Цэргийн төв эмнэлэгт мэргэжлийн сургалтын төвийг бий болгож эмчилгээ үйлчилгээ - сургалт судалгаа хоёрын уялдааг хангаж чадвал чадварлаг цэргийн эмч мэргэжилтэнтэй болно.

Эмч хүн өвчний шинж тэмдгийг үнэлж, шаардлагатай шинжилгээг төлөвлөж, дүгнэж, эмнэлзүйн зөв шийдвэрийг гаргаж, эмчилгээний төлөвлөгөөг боловсруулдаг талаар хэдэн арван жилийн судалгаан дээр үндэслэн баримтуудыг бий болгосон нь бий. Харин цэргийн эмчид бол дээрхи мэдлэгээс гадна цэргийн шинжлэх ухааны цогц мэдлэг эзэмшсэн байх шаардлага тавигдаж байдаг.

Цэргийн анагаах ухааны үндсэн зорилго нь зэвсэгт тэмцлийн үед хүн хүчний дайчилгааны нөөцөөр хангах, тайван цагт цэргийн алба хаагчдын цэргийн үүргээ гүйцэтгэхэд эрүүл мэндийн хувьд бэлэн байлгах, эмнэлгийн хангалтыг зохион байгуулах асуудал бөгөөд эдгээр чиг үүрэг нь гамшиг осол, олон улсын хүмүүнлэгийн ба цэргийн ажиллагаанд оролцох зэрэг олон чиглэлээр өргөжсөөр байна. Ялангуяа энхийг сахиулах ажиллагаанд цэргийн эмнэлгийн бие бүрэлдхүүн давамгайлан оролцож байгаа нь цэргийн эмнэлгийн хангалтын онол практикийн асуудал, цэргийн анагаах ухааны бодлого нь батлан хамгаалах салбарын бодлогын чухал хэсэг байх учиртайг илтгэн харуулж байгаа юм.

Цэргийн эмнэлэгийн шинжлэх ухаан нь цэргийн эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт ба цэргийн анагаах ухаан гэсэн үндсэн хоёр салбарт хуваагдана. Дээрхи хоёр салбар нь байлдааны ба тайван цагийн эмнэлгийн хангалтын удирдлага зохион байгуулалтын ба эмнэл зүйн асуудалыг шинжлэх ухааны цогц арга зүйн хэмжээнд судлаж, цэргийн эмнэлгийн онол практикийн бодлогыг боловсруулан хэргэжүүлэх зорилготой.

Цэргийн эмнэлгийн хангалтын энэ зорилгыг хэрэгжүүлэхэд цэргийн эмч мэргэжилтнүүдийн цэргийн ба цэргийн анагаах ухааны мэдлэг дадлагыг эзэмшүүлэх замаар бэлтгэн цэргийн бусад салбарын мэргэжилтнүүдийн түвшинд нийцүүлэх бэлтгэх шаардлагатай.

Дэлхийн өндөр хөгжилтэй томоохон гүрнүүдэд цэргийн эмч мэргэжлийн статус бүхий цэргийн эмнэлгийн мэргэжилтнүүдийг батлан хамгаалах сургалтын тогтолцоонд цэргийн сургуулиудаар бэлтгэдэг бөгөөд одоогоор манай улсад ийм тогтолцоо бүрдээгүй байна.

Цэргийн эмнэлгийн түүхэнд эдгээр мэргэжилтнүүдийн ОХУ-ын цэргийн эмнэлгийн академид бэлтгэж ирсэн бөгөөд 80 аад оны үеэс Монгол улсын Анагаах ухааны Дээд сургуулийн цэргийн факультет нээн бэлтгэж байжээ. Хожимоо АНУ, Герман, Хятад зэрэг зарим гадаад орнуудад эмнэл зүйн чиглэлээр цөөн тооны мэргэжилтэн бэлтгэсэн байна.

Өнөөгийн түвшинд цэргийн эмч сувилагч нарыг анагаах ухааны их дээд сургууль, сувилахуйн сургууль төгсөгчдийг цэргийн бэлтгэлийн богино хугацааны курсээр давтан сургах замаар бэлтгэж байгаа бөгөөд энэ нь цэргийн эмнэлгийн мэргэжилээс хол цэргийн албаны анхан шатны бэлтгэл сургалтын хөтөлбөр юм.

Олон улсын практикаас судлан дүгнэлт хийхэд Монгол улсын хувьд эхний шатанд эмнэлгийн мэргэжилтнүүдийг цэргийн албанд авахдаа цэргийн эмч, сувилагч тусгай хөтөлбөрөөр боловсрол олгох замаар цэргийн салбарт ажиллах мэргэжилтэнг сонгон авах эрх зүйн үндэсийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Цэргийн эмнэлгийн хүний нөөцийн бодлого, стратегийн баримт бичиг нь бусад төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн байгууллагаас эрс ялгаатай байдаг. Үүний тулд Батлан хамгаалах (БХ), Зэвсэгт хүчин (ЗХ)-ий хэмжээнд эмнэлгийн мэргэжилтэнг бүрдүүлж байгаа байдал хүний нөөцийн бодлого, баримталж ирсэн хүний нөөцийн бодлогод процессын шинжилгээ хийж үзэх шаардлагатай гэж үзлээ.

Батлан хамгаалах салбарт ажиллах эмч, эмнэлгийн хүний нөөцийн төлөвлөлтийн бодлогын саналыг боловсруулахдаа аль болох мэргэжилтэн бэлтгэх, сонгон шалгаруулж авах процессын хүчин зүйлсийг тооцоолсон учир хүний нөөцийн бодлогын шинэчлэлийг хийх болсон шалтгаанаар хэрхэн тооцоолсон талаар энд бичсэн болно.


Байгууллагын хүний нөөцийн бодлого гэдэг нь энэ асуудал хариуцсан салбар нэгжийн үйл ажиллагааны ерөнхий чиглэл болох бөгөөд хүн хүчний чадавхийг хадгалах, бэхжүүлэх, хөгжүүлэх болон зах зээлийн байнга хувьсан өөрчлөгдөж буй өөрчлөлтөд тухайн цаг үед нь хариу өгөх чадвартай, мэргэшсэн өндөр бүтээмж бүхий нягт хамт олныг бий болгохын тулд чиглэгдсэн зорилго ба зорилтуудыг боловсруулахад баримтлах зарчим, хэрэгжүүлэх арга, хэлбэр хийгээд зохион байгуулалтын механизмуудын нийлбэр цогц байдаг. Судалгаанаас дүгнэж үзвэл бид хүний хөөцийг бүрдүүлэх, хадгалах, хөгжүүлэх гэсэн гурван зарчмыг баримтлаж чадахгүй байна.

БХ- салбарт ажиллах эмч, эмнэлгийн хүний нөөцийн бодлогын үр дүнд тавих хяналтыг төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх ёстой.

Менежментийн онолоор аливаа байгууллагын хүний нөөцийн бодлогыг тодорхойлогч хүч бол удирдагч менежер байдаг. Менежер болон түүний багийн гаргасан шийдвэрээр бодлогыг хэрэгжүүлэх арга зүйгээ тодорхойлохдоо:

Бодит байдал —————> Төсөөлсөн байдал;

Бодит —————> Бодит байдал гэсэн менежментийн дүрмээр гаргалгаа хийж үр дүн гарч байна. 1 дүгээр зурагт



1 дүгээр зураг. Холбоос

Өнөөдөр цэргийн төв эмнэлэг болон БХ салбарт ажиллах эмч, эмнэлгийн хүний нөөцийн бодлого бодит байдал дээр ямар байна вэ? Энэ нь бодит байдал буюу доод нэгж дээр хэрхэн хэрэгжиж байна вэ? гэдгээс дүгнэлт хийж төсөөлж буй байдалд хэрхэн хүрэх вэ гэдэг зарчмыг тодорхойлно.

“**Бодит**” гэдэг ойлголтонд өнөөдөр БХ- салбарт ажиллах эмч, эмнэлгийн хүний нөөцийн талаар гаргасан эрх зүйн орчин ямар түшинд байна вэ?

“**Бодит байдал**” гэдэг ойлголтонд хүний нөөцийн талаар гаргасан эрх зүйн орчины хэрэгжилт ямар түшинд байна вэ? Тэдгээр тодорхойлогдох хооронд харилцан хамаарал бүхий ойлголтууд юм.

Тодруулга: БХ салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн ЗХЖШ-ын хүний нөөцийн хэлтэсийн мэдээнд дүгнэлт хийж үзвэл дурийн нэг анги, байгууллагын тайван цагийн орон тоо 90 хувийн хангалттай байхад “Бодит байдал” дээрээ анги, байгууллага дээрээ 70 хувийн хангалттай байгааг хэлнэ. Тухайн анги байгууллагаас гадаадад үүрэг гүйцэтгэх, богино хугацааны сургалтанд хамрагдах, түр өөр ажилд томилогдох зэрэг шалтгаанаар орон тоо 20 хувиар буурсан байгаа нь үүрэг гүйцэтгэх чадварт нөлөөлөх сөрөг хүчин зүйл болж эмч, эмнэлгийн мэргэжилтэний ажлын ачаалал 20-30 дахин нэмэгдэж байгаагаар томъёологдож байна.

“**Бодит байдал**”-д хийсэн шинжилгээний үр дүнгээр БХ, ЗХ-д ажиллаж эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүд нь бусад төрийн болон төрийн бус бизнесийн байгууллагын баримтлан явуулдаг хүний нөөцийн бодлогыг бодвол харьцангуй сайн эрх зүйн зохицуулалтай боловч тухайн ажлын байрны шалгуурыг бүрэн хангаж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Цэргийн төв эмнэлэг буюу ЗХ-ний ... дугаар ангид стратеги тактикийн боловсролтой мэргэжилтэн байхгүй, оператив тактикийн боловсролтой мэргэжилтэн – 18 хувь, тактикийн буюу тасаг салааны түвшингийн

боловсролтой мэргэжилтэн 52 хувь, 30 хувь нь цэргийн хэргийн ямар нэг нь боловсролгүй мэргэжилтэнгүүд ажиллаж байна.

Цэргийн төв эмнэлэг буюу ЗХ-ний ... дугаар анги дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болж байна. Өөрөөр хэлбэл хороо, бригад, дивизийн түвшинд үүрэг гүйцэтгэх мэдлэг чадвартай мэргэжилтэн шаардлагатай болж байгааг илэрхийлж байна. Энэ асуудлын алдаа хаана байна вэ?

Эрх зүйн зохицуулалт харьцангуй сайн байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэгч менежер буюу удирдлагын түвшинд алдаа байгаа нь судалгааны ажлын явцад харагдаж байна.

БХ салбарт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэний талаар баримтлах хүний нөөцийн бодлогын “**Бодит байдал**”-д хийсэн шинжилгээний үр дүнг шинэчилсэн бодлогын үр дүнд бий болох “**Төсөөлсөн байдал**”-тай харьцуулан үзэхэд бодлогын үр дүнд дараах дэд тогтолцоо хэрэгжих боломжтой гэсэн зураг гарч байна.

- Цэргийн төв эмнэлэг болон ЗХ-ий анги салбарт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх төгсөлтийн дараах сургалтын дэд тогтолцоо.
- Цэргийн төв эмнэлэг болон ЗХ-ий анги салбарт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэнд цэргийн боловсрол олгох сургалтын тогтолцоо;
- Цэргийн төв эмнэлэг болон ЗХ-ий анги салбарт ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн офицерын бүрэлдэхүүнийг цэргийн мэргэжилд мэргэшүүлэх сургалтын тогтолцоо;
- Мэдээллийн сан гэсэн асуудлыг хамруулан БХ салбарын эмнэлэгийн сургалтын бодлогыг боловсруулахаар төсөөлөгдөж байна.

Цэргийн төв эмнэлэг болон ЗХ-ий анги салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэний талаар баримтлаж буй хүний нөөцийн бодлого өнөөдөр байгаа бодит байдалд төсөөлсөн байдлаас дүгнэлт хийвэл бидний шинэчлэл өөрчлөлт хийх тулах цэг буюу хөгжлийн цонх нь эмч, эмнэлгийн мэргэжилтэнг давтан сургах, мэргэшүүлэх сургалтын тогтолцоо буюу “Төгсөлтийн дараах сургалт” байхаар томъёологдож байна.

Яагаад “Төгсөлтийн дараах сургалт” байна гэж?

- Улс орны эдийн засгийн хөгжлийн хандлага;
- Шинэчлэлийн Засгийн газраас дээд боловсролын салбарт хийж буй өөрчлөлт;
- Олон улсын стандарт ангилалд нийцүүлэн өөрчлөх;
- Олон улсын түвшний сургалт явуулах.

Яагаад “Төгсөлтийн дараах сургалт” байна гэж?

Төгсөлтийн дараах сургалтад хамрагдагсад суралцаж буй мэргэжлийн чиглэл тус бүрээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил

хийж шинэ мэдлэг технологи инновацийг бүтээж, бие даан ажиллах чадвар эзэмшдэг байна. Өөрөөр хэлбэл төгсөлтийн дараах сургалтаас “Шинэ санаа”, “Шилдэг санаачилгын цогцолбор”, “Оюуны үйлдвэрлэл”, “Хөгжлийн гарц” гэх мэт инноваци гарч, “Think Tank” хэлбэрийн судалгаа шинжилгээний ажил хийгдэж тухайн салбарын эдийн засгийн нөхцөл байдлыг зөвөөр үнэлж дүгнэх, учирч болох үр дагаврыг урьдчилан тооцоолох, сэргийлэх бодлого боловсруулах зэрэгт нэмэр болох санал санаачилга гардаг гэж үзэж болно.

Бага зардлаар өндөр мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх боломжтой. Мөн хүний нөөцийг хангах хэрэгцээ, шаардлагыг үндэслэн гадаад, дотоодын цэргийн академи, их дээд сургуульд сургах мэргэжил, хяналтын тоонд хяналт тавих, захиалгын дагуу сургаж бэлтгэх ажлыг хэн хэрхэн зохион байгуулах арга хэмжээг зааж өгнө. Хүний нөөцийн хэт ачаалал илүүдэл үүсгэхгүй байх үүднээс мэргэжлийн хангалтын байдалд хатуу хяналт тогтоон баримтлах.

Дахин мэргэшүүлэх гэдэгт суралцах, сургалтын үйл явц хоёулаа хамаарна. Энэ баримт бичгийн тухайд суралцах гэдэг нь ажлын байран дээрээ өөрийн мэдлэг, туршлага, чадавхийг дээшлүүлэх албан бус сурах үйл явцыг илэрхийлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг болон БХ-салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэхэд тусгайлсан захиалга АУШУҮИС болон бусад анагаах ухааны сургуульд суралцаж төгссөн төгсөгч нараас **Үндсэн нарийн мэргэжил олгох сургалт буюу /Резиденсийн сургалт/, Мэргэжил дээшлүүлэх сургалт**-ыг зохион байгуулан явуулж амжилттай сайн суралцаж төгссөн төгсөгч нараас сонгон шалгаруулан цэргийн мэргэжил олгох сургалтанд хамруулах дэд тогтолцоо байх юм.

Сургалтын төрөл, түвшинг нэгэнт тодорхойлсон бол одоо байгууллага сургалтыг хэнээр, ямар хугацаанд, ямар өртгөөр зохион байгуулахыг тодорхойлох ёстой. Зарим тохиолдолд хамгийн үр өгөөжтэй сургалтыг байгууллага дотроо боловсруулсан байдаг. Мэдээж тэргүүлэх чиглэлийг тогтоож, олон жилийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг гаргах нь зүйтэй.

Үүний тулд, ҮБХИС болон Цэргийн төв эмнэлэг дээр төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулж явуулах сургалтын албыг байгуулж, зөвшөөрөл, сургалт явуулах чиглэлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ ажлыг ЗХЖШ-ын хүн эмнэлгийн хэлтэс, БХ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэмжлэгтэйгээр нэн тэргүүнд хийх хэрэгтэй гэж үзлээ.

Өнөөдөр бусад адил төвшингийн 3 дугаар шатлалын эмнэлгүүдийн явуулж байгаа нарийн мэргэжлийн сургалт нь 44-66 багц цагийн агуулгын багтаамжтай 1-1,5 жилийн хугацаатай резиденсийн сургалт байна. Резиденсийн сургалтын нийт багц цагийн 20-25 хүртэл хувийг сургалт эрхлэх байгууллагад явагдах онолын сургалт /танхимийн/, мэргэжлийн

онцлогоос хамаарч 80-75-аас доошгүй хувь нь дадлагажих сургалт байна. Өөрөөр хэлбэл Резиденсийн сургалтанд хамрагсад нь дадлагажих эмч буюу эмчийн туслахаар ажиллаж эмчийн хийх ёстой бүхий л ажлыг хийж байгаа боловч тэд цалин авахгүй харин сургалтын агуулгад тохирсон төлбөрийг төлж ажиллаж суралцаж байна. Тийм учраас цэргийн төв эмнэлэг болон ҮБХИС-тай хамтран ЗХ-ний анги салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэх тэргүүлэх чиглэлийг зөв тогтоож, олон жилийн дэлгэрэнгүй төлөвлөгөө, сургалт явуулах сургалтын төлөвлөгөөг нарийн гаргах хэрэгтэй гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл салбарын хүний нөөцийг цэргийн төв эмнэлгийн сургалтын төв, Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль болон гадаад орнуудад Аюулгүй байдал, Батлан хамгаалахын чиглэлийн их сургууль, Академи, Коллежид бакалавр, магистр, докторын сургалтад иргэдийг сургаж бэлтгэх тогтолцоо юм.

Хэдийгээр бодлогын тодорхой асуудлыг шийдвэрлэхэд төрийн бус байгууллагууд амжилттай нөлөөлөл хийж түүний үр дүнд хүлээгдэж байсан бодлого гарсан зарим тохиолдол байгаа ч энэ нь нэг талаас тухайн асуудлын шинж онцлогоос ихээхэн хамаарч ирсэн байна. Нөгөө талаас бодлогын үйл явц Цэргийн төв эмнэлгийн оролцоо, нөлөөллийн үр дүн нь БХЯ, ЗХЖШ-ын хамтын ажиллагааг дэмжсэн орчин, бодлогын үйл явц дахь оролцоог зохицуулсан эрх зүйн орчин бүрхэг, дэмжсэн институтчилэлээс ихээхэн хамаарч байгааг урьд өмнө хийгдсэн судалгааны тайлангуудад дурджээ.

БХ салбар, Зэвсэгт хүчний эмнэлгийн байгууллагуудад ажиллах эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх тогтолцоо:

Салбарын хүний нөөцийг бэлтгэж, тасралтгүй хөгжүүлэх үйл ажиллагааны үндэс нь Батлан хамгаалахын боловсролын тогтолцоо байна. Батлан хамгаалахын боловсролын тогтолцоо гэж улс орныг Батлан хамгаалах зориулалттай үүрэг, хариуцлага хүлээсэн хуулийн этгээд болон Зэвсэгт хүчнийг тайван цагт бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах улсын дайчилгааны нөөцийг бэлтгэхэд чиглэгдсэн цэргийн болон цэрэгт шаардлагатай иргэний мэргэжилтэн бэлтгэх сургалт, боловсрол, мэргэшлийн үйл ажиллагааны цогцыг хэлнэ. Анагаах ухааны болон цэргийн алба хаагчдад мэргэжил олгох, ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байрны шаардлага, албан тушаалын өсөлтийг хангахад чиглэгдсэн шат дараалсан албан тушаалын, мэргэжил эзэмшүүлэх сургалт болно. Мэргэжил олгох сургалтын тогтолцоо нь мэргэжил олгох буюу мэргэшүүлэх гэсэн ангилалттай байна.

Зэвсэгт Хүчний анги салбар, Цэргийн төв эмнэлэгт эмч мэргэжилтэн хүний нөөцийг сургаж бэлтгэх үндсэн нэгж нь Сургалтын төв, ҮБХИС байх ба сургалтын үйл ажиллагаа нь боловсролын болон мэргэжил олгох сургалтыг Эрүүл мэнд, БХ салбарт үйлчилж буй эрх зүйн актууд, Монгол Улсын Боловсролын тухай хууль тогтоомжийн дагуу явуулна.

Зэвсэгт Хүчний анги салбар, Цэргийн төв эмнэлэгт эмч мэргэжилтэн

нарын албан тушаал, цолны үндсэн шалгуур нь боловсрол, цэргийн болон анагаах ухааны мэргэжлийн туршлага байх бөгөөд үүний тулд ахисан түвшний мэргэшүүлэх шат дараалсан сургалтад хамрагдсан байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Батлан хамгаалахын сайдын 1998 оны дугаар тушаалын хавсралт УБ.1998 “Батлан хамгаалах салбарт боловсон хүчин бэлтгэх үндсэн чиглэл”;
2. Батлан хамгаалахын сайдын 2008 оны 68 дугаар тушаалын хавсралт “Офицерийн алба хаах журам”;
3. Батлан хамгаалахын сайдын 2008 оны 75 дугаар тушаалын хавсралт “Ахлагчийн алба хаах журам”;
4. Батлан хамгаалахын сайдын 2008 оны 413 дугаар тушаалын хавсралт “Батлан хамгаалахын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлого, сургалтын тогтолцоо, үндсэн чиглэл”;
5. П.Наранцэцэг “Хүний нөөцийн менежмент” 2009 он;
6. Мягмаржав Г. Цэргийн сургалтыг эрчимжүүлэх онол, арга зүйн зарим асуудал, УБ. 1999. Цэргийн сургалтыг эрчимжүүлэх сурган хүмүүжүүлэх зарим асуудал, УБ.1995 он. 200 х;
7. Тогоо.Ц. Цэргийн мэргэжлийн шаталсан сургалтын тогтолцоо, агуулга, арга зүй, УБ. 1999. 125 х;
8. Алгаа.П. “Зэвсэгт хүчний офицер бэлтгэх сургалтын тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох арга зам” Цэргийн ухааны докторын дисс. УБ, 2003;
9. Паламдорж.Ш. ;Цэргийн боловсрол сургалтын тогтолцоо., УБ., 2001;
10. Американская система медицинского образования Украина, 1996;
11. Бюллетень Высшего аттестационного комитета Российской Федераций, Москва, 1993 №5.

Түшээ гүн Гадинбалын Чагдаржав ба Монгол Улсын батлан хамгаалах бодлого

Т.Сүхбаатар

БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын
төвийн дарга, доктор (Ph.D), хошууч

Монгол Улсынхаа тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, үндэстнийхээ эрх, эрх чөлөөний төлөө нэгэн насаа үл умартан мятаршгүй 1911 оны үндэсний хувьсгалын хэрэгт хүчин зүтгэж, 1911 оны 11 дүгээр сараас Халхын Хүрээний бүх хэргийг түр ерөнхийлөн захиран шийтгэх газрын анхны дарга болж, Улс үндэстнээ чөлөөлөх тэмцлийн утга учрыг олон түмэнд ойлгуулах, Халхын дөрвөн аймгаас цэрэг татах, Богдын лүндэнг монгол туургатанд хүргэх зэрэг ажлыг амжилттай зохион байгуулсан хүн бол хошой чин ван Гадинбалын Чагдаржав юм.

Г.Чагдаржав бол Үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд Монгол Улсын Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны тэргүүн сайдын албыг хашиж байжээ.

Гадинбалын Чагдаржав бол юуны өмнө Чингис хааны шууд алтан ургийн хиад Боржигин хүн билээ. Түүний удам гарал нь Батмөнх даян хааны арван нэгдүгээр хөвүүн Гэрсэнз жалайр хунтайжаас эхлэлтэй юм. Түүнд өвөг дээдэст байсан цэргийн эрдэм ухаан цэрэг эх оронч үзэл түүнд уламжлагдан ирсэн юм.

1896 онд өөрийн эцэг Гандинбалын орыг залгасан Чагдаржав Манжийн төрд зүтгэж байхдаа Монгол түмнээ туурга тусгаар улс болгож эрх чөлөө тусгаар тогтнолын төлөө тэмцэх чинхүү хүсэл эрмэлзэлтэй байсан бөгөөд бусад алтан ургийн ноёдын адил улс төрийн аятай цаг хугацааг л гагцхүү хүлээн сууж байжээ.

1911 онд үндэсний эх чөлөөний хувьсгал ялж Монголчууд Богд гэгээнийг хаан ширээнд залахад Чагдаржавт Монгол Улсын төрийн тамга өргөх¹ томоохон хувь заяа оногдсон юм. Энэ бол хэн хүнд олдоод байхгүй хувь тавилан мөн асар их итгэл хүлээлгэсэн гагцхүү алтан ургийн удмынханд олдох үйл явдал билээ.

Үүний дараа ч Богд хаан улсын эзэн хааны суудалд залраад буулгасан хишгээр Чагдаржав үе улиран Түшээт цол, төрийн жүн ван,

¹ МУУТА. ХА-3, Д-1, ХН-293, Б.28

улбар шар жолоо шагнаж шадар сайд² болгожээ.

Олноо өргөгдсөн Богд Хаант Монгол Улсын Засгийн газрын анхны таван яам нь Дотоодын хэргийг захиран шийтгэгч яам, Гадаад хэргийг бүгд эрхлэн шийтгэх яам, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам, Шүүх таслах хэргийг бүгд захирах яам, Сангийн хамаг хэрэг бүгд захиран шийтгэх яам нэртэйгээр байгуулж байсан. Үүнээс сангийн яамыг Г.Чагдаржав толгойлсон.

Монгол Улс 1911 онд төрийн тусгаар тогтнолоо сэргээж, улмаар улс гэрээ төвхнүүлэх, батлан хамгаалах санхүү, эдийн засаг, аж ахуйгаа бэхжүүлэх үйл хэрэгт хүн бүр хүчин зүтгэж, улсын сан хөмрөгийг бүрдүүлэхийн төлөө бүхий л нөөц бололцоогоо шавхан дайчилж, төрийн гааль, татварын орлогын баазыг зохих ёсоор арвижуулж, газрын хэвлийн баялгийг түрээсэлж мөнгө, санхүүгийн хэрэгцээт эх үүсвэрийг бүрэн бус боловч хангах эхлэлийг тавьсан байна. Үүнд сангийн яамны үүрэг нэн чухал гэдэг нь мэдээж.

Богд хаант Монгол Улсын Цэргийн яамны төсөв, түүнтэй холбоотой санхүүгийн бүхий л асуудал сангийн сайдын гарын үсгээр баталгааждаг байсан. Тэр бүхнийг хэрэгжүүлэгч нь сайд Г.Чагдаржав байсан.

Г.Чагдаржав хэдийгээр сангийн сайд байсан ч шадар сайдын хувьд цэрэг батлан хамгаалах бүхий л асуудалд өөрийн хүсэл зорилгоор оролцож байсан нь эдүгээ архивын олон баримтанд үлджээ.

1912 оны 06 сард Г.Чагдаржаваас сайд бэйсд бичсэн захидалд өвөрмонгол ах дүү нараас зэвсэг гуйж ирсэнд нэгэн мянган буу өгч одуулав гэх зэргээр цэрэг зэвсэгтэй холбоотой зарлиг олноор үйлдэж байжээ. Мөн анхны цэргийн ёс зүйн дүрмийг гаргасан ч байж болох зарлиг бий. 1913 оны 01 сарын 29 нд Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яам, Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яамны бичигт: “гэлэнгүүд хурал хурахаас бусад энгийн цагт бага орхимж хэрэглэн явахаас гадна шар, хар олноор золиг, монди хэмээн хараах жич, тэвэг өшиглөх явдлыг нийтээр чангалан цаазалж зогсоохтун”³ хэмээн айлдаж байжээ.

Монголчууд тусгаар тогтнолоо 1911 онд сэргээн зарласны дараагаар өмнө зүгт Дундад иргэн улсын зүгээс байнгын аюул заналхийлэл учруулах болсон. Тийм ч учраас Богдын засгийн газраас өөрийн цэрэг армийг шинэчлэн зохион байгуулж бэхжүүлэх асуудлыг шийдэж эхэлсэн.

Цэргийн яам 1914 оны байдлаар **52** хүний орон тоотой, тэдний цалинд **2451** лан мөнгө, бичиг хэргийн зардалд **13** лан, бүгд **2464** лан мөнгийг сар бүр зарсан байна. Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичгийн хоёрдугаар дэвтэрт зааснаар Цэргийн яамны орон тоог **50** хүнээр тогтоожээ.

Шинэ тулгар төрийг байгуулж, улс орны тусгаар тогтнолыг батлан хамгаалахад эн тэргүүнд:

- Цэргийн хууль цаазыг боловсруулан гаргаж, улс даяар чандлан

² МУУТА. ХА-6, Д-1, ХН-513. Б.1

³ МУУТА. ХА-7, ХН-1, Д-173. Б.1

- мөрдүүлэх;
- Түшмэл, цэргийг дайчлан дайлаар мордуулах, эр цэргийг төөлөх өөрөөр хэлбэл дайчилгааны бэлэн байдлыг хангах арга хэмжээ авчээ. Энэ цэргийг байнгын бус цэрэгт хамааруулж болно.
 - Дотоодыг хамгаалахад зориулж төвийн сургуультай цэрэг, цагдааг байгуулж, тэднийг сурган боловсруулж, байцаан шалгах; энэ үндсэн дээр байнгын (төвийн) цэргийг үүсгэх
 - Цэргийг орчин цагийн байлдааны зэвсгээр хангах, үүний тул гадаад орноос авсан зээлээр худалдан авах;
 - Цэргийн удирдах сайд жанжин, түшмэлийн зэрэг дэв цол хэргэмийг нарийвчлан тогтоож, гавъяа зүтгэл байгуулсныг ба цэргийн хэрэгт үнэн санаагаар тусалсан ноёд, иргэдийг хөхүүлэн шагнахыг чухалчилж байсан нь тодорхой байна. Үүнд Монгол Улсын цэргийн байгуулалтын үндсэн асуудал багтаж байв.

**Монгол Улсын төсвийн зарлагад цэргийн зардал,
түүний хувь (рублээр)⁴**

	1913/14	1914/15	1915/16	1916/17	1917/18
Зэвсэгт хүчинд	35,1903	35,1903	35,4017	45,6000	53,0636
Улсын төсөвт эзлэх хувь	27.8%	23.9%	21.7%	21.3%	25.3

Монгол Улсын цэргийн зардал 1913-1918 онд төсвийн зарлагын **21.3-27.8** хувийг эзэлж байв. Энэ бол Богд эзний засгийн газраас улс орны тусгаар тогтнолыг хамгаалах монгол туургатныг чөлөөлөх тэмцэлд ихээхэн ач холбогдол өгч ирснийг гэрчилнэ. Тэр хэрээр сангийн сайд гар таталгүй цэргийн яаманд хөрөнгө гарган өгч байсан юм. Тэгэхдээ Хаант Орос Улсаас янз бүрийн хугацаанд авсан 4 сая орчим рублийн зээлийн тодорхой хэсгийг цэргийг сургаж бэлтгэх, зэвсэг худалдан авахад зориулсныг тэмдэглэвэл зохино.

Монгол Улсын засгийн газрын өмнө цэрэг байгуулах явцад түүнийг орчин үеийн зэвсэглэлээр хангаж, байлдах чадвартай болгох явдал тэргүүн зэргийн зорилт болов. Эл асуудлыг шуурхай шийдвэрлэхийн тулд 1911 оноос эхлэн Хаант Оросын засгийн газраас зээл авах, түүнийг тодорхой хэсгийг зэвсэг худалдан авахад зориулахаар шийдвэрлэжээ.

Түүхч З.Лонжид⁵, Ж.Урангуа⁶ нар Оросоос хэрхэн хэдэн удаа болон ямар нөхцөлтэйгээр Монгол Улсын засгийн газар зээл авсан тухай нэлээд дэлгэрэнгүй судлан бичсэн нь бий. Уг олон удаагийн зээлийг авч батлан

⁴ Майский. Монголия накануне революции. М., 1960 номын 230 дахь талын материалаас авав.

⁵ З.Лонжид “Монгол Улсын санхүүгийн албаны түүх” УБ.,1999. “Түүх сөхөхүй” УБ.,2011

⁶ Ж. Урангуа “XX зууны эхэн үеийн Монгол Улс” УБ., 2006. “Монголын тусгаар тогтнолд хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс” УБ., 2010.

хамгаалах хүчин чадлаа бэхжүүлэхэд сангийн сайд Г.Чагдаржавын хувь хүний хичээл зүтгэл нэн их байсанг тэмдэглэх нь зүйтэй юм. Аливаа улс орны хөрөнгө санхүү чухамхүү сангийн сайдын үзэмж үзэл бодол үйл хэргээр хэрэгждэг нь бичигдээгүй хууль юм.

1912 оны эхээр Гадаад хэргийн сайд, Сангийн сайд нар хамтран **100** мянган целковыг 10 жилийн хугацаатай зээлж цэргийн хүнс, орос сургагчдын зардалд зориулахаар уйгагүй хөөцөлдөн хэлэлцэж М.Ханддорж, Г.Чагдаржав нар 1912 оны дөрөвдүгээр сарын 25 нд 4 зүйлт гэрээ байгуулан зөвшөөрүүлж чадсан байна.

Дараагийн томоохон зээл бол Монголын тал хаант Оросоос 2 сая рублийг 40 жилийн хугацаатай зээлэх хүсэлт гаргажээ. Удаан хугацаанд хэлэлцэж Сангийн сайдын уйгагүй хичээл зүтгэлийн ачаар зөвшөөрүүлж 1913 оны 2 сараас зээлээ авч эхэлжээ. Уг зээлийг мөн л Монгол бригадын зардал болон 5 замын байлдаанд зарцуулжээ⁷.

Дээрх 2 сая рублийн дараагаар бас нэгэн багахан хэмжээний зээл авч чадсан байна. Уг зээлийг юу юунд зарцуулах талаар 8 зүйлээр тодорхойлон бичиж Оросын талаас Коростовец, Намнансүрэн, Чагдаржав нар гарын үсэг зурсан байна.

Үүний зэрэгцээ Герман зэрэг улсаас шинэ боловсронгуй зэвсэг худалдан авахыг эрмэлзэж, зохих хэлэлцээ хийх болжээ. Энэ бүхний дүнд 1911/12 оны заагаар Хаант Оросоос буудлагын зэвсгийн эхний хэсгийг хүлээн авч, цэргээ зэвсэглэж эхэлсэн байна. Тухайлбал, 1912.03.01-ний байдлаар Монгол Улс Эрхүү, Амурын цэргийн тойргоос Хиагтаар дамжуулан **13,735** бердан буу, барга, дорнод монголчууд 1265, бүгд **15,000** бердан буу хүлээн авсан байна.

Мөн 1913 оны эхээр **6000** винтов, 2 пулемёт, 2000 сэлэм, 2 их буу, байлдааны хэрэгслийн хамт Хужир булангийн сургууль хүлээн авчээ.

Улмаар Монгол Улсын Засгийн газар Орос Улсаас буу зэвсэг авах тухай 1914.09.30-нд гэрээ байгуулав. Энэхүү гэрээний дагуу Их Орос улсын Хаан эзний засгийн газраас Монгол улсад үхэр буу 6, мөн бууны сум **3000**, пулемёт буу **4ш-ийг 40000** сумны хамт, винтов **20000**, сум **20** саяыг олгохоор тогтжээ. Гэвч энэ зэвсгийг бүрэн авч чадаагүй юм. Дээрх гэрээгээр Монгол Улс гадаад улс, гадаадын ба оросын иргэдийн пүүс компаниас буу зэвсэг авахыг хориглосон заалт орсон нь оросын ашиг сонирхолд нийцсэн, монголчуудыг хаан боогдуулсан заалт болсныг тэмдэглэвэл зохино.

1913 он бол Монгол Улс, түүний цэргийн түүхэнд гүн гүнзгий ул мөр үлдээсэн жил юм. Богд хааны засгийн газар Халх монголыг чөлөөлснөөр үйл ажиллагаагаа хязгаарлаагүй, нийт монгол овогтныг нэгтгэх тэмцлээ үргэлжлүүлэх, юуны өмнө Өвөр Монголыг Хятадын гараас чөлөөлөхийн төлөө шаргуу тэмцэл хийсэн билээ.

Монгол Улсын тусгаар тогтнолыг өвөр 6 чуулганы 49 хошуунаас 35 нь зөвшөөрөн хүлээж, Баргын 8 хошуу, Дөрвөдийн хоёр аймгийн

⁷ УТА, Ф-А4, Д.1, хн 136

16 хошуу, захчин 3 хошуу, Алтайн урианхайн 7 хошуу, Торгуудын 3 хошуу, хошоодын нэг хошуу, Ар Илийн цахарын (Сумъяа бэйс) нэг хошуу, Тагнын хоёр уранхай, хасагийн хэсэг ард зэрэг олон монголчууд дагаар оржээ. Хөх нуурын зүүн гарын чуулганы 24 засаг бас Богдын соёлд багтахаяа нотолжээ. Энэ мэтээр “... Монгол Улс дахиж мандахын шинж лавтай ургаж, дорно зүгийн Хянганы уулаас баруун этгээд Алтай нуруу хоёрын хооронд бүхий газар усаар эзэлсэн бүрэн эрхт Монгол Улс болон мандаж бүхий” нь нэгэнт тодорхой болсон байна.

Энэхүү бодит байдлыг ДИУ-ын (Дундад иргэн улсын) засгийн газар хүлээж зөвшөөрөөгүйгээр барахгүй, Дотоод Монголыг сэргийлэх, Гадаад Монголыг тулж байлдах их цэргийг Өвөр Монголд оруулж Халх Монголд шууд заналхийлэв. Энэ бол бодитой аюул байсан юм.

Эл нөхцөлд хил хязгаарыг сахин хамгаалах ба төвийн цэргийг хэрхэн дайчилсан тухай 1913 оноор авч үзвэл:

Цэргийн Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамнаас дөрвөн аймгаас цэрэг дайчлан нутгийн хязгаар, зарим чухал боомт газруудад суулгахаар 1913.02.27-нд зохих газруудад тушаасан байна. Үүнд:

- Түшээт хан аймгаас 1300;
- Сэцэн хан аймгаас 1260;
- Засагт хан аймгаас 620;
- Сайн ноён хан аймгаас 820.

БҮГД 4000 цэргийг дайчлан Нийслэл Хүрээнд ирүүлэн сурган боловсруулж, сэргийлэн хамгаалуулах;

Ховд, Улиастайд тус бүр 300 (бүгд 600) цэрэг суулгаж, тус тусын сайдуудад хавсарган захируулж, зах хязгаарыг сэргийлэх;

Дөрвөн аймгийн нутгийн хязгаарт өөр өөрийн 500 (бүгд 2000) цэрэг гаргаж чухал боомтыг сэргийлэн хамгаалуулах, тухайлбал, Түшээт хан аймгийн цэргийг Ачит гүн Бадрахаар, Сэцэн ханы цэргийг хурц гүн Түдэнгээр, Засагт ханы 250 цэргийг захирагч Тэгшжав, мээрэн тайж Сампил нараар удирдуулан өмнө хязгаарын Тахь хошуунд, үлдэх 250 цэргийг гүн Дашцэрэнгээр захируулж Захуй царамд, Сайн ноён хан аймгийн цэргийг Ёст засаг Чүлтэмээр захируулан түүний хошууны нутгийн баруун өмнө этгээд Ноён уулын баруун үзүүр, Сүүжийн газар 250, нутгийн өмнө Баруун Цохио уулын баруун үзүүр, Улаан тал хэмээх газар 250 цэргийг тус тус анги хуваан суулгах болжээ.

Энэ удаагийн дайчилгаагаар нийт 6600 цэрэг дайчилсан байна.

Энэхүү түгшүүртэй байдлыг харгалзан Монгол Улсын Засгийн газар Өвөр Монголын нутагт таван замаар цэрэг оруулах шийдвэрийг 1913.01.24-нд гаргажээ. Үүнийг түүхэнд таван замын цэрэг хэмээн нэрийджээ. Эдгээр нь:

- орлосон дэд сайд засаг чин ван Удайн харъяат цэргийг бэйс Чимэдсэрэнд, дэс түшмэл зоригт баатар гүн Тогтохын харъяат цэргийг хичээнгүй баатар гүн Найданжавт тус тус

- захируулан Егүзэр хутагт Галсандашийн хүрээний зүг;
- дэс түшмэл чин зүтгэлт гүн Хайсан, дэд зэрэг түшмэл Бавуужав нарын цэргийг гүн Наваангомбоор ерөнхийд нь захируулан Дарьгангын зүг;
- дэд сайд бишрэлт бэйс Насанравжихын цэргийг хоёр Сөнөд, Дөрвөд вангийн зүг;
- халхын цэргийн сургуулиас мордуулах 200 цэргийг сайд гүн Содномдоржийн цэрэгтэй нийлүүлэн Хөх хотын зүг;
- дэд зэрэг түшмэл Зүтгэлтийн цэргийг Урадын гурван гүн, Хатаны голын зүг тус тус мордуулжээ.

Цэргийг нийтэд нь Зүүн өмнө хязгаарыг захирсан жанжин Ж.Дамдинсүрэн ерөнхийлөн захирч явав. Эл цэрэг 1913 оны турш Өвөр монголын нутагт хятадын цэргийн давуу хүчний эсрэг хүнд ширүүн байлдаан хийсэн билээ.

Таван замын байлдааны хоёр дахь үед буюу 1913 оны зун Г.Чагдаржавыг баруун өмнө хязгаарын цэргийн хэргийг бүгд захирч, олон монголчуудыг илбэн тохинуулах сайдаар томилогджээ. Энэ бол таван замын байлдааныг эрчимжүүлэх үүднээс засгийн газраас гаргасан шийдвэр байсан юм. Монгол Улсын сайдуудын дотроос цэрэг захирсан ганц сайд тэрээр болжээ. Цэргийн аугаа их бодлоготон хүнд л ийм их итгэл найдвар олдох биз ээ.

Үүний хамт Богд хааны зарлигаар Нийслэл хүрээнээс цэргийн давшилтын чиглэлийг шинэчлэн тогтоосон байна. Энэ нь стратегийн дөрвөн чиглэлээр давшуулан өвөр Монголыг бүрэн чөлөөх явдал байжээ. Үүний нэг чиглэлд нь Чагдаржав, Галсанцанбантүгжням нарыг Улаанцав, Их зуу, Алшаа, Хөх хотын түмэд зэрэг олон монголчуудыг хамгаалан тохинуулахыг тушаажээ⁸.

Гэвч улс төрийн бусад хүчин зүйлсээс болж 1913 оны 11 сарын 30 нд Монгол Улсын Цэргийн яамнаас Чагдаржав, Галсанцанбантүгжням нарыг нэн түргэн Нийслэл Хүрээнд ирэхийг тушаасан байдаг.

Тэрээр өмнөд хязгаарыг тохинуулах сайд байх даа хэд хэдэн тушаал гаргасан байдаг. Түүний гаргасан тушаалуудын утгыг сийрүүлбээс цэргийн албан хаагчдаас хулгай дээрэм хийж байгаа үйлдлийг буруутган шийтгэсэн тушаал зарлиг байдаг.

Чингис хааны бие сүлд тугийг нийслэл хүрээнд залан авчрах хүндтэй үүрэг хэн бүхэнд олдоод байдаггүй билээ. Ийм хувь заяаг гагцхүү Чингисийн алтан ургийн Г.Чагдаржавт олдсон юм. Энэ нь Богд хаанаас ямар их итгэл хайрласан гэдэг нь харагдаж байгаа юм.

Г.Чагдаржавыг өмнөд хязгаарт гарамгай гавьяа байгуулсан учир Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас шагнасан байдаг.

1914 оны 06 сарын 14 нд Богдын засгийн газраас хүрээнд суугаа элчин Миллертэй хэлэлцээ хийхэд Г.Чагдаржав идэвхийлэн зүтгэл гаргаж

⁸ МУУТА-ын ТБА. Сх-А5. Д-1. Хн-97. Нуг 1.

Орос цэргийн сургагч нарыг урих, тэдгээрийн Монголд байх хугацааны орон байр унаа хөсөг, цалин пүнлүү, гээд нийгмийн бүхий л асуудлуудыг нь шийдэж өгөхөд хүчин зүтгэл гаргаж байсан нь сайшаалтай юм.

Энэ мэтчилэн баримт бүрийг сайтар ажваас сайд Г.Чагдаржав Монголынхоо газар нутаг, баялагт тун харам нэгэн байсан бөгөөд цэрэг батлан хамгаалах салбарын хөгжлийг түргэтгэхэд тустай дорвитой төслүүдийг зоригтой хэрэгжүүлэх алхмуудыг хийж байсан төр, нийгмийн тулхтай, алсын хараатай цэргийн нэрт зүтгэлтэн байжээ.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Д.Гомбосүрэн. Зэвсэгт хүчний байгуулалтын түүх . XX зуун УБ.2011 он;
2. Майский. Монголия накануне революции. М., 1960;
3. З.Лонжид “Монгол Улсын санхүүгийн албаны түүх” УБ.,1999. “Түүх сөхөхүй” УБ.,2011;
4. Ж.Урангуа “XX зууны эхэн үеийн Монгол Улс” УБ., 2006. “Монголын тусгаар тогтнолд хаант Оросын үзүүлсэн хүчин зүйлс” УБ., 2010;
5. УТА, Ф-А4, Д.1, хн 136;
6. МУУТА. ХА-3, Д-1, ХН-293, Б.28;
7. МУУТА-ын ТБА. Сх-А5. Д-1. Хн-97. Нуг 1;
8. МУУТА. ХА-6, Д-1, ХН-513. Б.1;
9. МУУТА. ХА-7, ХН-1, Д-173. Б.1.

Уйгурын хотын байршил, тархалт, зохион байгуулалтын ОНЦЛОГ

Ц.Бямба-Эрдэнэ

ББХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, дэслэгч

Агуулга: Монголчууд улс гэрийн хэмжээний хот суурин байгуулахад бүү хэл, нэг өрх айл нутаг сэлгэн нүүдэллэхдээ хүртэл гэр орноо барих газрын байдлыг онцгой их шинжин үзэж байж бууриа сонгодог уламжлалтай ард түмэн юм. Уйгурчууд хот балгад барьж суурьшин суух талаар бусад нүүдэлчдээс нэлээд онцлогтой байлаа. Тэд манихейн шашныг дэлгэрүүлж согдын гар урчуудын туслалцаатайгаар энэхүү шашны сүм дугана барьдаг байжээ. Уйгурууд дөрвөлжин шавар хэрэмт бэхлэлт хотуудыг их барьдаг ба хил хязгаарыг сэргийлэн хамгаалах бэхлэлт хотын бүхэл бүтэн сүлжээ бүрэлдэн тогтсон байжээ. Ялангуяа хил хязгаараа умар зүгээс сэргийлэн хамгаалах нумарсан хэлбэрт их бэхлэлт хэрэм, түүний бүрэлдэхүүнд олон тооны шивээ цайзыг оруулан барьсан байжээ. Энэ их хэрмийн дагуух хилийн 17 бэхлэлт цайзыг Тува улсын нутагт илрүүлэн судалсан байна. Бэхлэлт хотуудын зарим нь засаг захиргааны төвийн үүрэг ч гүйцэтгэж байжээ.

Түлхүүр үг: Уйгурын улс, хот суурин, хотын зохион байгуулалт, Хар балгас

Монголчууд улс гэрийн хэмжээний хот суурин байгуулахад бүү хэл, нэг өрх айл нутаг сэлгэн нүүдэллэхдээ хүртэл гэр орноо барих газрын байдлыг онцгой их шинжин үзэж байж бууриа сонгодог уламжлалтай ард түмэн юм. Тухайлбал, малчид буурь сэлгэн нүүдэллэхдээ, тухайн газар орноо бусдаас илүү сайн мэдэх өтгөс хөгшидөөсөө хаагуур нутаглах, хаана буувал зохимжтой болох зэргийг асуун зөвлөлдөж, хөгшдийн зааж зөвлөсөн мал ахуйдаа таацуулсан бэлчээр нутгийг сонгох буух бөгөөд “нүүхийн өмнө бэлчээрээ сонго, буухын өмнө бууриа хар” гэдэг үгээр тэр өрхийн тэргүүлэгч буюу эсвэл түүний ахмад хүү нарын хэн нэг нь шинэ бууцанд дөхөж очихын өмнө юмуу, үгүй бол нүүхээс хэд хоногийн өмнө тэрхүү заасан нутагт урьдаар очиж, өөрийн гэрийн шинэ буурийг сонгодог байна. Ийнхүү гэрийнхээ шинэ буурийг сонгохын тулд, гэрийн эзэн хүн нутаг харахаар явж, сонгосон газраа дугуй зураад, өвс, чулуу тавьж гэрийн “он” авдаг ёстой ажээ.¹

Монголын нүүдэлч малчид тийнхүү гэрийн буурь сонгохдоо цаг

¹ Эрдэнэбат У. Монголын хот суурины хоёр шинж. Археологийн судлал. Том XV. Fasc 11. УБ., 1995. 112-р тал

улирлын байдлаас шалтгаалан хэдийд, хаана, ямар газар буухаа шийдэх бөгөөд тухайн газар орны орчин тойрон, тухайлбал, уул, ус, өвс ургамал зэргийг нь нарийн ажиглан шинждэг байв.

Үүний нэгэн адил хот, барилгыг барьж байгуулах хамгийн тохиромтой буурийг олоход шинжээч нар тухайн газарт дараах шинж тэмдгүүд буй эсэхийг ихэд анхааран шинждэг байв. Үүнд: сүмийн хойт талд өндөр уулс, урд талд дов гүвээ, болдог толгой байх ба сүмийн баруун зүүн хоёр биеэр урсаж өмнө талд нь нийлэх хоёр гол байх, мөн энэ хөндийн төв хэсэг нь хад нуга хосолсон хотгор гүдгэр буюу үүгээрээ бөөн овоолсон үрийг санагдуулам, харин доод хэсэг нь зөрүүлсэн алга мэт байх ёстой бөгөөд хот байгуулах газрын зүүн талд уудам тал, өмнөд биед уул толгод, баруун талд эгц бөмбөгөр толгод, хойт талд татсан хөшиг мэт уул байх энэ дөрвөн шинжийг эрхэм болгож байжээ.²

Уйгурууд ч хот балгадыг барьж байгуулахдаа эдгээр зарчмыг баримталж байсан бололтой харагддаг. Тухайлбал, Уйгурын нийслэл Хар балгас хот Орхон Жирмэнтү хоёрголын бэлчирт, Чилэн балгас Орхон болон хөгшин Орхон хоёр голын бэлчирт, Бийбулагийн балгас Сэлэнгэ мөрний хөвөөнд, мөн ОХУ-ын Тува улсын нутагт орших Пор Бажийн хэмээх хотыг Тэр хол хэмээх нууран дээр байгуулсан нь эртний монголчууд хот балгад барихдаа уул, усыг онцгойлон анхаарч байсны илрэл гэлтэй.

Монгол улсын нутаг дэвсгэрээс илрэн оллоод байгаа Уйгурын үед холбогдох хотууд нь манай улсын төв, умард хэсгээр тархсанаас гадна өнөгийн ОХУ-ын Тува улсын нутгаар тархжээ. Энэ нь уйгуруудын төрөлх нутаг буюу Сэлэнгэ мөрний сав хийгээд хожим Түрэг улсыг эзлэн авч тэдний газар нутагт өөрсдийн хот суурингуудыг цогцлоон байгуулсан Орхон голын сав нутаг юм. Өөрөөр хэлбэл Уйгурын үед холбогдох хот балгад нь манай орны төв хэсэг буюу Орхон, Сэлэнгийн сав нутгаар тархжээ. Эдгээрийг дурьдвал: Архангай аймгийн Хотонт сумын нутаг Орхон, Жирмэнтэй голын бэлчирт орших Хар балгас, Булган аймгийн Сайхан сумын нутаг Сэлэнгэ мөрний хөвөөнд орших Бийбулагийн балгас³, Архангай аймгийн нутагт орших Цагаан сүмийн балгас, Өгийнуур сумын Өгийнуур багийн нутаг Орхон, Хөгшин Орхон хоёр голын хоорондох уудам цалгай хөндийн умард үзүүрт орших Чилэн балгас зэрэг хотуудыг дурьдаж болох ба сүүлийн үед зарим судлаачид Төв аймгийн Заамар сумын нутаг Туул голын хойд биед орших Хэрмэн дэнжийн балгас, Өвөрхангай аймгийн Хужирт сумын нутаг Хадны гол, Бургасны голын бэлчирт, Хадны голын зүүн дэнж дээр орших Бургасны хөндийн дөрвөлжин, Архангай аймгийн Өгийнуур сумын Тоглох багийн нутаг Хөх эрэг хэмээх газарт орших Хөх эргийн балгас, Архангай аймгийн Хотонт сумын Орхон багийн нутаг Гээг бүрд хэмээх жижиг нуурын баруун этгээдэд орших Гээг бүрдийн балгас⁴ зэргийг Уйгурын

² Мөн тэнд. 117-р тал

³ Баяр Д. Уйгурын Байбалык хотын тухай тэмдэглэл УБ., 2003. (Д.Баяр Монголын дундад зууны археологийн судалгаа, Бүтээлийн чуулган дэд боть 366-385-р тал)

⁴ Очир А, Эрдэнэболд Л, Уртнасан Э. Сүүлийн үед шинээр олдсон эртний хэдэн балгасны тухай.

үед холбогдуулан үзэх санал дэвшүүлсэн байна. Эдгээрээс Уйгур улсын нийслэл асан Ордубалык буюу нутгийнхны нэрлэж заншсанаар Хар Балгас хотын талаар авч үзье.

Хар балгас. Монгол Улсын төв хэсэгт орших Хангайн уулсын зүүн бэлээс эх авч урсах Орхон гол Архангай аймгийн Хотонт сумын нутгийг дайран хойшоо эргэж урсах ба түүний үзэсгэлэнт сайхан хөндийд алсаас бараантан харагдах хуучин сүрлэг том балгасыг нутгийнхан Хар Балгас гэдэг. Энэ бол Төв Азийн нүүдэлчин ард түмний дунд VIII-IX зууны үед төр улсаа байгуулан 100 орчим жил өнөөгийн Монголын хөрс шороон дээр оршин тогтнож байсан Уйгурын хаант улсын сүр жавхлантай нийслэл Ордубалык хэмээх их хотын нуранхай билээ.

Түүх сударт өгүүлж байхаар, 744 онд Уйгурын Яглагар овгийн Хиосу ноёны хөвгүүн Күл-Билгэ Түрэг улсын хааны цэргийг бутцохиж Уйгурын төр гүрнийг байгуулаад удалгүй 744 / 745 оны үес энэхүү хотын үндэс суурийг тавьсан гэх бөгөөд түүний хөвгүүн “Тэнгэрээс заяат төр засагч мэдэлтэй хаан” хэмээн алдаршсан Бугу чур 751 онд Түрэгийн хуучин нутаг Орхон Жирмэнтү хоёрын бэлчирт их нийслэл хотоо цогцлон байгуулж, төрийн өргөө, төрийн яам хоёр байгуулагдав хэмээжээ⁵.

Дундад улсын түүхийн мэдээнд: “Тянь Баогийн эхэн (751) оны үед Уйгурын Пэй-ло хааны өргөө орд У-тэ-цзянь (Этүгэн) уул, Хун (Орхон) голын хооронд нүүж буув. Түүний зүүн этгээд тэгш тал газар болно. Баруун этгээд Ү-тэ-цзянь уулаар, умар этгээд 600 ли (газар) хол Сянь-э (Сэлэнгэ) голоор савлана” гэсэн байдаг. Үүнээс үндэслэн, Хар Балгас анхан Орхоны хөндийд байгуулагдаагүй, харин есөн овгийн Уйгурын уг нутаг Сэлэнгэ хавь нутгаас хожим тэнд нүүж очсон бололтой гэсэн саналыг Х. Пэрлээ нарын эрдэмтэд дэвшүүлжээ.⁶

VIII зууны дунд үед Уйгур улс хүчирхэгийнхээ туйлд хүрсэн бөгөөд Алтайн уулсаас Хянган, говиос Саяны уулсын хоорондох нутгийг эзлэх болжээ. Хөрш орнуудтай эдийн засаг, соёлын харилцаа өрнүүлж, ялангуяа согд, хятад урчуудын хүчийг ашиглан хот суурин барьж байв. 821 оны үед Хар Балгасыг араб хүн Тамим ибн Бахр аль-Муттави “хаадын хот” хэмээн нэрлэж баян тансаг, үзэсгэлэнт сайхан хот гэж тодорхойлсон байдаг. 840 оны үед уг хот Енисеймөрнөөс ирсэн Киргис аймгийн довтолгоонд өртөж галдан шатаагджээ. Энэ тухай Финландын нэрт монголч эрдэмтэн Г.И. Рамстедт 1922 онд туурвисан “Уйгур улсын хураангуй түүх” зохиолдоо: “Сэлэнгэ Орхоны орчимд үлдсэн уйгур нь найман зуун дөчдүгээр (840) онд баруун хойно нутагтай киргисийн довтолгоонд алагдаад талагдаад цөөхөн болсноос гадна ноёд ч үгүй хоцорвой. Хойд Уйгурын ноёдын уг тасарсан энэ. Орхоны Хар Балгасун эвдэрхий болсон нь энэ. Үзэмжит бичигт олон хөшөө, чулууны хамхархай

Нүүдэлчдийн өв судлал. Том XIV, fasc I-43: УБ., 2013. 112-116-р тал

⁵ Рамстедт Г.И. Уйгур улсын түүхийн товч. УБ., 1922 ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг. Ф. IV., ХН. 16, Т. 56 (Кирилл бичигт сийрүүлсэн У. Эрдэнэбат. 1994 оны 10 дугаар сарын 20-ны өдөр. Улаанбаатар хот.) 7-р тал

⁶ Пэрлээ Х. БНМАУ-ын хот суурины товчоон. УБ., 1961. 50-р тал

болсон учир энэ. Хиргис улс нь бичиг ч үгүй, шашин ч үгүй мунхаг улс байсны тул хиргисийн хаадын нэр бичигдсэн газар нэг ч үгүй. Босгосон сайхан сүм суварга ч үгүй. Харин Уйгурын байгуулсан сүмэсийг эвдэж, сүмэст хураагдсан ном судрыг түймэрдүүлээд явсан улс бөлгөө”⁷.

Орхоны эвдэрхий Хар Балгасын үлдэгдлийг дэлхий дахины эрдэмтэд эртний судлалын үүднээс сонирхон шинжлэх болсон нь Монгол орны археологийн дурсгалын судалгааг эхлүүлсэн XIX зууны сүүл үест холбогдох юм. Энэхүү хотын ор үлдэгдлийг анх удаа шинжлэх ухааны зорилгын үүднээс тодорхойлсон хүн бол тухайн үеийн Монголын Нийслэл Хүрээнд сууж байсан Оросын Консулын газрын төлөөлөгч И.В. Падерин гэгч байв. Тэрбээр 1873 онд Монголын эртний нийслэл Хархорум хотын ор турийг эрж олох зорилго агуулан эртний түүх дурсгалаар нэн баялаг Орхоны хөндийгөөр аялахдаа Хар Балгас зэрэг эртний дурсгалт хотуудыг үзэж, эдгээрийн түүх намтар, хэн хэзээ үүсгэн барьсан болох талаар нутгийн ард түмний ярьж хэлэлцдэг домог яриа тэргүүтнийг тэмдэглэн авч бичгийн түүхийн сурвалжийн мэдээ, жуулчдын тэмдэглэлтэй харьцуулан түүхэн үнэнийг тогтоохыг зорьжээ. Падерин Хар Балгасыг нутгийнхан «Хар Хэрэм» хэмээн нэрлэдгийг анхааралдаа авч, энэ нь Хархорум хотын нэрийн сунжирсан дуудлага хэмээн үзэж Орхоны хөндийд байх энэхүү эртний хотын үлдэгдэл нь Их Монгол улсын нийслэл Хархорум хотын ор үлдэц мөн гэж үзсэн байна.

1889 онд Монголын төв нутаг Орхоны хөндийгөөр голлон судалгаа хийсэн Оросын эрдэмтэн Н.М. Ядринцев энд хүрэлцэн иржээ. Ядринцев тухайн жил Нийслэл Хүрээнээс Эрдэнэ Зуу орох замдаа Хар Бухын балгас орчимд Загастын хөндий, Хэрмэн хөндий нэртэй газарт эртний хэрмийн үлдэгдэл, эндээс холгүй Туул голын хөвөөн дэх Цогтын цагаан байшин, Өгий нуурын ойр байх Чилэнгийн балгас, Цагаан нуурын хөвөөнд байх Дойтын балгас, Уйгурын нийслэл Хар Балгас, Цагаан сүм, Хөх сүмийн балгас хэмээх дурсгалууд болон Эрдэнэ Зуу хийдийн дэргэд орших эртний хотын турийг үзэж сонирхон, тэндээс авчирсан гэрэлт хөшөө зэрэг эртний дурсгалт зүйл олноороо Эрдэнэ Зуу хийдийн дотор хадгалагдаж байгааг гол баримт болгон Их Монгол улсын нийслэл чухам тэнд оршиж байсныг газар дээр нь нягтлан шалгаж тодруулсан юм.

1891 оны 7 сарын 16-нд герман гаралтай, Оросын түрэг судлаач эрдэмтэн Вильхельм Радловын удирдсан шинжилгээний анги Хар Балгасанд хүрэлцэн иржээ. Экспедицийн гишүүдэд их хотын ор үлдэгдэл гүнзгий сэтгэгдэл төрүүлсний адил юуны өмнө тэнд байсан хагархай чулуун хөшөөний бичээсийг шинжлэх ухааны үүднээс онцгойлон сонирхож байв.

Японы эрдэмтэн Отани 1908 онд Бээжингээс Өргөө, Эрдэнэ Зуу, Улиастай, Шинжааны чиглэлээр аялан явахдаа Орхоны хөндий дэх Хар Балгасыг үзэж гэрэлт хөшөөний бичээсийг онцгой сонирхсон байна.

⁷ Рамстедт Г.И. Уйгур улсын түүхийн товч. УБ., 1922 ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг. Ф. IV., ХН. 16, Т. 56 (Кирилл бичигт сийрүүлсэн У. Эрдэнэбат. 1994 оны 10 дугаар сарын 20-ны өдөр. Улаанбаатар хот.) 7-р тал

Энэ тухай тэмдэглэлийг Отанигийн шинжилгээний ангийн гишүүн Номура, Тачибана нар хожим 1937 онд “Шин сай ки (Шинэ баруун газрын тэмдэглэл)” хэмээх хоёр боть номдоо хэвлүүлсэн байдаг. Тэнд бичсэнээр, 1908 онд Отаниг очиход Хар Балгасын гэрэлт хөшөөний 37 хагархай байсан ажээ. Номура, Тачибана нарын хэвлүүлсэн Отанигийн экспедицийн тэмдэглэл нэг нэгийгээ нөхөж өгөх бөгөөд Орхоны хөндийн эртний түүх, соёлын дурсгалын судалгаанд чухал баримт болох юм.

1909 онд Францын офицер Анри де Лякост гэгч засгийн газрынхаа зардлаар Хиагт-Өргөө-Эрдэнэ Зуу-Сайд вангийн хүрээ-Ховд гэсэн маршрутаар аялан явж Монгол орны хуучны дурсгалт зүйлсийг хайн сурвалжилж явахдаа Орхоны хөндий дэх Хар Балгасанд хүрэлцэн очиж уг хөшөөний бичээсийн хэв дардсыг хуулж авсныг хожим Жеймс Рассель Хамильтон судлаж 1990 онд нийтлүүлсэн байна.

1892 оны зун Австрийн эрдэмтэн Ханс Ледер Монголын **төв нутгийн хуучны** дурсгалт зүйлсийг үзэж аялан явахдаа Эрдэнэ Зуугаас баруун хойш 25 км зайтай орших, нутгийнхны Хар Балгас хэмээн нэрлэдэг эртний хотын үлдэгдлийг сонирхож тодорхойлсон байна. Тэрбээр энд мод, чулуугаар хийсэн барилгын материал ховор байснаас болж хотын ихэнхи оршин суугчид гэр асар хэрэглэн сууж байсан болов уу, бас худаг ухаж байсан ул мөр ер үзэгдэхгүй тул тэд хэрэгцээний усаа Жирмантайн голоос татсан сувгаас авч байсан байх, мөн хотын оршин суугчдын булш оршуулгын газар хаа нэгтээ ойролцоох ууланд бий болов уу гэх зэрэг олон сонирхолтой таамаглал дэвшүүлсэн юм. Тэрбээр Уйгурын хааны ордон байсан гэх цайзат хэрмийн үлдэгдлийг хааны ордон гэхээсээ илүүтэй бурханы шашны сүм байсан газар хэмээн үзсэн бөгөөд уйгурууд нэлээд дээр үех энэхүү шашныг хүлээн авсан сүсэгтнүүд байсан баримтыг дурджээ. Ледер хотын усны хангамж хийгээд хамгаалалтын хэрэм далангийн зохион байгуулалт, тэрчлэн гурван хэлээрх бичээстэй хөшөөний үлдэгдлийг ихэд сонирхож байсан авч өөрийг нь ирэхээс нэг хоёр жилийн өмнө Финляндын археологич, доктор Хайкель, Санкт-Петербургийн академич В. Радлов нар эрдэм шинжилгээний зорилгоор энд ирснийг мэдэж байсан тул тэдний бүтээлийг хүлээж буй тухайгаа дурдаж, судалгаагаа үүгээр хязгаарласан байна. Мөн тэрбээр энд харийн хүн байтугай нутгийн хүн байлаа ч гэсэн ямар нэг байдлаар газар ухаж сэндийчихийг огт таашаадаггүй тул шинжлэх ухааны зорилгоор малталт хийнэ гэдэг энэ оронд боломжгүй зүйл хэмээн бичиж байжээ.

Хар Балгасын ор үлдэгдлийн талаарх археологийн шинжилгээний хамгийн анхны нарийвчилсан тодорхойлолтыг хийсэн судлаач бол Д.А. Клеменц юм. Тэрбээр энэхүү судалгаагаа 1895 онд “Орхоны шинжилгээний ангийн” цуврал бүтээлийн хоёр дахь ботид нийтлүүлжээ. Түүний хийсэн энэ тодорхойлолт саяхан болтол Хар Балгасын үлдэгдэлд хийсэн хамгийн дэлгэрэнгүй тодорхойлолтын нэг байсан юм.

Польшийн нэрт монголч эрдэмтэн Владислав Котвичийн удирдсан шинжилгээний анги 1912 онд Монголын төв нутаг Орхоны хөндийд судалгаа шинжилгээ хийсэн билээ. Экспедицийн бүрэлдэхүүнд буриад

эрдэмтэн Ж. Цэвээн, түүний сургуулийн анд, Троицкосавск хотноо сууж байсан орос археологич К.А. Масков нар хамтран ажиллажээ. Тэд гол судалгаагаа Бичигтэй Улаан хад, Их Хөшөөт, Эрдэнэ Зуу, Хөшөө Цайдам зэрэг газар төвлөрүүлэн бичээс судлалын чиглэлээр түлхүү ажилласан байдаг.

БНМАУ-ын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн урилгаар уригдан ирсэн Зөвлөлтийн эрдэмтэн Д.Д. Букинич 1933-1934 онд Монголын төв нутгаар аялж олон чухал судалгаа хийсэн бөгөөд Букинич 1933 онд Хар Балгасын үлдэгдэл дээр 7 цооног малтсан бөгөөд нийт 4,48 куб. метр хэмжээтэй болсон ажээ.

Зөвлөлтийн археологич, профессор Сергей Киселевын удирдсан Монгол- Зөвлөлтийн шинжилгээний анги 1948-1949 онд Монгол оронд явуулсан археологийн судалгааныхаа нэгээхэн хэсгийг Хар Балгасын үлдэгдэл дээр хийсэн юм.

1976 ба 1979 оны зун археологич Д. Цэвээндорж, Ю.С. Худяков нар Хар Балгасын үлдэгдлийг шинжин үзэж, гол хэрэмт байгууламжийн тойм зураглал хийсний зэрэгцээ шавар вааран эдлэл голдуу түүвэр олдвор цуглуулсан байна. «Энэ судалгааны ажлын үр дүнд 1982 онд монгол, орос хоёр эрдэмтний хамтран бичсэн “Ордубалькийн керамик”, 1990 онд Ю.С. Худяковын “Монгол дахь Уйгурын соёлын дурсгалууд” хэмээх бэсрэг өгүүлэл нийтлэгджээ.

МЗСТХЭ-ийн ид ажиллаж байх үед хийсэн чухал нээлтийн нэг бол эрдэмтдийн дунд Хар Балгасын хоёрдугаар түрэг бичээс хэмээн нэршсэн хөшөөг олж судалсан явдал бодно. Энэ дурсгалыг Хар Балгасын их хэрмээс хойш 8 км-т орших Жирмэнтү голын зүүн эргээс анх 1973 онд Архангай аймгийн Хотонт сумын сургуулийн багш Мягмаржав олж сургуулийнхаа урд талбайд босгосныг 1975 онд МЗТСХЭ-ийн Бичээс судлалын хэсгийнхэн руни бичээстэй болохыг тодруулан мэдсэн бөгөөд 1976 онд Улаанбаатар хотноо ШУА-ийн археологийн лабораторид авч ирсэн байна.

Дашрамд дурдахад Хар Балгас орчмоос үүнээс өөр бичээст хөшөө нэг бус удаа олдож байсан аж. Тухайлбал: 1975 онд Архангай аймгийг Хотонт сумын малчин ард Ц. Балдан Хар Балгасны баруун урд хэсэгт өндөр хэрмээс 500 м орчим зайд тариа тарихаар хагалсан талбайгаас хятад бичигтэй жижиг хөшөө олж улмаар өөрийн нутгийн хүн болох Гандантэгчилэн хийдийн Соён-Нямбуу ламд өгснийг нь 1976 оны 2 сард ШУА-ийн мэдэлд шилжүүлэн авсан байна. Энэ олдвор өдгөө Улаанбаатар хотод Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалаглаж байгаа.

Монгол Германы хамтарсан Орхон экспедиц (MONDOREX) Хар балгаст 2007 оны зун агаарын лазер сканн буюу Airborne Laserscanning (ALS) ба LIDAR (Light Detection and Ranging) хэмээх аргаар нисдэг тэргэнд байрлуулсан лазерийн төхөөрөмжийн тусламжтай хэмжилт хийж эртний хотын өндөр нарийвчлалтай зургийг шинээр хийжээ. Судалгаанд Хар Балгасын төв хэсэгт буй 360 х 404 м хэмжээтэй, зарим газраа 10

гаруй м өндөр, дундаа нүсэр том суварганы үлдэгдэл бүхий их хэрэмт байгууламж, түүний эргэн тойрон дахь суурин амьдралын ул мөрийг хадгалсан 43 километр ам дөрвөлжин газар хамрагджээ.⁸

2009-2019 оны хооронд Монгол Германы хамтарсан Орхон экспедици Хар балгас хотын дэвсгэрт 6 газар малтлага судалгаа хийж байна.

Дүгнэлт

Уйгурууд дөрвөлжин шавар хэрэмт бэхлэлт хотуудыг их барьдаг ба хил хязгаарыг сэргийлэн хамгаалах бэхлэлт хотын бүхэл бүтэн сүлжээ бүрэлдэн тогтсон байжээ. Ялангуяа хил хязгаараа умар зүгээс сэргийлэн хамгаалах нумарсан хэлбэрт их бэхлэлт хэрэм, түүний бүрэлдэхүүнд олон тооны шивээ цайзыг оруулан барьсан байжээ. Энэ их хэрмийн дагуух хилийн 17 бэхлэлт цайзыг Тува улсын нутагт илрүүлэн судалсан байна. Бэхлэлт хотуудын зарим нь засаг захиргааны төвийн үүрэг ч гүйцэтгэж байжээ. Эдгээр нь суурин амьдралын төв болж газар тариалан, гар урлал, худалдаа наймаа цэцэглэн хөгжиж байжээ.⁹

ОХУ-ын Тувад судалсан Уйгурын хот сууриныг Ю.С. Худяков хамгаалалтын байгууламжуудын хувьд:

1. нэмэлт бэхэлгээгүй энгийн бүтэцтэй (Бай-Балык, Бажы-Алаак, Шагонарын 3-р)
2. нэмэлт бэхэлгээтэй, нарийн бүтэцтэй (Пор-Бажын, Орду-Балык) гэсэн үндсэн хоёр хэлбэрт хуваан үзэх санал дэвшүүлжээ¹⁰.

Гэвч Уйгурын сүм хийдийн болон иргэний архитектурын онцлогуудыг одоохондоо гүйцэд судлаагүй байна. Монголын газар нутаг дээрх Уйгурын хот суурин, хэрэм цайзийн доторхи барилга байгууламжийг бараг малтан судлаагүй байсаар байна.

Иймээс Уйгурын зан үйлийн болон иргэний уран барилгын зөвхөн зарим онцлог шинжийг тэмдэглэвэл: сүмийн цогцолборын суурь болгож довжоо байгуулдаг, барилгуудын тэгш өнцөгт төлөвлөлт, боржин суурин дээр модон багана босгодог, шатаасан тоосгоор хана босгодог, дээврийг шатаасан вааран хэсгүүдээр бүрхдэг бөгөөд нүүрийг нь хээлж чимэглэхийн хажуугаар будаж өнгөлөх нь бий зэрэг болно. Үүнтэй ижил барилгын арга, архитектурын хэсгүүдийг уйгурчууд Тувагийн ордон, сүм хийдийн цогцолборууд, үүний дотор юуны өмнө Пор-Бажыний хэрмийн ба ордны барилгад ашигласан байна.

Уйгурын бэхлэлтийн хамгийн чухал онцлог шинж нь хананы дагуу болон булангийн цамхагууд, цайзын дөрвөлжин хэлбэрийн зохион байгуулалт, аль нэгэн ханын төв хэсэгт хаалгатай байх зэрэг болно. Төв Азийн дундад зууны байлдааны бэхлэлтийн хувьд ховор тохиолддог онцлог нь хэрмийн хананы буланд барьсан бастион, форт, цитадель

⁸ Эрдэнэбат У. МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн салбарын оюутны 2013 оны зуны археологийн хээрийн шинжилгээний дадлагын тайлан. МУИС-ийн ШУС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн гар бичмэлийн сан хөмрөг. УБ., 2013. 5-19-р тал

⁹ Цэвээндорж Д, Баяр Д, Цэрэндагва Я, Очирхуяг Ц, Монголын археологи. УБ., 2002. 93-р тал

¹⁰ Ю.С.Худяков. Монгол дахь Уйгурын соёлын дурсгалууд. Төрбат Ц, Батбаяр Т. Монголын археологи, эртний түүхийн сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн. Улаанбаатар, 2009.

зэрэг юм. Хана дагуу сумны дусгалын хэмжээнд байрласан цонж, бастион, форт, цитадель зэрэг нь удаан хугацааны хориглолт хийх боломжийг нэмэгдүүлсэн байна. Энэ бүгд нь Орду-Балыкийн цайзыг Төв Ази дахь дундад зууны үеийн хамгийн боловсронгуй цэрэг-инженерийн байгууламжийн мөн гэж дүгнэхэд хүргэж байна.

Монголын төв нутаг Орхоны хөндийн Хар балгас (Ордубалык) болон Сэлэнгэ мөрний хойд эрэг дэх Бийбулагийн (Байбалык) балгасны зохион байгуулалтын онцлогийн хувьд, Орду-Балыкийн хамгаалах байгууламжийн систем, тухайлбал, өнцөгийн ба ханын цамхагууд бүхий хэрэм нь Монгол болон Тувагийн бусад Уйгарын хотуудын хийцтэй ойролцоо байна. Үүнд: Бай-балык, Пор-Бажын, Бажын-Алаак, Шагонарын гуравдугаар хэрэм зэрэг орно. Түүний хажуугаар дээрх дурсгалуудаас илүү нарийн түвэгтэй бөгөөд өөрийн хэв шинжтэй байгаагаараа нэлээд их ялгаатай байгаа билээ. Бастион, форт, хэрмийн өнцөгт байгуулсан цитадель, дотоод гуу суваг, хаалганы өмнөх давхар гуу суваг, донжон-цонжууд зэрэг нь нийслэлийн хэрмийг Уйгурын бусад бэхлэлт цайзаас ялгаруулж байжээ. Эдгээр ялгаанууд нь хаант улсын нийслэлийг хамгаалах ач холбогдлоос шалтгаалжээ.

Байбалыкийн байлдааны бэхлэлтийн систем нь хана болон цамхагийн төлөвлөлтөөрөө Уйгарын хамгаалалтын байгууламжийн бусад дурсгалуудтай адил төстэй байна. Энэ нь Орду-Балык ба Пор-Бажыны хэрэмнээс нилээд энгийн, харин Бажын-Алаак болон Шагонарын 3-р цайзтай ойролцоо юм.

Бай-Балыкийн хэрмийн хаалганы байгууламжийн бүрэлдэхүүнд орсон баганы боржин сууриуд нь цилиндр хэлбэртэй, 35-50 см диаметртэй. Энэ нь хэрмээс 12-20 см өндөр цухуйжээ. Сууриудын гадаргуу нь өө сэвгүй тэгшхэн, зөвхөн ганц дээр нь радиаль зураас татсан судалтай. Модон багана суулгах углуурга нь цилиндр, цилиндр гүнтэй тэг дарвалжин, тэг дөрвөлжин гүнтэй цилиндр зэрэг хэлбэртэй байна.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Баяр Д. Уйгурын Байбалык хотын тухай тэмдэглэл УБ., 2003. (Д.Баяр Монголын дундад зууны археологийн судалгаа, Бүтээлийн чуулган дэд боть)
2. Очир А, Эрдэнэболд Л, Уртнасан Э. Сүүлийн үед шинээр олдсон эртний хэдэн балгасны тухай. Нүүдэлчдийн өв судлал. Том XIV, fasc I-43: УБ., 2013. 112-116-р тал
3. Пэрлээ Х. БНМАУ-ын хот суурины товчоон. УБ., 1961. 50-р тал
4. Рамстедт Г.И. Уйгур улсын түүхийн товч. УБ., 1922 ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг. Ф. IV., ХН. 16, Т. 56 (Кирилл бичигт сийрүүлсэн У. Эрдэнэбат. 1994 оны 10 дугаар сарын 20-ны өдөр. Улаанбаатар хот.) 7-р тал
5. Худяков Ю.С., Монгол дахь Уйгурын соёлын дурсгалууд. Төрбат Ц, Батбаяр Т. Монголын археологи, эртний түүхийн сургалт,

судалгааны хэрэглэгдэхүүн. Улаанбаатар, 2009.

6. Цэвээндорж Д, Баяр Д, Цэрэндагва Я, Очирхуяг Ц. Монголын археологи. УБ., 2002. 93-р тал
7. Эрдэнэбат У. МУИС-ийн НШУС-ийн Археологи-Антропологийн салбарын оюутны 2013 оны зуны археологийн хээрийн шинжилгээний дадлагын тайлан. МУИС-ийн ШУС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн гар бичмэлийн сан хөмрөг. УБ., 2013. 5-19-р тал
8. Эрдэнэбат У. Монголын хот суурины хоёр шинж. Археологийн судлал. Том XV. Fasc 11. УБ., 1995. 112-р тал

Юань улс Корёгийн улс төрийн дотоод хэрэгт нөлөөлсөн нь

Г.Балжинням

ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн ЭЗМТ-ийн багш,
доктор (PhD)

М.Баярмаа

ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн ЭЗМТ-ийн багш,
докторант

Abstract

The Yuan influence the internal political affairs of Koryo Summary
The political relations between Yuan and Koryo were between 1260 and 1368. Under the influence of the Yuan Dynasty, military monarchy had lost its power over the 100-year rule of Koryo. Got chance to develop civil oriented governance. According to Korean historians, the Koryo period was greatly developed relay post system due to the Yuan demand added Mongolian style system to current system. At that time, the period of warfare like relationship was changed and the political relationship was stabilized.

Key words: Yuan, Koryo governance, political internal affairs.

Удиртгал

Чингис хааны үед бүрэлдэн тогтсон үндэсний эрх ашгийг дээдлэх бодлогыг Хубилай хаан дэлгэрүүлэн хөгжүүлсэн.^[1] 1260-аад онд Их Монгол улсын гадаад, дотоод улс төрийн байдал үлэмж ихээр өөрчлөгдсөн. 1259 онд Корё улс Их Монгол улсад дагаар орж, 1260 оны 4 сард Корё улсын ван “Тэнгэрийн зарлигийг хүлээж сууринаа заларсан таны ивээл нигүүсэлд бид багтах болно” хэмээн дагаар орсноо Их хаанд бичгээр мэдэгдсэн байдаг.^[2]

Юань улс-Корё улсын улс төрийн харилцаа Их Монгол улс-Корё улсын үеийнхээс шинэ агуулга, хэлбэрээр хөгжсөнөөрөө онцлогтой.

¹ Ж.Ганболд, Т.Мөнхцэцэг, Д.Наран, А.Пунсаг. Монголын Юань улс.2006. Улаанбаатар.129 дэх тал

² Тэнд 132 дахь талд

Ж. Бор. Гуулин улсын судар. Монгол хийгээд Евроазийн дипломат шастир. 2004. УБ. 694 дэх тал

Энэ нь:

1. 2 улсын хооронд 30 шахам жил үргэлжилсэн дайны эцэст улс төрийн харилцаа хэвийн болж, улмаар ойртон нягтруулж өгсөн.
2. Хэд хэдэн улс үндэстнийг хамарсан Монголын төв засаглалт олон талын харилцааны нэгдсэн дэг журам Корё улсад тогтож эхэлсэн.
3. Монголын хаадын алтан урагт Корё улсын вангийн удмынхны цус холилдох хүртэл харилцаа туйлын ойртон нягтарсан.
4. Корё улсын тусгаар тогтнол тодорхой хэмжээнд хадгадагдаж үлдсэн. Энэ нь Юань гүрний улс төрийн бодлогод татагдан орж, улс төрийн дотоод бодлого нь зохицуулагдаж байсан ч вангийн засаглалт төр нь оршин тогтнож, улс орондоо засаглалаа тогтоож байсан.

Юань улс-Корё улсын дайн тулалдааны шинжтэй байсан улс төрийн харилцаа өөрчлөгдөх болсон шалтгаан нь хоёр орны дотоод, гадаад түүхэн нөхцөл байдал, өөрчлөлтөөс урган гарсан бөгөөд зөвхөн хоёр орны хоорондын харилцаа биш, тэр үеийн олон улсын харилцааны бүрэлдэхүүн хэсэг болж ирсэн түүхтэй.

Юань улс Корё улстай харилцахдаа уян хатан бодлого явуулж байсан бөгөөд улсын дотоод байдал, үндэсний онцлог зэргийг харгалзсан бодлого явуулж байсан нь тухайн улсын нутаг дэвсгэр, засан тохинох эрх мэдлийг хэвээр нь үлдээж, өөрийн төлөөний байгууллага буюу элч илгээх, мөн вангаар нь дамжуулан эрхшээлдээ байлгах, улс төрийн дотоод хэрэгт нь нөлөөлөх аргыг хэрэглэж байснаар тодорхойлогддог.

Юань улс Корё улсад эрх мэдлээ тогтоогоод, Өмнөд Сүн улсыг эрхшээлдээ бүрэн оруулсны дараа Япон улсыг дагаар оруулахад гол үйл хэргээ чиглүүлсэн. Юуны түрүүнд 1280 онд Корё улсад “Дорныг засан тохиноулах алба” нэртэй өөрийн харъяаны байгууллагыг Корё улсад байгуулсан байна. 1281 онд Япон улс руу довтолсон довтолгоон бүтэлгүй болж, энэ байгууллагыг татан буулгаад, 1285 онд дахин сэргээгдсэн. 1299 оноос гол гол албан хаагчдыг Юанаас томилон ирүүлж, уг байгууллагыг бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлснээр үндсэн үүрэг нь өөрчлөгдөн, Корё улсын дотоод хэрэгт оролцох, хяналт тавих үйл ажиллагаа эхэлсэн.

Энэ нь Корё улсын ван Чун Релийн монгол хатан Хутугбэх насан эцэслэж, ван өөрөө нас өндөр болсон, 1298 оноос хүү Чон Сонд эрх мэдлээ шилжүүлсэнтэй холбоотой. Чун Сон нас залуу, Хубилай хааны дэргэд амьдарч байсан бөгөөд ван болмогцоо Корёгийн дотоод дахь бүх шатны түшмэл, тайж ноёд, язгууртны зэрэглэл тогтоох, цол хэргэм хүртээх, дэвшүүлэх зэрэг удирдлагын хуучин тогтоцоог өөрчлөх, өмнөх вангийн тойрон хүрээлэгчдийг солих, газрын шинэтгэл хийх зэргээр шийдэмгий өөрчлөлт хийх гэсэн эрмэлзэл, түүнийг эсэргүүцсэн эсэргүүцэл, Монгол, Солонгос хоёр хатны зөрчил зэргийг дотооддоо зохицуулахад бэрх болсон учир Юань гүрний зүгээс зохицуулах шаардлага бий болсонтой холбоотой. Үүнийг Чун Сонгийн ван ширээг эцэг Чун Релд нь эргүүлж өгсөн явдал үүнийг гэрчилнэ.

Корё улсын улс төрийн дотоод хэрэгт Юань улс оролцсон нь

Юань улс нөхцөл байдлыг газар дээр нь шалгаж зохицуулахаар 1299 оны намар улс төрийн зөвлөх, баруун зүүн гарын болон бичгийн түшмэл зэргийг томилон Корё улс руу илгээжээ. Тэдгээр хүмүүс Корё улсын улс төр, нийгмийн тогтолцоог өөрчилж, угсаа залгамжлах, Юань улсын төрийн тогтолцоог нэвтрүүлэх, Корё улсын язгууртнуудын цол хэргэмийг Юанийхаас нэг шат бууруулж, вангийн бүх төрлийн арга хэмжээний цар хүрээг хумин багасгах, захиргааны байгууллага, элдэв ямбатны тоог цөөлөх, цомхотгох зэрэг арга хэмжээнүүдийг авахыг эрмэлзэж байсан. Гэвч ширүүн эсэргүүцэлтэй тулгарч, үйл ажиллагаа нь дахин нэр төдий болжээ. Ингээд Чун Соныг вангийн ширээнээс огцруулж, Юань гүрэн төлөөний хүмүүсээ эргүүлж татсан. Хутугбэхи хатны шадар бараа бологчоор очсон Хурудай, Цахуйдай, Сэнгээ нарын 5 хүнд Корё улсын ямбатны цол хэргэм ^[3] эдлүүлсэн зэрэг нь монгол хатан вангийн ордонд хэр их эрх мэдэл, нөлөөтэй байсныг харуулж байна. Юань улс-Корё улсын харилцааны түүхэнд монголын хаад ноёдын угсааны 8 хатан Корё улсын вангийн өргөөнд очсон баримт байдаг.^[4]

Корё улсын дотоод хэрэгт Юань улсын зохицуулалтын шаардлага гарах бүрд Юаний элч төлөөлөгчид уг төлөөний газарт очиж, түүний үйл ажиллагаа нь идэвхждэг байсан. Корё улсыг Юань улсын дотоод муж болгох гэсэн санал Солонгосчуудаас өөрсдөөс нь хэд хэдэн удаа гарч байсан нь Юань улсын талаас Корё улсын улс төрийн дотоод хэрэгт ямар нэг хэмжээгээр нөлөөлж байсныг харуулдаг.

Юань улс Корё улсын улс төрийн харилцаанд чухал байр суурь эзэлдэг нэг үйл явдал бол Самбёлчогийн тулалдаан юм. Энэ тулалдаанд Юань улс Корё улсын вангийн хүсэлтээр хязгаарлагдмал тооны цэргийн хүч оруулж, Корёгийн сөрөг хүчнийг дарсан нь Корё улсын вангийн засаглалыг бэхжүүлсэн байна.

Хоёр орны хооронд зуучлах нь олон улсын харилцааны түгээмэл хэлбэр бөгөөд холбоотон болж, цэрэглэн довтлох нь түгээмэл байдаг. Юань улс Корё улсыг Японд зуучлуулах бодлого баримталж байсан бөгөөд зуучлуулах ба довтлохдоо хүчээр шахам татан оруулж, нутаг дэвсгэрийн зарим газрыг цэргийн түшиц газар болгон ашигласан. Энэ нь Японы зүгээс Корё улсын аюулгүй байдалд заналхийлэх улс төрийн шалтаг болсон байна. Үүний зэрэгцээ “Хубилай хаан 1274, 1275, 1281 онд 3 удаа Японыг довтолжээ. 1274 оны довтолгоонд Монгол цэргийн дарга захирсан Хятад Солонгос 25000 цэрэг оролцсон гэдэг. Энэ дайны бэлтгэл болгож 1271-1274 он хүртэл Солонгосын 30000 хүний хүчээр том жижиг 900 усан онгоц хийлгэсэн байна. 1281 онд 4400 завь онгоц, 140000 их цэргийн хүчээр довтлох болж, Монголын цэргийн жанжин Алахан цэргийг ерөнхийлөн удирджээ. Японтой дайтах дайны түшиц газрыг Корё улсыг болгожээ...”^[5] хэмээн доктор Ч.Далай судлан тэмдэглэжээ.

³ Б.Лхагваа. Монгол, Солонгосын харилцааны уламжлалаас. 1996.УБ. 129 дэх тал
Ж.Ганболд, Т.Мөнхцэнэг, Д.Наран, А.Пунсаг. Монголын Юань улс.2006. Улаанбаатар.133 дахь тал

⁴ Б.Лхагваа. Монгол, Солонгосын харилцааны уламжлалаас. 1996.УБ. 129 дэх тал

⁵ Ч.Далай. Монголын түүх. 1260-1368 он. 3-р дэвтэр. УБ. 1992 он

Корё улсын ванг хатадаар нь дамжуулж, Юань улсын бодлогыг тулган хүлээлгэх шинжтэй хандлага нэлээд их байсан нь Корё улсын улс төрийн дотоод хэрэгт Юань улс нөлөөлж байсныг нотолдог. Тус улсын улс төрийн дотоод хэрэгт оролцож байсан тохиолдлуудын дотроос Самбёлчогийн тулалдаанд Юань улс оролцсон хийгээд Япон улс руу довтлоход Корё улсыг дайчилсан нь дам биш шууд шинжтэй байв. Хубилай хаан 1262 онд Корё улсын тусгаар байдлыг хүндэтгэхийг, Япон улс руу довтлоход Корё улсыг дамжих цэргүүдэд “Солонга улсын замаар одоходоо Солонга улсын иргэнийг бүү хөнд”^[6] хэмээн онцлон анхааруулсан, Тогоонтөмөр хаан Корё улсын ван Ко Мин ванг огцруулах гэхэд Корё улс суудалд нь үлдээж өгөхийг хүссэнийг ёсоор болгосон зэргээс үзэхэд Юань улсын төрийн эрх баригчид Корё улсын улс төрийн дотоод хэрэгт оролцдог хэдий ч улсын тусгаар байдлыг нь хүндэтгэн үздэг байсныг харуулж байна.

Дүгнэлт

1392 онд Корё улс мөхөх хүртэл 120 гаруй жил тус орныг удирдан жолоодож ирсэн вангийн засаглал буюу иргэний засаглал сэргэн тогтсон өөрчлөлт нь Юань улсын зүгээс Корё улсын нийгэм, улс төрийн тогтолцоонд нөлөөлсөн хамгийн том гадаад нөлөөлөл байсан. Корё улсын вангийн засаглал хэзээнээс сэргэсэн талаар судлаачид санал зөрүүтэй байдаг ч доктор Б.Лхагваагийн судласнаар 1259 онд цэргийн засаглалын толгойлогч улс төрийн тавцангаас зайлуулагдан, вангийн хүүг Монголын эзэн хаанд бараалхуулахаар ирүүлснээс эхлэл нь тавигдаж, 1270 онд ван эх газарт бүрмөсөн гарснаар цэгцэрч, 1273 онд Самбёлчогийн салан тусгаарлагчдыг дарсан, 1274 оноос Юань улсын хааны ордныхонтой төрийн ураг барилдлага тогтоосноор бүрэн сэргэжээ. Ингэж вангийн засаглал, түүний үндэс суурь бэхжихийн хажуугаар өмнө нь огт байгаагүй улс төрийн шинэ хүчний дэглэм үүсч, засаглалд тодорхой байр суурь эзлэх болсон нь Юань улсын нөлөөллийн илрэл юм.

Хоёр улсын улс төрийн харилцаа өргөжихийн хирээр орчуулагчдын үүрэг төдийчинээ өсч, төрийн эрх мэдэлтнүүд улс төрийн байр сууриа бэхжүүлэхэд их тус дэм үзүүлсэн байна. Мөн улс төрийн хүрээнд үзүүлсэн бас нэг нөлөөлөл нь уламжлагдаж ирсэн вангийн хүрээнийхэнтэй гэр бүл болдог байсан хязгаарлагдмал зуршлыг халж, шинэ журам тогтоосон явдал байв. Юаний шууд нөлөөгөөр Корё улсын дотоод улс төрийн үйл амьдралд гарсан бас нэр өөрчлөлт бол шат дамжлага ихтэй олон тооны албадыг цомхотгох, элдэв эрх ямба эдлэгч олон тооны түшмэдийн тоог цөөлөн, цол хэргэмийг шатлан бууруулах арга хэмжээг авсан явдал юм. Монгол, Солонгос хатад бүсгүйчүүд ч 2 орны улс төрийн харилцааг өргөжүүлэхэд, тэр дундаа Монгол хатад Юань улсыг Корё улсын дотоод хэрэгт шууд оролцоход голлох үүрэг гүйцэтгэж байсныг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм. Чингисийн алтан ургийн цусанд Корё улсын

⁶ Б.Лхагваа. XIII-XIV зууны үеийн Монгол-Солонгосын улс төрийн харилцаа, онцлог шинж, ул мөр. УННС.1995 он. Докторын ажил. 67 дахь тал

вангийн удмын цус, Корё улсын вангийн удмын цусанд монгол цус холилдсон явдал 2 улсын эмэгтэйчүүд нь ч улс төрийн харилцаанд бие даасан өргөн үүрэг гүйцэтгэж, олон талт харилцааны нэг өвөрмөц шижим болж өгсөн төрийн ургийн хэлхээ холбоог ^[7] ч тодруулан судлууштай.

Эшлэл авсан, ашигласан материалын жагсаалт:

1. Ж.Ганболд, Т.Мөнхцэцэг, Д.Наран, А.Пунсаг. Монголын Юань улс.2006. Улаанбаатар.129 дэх тал. Тэнд 132 дахь талд
2. Ж. Бор. Гуулин улсын судар. Монгол хийгээд Евроазийн дипломат шастир. 2004. УБ. 694 дэх тал
3. Б.Лхагваа. Монгол, Солонгосын харилцааны уламжлалаас. 1996.УБ. 129 дэх тал
4. Ж.Ганболд, Т.Мөнхцэцэг, Д.Наран, А.Пунсаг. Монголын Юань улс.2006. Улаанбаатар.133 дахь тал
5. Б.Лхагваа. Монгол, Солонгосын харилцааны уламжлалаас. 1996.УБ. 129 дэх тал
6. Ч.Далай. Монголын түүх. 1260-1368 он. 3-р дэвтэр. УБ. 1992 он
7. Б.Лхагваа. XIII-XIV зууны үеийн Монгол-Солонгосын улс төрийн харилцаа, онцлог шинж, ул мөр. УННС.1995. Докторын ажил. 67 дахь тал
8. Г.Эрдэнэчимэг. Гуулин улсын үеийн Монгол хатдын эдийн засгийн түшиг тулгуур. ЭШБ. МУИС.2001. Боть 170

⁷ Г.Эрдэнэчимэг. Гуулин улсын үеийн Монгол хатдын эдийн засгийн түшиг тулгуур. ЭШБ. МУИС.2001. Боть 170

Өнгөрсөн зууны эхэн үеийн хилийн чанд дахь Орос орны цэргийн соёл

Игорь Домнин

Октябрын хувьсгал, иргэний дайны үр дүнд Орос орноос хоёр сая гаруй хүн иргэншил, эх нутгаа орхин гарсан байдаг. Цагааны цэргийн дайчин эрс эх орноосоо хувьсгалаар хөөгдөгсдийн тэн хагасыг эзэлж, олон түмний ухамсарт “Цагаан арми” гэсэн нэрнээс үүссэн “Хилийн чанд дахь цагаан армийн дүрвэгсэд” гэсэн нэршил хүртэл түгсэн байсан юм. 20-30-аад онуудад бүрэлдэж бий болсон хилийн чанд дахь оросын цэргийн соёл нь цэрэг-шинжлэх ухааны үйл ажиллагаа, цэргийн боловсрол, цэргийн байнгын хэвлэл болон өөрсдийн хамт олны цэргийн соёлын үйл ажиллагааг зохион байгуулах зэргээр илэрч байжээ. Энэхүү цэргийн соёлын түүхэн үзэгдэл нь үнэлж баршгүй бөгөөд эх оронд нь байнгын зэвсэгт хүчин байгаа нөхцөлд урд өмнө нь түүхэнд хэдэн мянгаар тоологдох цэргийн дүрвэгсэд байгаагүй, генерал Е.К.Миллерийн илэрхийлж хэлснээр хилийн чанд дахь дүрвэгсэд нь “оюун санаа, сэтгэлгээний байлдааны нэгж” –ийг төрүүлж өгсөн байна. 20-30-аад онуудын Европын тухай ярих юм бол оросын дайчдын үндсэн хэсэг нь энэ тивд бий болж, эхний жилүүдэд анхлан цэргийн нүүдэлчдийн хуарангууд Галлиполи, Лемнос, Чаталджа зэрэг газруудад байгуулагдаж байжээ. Энэ байрлалд Врангелийн армийн үлдэгдэл, хасгуудыг ирүүлж, харин тэнгисийн цэргийн үлдэгдэл Тунисийн Бизертэд бий болсон байлаа. Нэн хүнд ахуй, улс төрийн нарийн төвөгтэй, адармаатай нөхцөлд генерал Врангель, Кутенов болон цэргийн бусад удирдагч нар эдгээр цэргийн хуарангуудын амьдрал, үйл ажиллагааг зохион байгуулж, 1923 он гэхэд хүмүүсийг Европын орнууд /үндсэндээ Балканы хойгт/-д тараан байрлуулж чадсан байна. Бүхэлдээ, хилийн чанд дахь цэргийн байгууллага нь бүх дэлхийгээр таран түгсэн /Австраль, бүр цаашлаад Филиппин хүртлэх/ олон арван холбоод, нэгдэл, бүлгүүдийг багтаасан бүтэцтэй байв. Тэдгээрийн дийлэнх нь 1924 онд байгуулагдаж, одоо ч үйл ажиллагаа нь явагдсаар байгаа “Оросын цэргийн нийтлэг холбоо” –ын бүрэлдэхүүнд багтаж байв.

Цагаантны хөдөлгөөний удирдагчдын улс төр-стратегийн таамаглал, найдвар нь эдгээр байгууллагуудыг Орос дахь шинэ зэвсэгт тэмцэл, оросын үндэсний шинэ арми байгуулах үйл хэрэгт татан оролцуулах боломжийг үгүйсгэхгүй байсаар байв.

Энэхүү санаа, найдварын зэрэгцээ олон офицерууд өөрсдийн онолын түвшингөө өсгөн нэмэгдүүлэх, тэрчлэн, цагаачдын дунд дэлхийн дайн, иргэний дайны баялаг туршлага, сургамжид суурилсан цэргийн хэргийн боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх гэсэн сэтгэлийн уяа, тэмүүлэл, татах хүч сулраагүй байсан ажээ.

Врангель болон агуу гүн Николай Николаевичийн даалгавраар генерал Головин цэргийн дээд сургуулийг удирдах болов. Таван жилийн туршид үргэлжилсэн бэлтгэл ажлын дараа Париж хотноо 1927 онд Цэргийн шинжлэх ухааны дээд дамжаа нээгдэж, жилийн дараагаар анх байгуулсан генерал Головины нэрэмжит болжээ. Энэ байгууллага нь 1940 оныг хүртэл ажиллаж, олон тооны цэргийн боловсрол олгох сайн дурын дугуйлан /50 гаруй/, цэргийн сургууль, офицеруудын сургууль, дамжаа /арав гаруй/, кадетын корпус /эхлээд 3, 1940 он гэхэд 1/-уудын үйл ажиллагааг идэвхижүүлж байжээ.

Үүний зэрэгцээ Париж хотноо 30-аад онд генерал Головины санаачлагаар генерал А.Н. Шуберскийн удирдлага доор дайн, энхийн асуудлыг судлах Цэргийн шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулагдаж, Белград хотод филиалаа ажиллуулж байжээ.

30-аад онд Париж хотноо академийн боловсролын түвшинд сургалт явуулж байсан Цэрэг-техникийн дамжаанууд үйл ажиллагаагаа эрхлэж, хувьсгалаас өмнөх жилүүдэд Николаевскийн нэрэмжит инженерийн академид багшилж байсан бүрэлдэхүүн зонхилон ажиллаж байв.

30-аад оны сүүлийн жилүүдэд Оросын цэргийн байгууллагуудын Холбооны дэргэд хилийн чанд дахь оросуудын улс төр-засаг захиргааны сургууль үйл ажиллагаагаа явуулах оролдлого хийж байжээ. Энэхүү сургуулийг зохион байгуулагчдын бодлогоор, цэргийн болон улс төр-засаг захиргааны боловсролын нэгдлийг хангах зорилттой байсан ажээ.

Цэргийн мэдлэг, боловсрол олгох ажиллагаа зөвхөн мэргэжлийн сургууль, дамжааны хүрээнд зохион байгуулагдаагүй байна. Олон тооны генерал, офицерууд орой, шөнийн цагаар цэрэг-шинжлэх ухааны нийгэмлэг, офицеруудын клубүүдэд цугларцгааж, өөрсдийн үзэл бодол, илтгэлүүдийг хэлэлцүүлж, маргаан мэтгэлцээн хийцгээж байв. Энэ мэтийн нийгэмлэг, дугуйлангууд газар бүр байж, ялангуяа Белград, Париж, Сараева, Праг, Шанхай, Сан-Франциско хотуудад идэвхитэй үйл ажиллагаа явуулж байв. Хилийн чанд дахь Оросын цэргийн боловсрол нь системийн шинжийг агуулж байсан бөгөөд цэргийн анхан шатны боловсролоос цэргийн дээд боловсрол олгох түвшинд зохион байгуулагдаж байжээ.

Оросын цэргийн соёлын бүхий л хүрээ хилийн чанд дахь дүрвэгсдийн цэргийн үзэл бодлыг төлөөлж байлаа. Тэдний дотор бүхэнд нэр нөлөөтэй байсан Н.Головин, А.Баиов, А.Геруа, Б.Геруа, Ю.Данилов, А.Керсновский, А.Келчевский, В.Драгомиров, А.Драгомиров, А.Зайцов, А.Бубнов, Б.Штейфон, Е.Месснер, А.Мариюшкин, Н.Колесников, А.Гулевич нарын зэрэг хүмүүс байв.

Тэд дэлхийн Нэгдүгээр дайны баялаг туршлагаас сэхээрэл авч, хилийн чанд дахь цэрэг хүний оюуны бүтээн байгуулах хүсэл эрмэлзлэлдээ хөтлөглөн оросын ирээдүйн армийг бүтээн байгуулах үзэл баримтлалыг боловсруулцгааж байлаа. Тэдний бүтээлийн зарим нэгийг нь нэрлэвэл, Н.Головины “Оросын зэвсэгт хүчний ирээдүйн дүр төрхийн тухай эрэгцүүлэл”, А.Баиовын “Оросын ирээдүйн армийн тулгуур үндсүүд”, А.Керсновскийн “Манай ирээдүйн офицерын корпус, “Манай ирээдүйн цомхон арми” зэрэг бүтээлийг нэрлэж болно.

Хилийн чандад амьдрах болсон цэргийн сэхээтнүүд 20-иод оны бүр эхэн үеэс мэргэжлийн чанарын шинэ маягийн арми руу шилжин орох шаардлага бий болсон, Оросын цэргийн номлолыг буй болгох хэрэгцээ, шаардлага үндэстэн-төр улсын эрх ашгаас үүдэн гарч байгаа тухай үзэл бодлыг дэвшүүлцгээж байв.

Цэргийн мэргэжилтнүүд цэргийн сэтгэл зүй, цэргийн сурганы асуудалд ихээхэн анхаарал хандуулж байжээ. Цэргийн хүмүүжил, эх оронч үзлээр залуу үеийг хүмүүжүүлэх тухай генерал П.Ольховский, А.Болдунов, П.Краснов нарын алдартай бүтээлүүд гарч байв. Орос орны түүхэн ирээдүй, тухайн эриний цэрэг улс төр-нийгмийн байдлыг ухаарч эрэгцүүлэн бодох оролдлого хийсэн А.Геруагийн “Полчище” – “Үй түмэн цэрэг” бүтээл 1923 оны үед хэвлэгдэж гарснаараа нийгэм-улс төр, цэргийн байгуулалтын хэрэг явдлыг задлан шинжлэх үйлсэд ихээхэн үлгэр дууриалал үзүүлсэн байна.

Уг номын үндсэн агуулга нь, ард түмний зэвсгийг хураах /эс тэгвээс зэвсэглэсэн ард түмэн юуны түрүүнд өөрөө өөртөө аюултай/, нийгмийн тогтвортой байдлыг хангах, дайныг хүмүүнлэг болгох хүчин зүйлсийн нэг болох мэргэжлийн авсаархан армитай болох, армийг хорлон сөнөөж, хүчийг нь сарниулж байгаа нам-улс төрийн салбар дахь талцал, хуваагдмал байдлыг гэтлэн давах хэрэгцээ, шаардлага байна. Үүнд л хилийн чандад дүрвэн гарсан цэргийнхний эх орноо гэсэн цэрэг хүний бодол, сэтгэлгээний үндсэн агуулга оршиж, энэ утгаараа нийгмийн шинжлэх ухааны асуудалд татагдаж, цэргийн түүхийн асуудлыг нийгмийн бүхий л орон зай, ялангуяа улс төр, нийгмийн амьдралтай салшгүй холбоо, харилцаанд авч үзэж байжээ.

Цэргийн сэтгэлгээний бусдаас ялгарах өөр нэг тал гэвэл, оросын уламжлалт сэтгэлгээний салаа мөчрүүдэд ихээхэн тодорхой байдлаар хоёрдмол санаа буюу “славянчлах үзэл”, “баруунчлах үзэл” хийсвэр байдлаар буй болж байгаа байдал юм. Энэ байдлын анхны төлөөлөгчид нь А.Баиов, Б.Штейфон, А.Драгомиров болон бусад, хоёрдогчийн төлөөлөгчид – Н.Головин, А.Зайцов, Н.Пятницкий болон тэдний хамтран зүтгэгчид юм.

Цэргийн сэтгэлгээний эдгээр салаа мөчрүүдийн хооронд цэргийн байгуулалт, дайныг явуулах зэрэг олон тооны асуудлаар байнгын маргаан, мэтгэлцээн явагдаж байв. “Славянчлах” үзэлтэй цэргийнхэн эх орны туршлага, сургамжаар их төлөв баримжаалж, “баруунчлах” үзэлтнүүдийг гадаадын цэргийн онолчдын үзэл бодлыг хэт их шүтэн

бишрэх болсныг нь шүүмжилж байв.

Оросын хилийн чанд дахь цэргийнхний амьдралд ихээхэн чухалд тооцогдож байсан зүйл нь цэргийн сэдвээр тогтмол хэвлэгддэг байсан сонин хэвлэл юм. Төрөл бүрийн чиглэлээр хэвлэгдэж байсан 100 гаруй сонин хэвлэл байжээ. Цэргийн асуудлаар бүтээл, туурвил хэвлүүлэх ажлыг хошуучлагчийн нэг Б.Штейфон нэгэнтээ тэмдэглэхдээ, “Бүхэлдээ ядуу, зүдүүгийн төлөөлөл болох бид нар олон олон улс гүрэнд байхгүй цэргийн байнгын хэвлэлийг бий болгож чадлаа” хэмээн бодит байдлыг илэрхийж байв.

Цэргийн байнгын хэвлэлүүдийг гол төлөв дараах чиглэл, агуулгаар нь дараах хэсэгт хувааж болохоор байжээ. Үүнд: Шинжлэх ухааны, энэ чиглэлээр хэвлэгдэж байсан үндсэн хэвлэлүүдийн тоонд, “Военный сборник – Цэргийн товхимол” /Белград/, “Война и мир – Дайн ба Энх” /Берлин/, “Вестник военных знаний – Цэргийн мэдлэгийн мэдээ” /Сараева/, “Осведомитель – Мэдээлэгч” /Белград/, Нийгмийн ухааны – “Часовой – Харуул” /Париж-Брюссель/, “Армия и Флот – Арми ба Флот” /Шанхай/, “Русский военный вестник – Оросын цэргийн мэдээ” /Белград/, Түүхийн – “Военная быль – Цэргийн үнэн явдал” /Париж/, “Военно-исторический вестник – Цэргийн түүхийн мэдээ” /Париж/, Нарийн мэргэжлийн – “Артиллерийский журнал – Их буучдын сэтгүүл”, “Авиационный бюллетень” – Авиацийн мэдээ”, “Вахтенный журнал – Манаачийн сэтгүүл” болон бусад. Эдгээр сэтгүүлүүдээс зөвхөн тодорхой хэсэг нь л типографын аргаар хэвлэгдэж байв. Олонхи нь илтгэгчдийнхээ санаачилга, хүчин чармайлтын үр дүнд олон арван хувиар олшруулагдан түгээгдэж байжээ. Зарим нэг нь хэвлэлийн машинаар, бүр гар бичмэлийн аргаар түгээгдэж байсан ажээ. Хэвлэн нийтлүүлж байгаа хүмүүсийн намтар түүх мөн л олон янзын дүр төрхтэй байжээ. Нэг хэсэг нь богинохон амьдарсан байхад нөгөө хэсэг нь олон жилийн амьдрал, хүнд хүчир замыг туулсан байна. Жишээ нь, Хилийн чандад дүрэвсэн оросуудын дайчин алдрын холбоо хэлхээний байгууллагын сэтгүүл болох “Часовой” сэтгүүлийн түүхэн замнал гэвэл, 1929 оны нэгдүгээр сараас 1988 оныг хүртлэх хугацаанд нийт 668 дугаар гарч, хожим нь В.В.Орехов, Е.Тарусский нарын редакци, удирдлагын доор Оросын Үндэсний Нэгдэлийн байгууллагын хэвлэл болсон түүхтэй. Уг сэтгүүл нь хилийн чандад амьдарч байгаа оросын эх орноо гэсэн дүрвэгч дайчин хүмүүсийн амьдралын тухай боломжтой бүх мэдээллийг том хэмжээгээр хэвлэгддэг 40 хуудас бүхий сэтгүүлээр нийтлэдэг байжээ.

Энэ сэтгүүлийн дугаар бүхэн нь оросын цэргийн дүрвэгсдийн ахуй байдлыг нэгтгэн тусгасан он дарааллын түүхэн бичээс болсон байна. Цэрэг-шинжлэх ухаанчдын дур сонирхлыг “зузаан” сэтгүүлүүд ихээхэн татаж анхаарал байлаа. Тухайлбал: В.М.Пронин, И.Ф.Патронов нарын редакцитай “Цэргийн мэдлэгийг сонирхогчдын нийгэмлэгийн цэргийн эмхэтгэл”, М.И.Тимонов, А.К.Келчевский, В.В.Колоковский нарын редакцитай “Дайн ба энх”, К.К.Шмигельский редакцитай “Цэргийн мэдлэгийн мэдээ” зэргийг нэрлэж болно. Эдгээр сэтгүүлүүдэд

хилийн чандад амьдарч байсан цэргийн оюун ухааны сорууд бүтээлээ нийтлүүлж байв. Тухайлбал, Н.Головин, Б.Геруа, А.Геруа, А.Баиов, А.Келчевский, Е.Новицкий, В.Ворисов, А.Бубнов, Б.Штейфон болон нэлээд залуу насны К.Керсновский, Е.Месснер нар, бусдыг дурьдаж болох юм. Олон хэвлэлийн газар тодорхой хэмжээгээр өөрсдийн эзэд, редакцуудын онцлогыг харуулж байв. Энэ нь үнэхээр чухал байсан бөгөөд яагаад гэвэл, хилийн чандад хэвлэгдэж байсан цэргийн байнгын хэвлэлүүдийн зонхилох хэсэг нь өөрсдийн санаачлагчдын асар их оюун санаа /тэрчлэн санхүүгийн/ ачаалал доор оршин тогтнож байжээ. Тэдгээрийн тоонд, өмнө нь дурдагдаж байсан В. Орехов, Е.Тарусский нарын “Часовой”, А.Гериний “Военная быль” Рклицкийн “Русский военный вестник” нэрээр хожим нь хэвлэгдэж байсан “Царский вестник” сэтгүүлүүдийг нэрлэж болно. Ийм хүмүүсийн тоонд Шанхайд хэвлэгдэж байсан “Армия и Флот” сэтгүүлийн редакци-хэвлэн нийтлэгч хурандаа И.В.Колесниковыг нэрлэж болох юм. Тэрээр 1925 оноос сэтгүүлээ гаргаж, 1936 оны хооронд нийтдээ 48 дугаарыг хэвлүүлж байжээ. Энэ сэтгүүлийн дугааруудад улс төрийн цар хүрээтэй мэдээ, мэдээлэл хэвлэгдэж байсны зэрэгцээ цэргийн шинжлэх ухааны бүтээлүүд, цэргийн сургалт, хүмүүжлийн болоод гүн ухаан, сэтгэл зүйн сэдэвтэй өгүүлэл, материалууд хэвлэгдэж байжээ. Колесников өргөн мэдлэг, танин мэдэхүйн болон уран зохиолын хэмжээлшгүй авъяас билэгтний нэгэн байсан бөгөөд тэрээр “Франц уу, эсвэл Герман уу”, “Святая Русь”, “Диктатор-Дарангуйлагч”, “Суворов”, “Дайны философи” зэрэг бүтээлийг туурвиж байсан ажээ. Сэтгүүлийнхээ хуудсаар дамжуулан тэрээр цэргийн шинжлэх ухаан, боловсролын өнгө төрхийн асуудлаар цаглашгүй тэмцэгч байснаар барахгүй цэргийнхэн эрч хүчтэй байхыг хөхүүлэн дэмжигч байж, хилийн чандад суугаа хүмүүсийн дотор бэртэгчин үзэл, хагалан бутаргахын эсрэг хүчтэй тэмцэгч байж, оросын соёл, оросын оюун санааг хамгаалахын төлөө явж байжээ.

Дүрвэгчдийн томоохон төвүүдэд цэргийнхэн музей, номын сангууд ажиллуулж, цэргийн уламжлал, ритуалуудыг хадгалж үлдэхийн төлөө ихээхэн ажил зохиож байсан нь чухал юм. Цэргийнхний дунд олон тооны яруу найрагч, зохиолчид байжээ.

Тэдгээрийн нэг нь П.Краснов байсан бөгөөд 20-30-аад оны оросын цагаачид түүний олон арван роман, тууж, өгүүлэлүүдийг шимтэн уншицгаадаг байжээ. Түүний зохиолууд Европ, Азийн орнуудын 11 хэл дээр орчуулагдаж байжээ.

Цагаачдын цэргийн соёлын агуулга нь зөвхөн цэрэг, дайчин үзлээр хязгаарлагдахгүй байв. Оросын хилийн чандад амьдарч байсан эрдэмтэн, нийтлэгчдийн дайн, энхийн асуудлаар үлдээсэн асар их өв уламжлал нь цагаач, дүрвэгсдийн нэг ёсны цэрэг, батлан хамгаалахын тухай бодол эргэцүүлэл байжээ. Л.Карасин цэргийнхэн, түүгээр зогсохгүй “орон тооны” эрдэмтэд, хүсэл тэмүүлэлдээ хөтлөгдсөн ухамсартай жирийн орос хүмүүсийг хүртэл дайн, энхийн асуудалд ажил хэрэгч, үнэн сэтгэлээсээ анхаарал хандуулахыг уриалж байв. Карасины үзлээр

“дайн бол оросын түүхийн нэн чухалд тооцогдох бодит үйл хэрэг, ийм ч учраас дайныг оросын эрх ашгийн үүднээс тунгаан бодох нь оросууд бидний хувьд нэн их чухалд тооцогдох асуудал юм” гэжээ. И.А.Ильин бол эр зориг, сэтгэлгээний онцгой хатуужлын эзэн байсан юм. Түүний олон олон бүтээл, туурвилууд нь цэрэг хүний дайчин зан чанарыг харуулахад зориулагдсан байна. Тэрээр оросын армид “манай үндэстний баатарлаг гавъяат үйлс биеллээ олж”, “эх орны бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолын цайз” буй болохыг харж, оюун санааны соёл болон улс орны батлан хамгаалах хэрэг явдал өөр хоорондоо гүн гүнзгий холбоо, хэлхээтэй байдаг бөгөөд энэхүү холбоос ард түмний хувь заяаг олонтаа илэрхийлэгч болж байдаг. Н.Бердяев, П.Струве, П.Сорокин, Ф.Степун, Г.Федотов, П.Тимашев, Е.Спекторский, М.Таубе хийгээд цөллөгт байсан нэр нөлөөтэй болон нэр нь тодроогүй бусад ухаантнуудын дайн, армийн тухай бодол эргэцүүлэл нь олон талаар сонирхол татахуйц, үнэт зүйл юм. Тэдний үзэл бодол нь хилийн чандад амьдран суугчдын цэрэг- онол арга зүйн өвийг ихээхэн баяжуулж өгсөн байдаг. Оросын хилийн чанд дахь цэргийн соёлын үзэгдэл нь орчин үеийн түүхэнд ач холбогдлоороо үнэлж баршгүй юм. Энэхүү соёл нь хувьсгалын өмнөх үеийн Орос орны цэргийн соёлтой хүйн холбоотой, түүний үргэлжлэл юм. Цөллөгт байгсадын цэргийн соёл нь ЗХУ-ын цэргийн соёлтой нэг цаг хугацаанд байж, ялгарах онцлог нь гэвэл, бие даасан, олон талын үзэл, чиглэлийн шинж чанарыг илэрхийлж байсан учраас агуулгын хувьд ихээхэн баян, сонирхол татахуйц байсан ажээ. Хилийн чанд дахь Оросын цэрэг-оюун санааны өв уламжлал нь орчин үеийн Эх орноо хамгаалагчид болон бүх оросуудын түүхэн эх оронч ухамсарыг бүрэлдүүлэхэд ашиг тусаа өгөх юм. Оросын агуу их сэтгэгчдийн нэгэн төлөөлөгч Б.Н.Чичериний тэмдэглэхдээ, “энэхүү өв уламжлалаар эх орныхоо цэргийн соёлын алтан хуудсыг нэгээр баяжуулж, шинэ зам, чиглэлийг нээгээд зогсохгүй, нэгэнт бий болгосноо хадгалж хамгаалаад зогсохгүй, үнэн бодьтой хөгжлийн ирээдүйг нээж байна” гэжээ.

* * *

Өнөөдөр Оросын хилийн чанд дахь цэргийн үзэл бодлын асуудлыг эрэн хайх, нэгтгэн дүгнэх, ухамсарлаж ойлгох, нийтийн хүртээл болгох ажлын үнэмлэхүй хэсгийг ОХУ-ын Цэргийн их сургуулийн дэргэдэх түүх шинжилгээний хэвлэлийн газарт үйл ажиллагаа явуулж байгаа “Оросын цэргийн товхимол” хэвлэлийн газар эрхлэн явуулж байна. “Оросын цэргийн товхимол” хэвлэл нь “Воин” нэртэй нийгмийн нэгдлийн газартай хамтран ажиллаж, хилийн чандад суугаа өөрийн гэсэн өнгө төрхөөр бусдыгаа манлайж байгаа зохиогчдын бүтээлийн хоёр боть бүтээлийг “Оросын офицерын номын сан” нэрээр хэвлэн гаргаж байна. Анхны боть нь “Дайны философи” нийтлэг нэртэйгээр дайн, армийн тухай үзэл бодлыг задлан шинжлэх өргөн агуулга бүхий хэд хэдэн зохиол бүтээлийг багтааж байгаа юм. Хоёр дахь боть нь “Армийн зүрх сэтгэл” нэртэйгээр цэргийн сэтгэл зүй, цэргийн сурган зүйн үзэл

бодлын асуудлыг тусгасан байна.

Санал болгож байгаа зохиолуудын дийлэнх нь Орост анх удаагаа хэвлэгдэж байгаа, тухайлбал, А.Керсновскийн “Дайн философи”, А.Мартюшкины “Дайныг санагтун”, П.Красновын “Армийн зүрх сэтгэл” болон бусад бүтээлүүдийг нэрлэж байна.

Уншигч та бүхэн өөрийн хүсэл, оюун ухааны түвшингээр эдгээр бүтээлч, уйгагүй сэтгэгчдийн зохиол, бүтээлийн түүхэн ач холбогдолд үнэлгээ өгч, оросын алдартай цэргийн зохиолчдын чухам юугаар нь оюун ухаанаа цэнэглэх боломжтойг сонгох боломжтой юм. Мэдээж олон тооны хэлсэн зүйлс, үзэл санаа бидний олон жилийн туршид удирдлага болж, бидний оюун тархи “тэжээгдэж” байснаас эрс ялгаатай байх нь ойлгомжтой. Гэвч, Орос хүмүүсийн бий болгосон өв уламжлал, түүхийн гашуун туршлагаар бий болж, зовлон гасланг туйлын их амссан Орос орон түүний ард түмний нулимс, цусаар гагнагдсан түүхтэй. Орос орон, түүний “ирээдүйн” армид хэрэг болгох найдвар тээж, цаг цагийн аясад хилийн чандад амьдарч байсан /буй/ цэргийн шилдэг ухаантан, мэргэд өөрсдийн зохиол, бүтээлийг ийнхүү зориулжээ. Миний бие А.Керсновскийн “ Дайны Философи” зохиолыг орчуулаад байгаа юм.

*Орчуулж, хэвлэлд бэлтгэсэн
доктор (Ph.D), профессор Ч.Улаанхүү*

“ХАЛХЫН ГОЛЫН ДАЙН-80 ЖИЛ” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал

Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80 жилийн ойн хүрээнд “Халхын голын дайны ялалт-80 жил” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 08 дугаар сарын 23-ний өдөр Батлан хамгаалах яам, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн хамтран зохион байгууллаа. Хурлыг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн “Олон улсын хурлын танхим”-д хийсэн бөгөөд хуралд Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга З.Энхболд, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хошууч генерал А.Ганбат, Агаарын цэргийн командлагч бригадын генерал О.Энхбаяр болон ҮАБЗ-ийн Ажлын алба, УИХ-ын Тамгын газар, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын алба, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Ажлын алба, Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэн, Монгол Улсын Боловсролын их сургууль, Архивийн ерөнхий газрын албан тушаалтан, эрдэмтэн, судлаачид оролцлоо.

Мөн ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К. Азизов, БНЭУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.Р.Сингх, БНАСАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Элчин зөвлөх Хан Чол Мин болон ОХУ, БНТУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яамдын дэргэдэх цэрэг-агаарын цэргийн атташе нар үзэж сонирхсон.

ОХУ-ын ЗХЖШ-ын Цэргийн академийн эрдэм шинжилгээний (цэргийн түүхийн) хүрээлэнгийн газрын дарга, түүхийн ухааны доктор (Ph.D), доцент, хурандаа Шагов Андрей Евгеньевич, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Будда судлалын хүрээлэнгийн захирал, академич, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Борис Ванданович Базаров, тус хүрээлэнгийн Төв Азийн түүх, соёлын тэнхимийн ахлах судлаач, түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн, профессор Леонид Владимирович Курас, ахлах судлаач, түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн Виктор Борисович Базаров, ОХУ-ын ЗХЖШ-ын Цэргийн академийн эрдэм шинжилгээний (цэргийн түүхийн) хүрээлэнгийн хэлтсийн орлогч дарга, цэргийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн, дэд хурандаа Прямыцын Владимир Николаевич, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, түүхийн шинжлэх ухааны дэд эрдэмтэн, доцент, цэргийн шинжлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн, бэлтгэл хурандаа Борис Александрович Божедомов, ОХУ-ын Элчин сайдын яамны зөвлөх, дэд эрдэмтэн, профессор Евгений Иванович Лиштованный, ОХУ дахь Г.К.Жуковын музейн эрдэм шинжилгээний ажилтан Олег Владимирович Ежов, Буриадын үндэсний музейн захирал, дэд эрдэмтэн Татьяна Анатольевна Бороноева, ОХУ-ын Эрхүүгийн Их сургуулийн захирлын зөвлөх Непомнящих Игорь Витальевич,

БНХАУ-ын Өвөр-Монголын өөртөө засах орны Хөлөнбуйр хотын Номунхан дайны судалгааны төвийн ахлах мэргэжилтэн Шү Жань Жян тэргүүтэй дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид тус тус илтгэл тавьж оролцлоо.



“Халхын голын дайн-80” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогчид дурсгалын зураг татуулав.



“Халхын голын дайн-80” Олон улсын хуралд оролцогчид, зочид төлөөлөгчид

“АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ СУДЛАЛ: ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ”

эрдэм шинжилгээний хурал

Цэргийн эрдэм судлалын 60 жил, Батлан хамгаалах яамны ШУТЗ-ийн 30 жил, БХЭШХ-ийн 40 жилийн ойг тохиолдуулан БХЯ, ҮБХИС, БХЭШХ хамтран “Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал: өнөө ба ирээдүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 11 дүгээр сар 14-ний өдөр ҮБХИС-ийн “Сүбээдэй” олон улсын хурлын танхимд амжилттай зохион байгууллаа. Хуралд Батлан хамгаалахын дэд сайд, Батлан хамгаалах яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дарга Т.Дуламдорж, Батлан хамгаалах яамны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын дарга, хурандаа Д.Ганхуяг, Зэвсэгт Хүчний Жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирал хурандаа П.Жаргалан, МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн захирал С.Баттулга болон аюулгүй байдал судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг албан тушаалтан, эрдэмтэн, судлаачид оролцлоо.



*Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал: өнөө ба ирээдүй”
эрдэм шинжилгээний хуралд оролцогсод*

“ЦЭРГИЙН ЭРДЭМ СУДЛАЛ - 60 ЖИЛ”

эрдэм шинжилгээний хурал



Монгол улсад цэргийн эрдэм судлал үүсч хөгжсөний 60 жил, Монгол Улсын Батлан хамгаалах яамны Шинжлэх Ухаан технологийн зөвлөлийн 30 жил, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Цэргийн эрдэм судлал - 60 жил” эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн “Соёлын төв”-д зохион байгуулав.

Эрдэм шинжилгээний хуралд Зэвсэгт Хүчний Жанжин штабын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, Батлан хамгаалах яамны гадаад хамтын ажиллагааны газрын дарга, хурандаа Э.Гансүх, ҮБХИС-ийн захирал, профессор, хурандаа П.Жаргалан, БХЭШХ-ийн захирал, доктор(Ph.D), профессор, хурандаа Б.Мөнхсайхан, БХЭШХ-ийн эрдэмтэн судлаачид, ахмадуудын төлөөлөл, ҮБХИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүд, эрдэмтэн багш нар, сонсогч оюутнуудын төлөөлөл оролцлоо.



“Цэргийн эрдэм судлал - 60 жил” эрдэм шинжилгээний хуралд оролцогсад

БХЭШХ-ИЙН 2019 ОНЫ БҮТЭЭЛҮҮД



БХЭШХ-ИЙН 2019 ОНЫ БҮТЭЭЛҮҮД

